НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

Хуульчдын гудамж 13/1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-11) 32 29 36,
Цахим шуудан: info@nduz.gov.mn,
Цахим хуудас: www.nduz.gov.mn

2026.04.30 № 48

танай ____________-ны №____________-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА П.ГАНЗОРИГ ТАНАА

Тайлан хүргүүлэх тухай

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.12 дугаар хэсэгт "Үндэсний зөвлөл ажлаа Улсын Их Хуралд жил бүр тайлагнана" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны үйл ажиллагааны тайлан, системчилсэн үнэлгээний тайлан, холбогдох бусад эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хамт хавсралтаар хүргүүлж байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны тайлан 2025 он (хуудас 63)
2. Системчилсэн үнэлгээний тайлан 2025 он (хуудас 43)
3. МУ-ын урт хугацааны "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн хэрэгжилт (хуудас 7)
4. МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (хуудас 3)
5. ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт (хуудас 16)
6. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт (хуудас 1)
7. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт (хуудас 60)
8. Шилэн дансны хуулийн хэрэгжилт (хуудас 6)
9. Нийтийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээний тайлан (хуудас 6)
10. Байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан (хуудас 74)
11. НДБ-ын 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан

Хавсралт 279 хуудастай.

Хүндэтгэсэн:

ДАРГА Т.АУБАКИР

1000004

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН**
**ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ**

# НИЙГМИЙН ДААТГАЛЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

2026 он

# АГУУЛГА


ӨМНӨХ ҮГ

1. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ
2. НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО
3. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
   - 3.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэн эрх
   - 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн
   - 3.3 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан, шийдвэр
   - 3.4 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн хорооны үйл ажиллагаа
4. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ
   - 4.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв
   - 4.2 Нийгмийн даатгалын сангийн орлого
   - 4.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт
5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР, ЗАРДАЛ
   - 5.1 Тэтгэвэр олголт
   - 5.2 Тэтгэмж олголт
   - 5.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон төлбөр, зардал
   - 5.4 Ажилгүйдлийн тэтгэмж олголт
6. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА
   - 6.1 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалт
   - 6.2 Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа
7. ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ
8. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХАРИЛЦАХ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ, АВЛАГА
   - 8.1 Нийгмийн даатгалын хамралт
   - 8.2 Нийгмийн даатгалын сангийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл
   - 8.3 Нийгмийн даатгалын сангийн авлага
9. КАПИТАЛ, ЧИНГИС ХААН БАНКНЫ ӨР ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТАЛААР
   - 9.1 Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн өр төлбөрийг төлүүлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
   - 9.2 Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ
10. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ
   - 10.1 Хөгжлийн бодлого, төрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилт, хяналт
   - 10.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хяналт
   - 10.3 Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны төлөвлөгөөний биелэлт

**11. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖУУЛАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ, ХҮРТЭЭМЖ**
11.1 Мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлт
11.2 Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалт
**12. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛ**
**13. ХЯНАЛТ ШАЛГАЛТ**
13.1 Дээд газрын хяналт шалгалт
13.2 Төлөвлөгөөт хяналт шалгалт
13.3 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт
13.4 Нийгмийн хамгааллын хяналт шалгалт
**14. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ**
14.1 Мэдээллийн ил тод байдал
14.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
14.3 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах
14.4 Лавлах үйлчилгээ
**15. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ**
**16. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА**
16.1 Хүний нөөц
16.2 Үйл ажиллагааны зардал
**17. ДҮГНЭЛТ**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| Товчлол | Тайлал |
|---|---|
| АА | Ажлын алба |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АО | Ажил олгогч |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ГБХНХЯ | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ЗГ | Засгийн газар |
| ЗХХАУНС | Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сан |
| КБЭХА | Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагч |
| МБ | Монголбанк |
| МУ | Монгол улс |
| МУИС | Монгол улсын их сургууль |
| МХ | Мэргэжлийн хороо |
| МҮЭХ | Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз |
| НД | Нийгмийн даатгал |
| НББХ | Нийгмийн бодлогын байнгын хороо |
| НДБ | Нийгмийн даатгалын байгууллага |
| НДГ | Нийгмийн даатгалын газар |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НДСЧҮ | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл |
| ОНХЗ | Олон нийтийн хяналтын зөвлөл |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СЭЗИС | Санхүү, эдийн засгийн их сургууль |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТДНД | Тэтгэврийн даатгалын нэрийн данс |
| ТДС | Тэтгэврийн даатгалын сан |
| ТНС | Тэтгэврийн нөөц сан |
| ХААИС | Хөдөө аж ахуйн их сургууль |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ХЧТА | Хөдөлмөрийн чадвар түр алдалт |
| ЦХТАО | Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| Хүснэгтийн дугаар | Хүснэгтийн нэр |
|---|---|
| Хүснэгт 1. | НДҮЗ-ийн хуралдааны мэдээлэл |
| Хүснэгт 2. | НДҮЗ-ийн баталсан тогтоол |
| Хүснэгт 3. | ЗХХАУНС-д бүртгүүлсэн тогтоол |
| Хүснэгт 4. | МХ-ны хуралдааны мэдээлэл |
| Хүснэгт 5. | МХ-ны гишүүдийн НД-ын чиглэлээр хийсэн бүтээлүүд |
| Хүснэгт 6. | НДС-ийн орлогын биелэлт, төрлөөр |
| Хүснэгт 7. | НДС-ийн орлогын гүйцэтгэл, сангаар |
| Хүснэгт 8. | НДС-ийн зарлагын гүйцэтгэл, сангаар |
| Хүснэгт 9. | НДС-аар үйлчлүүлсэн хүний тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 10. | Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 11. | Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 12. | ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 13. | Үнэт цаасны хүүгийн тооцоолол |
| Хүснэгт 14. | Хуралдаан, уулзалтын мэдээлэл |
| Хүснэгт 15. | ТНС-ийн харилцах дансны үлдэгдэл |
| Хүснэгт 16. | 2025 оны жилийн эцсийн авлага барагдуулалтын мэдээ |
| Хүснэгт 17. | НД-ын санхүүжилт 2020-2025 он |
| Хүснэгт 18. | Өр төлбөр барагдуулалт |
| Хүснэгт 19. | НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан болон борлуулсанх өрөнгө |
| Хүснэгт 20. | НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгө |
| Хүснэгт 21. | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт |
| Хүснэгт 22. | Хяналтад авсан шийдвэрийн заалтууд |
| Хүснэгт 23. | Хууль, тогтоол, шийдвэрийн биелэлт |
| Хүснэгт 24. | Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон хүний тоо |
| Хүснэгт 25. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байдал |
| Хүснэгт 26. | Хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан |
| Хүснэгт 27. | Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн тоон үзүүлэлт |
| Хүснэгт 28. | Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчил |
| Хүснэгт 29. | Дотоодын хяналт шалгалтын тайлангийн нэгтгэл |
| Хүснэгт 30. | Ажилгүйдлийн даатгалын сангийн илэрсэн зөрчил |
| Хүснэгт 31. | Мэдээллийн ил тод, нээлттэй байдал |
| Хүснэгт 32. | Мэдээлэл байршуулалт |
| Хүснэгт 33. | НД-ын салбарын албан хаагчдын бүтэц, албан тушаалын ангилал |
| Хүснэгт 34. | НД-ын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил, нас хүйсийн мэдээлэл |

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ


| Графикийн дугаар | Графикийн нэр |
|---|---|
| График 1. | НДБ-ын тогтолцоо |
| График 2. | МХ-ны бүтэц, бүрэлдэхүүн |
| График 3. | НДС-ийн төсөв |
| График 4. | НДС-ийн орлогын бүтэц, эзлэх хувь |
| График 5. | Тэтгэврийн зарлага |
| График 6. | Тэтгэвэр авагчдын бүтэц |
| График 7. | Тэтгэврийн хэмжээ |
| График 8. | Тэтгэмжийн зарлага |
| График 9. | ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага |
| График 10. | Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| График 11. | НДС-ийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого |
| График 12. | Хуримтлалын сангийн бүтэц |
| График 13. | НД-ын хамрапт |
| График 14. | НДС-ийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл |
| График 15. | НДШ-ийн өр, авлага |
| График 16. | Борлуулсан хөрөнгө |
| График 17. | Өр төлбөр барагдуулалтын явц |
| График 18. | НДС болон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч |
| График 19. | НДБ-ын үйл ажиллагааны зардал |

## ЗУРГИЙН ТАЙЛБАР


| Зургийн дугаар | Зургийн нэр |
|---|---|
| Зураг 1. | НДҮЗ-ийн бүрэлдэхүүн |
| Зураг 2. | МХ-ны хуралдаан |
| Зураг 3. | Хяналтын зөвлөлөөс хийсэн сургалт |
| Зураг 4. | ОНХЗ-ийн уулзалт |
| Зураг 5. | Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал |
| Зураг 6. | НДШ-ийн авлага, өмчийн хэлбэрээр |
| Зураг 7. | Олон жилийн насжилттай, өндөр дүнтэй авлага |
| Зураг 8. | НДЕГ-т хийсэн сургалт |

## ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

| Хавсралтын дугаар | Хавсралтын нэр |
|---|---|
| Хавсралт 1. | МУ-ын урт хугацааны "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн хэрэгжилт |
| Хавсралт 2. | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт |
| Хавсралт 3. | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт |
| Хавсралт 4. | МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт |
| Хавсралт 5. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт |
| Хавсралт 6. | Шилэн дансны хуулийн хэрэгжилт |
| Хавсралт 7. | Байгууллагын ил тод байдлын үнэлгээний тайлан |
| Хавсралт 8. | Байгууллагын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан |
| Хавсралт 9. | НДБ-ын 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлан |

## ӨМНӨХ ҮГ



НДҮЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байна.

НДҮЗ нь УИХ-аас томилогддог, НД-ын тогтолцооны удирдах дээд байгууллага бөгөөд 2025 онд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, НД-ын хууль тогтоомжуудад заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн НД-ын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд НДҮЗ нь НД-ын талаар төрөөс баримтлах бодлого, НД-ын багц хууль, холбогдох бусад хууль тогтоомж, УИХ, ЗГ-аас баталсан дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд НД-ын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангахтай холбоотой дүрэм, журам, зөвлөмж, аргачлал, батлах, хяналт тавих, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт НД-ын чиглэлээр тусгагдсан зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах, НДС-ийн орлого, зарлага, НДС-ийн болон салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хэлэлцэх, дүгнэлт гаргах, НД-ын хамралтыг нэмэгдүүлэх, сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, иргэн, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн НД-ын талаарх хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

НД-ын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулаад байгаа бөгөөд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг УИХ-д өргөн бариад байна. Энэхүү хуулийн төсөл нь МУ-д тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах юм.

НДС-д 2025 онд 5.2 их наяд төгрөгийн орлого хуримтлуулж, 723.5 мянган хүнд 5.8 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олголоо. Жилийн эцсийн байдлаар НД-ын мэдээллийн санд 63.8 мянган АО, 1.2 сая албан журмаар, 170.0 мянган сайн дураар даатгуулагч бүртгэгдсэн нь НД-ын хамралт өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 6.0 хувиар нэмэгдүүлснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган төгрөг, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 572.0 мянган төгрөг болж, дундаж тэтгэвэр 870.9 мянган төгрөгт хүрч, тэтгэврийн нэмэгдэлд 300.1 тэрбум төгрөг зарцуулсан. Мөн 0-3 насны хүүхдээ асарч байгаа 16.9 мянган эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 3.9 мянган эх /эцэг болон 55.2 мянган малчны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс болон тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж, нийгмийн даатгалд хамруулав. Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа 3.6 мянган хүний тэтгэврийн хэмжээг нас барсан нөхөр /эхнэр/-ийн авч байсан тэтгэврийн 20.0 хувиар нэмэгдүүлэв.

Тайлангийн хугацаанд НДСЧҮ-ээс 700.0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 15.0 хувийн хүүтэй байршуулснаар 70.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгийг арвижуулсан байна. ЗГ-ын үнэт цаасны хүүгийн орлого 27.0 тэрбум төгрөг орж, НДС-г нэмэгдүүллээ.

Нас барсан даатгуулагчийн болон амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг буяны зан үйлийн зардлын өсөлттэй уялдуулж 3.0-4.5 сая төгрөг болгон тус тус 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тэдний гэр бүлд нь тохиолдсон санхүүгийн эрсдэлийг хуваалцах чухал шийдвэр болов.

НДҮЗ нь тайлангийн хугацаанд нийт 6 удаа хуралдаж, 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 25 тогтоол батлан гаргасан бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэх 4 тогтоолыг ЗХХАУНС-д бүртгүүлэв. МХ нийтдээ 7 удаа хуралдаж 13 асуудлыг хэлэлцэж, дүгнэлт зөвлөмж, санал гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн байна. ОНХЗ 5 удаа хуралдаж, 16 дүгнэлт, 22 зөвлөмжийг гаргаж, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаа, НДС-ийн болон НДБ-ын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллалаа.

НД-ын харилцаанд оролцогч, хамтран ажилласан ЗГ, АО, даатгуулагч талуудад талархал дэвшүүлье.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Т.АУБАКИР

## 1.АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ

**АЛСЫН ХАРАА**

Нийгмийн түншлэгч талуудын тэгш оролцоог хангаж, нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, нийгмийн даатгалын тогтолцоонд хувийн хэвшлийн оролцоог дэмжин, нийгмийн даатгалын сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц нийгмийн даатгалын бие даасан тогтолцоог бий болгон хөгжүүлнэ.

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

Нийгмийн даатгалын үйл ажиллагаанд оролцогч талуудын тэгш оролцоотойгоор нийгмийн даатгалын эрх зүйн орчин, тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгож, төрөөс баримталж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хүн амын насжилт, хөдөлмөр эрхлэлт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо, нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлтэй уялдуулан тэтгэврийн даатгалын тогтолцоог шинэчилж, олон давхаргат тогтолцоог бий болгох, хүн амыг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг өсгөн арвижуулах, нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, иргэдийнхээ нийгмийн баталгааг хангана.

**ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ**

Даатгуулагч, ажил олгогч, Засгийн газрын нийгмийн даатгалын үйл ажиллагаанд тэгш оролцох боломж, нөхцөлийг хангаж, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад хяналт тавьж, нийгмийн даатгалын үйлчилгээг чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн даатгалтай холбоотой асуудлыг хамтын удирдлагын хүрээнд олонхын саналаар шийдвэрлэж, гаргасан эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

## 2.НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт "Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ" гэж заасан.

НДҮЗ нь ЗГ, даатгуулагч, АО-ийг төлөөлсөн нийт 9 гишүүнтэй бөгөөд АА нь 9 орон тоотойгоор НДҮЗ-ийн бүрэн эрх, үйл ажиллагааг хэвийн явуулах, НД-ын асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, судалгаа, дүгнэлт гаргуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих чиг үүрэгтэй ажиллаж байна. НД-ын бодлогын хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий нийт 1285 алба хаагч, улсын байцаагчид салбарын хэмжээнд ажиллаж байна.

Мөн НДҮЗ-ийн дэргэд НДБ-ын хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, нийгмийн даатгалын аливаа асуудлаар шийдвэр гаргахад мэргэжлийн зөвлөгөө, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй орон тооны бус 9 гишүүнтэй МХ, НДС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус 7 гишүүнтэй ОНХЗ тус тус ажиллаж байна.

*График 1. НДБ-ын тогтолцоо*



## 3.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 3.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэн эрх

НД-ын хууль тогтоомжийн дагуу ЗГ, АО, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалсан тэгш оролцоотой, бие даасан, орлогоороо зарлагаа нөхөж ажиллах даатгалын санг бүрдүүлэн, НДС-ийн тогтвортой үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг хянаж, нэгдсэн удирдлагаар хангах зорилго бүхий НДҮЗ-тэй байхаар хуульчилсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9 дэх хэсэг, УИХ-ын НББХ-ны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан НДҮЗ-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу НДҮЗ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- НД-ын хууль тогтоомжийн хэрэгжилт, НД-ын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр шийдвэр гаргах, санал, дүгнэлт өгөх;
- НД-ын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;
- Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой болон НД-ын хууль тогтоомжид заасны дагуу тогтоол, дүрэм, журам, аргачлал батлах, зөвлөмж гаргах;
- НД-ын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх;
- НДС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг хэлэлцэн, дүгнэлт, шийдвэр гаргах;
- НДС-ийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд санал өгөх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих;
- НДС-аас олгох тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын төлбөрийн хэмжээг өөрчлөх, сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах талаар НД-ын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас боловсруулсан тооцоо судалгаа, саналыг хянаж, санал, дүгнэлт гаргах;
- НД-ын хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах, НД-ын талаарх олон нийтийн итгэл, үнэмшлийг дээшлүүлэх, НДБ-ын үйл ажиллагаа, мэдээллийн технологи, програм хангамж, НД-ын үйлчилгээг сайжруулахад санал, дүгнэлт өгөх;
- Эрүүл мэндийн магадлалын зөвлөл болон Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих, боловсронгуй болгох талаар санал боловсруулах;
- АО, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, НДБ-д зөвлөмж, чиглэл өгөх;
- АА, МХ, ОНХЗ-ийг удирдлага, чиг үүргээр хангаж ажиллах;
- НДС-ийн төсвийн орлого, зарлагад хийх хяналт шалгалтад МХ, ОНХЗ-ийг оролцуулах;
- НД-ын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас Үндэсний зөвлөлийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай дэмжлэг, мэдээлэл, судалгаа авах зэрэг болно.

### 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.2 дахь хэсэгт НДҮЗ-ийн дарга, гишүүдийг талуудын санал болгосноор УИХ нэр дэвшигчийн сонсгол хийж, 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд дараах бүрэлдэхүүнтэй байна:

1. ЗГ-ыг төлөөлж хөдөлмөр, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг хүн;
2. Даатгуулагчийг төлөөлж даатгуулагчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан үйлдвэрчний эвлэлээс гурван хүн;
3. АО-ийг төлөөлж ажил олгогчийн олонхын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагаас гурван хүн;

*Зураг 1. НДҮЗ-ийн бүрэлдэхүүн*




### 3.3 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаан, шийдвэр

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэг, УИХ-ын НББХ-ны 2024 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан НДҮЗ-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна" гэж, мөн хуулийн 35.11 дэх хэсэгт "Үндэсний зөвлөл гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэйгээр улирал бүр хуралдана" гэж тус тус заасны дагуу НДҮЗ нь тайлангийн хугацаанд нийт 6 удаа хуралдав.

*Хүснэгт 1. НДҮЗ-ийн хуралдааны мэдээлэл*

| № | Огноо | Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд | Ирц |
|---|---|---|---|
| 1. | 2025.01.27 | 1.КБЭХА болон Чингис хаан банкнаас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах талаар хийж байгаа ажилтай танилцаж, эрчимжүүлэх үүрэг даалгавар өглөө.<br>2.“Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ын шинэчилсэн төслийг хэлэлцэж, баталлаа.<br>3.Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл “К”-ийг 2025 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар тогтоов.<br>4.“Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” НДҮЗ-ийн тогтоолын төслийг хэлэлцээд, хойшлуулахаар шийдвэрлэв.<br>5.“Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай” НДҮЗ-ийн тогтоолын төслийг хэлэлцээд МХ-ны дүгнэлт гарсны дараа дахин хэлэлцэхээр хойшлуулав.<br>6.НДҮЗ-ийн дэргэдэх орон тооны бус МХ-ны 2025 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэж батлав.<br>7.Орон тооны бус ОНХЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, батлав. | 88.8% |
| 2. | 2025.02.07 | 1.КБЭХА болон Чингис хаан банкнаас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах талаар хийж байгаа ажилтай танилцаж, эрчимжүүлэх үүрэг даалгавар өглөө.<br>2. 2025 онд НДСЧҮ-ээс арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг 11.4 хувиар тогтоов.<br>3.“Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” НДҮЗ-ийн тогтоолын төслийг дараагийн хуралдаанаар хэлэлцэхээр дахин хойшлуулав.<br>4.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг хэлэлцэж, батлав. | 100.0% |
| 3. | 2025.02.24 | 1.МХ, ОНХЗ-ийн гишүүдийн МБ, СЗХ-нд хийсэн уулзалтын дүнг сонсов.<br>2.НДСЧҮ-ээс ЗГ-ын үнэт цаасанд байршуулах хөрөнгийн талаар ГБХНХЯ-аас ирүүлсэн санал МХ-оос өгсөн дүгнэлттэй танилцав.<br>3.“Засгийн газрын үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай” ЗГ-ын тогтоолын төсөлтэй танилцаж, 300.0 хүртэлх тэрбум төгрөгөөр ЗГ-ын үнэт цаас худалдан авахыг дэмжив.<br>4.НДСЧҮ-ээс 2025 онд арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр батлав. | 88.8% |
| 4. | 2025.03.24 /НДҮЗ-ийн хуралдааны журмын | 1.НДСЧҮ-ийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээ тогтоох тухай МХ-ны дүгнэлт, зөвлөмжтэй танилцав. | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | 8.1.4 дэх заалт/ | 2.МБ-ны бодлогын хүү өөрчлөгдсөнтэй холбоотойгоор НДСЧҮ-ийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар шинэчлэн батлав. | |
| 5. | 2025.07.23 | 1.ТДНД-ны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоов.<br>2.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 3.0, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг 4.5 сая төгрөг болгон шинэчлэн тогтоож, тус тус 1.0 сая төгрөгөөр нэмэх шийдвэр гаргалаа.<br>3.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хэмжээг нэг ор хоногт 110.0 мянган төгрөгөөр тогтоов.<br>4.НДБ-ын үйл ажиллагаанд хэрэглэх тооны тайлан, мэдээлэл судалгааны баримт бичгийн 14, НДШ төлөлт, тэтгэвэр тогтоолт, олголттой холбоотой мэдээлэл лавлагааны баримт бичгийн 10, нийт 24 төрлийн маягтын загвартай танилцаад баталж, хэрэглэхийг НДЕГ-т зөвшөөрлөө.<br>5.НДЕГ-аас оруулсан НДС-ийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсөөллийн жилд НД-ын 4 санд 6.0-6.7 их наяд төгрөгийн орлого бүрдэхээр, үүнээс улсын төсвөөс 3.0-3.2 их наяд төгрөг авахаар, сангийн зарлагыг 7.2-8.8 их наяд төгрөгөөр тус тус тооцсон тооцооллуудтай танилцав.<br>6.Чингис хаан банкнаас 2.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 8, Капитал банкнаас 1.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 9 ширхэг үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авахыг НДЕГ-т зөвшөөрөв. | 77.7% |
| 6. | 2025.12.22 | 1.НДС-ийн 2025 оны хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланг сонсож, 33 НДБ-ыг хамруулсан нэгдсэн гүйцэтгэлээр НДС орлого 3.3, зарлага 2.9 их наяд төгрөгт хүрсэн тухай тайлантай танилцлаа.<br>2."Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам"-ыг баталсан НДҮЗ-ийн тогтоолыг НД-ын багц хуульд нийцүүлэн хүчингүй болгов.<br>3."Нийгмийн даатгалын төлөөлөгч ажиллуулах тухай журам"-ыг баталсан НДҮЗ-ийн тогтоолыг НД-ын багц хуульд нийцүүлэн хүчингүй болгов.<br>4."Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ыг шинэчлэн батлав.<br>5.Капитал банкнаас 5.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 2 ширхэг үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авахыг НДЕГ-т зөвшөөрөв.<br>6.НДСЧҮ-ээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахад хэрэглэх "Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар"-ыг шинэчлэн батлав.<br>7.ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахад хэрэглэх "Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар"-ыг батлав.<br>8.НДҮЗ-ийн дэд даргаар АО-ийг төлөөлсөн гишүүн Э.Энхжаргалыг томилов. | 100.0% |

НДҮЗ-ийн 2023 оны 17 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдааны журам"-ын дагуу хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын танилцуулга, тогтоолын төслийг ГБХНХЯ-ны холбогдох газар, хэлтэс, НДЕГ-аас хүлээн авч, хянаж НДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг АА зохион байгуулан ажиллалаа.

Тайлангийн хугацаанд НДҮЗ нь нийтдээ 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 25 тогтоол батлан гаргасан.

*Хүснэгт 2. НДҮЗ-ийн баталсан тогтоол**

| Тогтоолын дугаар | Тогтоолын нэр |
|---|---|
| 01 | Журам батлах тухай. (Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам) |
| 02 | Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тогтоох тухай. |
| 03 | Төлөвлөгөө батлах тухай. (Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны 2025 оны ажлын төлөвлөгөө) |
| 04 | Төлөвлөгөө батлах тухай. (Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө) |
| 05 | Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай. |
| 06 | Төлөвлөгөө батлах тухай. (Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө) |
| 07 | Хөрөнгийн хэмжээг тогтоох тухай. (НДСЧҮ-ээс арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгө) |
| 08 | Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг шинэчлэн батлах тухай. |
| 10 | Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай. |
| 11 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай. |
| 12 | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай. |
| 13 | Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай. |
| 15 | Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. (Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө) |
| 19 | Журам шинэчлэн батлах тухай. (Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам) |
| 20 | Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай. |
| 21 | Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар шинэчлэн батлах тухай. (Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загвар) |
| 22 | Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар батлах тухай. (Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загвар) |
| 24 | Үндэсний зөвлөлийн дэд даргыг томилох тухай. |

*Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан НДҮЗ-ийн дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжийг агуулсан тогтоолыг оруулаагүй болно.

НДҮЗ-өөс батлан гаргасан тогтоолуудаас нийтээр заавал дагаж мөрдүүлэх 4 тогтоолыг ЗХХАУНС-д бүртгүүлэв.

*Хүснэгт 3. ЗХХАУНС-д бүртгүүлсэн тогтоол*

| № | Батлагдсан огноо | Тогтоолын дугаар | Тогтоолын нэр | Бүртгэлийн огноо, дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | 2025.01.27 | 01 | Журам батлах тухай. (Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам) | 2025.02.24 №7144 |
| 2 | 2025.07.23 | 10 | Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай | 2025.08.07 №7335 |
| 3 | 2025.07.23 | 11 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | 2025.08.07 №7336 |
| 4 | 2025.07.23 | 12 | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай | 2025.08.07 №7337 |

*<u>НДС-ийн хөрөнгийг арвижуулав</u>*

НДҮЗ-ийн 05, 07, 08 дугаар тогтоолуудаар МХ-ны эрсдэлийг тооцсон мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн 2025 онд НДСЧҮ-ээс мөнгөн хадгаламж хэлбэрээр арилжааны банканд байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар тус тус баталсан ба арилжааны банкуудтай хэлэлцээр хийж 15 хувийн хүүтэйгээр байршуулсан. Ингэснээр НДС-ийн хөрөнгийг 105.0 тэрбум төгрөгөөр арвижуулах боломж бүрдсэн бөгөөд тайлант оны 5-12 дугаар сарын хүү болох 70.2 тэрбум төгрөгөөр сангийн хөрөнгө нэмэгдлээ. ЗГ-ын үнэт цаасны хүү болох 27.0 тэрбум төгрөгийн өгөөжийг НДС-д оруулаад байна. Мөн НДҮЗ-ийн 22 дугаар тогтоолоор ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загварыг баталснаар ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж, тус хөрөнгийг арвижуулан өсгөх боломжийг хангаж өглөө.

НДҮЗ-ийн 2025 оны 13, 20 дугаар тогтоолуудаар НДҮЗ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу КБЭХА-аас 6.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 11, Чингис хаан банкнаас 2.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 8 ширхэг үл хөдлөх хөрөнгийг тус тус НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авснаар Капитал, Чингис хаан банкнаас авах НДС-ийн авлага багасаж, орлого нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

*<u>НД-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалсан чухал шийдвэрүүдийг гаргав.</u>*

Монголын "Буяны зан үйлийн холбоо" ТББ-ын гаргасан буяны үйл ажиллагаа эрхэлдэг 14 ААНБ-ын үнэ тарифын судалгаанаас үзэхэд үйлчилгээний дундаж үнэ 2.9-10.9 сая төгрөг байгаа нь нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгодог тэтгэмжээс 0.9-8.9 сая төгрөгөөр их байгаа юм. Иймд НДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолоор тэтгэмжийн хэмжээг буяны зан үйлийн зардлын өсөлттэй уялдуулж, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 3.0, амьгүй донор болж

эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг 4.5 сая төгрөг болгон тус тус 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинэчлэн тогтоов. Ингэснээр нас барсан даатгуулагчийг оршоох, чандарлах дундаж зардлыг бүрэн, харьцангуй өндөр зардлын 30 орчим хувийг НДС-аас бүрдүүлж, гэр бүлд нь тохиолдсон санхүүгийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой шийдвэр болов.

НДС-аас даатгуулагчдад үзүүлдэг үйлчилгээний нэг нь ҮОМШӨ-ний даатгалын сангаас сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээний ор хоногийн төлбөрийг олгодог. Бараа бүтээгдэхүүний үнэ, ашиглалтын болон хэрэглээний зардлууд тогтмол өсч байгаатай холбоотойгоор одоо мөрдөгдөж байгаа ор хоногийн төлбөр нь нэг даатгуулагчийн сувилалд хэвтэн эмчлүүлэхэд гардаг бодит зардалд хүрэхгүй байна. Мөн ердийн рашаан, сувиллын үнэд судалгаа хийхэд нэг ор хоногийн дундаж үнэ нь 107.1-128.6 мянган төгрөг байна. Иймд ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжих сувилалд олгох нэг ор хоногийн зардлын хэмжээг 110.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг авлаа.

ГБХНХЯ, ҮСХ-ны санал болон МХ-ны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн ТДНД-ны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувь, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл "К" коэффициентийг 2025 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар тогтоов. Өндөр насны тэтгэврийг ТДНД-ны аргаар бодох 2 гол үзүүлэлтийг ийнхүү шинэчлэн тогтоосноор тухайн жилд өндөр насны тэтгэврээ энэ аргаар тогтоолгох иргэний тэтгэврийн хэмжээг бодитой тогтоох шийдвэр болж байна.

НДҮЗ-ийн 2025 оны 06 дугаар тогтоолоор ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг баталж, уг арга хэмжээний зардалд 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.

### 3.4 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн хорооны үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.17 дахь хэсэгт "Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлага, актуар тооцоолол хийх, хөрөнгө оруулалт, аудитийн орон тооны бус мэргэжлийн хороог Үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна." гэж заасан.

МХ нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЗГ-ын 2024 оны 254, 256 дугаар тогтоол, "Мэргэжлийн хорооны ажиллах журам"-ын хүрээнд НД-ын тогтолцоо, хууль тогтоомж, НДБ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад НДҮЗ-д мэргэжлийн зөвлөгөө, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй бөгөөд судалгаа, эрсдэлийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж, санал гаргана.

*График 2. МХ-ны бүтэц, бүрэлдэхүүн*




МХ-ны гишүүдийн үйл ажиллагааны чиглэл:

1.Эрсдэлийн удирдлагын асуудал хариуцсан гишүүн;

1.1.НДС-ийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтад хяналт тавих, НДСЧҮ болон эрсдэлийн сангийн хөрөнгийг банканд байршуулах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахад судалгаа тооцоолол хийх, эрсдэлийг үнэлэх, дүгнэлт, санал боловсруулах.

2.Актуар тооцоолол хариуцсан гишүүн;

2.1.Хүн амын насны бүтэц, интервалаар тооцсон тооцоолол, төрөлтийн хувь хэмжээний өөрчлөлт, үнийн өсөлт зэрэг нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийн хүчин зүйлүүдийн нөлөөллийг харгалзан НДС-ын орлого зарлага, АО, даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувь хэмжээ, тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ зэрэг НД-ын тогтолцоонд зайлшгүй шаардлагатай хэтийн тооцоолол хийх, санал боловсруулах.

2.2.НДС-ын орлого, зарлагын хэтийн төлөв байдал, даатгуулагч, тэтгэвэр авагчдын тоо хэмжээ ирээдүйд хэрхэн өөрчлөгдөхийг тооцож, нийгэм, эдийн засаг, холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, өөрчлөлтийн нөлөөллийг харгалзан сангийн хэтийн төлөвийг тооцож, НД-ын шийдвэрт тусгуулах, санал боловсруулах.

3.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан гишүүн;

3.1.НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахтай холбоотой судалгаа тооцоолол хийж, дүгнэлт, санал боловсруулах.

3.2.Тухайлсан хуулиар зохицуулсан эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд хөрөнгө оруулахтай холбоотой судалгаа, тооцоолол хийх, санал дүгнэлт боловсруулах.

4.Аудитын асуудал хариуцсан гишүүн;

4.1.НД-ын хууль тогтоомж, НДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд болон хууль тогтоомжуудын нийцэлд аудит хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах.

МХ нь аливаа асуудалд дүгнэлт хийхдээ бодит мэдээлэл, тоо баримтад тулгуурлан, эрх зүйн орчны зохицуулалтын эерэг болон сөрөг тал, сангийн үйл ажиллагаанд тулгарч байгаа саад бэрхшээлүүдийг олон талаас нь харж, үнэлж дүгнэн, хараат бусаар хэлэлцэж, шийдвэр гаргах зарчмыг баримтлан ажиллав.

*Зураг 2.МХ-ны хуралдаан*



Тайлангийн жилд МХ нийтдээ 7 удаа хуралдаж 13 асуудлыг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж, санал гарган ГБХНХЯ, НДҮЗ, НДЕГ-т тус тус хүргүүлсэн байна.

*Хүснэгт 4. МХ-ны хуралдааны мэдээлэл*

| № | Хуралдсан огноо | Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд | Ирц |
|---|---|---|---|
| 1. | 2025.01.06 | 1.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, НДҮЗ-ийн АА, МХ, ОНХЗ-тэй хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслүүдийг тус тус хэлэлцэж, гишүүдээс гаргасан саналуудыг тусгаж, батлуулахаар НДҮЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв. | 100% |
| 2. | 2025.01.27 | 1.ТДНД-ны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг жилийн 12.2 хувиар тогтоох дүгнэлт гаргав. | 100% |
| | | 2.НДСЧҮ-ийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг 11.4 хувиар тогтоохыг дэмжиж, дүгнэлт зөвлөмж гаргав. | |

| | | | |
|---|---|---|---|
| 3. | 2025.02.19 | 1."ЗГ-ын үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээ батлах тухай" ЗГ-ын тогтоолын төслийг хэлэлцэж, НДСЧҮ-ээс 300.0 тэрбум төгрөгөөр ЗГ-ын үнэт цаас авахыг дэмжиж, дүгнэлт гаргав.<br>2.НДСЧҮ-ээс Төрийн сангийн нэгдсэн данс болон системийн нөлөө бүхий арилжааны банкнуудад мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр тогтоох саналыг дэмжиж, дүгнэлт, зөвлөмж гаргав.<br>3.ГБХНХЯ-наас ирүүлсэн "Оюутан, залуучууд, ахмад насны нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх бодлогын зураглал"-д дүгнэлт гаргуулах тухай албан бичигтэй танилцаж, 5 чиглэлээр дүгнэлт гаргаж, хүргүүлэв.<br>4.МБ, СЗХ-нд хийсэн уулзалтын тайланг сонсоод НДҮЗ-ийн хуралдаанд танилцуулахаар болов. | 100% |
| 4. | 2025.04.04 | 1.2025 онд НДСЧҮ-ээс банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн хэмжээг НДЕГ-аас ирүүлсэн 2 дахь хувилбар буюу 4 банканд ижил хувиар байршуулахыг дэмжсэн дүгнэлт, зөвлөмж гаргав. | 100% |
| 5. | 2025.06.18 | 1.ГБХНХЯ-аас боловсруулсан НД-ын багц хуулиуд, холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцээд 12 санал гаргаж, тайлбар, үндэслэлийн хамт хүргүүлэв. | 88.9% |
| 6. | 2025.10.15 | 1.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд, цаашид улам эрчимжүүлж ажиллахыг гишүүдэд үүрэг болгов. | 88.9% |
| 7. | 2025.12.04 | 1."Банкнуудын үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал"-ын төслийг хэлэлцээд "Арилжааны банканд мөнгөн хадгаламж байршуулахад баримтлах журам" гэж өөрчлөх зөвлөмж өгөв.<br>2.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд, цаашид улам эрчимжүүлж ажиллахыг гишүүдэд үүрэг болгов.<br>3.Хорооны 2025 оны жилийн эцсийн ажлын тайланг сонсож, НДҮЗ-д танилцуулахыг МХ-ны даргад даалгалаа. | 77.8% |

МХ тайлант оны эхэнд НДЕГ-ын удирдлагуудтай НД-ын хууль эрх зүйн орчин, байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэлүүд, байгууллагын эрх үүрэг, сангийн орлого, зарлага, харилцах дансны чөлөөт үлдэгдэл, хадгаламж, хуримтлал, төлбөрийн чадвар, өр авлага, даатгуулагч, АО-дын тоо гэх мэт үндсэн параметр үзүүлэлтүүдтэй танилцаж, тулгамдаж байгаа зарим асуудлуудыг хэрхэн оновчтой шийдвэрлэх талаар санал солилцлоо. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтын дагуу МБ-аас гаргах үнэт цаасны арилжаанд НДС оролцох боломж, хувийн хэвшлийн байгууллагууд тэтгэврийн даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн тохиолдолд СЗХ хяналт тавих боломж байгаа эсэх зэрэг асуудлуудын талаар МБ, СЗХ-ны төлөөлөлтэй уулзав.

НДЕГ-аас НДСЧҮ-ийг банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудад байршуулахаар ирүүлсэн тооцоо судалгаа, ТДНД-ны орлогод тооцох хүүгийн хэмжээ, мөнгөн хадгаламжийн хүүгийн доод хэмжээг тогтоох аргачлал зэрэг баримт бичгүүдтэй танилцаж, санал дүгнэлтээ тухай бүр гаргаж, НДҮЗ-ийн АА-аар дамжуулан хүргүүлж байсан болно.

НДС-ийн 2013-2023 оны чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулснаас орсон хүүгийн орлого, мөн үүссэн эрсдэлийг судлах удирдамжийг баталж, ажлын хэсэг томилон ажиллуулав. НДЕГ-аас ирүүлсэн ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд байршуулахаар ирүүлсэн саналтай танилцаж, зөвлөмж боловсруулж хүргүүллээ. Мөн Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй тогтмол ашигтай ажиллаж байгаа зарим компаниудын хувьцааны өгөөжийн талаарх судалгааг хийж цаашдын чиг хандлагын талаар санал боловсруулж, НДҮЗ-д танилцуулав.

НДЕГ-аас 2025 оны эхэнд сангуудын чөлөөт үлдэгдлийн талаар ирүүлсэн тоо мэдээлэл, тооцоо судалгаа, танилцуулгатай танилцаж, тэтгэмжийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөрөнгө оруулалтад байршуулж болох хөрөнгийн хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийж дүгнэлт, зөвлөмж боловсруулан хүргүүлсэн.

НДС-ийн 2013-2023 оны чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулснаас олсон орлого, үүссэн эрсдэлд судалгаа хийж, НДҮЗ-д танилцуулсан.

ГБХНХЯ-аас боловсруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын гишүүн Б.Түвшин нарын гишүүдийн санаачлан өргөн барьсан хуулийн төсөлтэй танилцаж, Малчны тухай хуульд заасан "өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх;" гэсэн заалтыг хүчингүй болгох тухай хуулийн төсөл боловсруулан, НД-ын багц хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төсөлтэй хамт хүргүүлэх, үүнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан "24.1.6.Малчны тухай хуульд заасан бол." гэснийг хасах санал гаргасан.

Аудитын асуудал хариуцсан гишүүд НД-ын хууль эрх зүйн зохицуулалт, сангийн төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлөл үзүүлж байгаад үнэлэлт, дүгнэлт хийх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн заалт нэг бүрийг нарийвчлан судалж, нөлөөлөл үзүүлж болох эерэг болон сөрөг талуудыг гаргаж, танилцуулга бэлтгэлээ. Мөн НД-ын багц хуулиудын зарим зохицуулалт даатгуулагч болон АО-дын эрх ашгийг хэрхэн хөндөж байгааг судалж, судалгааны ажлын дүгнэлт бэлтгэсэн.

*Хүснэгт 5. МХ-ны гишүүдийн НД-ын чиглэлээр хийсэн бүтээлүүд*

| № | Гишүүний нэр | Судалгаа, шинжилгээний бүтээлийн нэр | Судалгаа, шинжилгээний бүтээлд дэвшүүлсэн зорилтууд, шийдвэрлэх арга зам |
|---|---|---|---|
| 1. | Г.Бурмаа, МУИС-ийн Бизнесийн сургуулийн зөвлөх профессор, Д.Далхжав, ХААИС-ийн Эдийн засаг, | НД-ын багц хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, даатгуулагчийн эрх ашгийг хөндөж буй | Уг судалгаанд 2024 оноос хэрэгжиж эхэлсэн НД-ын багц хуулийн зарим заалтууд даатгуулагч болон АО-ийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа асуудлыг гаргаж тавихыг зорьсон ба цаашид энэхүү хуульд дараах нэмэлт өөрчлөлтийг хийх шаардлагатай гэж үзжээ. Үүнд: |

| | | | |
|---|---|---|---|
| | бизнесийн сургуулийн зөвлөх профессор | зарим заалтууд, өөрчлөх шаардлага | -НД-ын харилцаанд даатгалын зарчмыг хатуу баримтлах<br>-Улс төрийн нөлөөлөл, улс төрчдийн амлалтаас ангид байлгах<br>-Нийгмийн халамжийн шинж чанартай тэтгэвэр, тэтгэмжийг НДС-аас тусгаарлах<br>-Хуульд заасан хугацаанд итгэлцүүрийг шинэчилж, тэтгэврийг индексжүүлж байх. |
| 2. | НДҮЗ-ийн дэргэдэх МХ-ны гишүүн<br>З.Ядмаа (ХААИС-ийн багш, Доктор)<br>Ч.Өнөржаргал (СЭЗИС-ийн багш, магистр)<br>НДҮЗ-ийн дэргэдэх ОНХЗ-ийн гишүүн<br>С.Ариунаа (МУИС-ийн багш, Доктор)<br>П.Баянсан (МУИС-ийн багш, Доктор) | НДБ-ын авлагын менежмент, түүнийг сайжруулах арга замууд *(онол, практикийн санал, зөвлөмж)* | 1.НДЕГ-ын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 15 санал:<br>-Хууль эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох чиглэлээр-4,<br>-Техник технологи, системийн шинэчлэл, мэдээллийн сангийн чиглэлээр-5,<br>-НД-ын байцаагчдыг чадавхжуулах, урамшуулах чиглэлээр-1<br>-АО-той харилцах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр-5<br>2.Аймаг, дүүргийн НДГ-ын удирдлагын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 12 санал:<br>-Зохион байгуулалтын шинжтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх чиглэлээр-4,<br>-АО-той харилцах стратеги боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр-3,<br>-НД-ын байцаагчдыг чадавхжуулах, урамшуулах чиглэлээр-5,<br>3.НД-ын байцаагч, ажилтнуудын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 6 санал:<br>-Техник технологи, системийн шинэчлэл хийх чиглэлээр-3,<br>-АО-той харилцах стратеги боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр-3,<br>Бүгд 3 түвшинд нийт 33 арга хэмжээг авч ажиллах санал зөвлөмж өгсөн. |
| 3. | Д.Далхжав (Доктор, зөвлөх профессор)<br>З.Ядмаа (Доктор, дэд профессор)<br>Ц.Дашдондог (Доктор, дэд профессор) | Санхүүгийн зах зээл дээр сүүлийн 3 жилд тогтвортой өндөр өгөөж өгч байгаа үнэт цааснуудын талаар судалгаа. *(ЗГ-ын 2024 оны 254 дугаар тогтоолоор батлсан журмын 2.1-д заасныг бусад)* | НДСЧҮ-ийг хөрөнгө оруулалтын бусад хэрэгсэл болох хувьцаа, ЗГ-ын дотоод үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хөрөнгө оруулалтын сан зэрэгт оруулах боломж, өгөөж, эрсдэлийн талаар судалсан. Хөрөнгө оруулах санхүүгийн хэрэгслийн харьцуулсан өгөөжөөс харахад НДСЧҮ-ийг байршуулах боломжтой хэрэгсэл нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас байна. Гэхдээ хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны багтаамж нь одоогийн байдлаар 134.0 тэрбум төгрөг байна. Хувьцаа болон хөрөнгө оруулалтын сангийн өгөөж нь харьцангуй тогтворгүй, доогуур хувьтай байгаа учраас хөрөнгө оруулахад эрсдэлтэй байна. Компаний бондын хувьд хэдийгээр хүлээгдэж байгаа өгөөж өндөр ч гэсэн бондын зориулалт, компаний эрсдэл даах чадвар зэргээс хамаарч хөрөнгө оруулахад эрсдэлтэй байх магадлалтай. |

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Г.Отгонсүрэн (Доктор, дэд профессор) | НДС-ийн орлого, зарлагад нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ. | НДС-ийн зарлага нь эдийн засгийн өсөлт, орлогын түвшин, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал болон хүн амын бүтэц зэрэг олон хүчин зүйлийн харилцан үйлчлэлээр тодорхойлогддог байна. Иймээс НДС-ийн бодлогыг дангаар нь авч үзэх бус макро эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, орлогын бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх нь сангийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах үндсэн нөхцөл гэж дүгнэсэн байна. Цаашид эдийн засгийн өсөлт болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг НДС-ийн тогтвортой байдалтай уялдуулах нь зүйтэй. Судалгааны үр дүнгээс үзэхэд бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, дундаж цалин, өрхийн орлого нь НДС-ийн зарлагад зэрэг статистикийн ач холбогдолтой нөлөө үзүүлж байгааг харгалзан үзвэл албан ёсны ажлын байрыг нэмэгдүүлэх, шимтгэл төлөгчдийн суурийг тэлэх бодлого нь сангийн санхүүгийн чадавхыг бэхжүүлэх ач холбогдолтой. Инфляцын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор тэтгэвэр, тэтгэмжийн бодит худалдан авах чадварыг хамгаалах шаардлагатай. Инфляци нь НДС-ийн зарлагад сөрөг нөлөө үзүүлж байгаа тул инфляцтай уялдсан индексжүүлэлтийн механизмыг хэрэгжүүлэх нь сангийн бодит үнэ цэнийг хадгалахад чухал ач холбогдолтой. Ажилгүйдлийг бууруулах, хөдөлмөрийн зах зээлийн идэвхийг нэмэгдүүлэх бодлогыг эрчимжүүлэх нь зүйтэй. Ажилгүйдлийн түвшин өсөх нь НДС-ийн зарлагад сөрөг нөлөө үзүүлж байгааг судалгааны үр дүн харуулсан тул хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого нь шимтгэл төлөгчдийн тоог нэмэгдүүлж, сангийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй. Тэтгэвэр авагчдын тоо нэмэгдэх хандлагыг харгалзан тэтгэврийн тогтолцооны урт хугацааны шинэчлэлийг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай. Судалгааны үр дүнд тэтгэвэр авагчдын тоо нь НДС-ийн зарлагад зэрэг ач холбогдолтой нөлөө үзүүлж байгаа тул хүн амын насжилттай уялдсан бодлогын шийдвэр гаргах нь зүйтэй гэж дүгнэсэн байна. |
| 5. | Д.Далхжав (Доктор, зөвлөх профессор) Г.Бурмаа (Доктор, профессор) | Төрийн аудитын байгууллагаас НДС-ийн 2023-2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, түүний хэрэгжилтэд МХ-оос хийсэн | 1.НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн дагуу НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн програмд өөрчлөлт, шинэчлэлтийг бүрэн хийж чадаагүй.<br>2.НДС-ийн санхүүгийн тайланд аудит хийх явцад өндөр дүн бүхий залруулга хийсэн тохиолдлууд түгээмэл гарч байгаа нь НД-ын салбарт ажиллаж байгаа ерөнхий болон ахлах нягтлан бодогчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар сул байгаатай холбоотой байна. |

| | | |
|---|---|---|
| | дүгнэлт, танилцуулга. | 3.ҮАГ-аас өмнөх аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага бүрэн биелэгдэхгүй байна.<br>4.НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн SICOS програмыг НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй уялдуулах.<br>5.Аудитын залруулгын талаар НД-ын болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НДС-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын олон улсын стандарт зэрэг хууль эрх зүйн баримт бичгүүдийн хоорондын нийцэлд судалгаа хийж, дүгнэлт тайлбар гаргах.<br>6.Эзэн холбогдогч тодорхой бус, нэхэмжлэх эзэнгүй олон он дамжсан авлага, өглөгийг барагдуулах талаар жил бүрийн аудитын дүгнэлтэд орж биелэгдэх боломжгүй явж ирснийг анхаарч тусгайлсан судалгаа гаргаж, хэрхэн шийдвэрлэх талаар асуудал боловсруулж, эрх бүхий байгууллагуудад уламжилж шийдвэрлүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт, зөвлөмж гаргасан. |

НДЕГ, аймаг, дүүргийн НДГ-ын бүтэц, орон тоо, ажлын байрны тодорхойлолт, чиг үүрэгтэй танилцаж, ЗГ-аас дэвшүүлсэн төсвийн хэмнэлтийн бодлоготой хэрхэн нийцүүлэн ажиллаж байгаад судалгаа хийж, үнэлэлт дүгнэлт танилцуулга, зөвлөмж гаргасан.

НД-ын багц хуулиудын зарим заалтууд даатгуулагч болон АО-дын эрх ашгийг хэрхэн хөндөж байгаад онол, арга зүйн талаас судалгаа, шинжилгээ хийж, нийгмийн тодорхой хэсэг бүлэгт давуу эрх олгож, зарим даатгуулагчийн эрх ашгийг сөргөөр хөндөж байгаад харьцуулалт хийж засч залруулах санал оруулав. Мөн АО-оос төлөх шимтгэлд илүү ачаалал үзүүлж байгаа зарим заалтуудыг залруулах саналыг гаргасан.

МХ 2026 онд 5 зорилтын хүрээнд 13 арга хэмжээг авч ажиллахаар төлөвлөөд байна.

## 4.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ

### 4.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар НДС-ийн орлогыг 5,455.6 тэрбум төгрөг, зарлагыг 5,869.5 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 5,231.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, орлогын гүйцэтгэл 95.9 хувь, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 5,848.5 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 99.6 хувьтай байна. 2024 оноос хэрэгжиж эхэлсэн НД-ын багц хуульд заасны дагуу даатгуулагчийн төлөх зарим шимтгэлийг улсын төсвөөс хариуцах болсонтой холбогдуулан улсын төсвөөс олгох дэмжлэг өнгөрсөн оноос 23.6 хувиар нэмэгдэж, 1,452.5 тэрбум төгрөг болсон.

*График 3 . НДС-ийн төсөв /тэрбум.төг/*




## 4.2 Нийгмийн даатгалын сангийн орлого

Тайлангийн хугацаанд НДС-д 5,455.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 5,231.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлсэн. /Энэ дунд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,452.5 тэрбум төгрөг ороогүй./

*График 4. НДС-ийн орлогын бүтэц, эзлэх хувь*




Нийт шимтгэлийн орлогын 52.9 хувь буюу 2,765.9 тэрбум төгрөгийг АО-ийн төлсөн шимтгэл, 40.9 хувь буюу 2,138.1 тэрбум төгрөгийг албан журмаар даатгуулагчийн төлсөн шимтгэл, 3.8 хувь буюу 201.4 тэрбум төгрөгийг сайн дураар даатгуулагч /гадаадад ажиллаж буй иргэд, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн шимтгэлийн орлого/, 2.4 хувь буюу 126.5 тэрбум төгрөгийг бусад орлого эзэлж байна.

*Хүснэгт 6. НДС-ийн орлогын биелэлт, төрлөөр /тэрбум.төг, хувиар/*

| № | Орлогын төрөл | 2024 | 2025 | Өмнөх онтой харьцуулсан /хувь/ |
|---|---|---|---|---|
| 1 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 1,175.0 | 1,452.5 | 23.6 |
| 2 | АО-ийн төлсөн шимтгэлийн орлого | 2,457.5 | 2,765.9 | 12.5 |
| 3 | Албан журмаар даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 1,758.0 | 2,138.1 | 21.6 |
| 4 | Сайн дураар даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 184.5 | 198.7 | 7.6 |
| 5 | Гадаадад ажиллаж буй иргэдийн төлсөн шимтгэлийн орлого | 1.5 | 1.1 | -26.6 |
| 6 | ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 1.8 | 1.6 | -11.1 |
| 7 | Бусад орлого | 31.4 | 126.5 | 302.8 |
| | **Нийт** | **5,609.7** | **6,684.4** | **19.2** |

*Хүснэгт 7. НДС-ийн орлогын гүйцэтгэл, сангаар /тэрбум.төг, хувиар/*

| № | Орлого | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт орлогод эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 4,239.8 | 81.0 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 479.5 | 9.2 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 353.3 | 6.8 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 159.3 | 3.0 |
| | **Нийт** | **5,231.9** | **100.0** |

### 4.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

НДС-ийн зардлын төсөв 5,869.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 5,848.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт зарцуулсан.

*Хүснэгт 8. НДС-ийн зарлагын гүйцэтгэл, сангаар /тэрбум.төг, хувиар/*

| № | Зардал | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 5,341.2 | 91.3 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 291.5 | 5.0 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 52.1 | 0.9 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 163.7 | 2.8 |
| | **Нийт** | **5,848.5** | **100.0** |

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 741.3 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өссөн.

*Хүснэгт 9. НДС-аар үйлчлүүлсэн хүний тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Нийгмийн даатгалын сан | 2023 | | 2024 | | 2025 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тэтгэвэр | 486.4 | 3,617.0 | 505.6 | 4,666.5 | 521.5 | 5,341.2 |
| 2 | Тэтгэмж | 248.7 | 212.5 | 176.8 | 256.3 | 161.3 | 291.5 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | ҮОМШӨ | 7.4 | 41.5 | 6.7 | 48.1 | 6.6 | 52.1 |
| 4 | Ажилгүйдэл | 30.1 | 110.2 | 30.8 | 136.3 | 34.1 | 163.7 |
| 5 | Даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 50 хувийн буцаалт | 310.9 | 11.8 | - | - | - | - |
| 6 | Үйл ажиллагааны зардал | - | 43.2 | - | - | - | - |
| | **Нийт** | **1,083.5** | **4,036.2** | **699.0** | **5,107.2** | **723.5** | **5,848.5** |

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.5 мянган хүн /0.5 хувь/, зарцуулалт 741.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

## 5.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨР ЗАРДАЛ

### 5.1 Тэтгэвэр олголт

ТДС-аас 2025 онд нийт 521.5 мянган тэтгэвэр авагчдад 5,341.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

*Хүснэгт 10. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Өндөр насны тэтгэвэр | 382.8 | 2,887.2 | 402.3 | 3,760.4 | 418.8 | 4,315.8 |
| 2 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 62.5 | 341.8 | 61.6 | 410.7 | 59.4 | 455.5 |
| 3 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 19.8 | 113.4 | 20.0 | 137.1 | 20.3 | 157.7 |
| 4 | Цэргийн тэтгэвэр | 21.3 | 273.1 | 21.7 | 358.0 | 23.0 | 411.4 |
| 5 | Олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.3 | - | 0.8 |
| | **Нийт** | **486.4** | **3,615.5** | **505.6** | **4,666.5** | **521.5** | **5,341.2** |

*График 5. Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/*




Тэтгэврийн даатгалын зардал өмнөх оноос 674.7 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өссөн.

*График 6. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/*




Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 91.3 хувь нь бүрэн тэтгэвэр, 8.7 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байна.

*График 7. Тэтгэврийн хэмжээ /мян.төг/*




Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.

### 5.2 Тэтгэмж олголт

Тэтгэмжийн даатгалын сангаас 161.3 мянган даатгуулагчдад 291.5 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгожээ.

*Хүснэгт 11. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж | 145.6 | 32.6 | 90.3 | 38.1 | 94.2 | 44.6 |
| 2 | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж | 61.6 | 147.7 | 51.3 | 187.8 | 53.1 | 215.9 |
| 3 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж | 14.2 | 28.3 | 14.3 | 29.0 | 14.0 | 28.1 |
| 4 | Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл, тэтгэмж | 27.3 | 3.8 | 20.9 | 1.35 | 8.9 | 2.9 |
| 5 | Олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.05 | - | 0.06 |
| | **Нийт** | **248.7** | **212.4** | **176.8** | **256.3** | **161.3** | **291.5** |

*График 8. Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/*




Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.2 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

**5.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон төлбөр, зардал**

2025 оны жилийн эцсийн байдлаар 6.6 мянган даатгуулагчдад хөдөлмөрийн чадвар алдсан, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 52.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

*Хүснэгт 12. ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Тэтгэвэр, тэтгэмжийн төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 3.5 | 31.8 | 3.4 | 37.5 | 2.9 | 38.2 |
| 2 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 0.5 | 4.0 | 0.4 | 4.8 | 0.4 | 5.8 |
| 3 | ХЧТА-ны тэтгэмж | 1.5 | 1.8 | 1.2 | 2.6 | 1.8 | 3.8 |
| 4 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж | - | - | - | 0.09 | 0.03 | 0.08 |
| 4 | Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр | 0.01 | 0.01 | 0.01 | 0.02 | 1.3 | 0.01 |
| 5 | Рашаан сувиллын зардал | 1.9 | - | 1.7 | 1.3 | 0.2 | 1.0 |
| 6 | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | - | 1.1 | - | 0.04 | - | 1.5 |
| 7 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл | - | 1.8 | - | 1.7 | - | 1.6 |
| 8 | Олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.08 | - | 0.07 |
| | **Нийт** | **7.4** | **41.5** | **6.7** | **48.1** | **6.6** | **52.1** |

*График 9. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/*




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага өмнөх оноос 4.0 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

### 5.4 Ажилгүйдлийн тэтгэмж олголт

2025 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 34.1 мянган даатгуулагч 163.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авч өмнөх оноос 27.4 тэрбум төгрөг буюу 20.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 10. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*



## 6.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГА

### 6.1 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалт

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журам"-д НДСЧҮ-ийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар заасан. Үүнд:

- ЗГ-ын үнэт цаас
- МБ-ны үнэт цаас
- Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж
- Банкны тухай хуулийн 13.1.20-д заасан арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж болно.

*ЗГ-ын үнэт цаас худалдан авах талаар*

2024 онд худалдан авсан ЗГ-ын 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хүүгийн орлого нийт 83.5 тэрбум төгрөгийн орлого орно. Үүнээс 2025 онд хүүгийн орлого 27.0 тэрбум төгрөг орсон.

*Хүснэгт 13. Үнэт цаасны хүүгийн тооцоолол /төгрөгөөр/*

| № | Хугацаа | 1 жил | 2 жил | 3 жил | Дүн |
|---|---|---|---|---|---|
| | | 8.50-9.50% | 9.0% | 9.5% | |
| | ЗГ-ын ҮЦ | 179/НД-106/25 гэрээтэй 100,000,000,000 | 100,000,000,000.00 | 100,000,000,000.00 | 300,000,000,000.00 |
| 1 | 2025.05.15 | 4,215,068,493.15 | 4,463,013,698.63 | 4,710,958,904.11 | 13,389,041,095.89 |
| 2 | 2025.11.15 | 4,284,931,506.85 | 4,536,986,301.37 | 4,789,041,095.89 | 13,610,958,904.11 |
| | | 2025 онд НДС-нд төвлөрсөн үнэт цаасны хүү | | | **27,000,000,000.00** |
| 3 | 2026.05.15 | | 4,463,013,698.63 | 4,710,958,904.11 | 9,173,972,602.74 |
| 4 | 2026.11.15 | | 4,536,986,301.37 | 4,789,041,095.89 | 9,326,027,397.26 |
| 5 | 2027.05.15 | | | 4,710,958,904.11 | 4,710,958,904.11 |
| 6 | 2027.11.15 | | | 4,789,041,095.89 | 4,789,041,095.89 |
| | Нийт хүү дүн | 8,500,000,000.00 | 18,000,000,000.00 | 28,500,000,000.00 | **55,000,000,000.00** |
| 1 | 2026.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 2 | 2026.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| 3 | 2027.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 4 | 2027.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| 5 | 2028.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 6 | 2028.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| | 179/НД-106/25 гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 15-нд сунгасан бондын хүү | **28,500,000,000.00** | | | |
| | **Нийт** | **37,000,000,000.00** | **18,000,000,000.00** | **28,500,000,000.00** | **83,500,000,000.00** |

ЗГ-ын 2025 оны 192 дугаар тогтоолоор НДСЧҮ-ээс 300.0 тэрбум төгрөгөөр үнэт цаас худалдан авах хөрөнгө батлагдсан боловч Сангийн яамнаас үнэт цаасыг нээлттэйгээр арилжсан ба нээлттэй арилжаанд оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулан ГБХНХЯ-нд холбогдох саналыг хүргүүлээд байна.

*МБ-ны үнэт цаас худалдан авах талаар*

МБ нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг зорилтот түвшинд тогтворжуулах зорилгоор банкны систем дэх төгрөгийн илүүдэл нөөцийг нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар татах зорилгоор үнэт цаасны арилжааг зохион байгуулдаг тул хөрөнгө оруулалтын хэрэгслээр ашиглах боломжгүй гэсэн байр суурьтай байгаа учраас одоог хүртэл МБ-ны үнэт цаасыг худалдан аваагүй байна.

*Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж*

Сангийн яам төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах зөвшөөрөл олгоогүй тул тайлангийн хугацаанд НДСЧҮ-ээс төрийн санд мөнгөн хадгаламж байршуулаагүй. ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ын 5.7 дахь хэсэгт "Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байгаа нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэлд сар бүр хүү тооцож олгоно. Хүүгийн хэмжээ нь Монголбанкнаас Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлд тооцож олгодог хүүгийн хэмжээтэй тэнцүү байна." гэж заасан боловч одоогоор энэ зохицуулалт хэрэгжихгүй байна.

*Банкны тухай хуулийн 13.1.20-д заасан арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламж*

МХ-ны дүгнэлт зөвлөмжийг үндэслэн НДҮЗ-ийн 07, 08 дугаар тогтоолуудаар 2025 онд НДСЧҮ-ээс Банкны тухай хуулийн 13.1.20-д заасан системийн нөлөө бүхий арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөг, хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар тус тус оны эхэнд шинэчлэн баталсан. Эдгээр шийдвэрийг үндэслэн НДЕГ-аас Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкнуудтай хэлцэл хийж, энэхүү 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэйгээр мөнгөн хадгаламж хэлбэрээр дээрх 4 банканд хуваан байршуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтын дүнд нийт 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор НДС-ийн орлого арвижих боломж бүрдсэн. Банкуудтай байгуулсан гэрээний дагуу 05-12 дугаар сарын хүү болох 70.2 тэрбум төгрөгийг НДС-д төвлөрүүлж, https://shilendans.gov.mn/ сайт, https://www.ndaatgal.mn/ цахим хуудсаар даатгуулагч, иргэдэд тогтмол, ил тод мэдээлж байна.

*График 11. НДС-ийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого*




**6.2 Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа.**

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлтэй байна” гэж, мөн зүйлийн 13.7 дахь хэсэгт “Олон нийтийн хяналтын зөвлөл нь төрийн болон төрийн бус байгууллага, хөрөнгө оруулалтын мэргэжлийн хороо, даатгуулагчийн төлөөлөл бүхий 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг зөвлөлийн дүрмийг хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална” гэж тус тус заасан.

Тус зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд оруулах журам”-ийн дагуу НДСЧҮ-ээс

1.ЗГ-ын үнэт цаас худалдан авах;

2.МБ-ны үнэт цаас худалдан авах;

3.Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах,

4.Системийн нөлөө бүхий арилжааны банканд хадгаламж болон харилцах дансанд хадгалуулах хэлбэрээр байршуулах үйл ажиллагаанд тус тус хяналт тавьж ажилласан.

Тайлант онд танхимаар 3 удаа, цахимаар 2 удаа, нийтдээ 5 удаа хуралдаж, 5 удаа ажлын уулзалт зохион байгуулсан байна. ОНХЗ-өөс эрхлэх асуудлын хүрээнд НДЕГ-т нийт 16 дүгнэлт, 22 зөвлөмжийг хүргүүлэв.

Үүнд:

- НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааны тайлан, мэдээлэлд хяналт, шалгалт хийж, цаашид анхаарах асуудлаар 9 дүгнэлт, 10 зөвлөмж;

- Сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй мэдээлсэн байдалд шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авах талаар 1 дүгнэлт, 4 зөвлөмж;
- НДС-ийн санхүүгийн болон нэгдсэн төсвийн 2025 оны 2 дугаар улирлын мониторинг хийсэн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар 1 дүгнэлт, 8 зөвлөмж;
- НДБ-ын үйл ажиллагааны төсвийн 2025 оны 2 дугаар улирлын мониторинг хийсэн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг үндэслэн цаашид анхаарах асуудлаар 5 дүгнэлт.

*Хүснэгт 14. Хуралдаан, уулзалтын мэдээлэл*

| № | Хугацаа | Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд |
|---|---|---|
| 1. | 2025.01.06 | 1.ОНХЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, НДҮЗ-ийн АА, МХ-той хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслүүдийг хэлэлцэж, гишүүдийн саналыг тусган НДҮЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 2. | 2025.02.07 | 1.Мөнгөний бодлого, арилжааны банкны дундаж хүү, 2025 онд төрөөс баримтлах мөнгөний бодлогын хүрээнд гадаад худалдааны тэнцэл, валютын нөөц, инфляц, тэтгэврийн зээлийн өсөлт, бууралтын талаарх мэдээлэл, мөн тэтгэврийн зээлийн хүүг бууруулах боломж, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, ЗГ-аас гаргасан бондыг үнэт цаасны зах зээлд арилжаалах бэлтгэл хангах, ҮЦ-ны зах зээлийн өгөөжийг хадгаламжийн хүүтэй харьцуулан статистик мэдээлэл зэрэг асуудлаар МБ-ны төлөөлөл, СЗХ, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөлтэй уулзалт зохион байгуулагдсан талаар зөвлөлийн дарга танилцуулсныг хэлэлцэж, мэдээлэлтэй танилцав. |
| 3. | 2025.03.17 | 1.НДЕГ-ын дарга, удирдлагуудтай уулзаж, зөвлөлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болон хяналтын чиг үүргийн талаарх асуудлыг хэлэлцэж хамтран ажиллахаар шийдвэрлэв. |
| 4. | 2025.03.24 | 1.ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журмын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд НДСЧҮ-ийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахтай холбоотой зохицуулалтын хэрэгжилтийг хянан үзэж, холбогдох тайлан, зөвлөмжийг боловсруулан НДЕГ-т хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 5. | 2025.04.05 | 1.ЗГ-ын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 2024 оны 199/НД73/24 дугаар гэрээний хэрэгжилттэй танилцаж гэрээ хэвийн хэрэгжиж, хүүгийн орлогыг тогтоосон хугацаанд НД-ын холбогдох санд төвлөрүүлж байгааг дүгнэв. |
| | | 2.МБ арилжааны банкнаас бусад байгууллага сангаас үнэт цаас худалдан авах боломжгүй тухай мэдээллийг НДЕГ-т ирүүлсэн. НДСЧҮ-ээс МБ-ны үнэт цаас худалдан авах үйл ажиллагаа хийгдээгүй талаар хэлэлцэж, холбогдох тайлан, зөвлөмжид тусгахыг шийдвэрлэв. |
| | | 3."ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан "НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ын 5.7-д "Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байгаа нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэлд сар бүр хүү тооцож |

| | | |
|---|---|---|
| | | олгоно. Хүүгийн хэмжээ нь Монголбанкнаас Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлд тооцож олгодог хүүгийн хэмжээтэй тэнцүү байна." гэсэн зохицуулалт хэрэгжихгүй байна. Холбогдох журмын хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргаж, тайланг хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 6. | 2025.04.21 | 1.НДСЧҮ-ийг системийн нөлөө бүхий банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах талаар "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний төсөл, холбогдох мэдээллийг ОНХЗ-ийн 3 дугаар хуралдаанаар хэлэлцэж цаашид анхаарах дүгнэлт, зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| | | 2.2025 онд НДСЧҮ-ээс банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн хэмжээг банк бүрээр тогтоохдоо аль нэг банканд давуу байдал олгохгүй байх, өөрийн хөрөнгөөс хувь тэнцүүлэн тогтоох чиглэл баримтлах тухай дүгнэлт, зөвлөмж гаргав. |
| 7. | 2025.05.16 | 1.Шударга өрсөлдөөний хууль тогтоомжийн талаарх мэдээллийг хэлэлцэж, холбогдох албан хаагчдыг хамруулах, цаашид анхаарах чиглэлээр санал солилцов. |
| 8. | 2025.07.04 | 1.Удирдамж батлан 2 багийг томилж НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болон ил тод, нээлттэй шилэн байдлыг хэрхэн хэрэгжүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав. Тайлан бэлтгэж цаашид анхаарах асуудлаар НДЕГ-т зөвлөмж, дүгнэлт хүргүүлэхээр болов. Үр дүн хангалтгүй, хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал үүсээгүй. |
| | | 2.НДЕГ-т 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр өгсөн 6 зөвлөмжийн биелэлтийг зөвлөлийн даргын 07 дугаар сарын 04-ний өдөр баталсан удирдамжийн хүрээнд тооцож, тайлбар гаргуулсан бөгөөд 1 зөвлөмж хэрэгжээгүй, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа байв. Зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, биелэлтийг сайжруулах чиглэлээр холбогдох тайлбар, арга хэмжээ авахыг үүрэг болгов. |
| 9. | 2025.09.18 | 1.2025 оны эхний 3 сарын НДС-ийн орлого бүрдүүлэлт зарцуулалт, зарлагын гүйцэтгэл болон бусад холбогдох нээлттэй мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийх ажлын удирдамж батлан ажиллах 2 багийг томилон, тайлан танилцуулга зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 10. | 2025.10.22 | 1.НДС-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн 2025 оны 2 дугаар улирлын тайланд дүн шинжилгээ, мониторинг хийх удирдамжийн дагуу зөвлөлийн гишүүд тайланд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, холбогдох тайлан, мэдээллийг хүргүүлэхээр болов. |
| | | 2.НДБ-ын төсвийн гүйцэтгэлийн 2 дугаар улирлын тайлангийн тоо, мэдээлэлд дүн шинжилгээг хийж ажлын тайлан мэдээллийг НДҮЗ-ийн АА-нд хүргүүлэхээр болов. |
| 11. | 2025.11.15 | 1.Макро эдийн засгийн мэдээлэл, үнэт цаасны зах зээлийн индекс мэдээнд дүн шинжилгээ хийсэн танилцуулга боловсруулан АА-нд хүргүүлэхийг шийдвэрлэв. |
| 12. | 2025.12.04 | 1.2025 оны 125 дугаар албан бичигт НДЕГ-аас боловсруулсан тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг арилжааны банканд байршуулахтай холбоотой "Мөнгөн хадгаламжийн гэрээний болон "Банкнуудын үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал"-ын төсөлтэй зөвлөлийн гишүүд танилцаж хариуг хүргүүлэхээр болов. |
| | | 2.НДЕГ-т, орон нутгийн НД-ын болон холбогдох байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлт, саналыг судалж, эрэмбэлэн зөвлөлийн чиг үүрэгт болон АО, даатгуулагчийн нийтлэг эрх ашигт хамаарах өргөдөл гомдол, саналын шийдвэрлэлттэй танилцав. НДСЧҮ-ийг |

| | | |
|---|---|---|
| | | санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар өргөдөл, гомдол санал, хүсэлт ирээгүй байна. |
| | | 3.Жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг үүрэг болгосон. |
| 13. | 2025.12.10 | 1.2025 оны жилийн эцсийн ажлын тайланг гүйцэтгэх, биелэлтийг дүгнэх талаар хэлэлцэн, НДҮЗ-ийн хурлаар танилцуулах болов. |

*Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж байгаа үйл ажиллагаатай танилцан хяналт тавьж, ажилласан талаар*

ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан НДСЧҮ-ээс санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журмын хэрэгжилтэд хяналт тавьж НДСЧҮ-ийг банканд хадгаламж хэлбэрээр байршуулах ажиллагааны хэрэгжилт хэвийн явагдаж, хүүгийн орлого хугацаандаа төвлөрч байгааг тогтоож, дүгнэлт, зөвлөмж боловсруулан НДҮЗ-ийн АА-аар дамжуулан НДЕГ-т хүргүүлэв.

ЗГ-ын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 2024 оны 199/НД73/24 дугаар гэрээний хэрэгжилттэй танилцахад гэрээ хэвийн хэрэгжиж хүүгийн орлогыг тогтоосон хугацаанд НДС-д төвлөрүүлсэн байна.

2025 онд НДСЧҮ-ийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах талаар, "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний төсөл, холбогдох мэдээллийг судлав. Хадгаламж байршуулахдаа аль нэг банканд давуу байдал олгохгүй байх, өөрийн хөрөнгийн хэмжээнд хувь тэнцүүлэн байршуулах зарчим баримтлах зөвлөмж гаргасан.

НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг НДЕГ-ын холбогдох албан тушаалтан хараат бусаар, нөлөөнд автахгүй, бие даан, хууль дээдлэн, шударга ажиллаж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт тавьж, НДЕГ-аас НДСЧҮ-ийг арилжааны банканд байршуулах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хэрхэн хэрэгжүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судалж, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллав. Хяналтын үр дүнд ноцтой зөрчил илрээгүй боловч зарим журмын хэрэгжилт хангалтгүй байгаа нь анхаарах шаардлагатай байна.

НДС-ийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, ашигт ажиллагааны түвшинд мониторинг, дүн шинжилгээ хийж, НДС-ийн 2025 оны эхний 3 сарын орлого, зарлагын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээний танилцуулгыг боловсруулан, холбогдох дүгнэлт, зөвлөмжийн хамт НДҮЗ-ийн АА-нд хүргүүлэн ажилласан.

НДСЧҮ-ийг ЗГ-ын болон МБ-ны үнэт цаас худалдан авах, Төрийн сангийн нэгдсэн данс болон системийн нөлөө бүхий арилжааны банканд мөнгөн хадгаламж, харилцах дансны хэлбэрээр байршуулах үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох гэрээ, хэлцлийн хэрэгжилт, ил тод байдал, хууль, журмын нийцлийг хянан үзэв. Мөн 2025 оны 2 дугаар улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн тоо

мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, холбогдох тайланг боловсруулан хүргүүлсэн бөгөөд байгууллагын төсвийн гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээний талаар танилцуулга, мэдээлэл өгч цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөв.

Макро эдийн засаг, үнэт цаасны зах зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж танилцуулга бэлтгэн хүргүүлэв. Энэ хүрээнд холбогдох мэдээллийг НДҮЗ-ийн АА-аар дамжуулан авч, байгууллагуудын уялдаа холбоог ханган ажилласан бөгөөд хяналт-шинжилгээний үр дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулж, НДҮЗ-ийн АА-нд хүргүүлсэн болно.

*Зураг 3. Хяналтын зөвлөлөөс хийсэн сургалт*



-НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан үйл ажиллагаа болон арилжааны банканд мөнгөн хадгаламж байршуулахдаа ил тод, нээлттэй байх хүрээнд хэрхэн ажилласан талаарх байдалд хийсэн зөвлөлийн ажлын тайлан, танилцуулгыг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр танилцуулав. Энэхүү арга хэмжээнд НДЕГ-ын ажилтнууд танхимаар, 21 аймаг, 9 дүүргийн НД-ын ажилтнууд цахимаар оролцон нийт 400 хүн хамрагдав.

-НДС-ийн 2025 оны эхний 3 сарын орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад мониторинг, дүн шинжилгээ хийсэн тухай танилцуулга нь үндсэн 3 хэсгээс бүрдсэн.

1.НДС-ийн орлогын бүрдүүлэлтийн дүн, НД-ын хамралт, шимтгэл ногдуулсан ЦХТАО, НДШ-ийн орлого, авлагын мэдээлэл

2.НДС-ийн зарцуулалтын дүн шинжилгээг сан тус бүрээр хийсэн тухай

3.НДС-ийн ашигт ажиллагааны түвшний шинжилгээг сан тус бүрээр хийсэн тухайгаа тус тус дурдаж дүгнэлт, зөвлөмжийг тусгасан тайлан болон, НДС-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн 2025 оны 2 дугаар улирлын тайлангийн холбогдох тоо, мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ, мониторинг хийсэн ажлын тайлан, шударга өрсөлдөөний хууль тогтоомжийн талаарх мэдээллийг 04 дүгээр улиралд зөвлөлийн гишүүн Г.Ганчимэг, Б.Мөнххананд нар НДЕГ-ын ажилтнуудад танилцуулсан болно.

ГБХНХЯ-аас 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Нийгмийн хамгааллын үндэсний тогтолцооны үзэл баримтлалыг танилцуулах хэлэлцүүлэг, 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Өндөр насны тэтгэврийг ойлгох нь:

түүхэн замнал, зорилт шинэчлэлийн бодлогууд” семинарт тус зөвлөлийн гишүүд оролцсон болно.

ОНХЗ нь НДСЧҮ-ийг найдвартай, үр өгөөжтэй санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхэд хяналт тавьж ажиллаж байгаа талаар тус зөвлөлийн гишүүн П.Баянсан НДЕГ-ын facebook группт пост байршуулсан. Зөвлөл нь 2025 онд төлөвлөсөн ажлаа бүрэн биелүүлж, АА-ыг тус зөвлөлийн эрхлэх чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээллээр хангаж ажилласан байна.

*Зураг 4. ОНХЗ-ийн уулзалт*



## 7.ТЭТГЭВРИЙН НӨӨЦ САН БҮРДҮҮЛЭЛТ

НД-ын багц хууль, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу шилжих, даатгуулагчийн нэрийн дансны орлогыг үе шаттай мөнгөжүүлэх, тодорхой хувийг хуримтлалын нэгдсэн санд байршуулах замаар эрүүл мэнд, боловсрол, орон сууцны санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулах нөхцөл бүрдсэн билээ.

*Зураг 5. Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал*



ЗГ-ын 2024 оны 256 дугаар тогтоолоор "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам"-ыг баталж, НДШ төлж буй 1.2 сая даатгуулагч бүр "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болж, нийт 295.3 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүслээ.

*График 12. Хуримтлалын сангийн бүтэц*




Тайлангийн хугацаанд ТДС-аас 80.0 тэрбум төгрөгийг ТНС-нд нэмж байршуулж, 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2025 оны харилцах дансны хүүгийн орлого 7.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 302.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Харин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцах дансанд байсан 215.3 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, 15.11 хувийн хүүтэй Төр, Хаан, Голомт, Худалдаа хөгжлийн банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж эхэлсэн бөгөөд оны сүүлчийн нэг өдрийн хүү болох 89.1 сая төгрөгийг ТНС-д төвлөрүүлсэн.

*Хүснэгт 15. ТНС-ийн харилцах дансны үлдэгдэл /сая.төг/*

| № | Үзүүлэлт | Худалдаа хөгжлийн банк | Хаан банк | Голомт банк | Төрийн банк | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Харилцах дансны 2024 оны үлдэгдэл | 61,859.1 | 81,370.0 | 41,582.9 | 30,494.9 | 215,306.9 |
| 2 | 2025 онд нэмж байршуулсан | - | 35,000.0 | 20,000.0 | 25,000.0 | 80,000.0 |
| 3 | 2025 оны харилцахын хүүгийн орлого | 1,877.2 | 2,625.4 | 1,397.8 | 1,391.9 | 7,292.3 |
| 4 | 2025.12.30-ний үлдэгдэл | 63,736.3 | 118,995.4 | 62,980.7 | 56,886.8 | 302,599.3 |
| 5 | Хадгаламжид байршуулсан дүн 2025.12.31 | 51,541.0 | 92,635.2 | 49,164.4 | 21,966.5 | 215,307.1 |
| 6 | Хадгаламжийн хүү 1 хоног | 21.3 | 38.4 | 20.3 | 9.1 | 89.1 |
| 7 | Харилцах дансны 2025 оны үлдэгдэл | 12,217.0 | 26,398.6 | 13,836.6 | 34,929.4 | 87,381.3 |

Даатгуулагч нь өөрийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын мэдээллээ төрийн үйлчилгээний "E-Mongolia" системийн "Профайл" цэс, НДБ-ын portal.ndaatgal.mn цахим систем болон гар утасны "nDaatgal" аппликейшны "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал" хэсгээс харах боломжтой.

Даатгуулагч ТНС-д байршуулсан мөнгөн хөрөнгөө ямар санхүүгийн хэрэгсэлд оруулахаа сонгох боломжийг нь бүрдүүлж, гар утасны Ndaatgal аппликэйшн болон даатгуулагчдад зориулсан www.portal.ndaatgal.mn цахим хуудсаар санал авах ажлыг 7 дугаар сараас эхлүүллээ.

## 8.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ХАРИЛЦАХ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ, АВЛАГА

### 8.1 Нийгмийн даатгалын хамралт

2025 онд НД-д 63.8 мянган ААНБ, албан журмаар 1190.7, сайн дураар 169.8, малчин 56.5 мянган даатгуулагч мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байна.

*График 13. НД-ын хамралт /мян.хүн, ажил олгогч/*




НД-ын мэдээллийн санд 63.8 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2024 онтой харьцуулахад 7.1 мянган АО буюу өмнөх оны суурь түвшингээс 93.4 хувиар нэмэгдэж, 112.2 мянган хүнийг албан журмаар даатгалд шинээр хамруулан ажилласан. 2025 онд хүрэх түвшингээс 85.7 хувь буюу 23.1 мянган хүнийг сайн дураар даатгалд шинээр, нийт хамрагдвал зохих малчдын тоог 125.6 хувь буюу 10.7 мянгаар нэмэгдүүлж ажилласан байна. Мөн 505.0 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 1.3 мянган эхийг сайн дураар даатгалд нэмж хамруулав.

### 8.2 Нийгмийн даатгалын сангийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл

2025 оны жилийн эцсийн байдлаар НДС дотоод, гадаадын 9 арилжааны банкны харилцах дансанд 2,255.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*График 14. НДС-ийн харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл /тэрбум.төг/*




### 8.3 Нийгмийн даатгалын сангийн авлага

НДБ-д 2025 онд 638.0 мянган АО, 1,350.0 мянган даатгуулагч, 5.2 тэрбум төгрөгийн НДШ-ийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 95.9 хувиар бүрдүүлсэн.

*График 15. НДШ-ийн өр, авлага тэрбум.төг/*




НДС-ийн 36.3 мянган ААНБ-аас авах шимтгэлийн авлага 2025 оны эхэнд 520.5 тэрбум төгрөг байсан бөгөөд тайлангийн хугацаанд 24.2 мянган ААНБ-ын 266.7 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, оны эхний авлагыг 51.3 хувиар бууруулсан боловч оны эцэст 40.7 мянган АО-ын 697.6 тэрбум төгрөгт хүрч энэ онд 430.9 тэрбум төгрөгийн өр шинээр үүссэн.

Энэ нь нийт АО-ын 64.1 хувьд нь 370.3 мянган даатгуулагч ажиллаж байгаа нь нийт даатгуулагчдын 30.8 хувийг эзэлж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт авлагын 15.6 хувь буюу 109.0 тэрбум төгрөг нь эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэн бүртгэгдсэн бөгөөд 84.4 хувь буюу 588.6 тэрбум төгрөг нь НДШ-ийн авлага байна.

*Хүснэгт 16. 2025 оны жилийн эцсийн авлага барагдуулалтын мэдээ /тэрбум.төг/*

| 2025 оны НДШ-ийн авлага | | 2025 онд барагдуулсан дүнгээр | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт барагдуулсан | | | Хэсэгчилж барагдуулсан | | Бүрэн барагдуулсан | | Барагдуулаагүй АО тоо | Барагдуулаагүй авлагын дүн |
| АО тоо | Авлагын дүн | АО тоо | Авлагын дүн | Хувь | АО тоо | Авлагын дүн | АО тоо | Авлагын дүн | | |
| **36.3** | **520.5** | **24.2** | **266.7** | **51.3** | **2.7** | **42.7** | **21.5** | **224.0** | **12.1** | **253.8** |

Нийт 697.6 тэрбум төгрөгийн НДШ-ийн өрийн 5.9 хувь буюу 40.7 тэрбум төгрөг нь урсгал (0-30 хоногийн насжилттай), 94.1 хувь буюу 656.8 тэрбум төгрөгийн өр нь хуримтлагдсан байна.

*Зураг 6. НДШ-ийн авлага, өмчийн хэлбэрээр /тэрбум.төг, хувиар/*




*__Улсын төсвөөс авах авлага__*

УИХ-аас 2020 онд баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу үзүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлтөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 197.2 тэрбум төгрөгийн улсын төсвийн санхүүжилтийн авлагатай байна.

*Хүснэгт 17. НД-ын санхүүжилт 2020-2025 он /тэрбум.төг/*

| Д/д | Үзүүлэлт | Дүн | Дүнд эзлэх хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Шимтгэлээс чөлөөлөлт – ААНБ | 793.6 | 86.36% | 38.8 мянган ААНБ, 411.7 мянган даатгуулагч |
| 2 | Шимтгэлээс чөлөөлөлт – Сайн дураар даатгуулагч | 81.4 | 8.85% | 169.2 мянган даатгуулагч |
| 3 | Ажилгүйдлийн даатгалын дэмжлэг | 44.1 | 4.80% | 80.9 мянган даатгуулагч |
| 4 | Нийт санхүүжилтийн авлага | 919.2 | 100% | НДШ-ээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн улсын төсвийн санхүүжилтийн авлага |
| 5 | Олгосон санхүүжилт 2020–2025 | 722.0 | 78.55% | Улсын төсөв + олон улсын төсөл |
| 7 | 2025 оны үлдэгдэл авлага | 197.2 | 21.45% | Төсөвт шилжээгүй үлдэгдэл |

*__Олон жилийн насжилттай, өндөр дүнтэй бусад авлага__*

2003 оноос өмнөх хугацаанд НДС-д үүсч хуримтлагдсан 6.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч, 271.8 сая төгрөг, 2025 онд ХОТШ банкны өрнөөс 9.8 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд нийт 6.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Зураг 7. Олон жилийн насжилттай, өндөр дүнтэй авлага /тэрбум.төг/*




## 9.КАПИТАЛ, ЧИНГИС ХААН БАНКНЫ ӨР ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТАЛААР

### 9.1 Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн өр төлбөрийг төлүүлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

КБЭХА-аас НДС-ийн өр төлбөрт 104.2 тэрбум төгрөг барагдуулах шүүхийн шийдвэр гарснаас хойш 2025 оны жилийн эцэст хүртэл нийт 46.6 тэрбум төгрөгийн өрийг барагдуулах арга хэмжээ аваад байна. Үүнээс 15.0 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 31.5 тэрбум төгрөгийн 89 ширхэг үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 57.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь УОМШӨ-ний даатгалын сангийн өр төлбөр болно. Тайлант хугацаанд 8.1 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулсан.

*Хүснэгт 18. Өр төлбөр барагдуулалт /сая.төг/*

| № | Төлбөр барагдуулсан хугацаа | Барагдуулсан өр төлбөр | | |
|---|---|---|---|---|
| | | Мөнгөн хөрөнгөөр | Үл хөдлөх хөрөнгөөр | Нийт |
| 1 | 2020 он | 826.7 | - | 826.7 |
| 2 | 2021 он | 7,223.4 | 22,123.5 | 29,346.9 |
| 3 | 2022 он | 1,744.8 | 2,905.2 | 4,650.0 |
| 4 | 2023 он | 1,183.0 | - | 1,183.0 |
| 5 | 2024 он | 2,500.0 | - | 2,500.0 |
| 6 | 2025 он | 1,600.0 | 6,530.7 | 8,130.7 |
| | **Дүн** | **15,077.90** | **31,559.4** | **46,637.3** |

2025 онд өр төлбөрт хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөөс 189.8 сая төгрөгийн өртөгтэй 1 ширхэг үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж, төлбөрийг НДС-д төвлөрүүлсэн.

НДҮЗ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын дагуу үл хөдлөх хөрөнгийг 22 иргэн, ААНБ-д түрээслүүлснээр 2025 онд 335.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг НДС-д төвлөрүүлэв.

*Хүснэгт 19. НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан болон борлуулсан хөрөнгө /сая.төг/*

| № | Төрөл | Хүлээн авсан хөрөнгө | | Борлуулсан хөрөнгийн мэдээлэл | | | Үлдэгдэл хөрөнгө | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Мөнгөн дүн | Тоо | КБЭХА-ийн үнэ | Борлуулсан үнэ | Тоо | Мөнгөн дүн |
| 1 | Газар, гражтай газар | 15 | 2,133.0 | 9 | 1,921.5 | 1,982.8 | 6 | 211.5 |
| 2 | Орон сууц | 32 | 6,233.5 | 28 | 5,220.4 | 5,354.4 | 4 | 1,013.1 |
| 3 | Зоорь, агуулах | 14 | 580.0 | 14 | 580.0 | 640.0 | 0 | - |
| 4 | Хувийн сууц, газар | 4 | 75.4 | 0 | - | - | 4 | 75.4 |
| 5 | Үйлдвэр, үйлчилгээ, оффисын зориулалттай хөрөнгө | 12 | 17,294.7 | 1 | 243.5 | 255.4 | 10 | 17,051.1 |
| 6 | Орон сууцнаас бусад хөрөнгө | 12 | 5,242.8 | 10 | 3,720.1 | 3,830.5 | 2 | 1,522.7 |
| | **Нийт** | **89** | **31,559.4** | **62** | **11,685.5** | **12,063.1** | **27** | **19,873.9** |

НД-ын өр төлбөрт 2025 онд шинээр 6.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 189.8 сая төгрөгийн үнэлгээтэй 1 ширхэг үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж, 19.8 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 27 ширхэг үл хөдлөх хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

*График 16. Борлуулсан хөрөнгө /тэрбум.төг/*




Өр төлбөрийг барагдуулах асуудлаар ЗГ, ГБХНХЯ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу НДЕГ-аас НДС-ийн авлагыг барагдуулахаар шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд ЗГ, Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг холбогдох бусад байгууллагууд болон мэргэжлийн хууль эрх зүй, өмгөөллийн байгууллагатай хамтран ажиллаж байна.

**9.2 Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Чингис хаан банк ХХК-иас НДС-ийн өр төлбөрт 103.6 тэрбум төгрөг барагдуулахаас 19.9 тэрбум төгрөгийн өрийг барагдуулах арга хэмжээ аваад байна. Үүнээс 12.4 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 7.5 тэрбум төгрөгийн 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, 83.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 11.5 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулсан байна.

*График 17. Өр төлбөр барагдуулалтын явц*




НДҮЗ-ийн 2024 оны 08, 2025 оны 13 дугаар тогтоолоор Чингис хаан банкнаас 7.49 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг өр төлбөрт тооцон авлаа.

*Хүснэгт 20. НДС-ийн нэхэмжилсэн төлбөрт хүлээн авсан хөрөнгө /сая.төг/*

| № | Хөрөнгийн төрөл | Тоо | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | Орон сууц | 9 | 3,477.7 |
| 2 | Оффис, үйлчилгээний барилга | 2 | 4,014.9 |
| | **Нийт дүн** | **11** | **7,492.6** |

## 10.ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

УИХ-аас батлан гаргасан МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл болон ЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, албан даалгавар, НДҮЗ-ийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд холбогдох мэдээ, мэдээллийг үндэслэн ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

### 10.1 Хөгжлийн бодлого, мөрийн хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилт, хяналт

НД-ын чиглэлээр МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” баримт бичигт тусгагдсан 2 зорилт, 9 арга хэмжээний хэрэгжилт 92.0, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилт 100.0, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2 зорилт, 11 арга хэмжээний хэрэгжилт 95.8, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 2 зорилт, 4 арга хэмжээний хэрэгжилт 100.0, нийт дүнгээр 96.95 хувийн биелэлттэй буюу “Үр дүнтэй” гэж дүгнэлээ.

*Хүснэгт 21. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт /тоо, хувиар/*

| № | Хөгжлийн бодлого, чиглэлийн нэр | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | “Алсын хараа-2050” | 2 | 9 | 92.0 |
| 2 | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | 2 | 4 | 100.0 |
| 3 | МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө | 1 | 1 | 100.0 |
| 4 | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 2 | 11 | 95.8 |
| 5 | **Нийт дүн** | **7** | **25** | **96.95** |

"Үр дүнтэй" буюу хэрэгжиж байгаа, зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, цаашид үргэлжлүүлэн хэрэгжих 25 арга хэмжээнээс 90.0-100.0 хувийн хэрэгжилттэй 23 арга хэмжээ, 80.0-90.0 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ;

"Үр дүн хүлээгдэж байгаа" буюу зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, үр дүн гарч байгаа, өөрсдөөс хамаарах шийдвэрийг бүрэн гаргасан, хэрэгжилт үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 1 арга хэмжээ тус тус байна.

### 10.2 Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хяналт

МУ-ын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, НДҮЗ-ийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалтыг тус тус салбарын хэмжээнд хяналтад авсан.

*Хүснэгт 22. Хяналтад авсан шийдвэрийн заалтууд*

| № | Шийдвэрийн нэр | Шийдвэрийн тоо | Заалтын тоо |
|---|---|---|---|
| 1 | МУ-ын хууль | 2 | 2 |
| 2 | УИХ-ын байнгын хорооны тогтоол | 1 | 1 |
| 3 | ЗГ-ын тогтоол | 5 | 5 |
| 4 | Ерөнхий сайдын захирамж | 1 | 2 |
| 5 | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 14 | 23 |
| 6 | Ерөнхий сайдын албан даалгавар | 2 | 22 |
| 7 | НДҮЗ-ийн тогтоол | 12 | 13 |
| | **Нийт** | **37** | **68** |

Хяналтад авсан шийдвэрийн заалтуудын хэрэгжилт:

- МУ-ын хууль: 2 шийдвэрийн 2 заалтын биелэлт "Бүрэн хэрэгжсэн" буюу 100.0 хувь;
- УИХ-ын байнгын хорооны тогтоол: 1 шийдвэрийн 1 заалтын биелэлт "Хэрэгжих шатанд" буюу 50.0 хувь;
- ЗГ-ын тогтоол: 5 шийдвэрийн 5 заалтаас "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 2, "бүрэн хэрэгжсэн" буюу 100.0 хувийн биелэлттэй 2, "хэрэгжих шатанд" буюу 50.0 хувийн биелэлттэй 1 шийдвэр. Биелэлтийн дундаж 83.3 хувь;
- Ерөнхий сайдын захирамж: 1 шийдвэрийн 2 заалт "бүрэн хэрэгжсэн" буюу 100.0 хувийн биелэлттэй.
- ЗГ-ын хуралдааны тэмдэглэл: 14 шийдвэрийн 23 заалт байна. "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 4, "бүрэн хэрэгжсэн" буюу 100.0 хувийн биелэлттэй 17, "хэрэгжих шатанд" буюу 50.0 хувийн биелэлттэй 2 шийдвэр. Биелэлтийн дундаж 94.7 хувь;

- Ерөнхий сайдын албан даалгавар: 2 шийдвэрийн 22 заалт байна. “бүрэн хэрэгжсэн” буюу 100.0 хувийн биелэлттэй 20, “хэрэгжих шатанд” буюу 50.0 хувийн биелэлттэй 3 шийдвэр. Биелэлтийн дундаж 95.5 хувь;

- НДҮЗ-ийн тогтоол: 12 шийдвэрийн 13 заалт байна. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 2, “бүрэн хэрэгжсэн” буюу 100.0 хувийн биелэлттэй 10, “хэрэгжих шатанд” буюу 50.0 хувийн биелэлттэй 1 шийдвэр. Биелэлтийн дундаж 95.5 хувь;

*Хүснэгт 23. Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт /хувиар/*

| Хууль, тогтоол шийдвэр | | | Бүгд | Үүнээс: УИХ-ын байнгын Хорооны тогтоол | ЗГ-ын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | Ерөнхий сайдын албан даалгавар | МУ-ын хууль | НДҮЗ-ийн тогтоол |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | | 37 | 1 | 5 | 1 | 14 | 2 | 2 | 12 |
| Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо | | | 68 | 1 | 5 | 2 | 23 | 22 | 2 | 13 |
| Үнэлгээ | Хэрэгжсэн | | 53 | - | 2 | 2 | 17 | 20 | 2 | 10 |
| | Хэрэгжих шатанд | Тодорхой үр дүнд хүрсэн | 7 | 1 | 1 | | 2 | 2 | | 1 |
| | | Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай/ | - | - | - | - | - | - | - | - |
| | Хэрэгжээгүй | Зохион байгуулалтаас | - | - | - | - | - | - | - | - |
| | | Хөрөнгө дутагдсанаас | - | - | - | - | - | - | - | - |
| | Хугацаа болоогүй | | 8 | - | 2 | | 4 | - | - | 2 |
| | Хэрэгжих боломжгүй | | - | - | - | - | - | - | - | - |
| Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/ | | | 25 | - | 2 | - | 5 | 6 | 2 | 10 |
| **Дүн** | | | **94.2** | **50.0** | **83.3** | **100.0** | **94.7** | **95.5** | **100.0** | **95.5** |

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээгээр:

- “Хэрэгжсэн” буюу биелэлт бүрэн хангагдсан 53;
- “Хэрэгжих шатанд” буюу зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарсан, дээд шатны байгууллагад хүргүүлсэн “тодорхой үр дүнд хүрсэн” 7;
- “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” 8;
- “Тухайн шийдвэрт заасан хугацаа дууссан”, “бүрэн хэрэгжсэн” хяналтаас хасуулах 5 шийдвэрийн 25 заалт байна.

НД-ын салбарын хэмжээнд хэрэгжиж буй шийдвэрийн хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 37 хууль, тогтоол, шийдвэрийн 68 заалтын 88.3 хувь

"Хэрэгжсэн", 5.83 хувь "Хэрэгжих шатанд", 11.8 хувь "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" биелэлтийн дундаж 94.2 хувиар дүгнэгдлээ.

### 10.3 Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны төлөвлөгөөний биелэлт

НДБ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 9 зорилт, 69 арга хэмжээний жилийн эцсийн биелэлтийг 94.8 хувь буюу "Бүрэн хангалттай" гэж үнэлж, дүгнэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт:

- "Бүрэн хангалттай" 85.0 буюу түүнээс дээш хувиар (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн) 100.0 хувийн биелэлттэй 43, 85.0-95.0 хувийн биелэлттэй 19, нийт 62 арга хэмжээ;
- "Хангалттай" буюу 70.0-84.3 хувиар (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах) үнэлэгдсэн 6 арга хэмжээ;
- "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 1 арга хэмжээ байна.

## 11.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАХИМЖУУЛАЛТ, ХӨГЖҮҮЛЭЛТ, ХҮРТЭЭМЖ

### 11.1 Мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлт

НДБ төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх, ашиг сонирхлоос ангид байх зорилтын хүрээнд салбарын хэмжээнд ашиглагддаг мэдээллийн нэгдсэн SICOS системийг 320 суманд нэвтрүүлж дуусгалаа. Ингэснээр:

- АО-ийн НДШ-ийн тайлан хүлээн авах;
- Шинэ АО бүртгэх;
- АО-ийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх;
- Сайн дураар даатгалын гэрээ байгуулах;
- Сайн дураар даатгуулагчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх;
- Тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлт үүсгэх;
- Даатгуулагчийн хүсэлтээр НДШ төлөлтийн лавлагаа гаргах зэрэг дээрх бүх үйлчилгээг иргэд сумандаа нэг дороос авах боломжтой болж, үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал сайжирлаа.

Тайлант хугацаанд шинээр 3 бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлэв:

1.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг хэлэлцэн шийдвэрлэсэн мэдээллийг бүртгэх, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг програмчлан шинээр дэд систем хөгжүүлэн нэвтрүүлснээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох.

2."Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам"-д заасан аргачлалын дагуу даатгуулагчийн 2024 он ба түүнээс өмнөх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийг автоматаар тооцоолон буцаан олгох.

3.НД-ын нийт бүтээгдэхүүн үйлчилгээний тоон мэдээллийг дэлгэрэнгүй харах боломж бүхий "Dashboard"-ыг шинэчлэн боловсруулж нэвтрүүлсэн. Уг "Dashboard"-оос НД-ын бүтээгдэхүүн үйлчилгээний нийт 25 төрлийн багц мэдээллийг харьяалагдах аймаг, дүүргээр задлан дэлгэрэнгүй харах боломжийг бүрдүүллээ.

### 11.2 Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалт

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон НД-ын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, АО, харилцагч байгууллагуудад НД-ын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Үүний дүнд мэдээллийн нэгдсэн систем (Sicos)-ээр 259.3, Portal.ndaatgal.mn системээр 216.2, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган АО-ийн НДШ-ийн тайланг цахимаар хүлээн авч 98.0 хувийг шийдвэрлэлээ. НД-ын 81 үйлчилгээнээс 46 үйлчилгээ бүрэн цахимжсан байна.

## 12.ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛ

Тайлангийн хугацаанд төв болон аймаг, дүүргийн 31 зөвлөл нь ЗГ-ын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-ийн дагуу 300 гаруй гишүүдтэйгээр эрүүл мэндийн магадлах үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэн явууллаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 99639 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.0 хувиар буурсан байна. Нийслэлд 37089, орон нутагт 58832 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгожээ.

*Хүснэгт 24. Нийт хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, тогтоолгосон хүний тоо /сүүлийн 10 жилээр/*

| № | Он | Хүний тоо | | Бүгд | Өмнөх онтой харьцуулсан хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Нийгмийн даатгалын сан | Нийгмийн халамжийн сан | | |
| 1 | 2016 | 63237 | 48786 | 112023 | -2.1 |
| 2 | 2017 | 72311 | 42059 | 114370 | 2.1 |
| 3 | 2018 | 69827 | 41637 | 111464 | -2.5 |
| 4 | 2019 | 71722 | 39664 | 111386 | -0.1 |
| 5 | 2020 | 72151 | 38242 | 110393 | -0.9 |
| 6 | 2021 | 67132 | 38475 | 105607 | -4.3 |
| 7 | 2022 | 64717 | 38518 | 103235 | -2.2 |
| 8 | 2023 | 63441 | 39234 | 102675 | -0.5 |
| 9 | 2024 | 62447 | 39165 | 101612 | -1.0 |
| 10 | 2025 | 61352 | 38287 | 99639 | -2.0 |

2016-2025 оныг хүртэл хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт хүний тоо 11.1 хувиар, үүнээс: НДС-аас хөдөлмөрийн чадвар алдсан тэтгэвэр авагчдын тоо 3.0 хувь, нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагчдын тоо 21.5 хувиар тус тус буурсан байна.

*График 18. НДС болон нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авагч /тоогоор/*




Улсын хэмжээнд эрүүл мэндийн магадлалын цахим мэдээллийн санд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн 108296 иргэн бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 10054 иргэн шинээр тогтоолгож, 41680 иргэн хугацаагаа сунгуулж, 8647 иргэний шийдвэр цуцлагдсан байна.

*Хүснэгт 25. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байдал**

| № | Шалтгаан | Шийдвэрийн төрөл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сунгасан | Шинээр тогтоосон | Шилжин ирсэн | Хурлаар ороогүй | Тогтоосон шийдвэр идэвхтэй | Цуцалсан | Нийт |
| 1 | Ахуйн осол | 527 | 236 | 0 | 0 | 763 | 312 | 1075 |
| 2 | Ердийн өвчин | 39184 | 9631 | 498 | 46214 | 95527 | 8011 | 103538 |
| 3 | Мэргэжлээс шалтгаалсан өвчин | 1334 | 54 | 0 | 624 | 2012 | 214 | 2226 |
| 4 | Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй | 366 | 38 | 1 | 0 | 405 | 34 | 439 |
| 5 | Үйлдвэрлэлийн осол | 219 | 85 | 5 | 562 | 871 | 81 | 952 |
| 6 | Хүүхэд насандаа | 51 | 10 | 0 | 0 | 61 | 5 | 66 |
| | **Нийт** | **41681** | **10054** | **504** | **47400** | **99639** | **8657** | **108296** |

*Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авдаг хүний тоо орсон.

*Хүснэгт 26. Хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан /сүүлийн 3 жилээр/*

| № | Шалтгаан | 2023 | | 2024 | | 2025 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| 1 | Ердийн өвчин, ахуйн осол | 99172 | 96.6 | 98408 | 96.8 | 96756 | 97.1 |
| 2 | Мэргэжлээс шалтгаалсан | 2600 | 2.5 | 2282 | 2.2 | 2012 | 2.0 |
| 3 | Үйлдвэрлэлийн осол | 903 | 0.9 | 922 | 0.9 | 871 | 0.9 |
| | **Нийт** | **102675** | **100.0** | **101612** | **100.0** | **99639** | **100.0** |

Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн иргэдийн тоо жил дараалан буурч байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо мөн буурч, өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 5.5 хувиар буурсан байна.

## 13.ХЯНАЛТ ШАЛГАЛТ

НД-ын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, өмнөх онд хийгдсэн хяналт шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

### 13.1 Дээд газрын хяналт, шалгалт

НДҮЗ-өөс МХ, ОНХЗ-тэй хамтран Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9, НДҮЗ-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн НДГ-дад НД-ын хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, НД-ын асуудлаар шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээлэлд тулгуурлан дүгнэлт, зөвлөмж гаргах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар ЗГ, НДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагаа, АО, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөмж, дүгнэлт өглөө.

### 13.2 Төлөвлөгөөт хяналт, шалгалт

Нэг.НД-ын багц хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Дундговь, Сэлэнгэ, Завхан, Орхон аймаг, Багахангай, Чингэлтэй дүүргийн НДГ-т төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2018-2024 оны үйл ажиллагааг хамруулан НДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгаж, ердийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгосон нийт 17015 иргэний тэтгэврийн тогтоолт, олголтын үндэслэл, мөн давхардсан тоогоор нийт 234791 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд тулгуурлан шалгалаа.

*Хүснэгт 27. Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн тоон үзүүлэлт*

| № | Шалгалт хийсэн аймаг, дүүрэг | Шалгалтад хамрагдсан огноо | Санхүүгийн жил | Хувийн хэргийн тооллого | Тэтгэвэр-ийн олголт /цахим/ | Шинэ болон нөхцөлийн тэтгэврийн тогтоолт | Тэтгэмж | | Шимтгэлийн тайлан авалт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Цахим | Цаас | Цахим | Цаас |
| 1 | Багахангай | 2022-2024 | 3 | 830 | 2319 | 256 | 61 | 605 | 13 | 183 |
| 2 | Дундговь | 2018-2023 | 6 | 349 | 50577 | 2705 | 897 | 15946 | 16 | 532 |
| 3 | Чингэлтэй | 2022-2024 | 3 | 1165 | 77210 | 6831 | 1031 | 41046 | 10337 | 6700 |
| 4 | Сэлэнгэ | 2023-2024 | 2 | 1140 | 42637 | 4084 | 381 | 12933 | 98 | 490 |
| 5 | Завхан | 2023-2024 | 2 | 639 | 27088 | 2199 | 287 | 3521 | 177 | 712 |
| 6 | Орхон | 2019-2023 | 5 | - | 34960 | 940 | - | - | 2112 | - |
| | **Дүн** | **2018-2024** | **21** | **4123** | **234791** | **17015** | **2657** | **74051** | **12753** | **8617** |

Дээрх аймаг, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 947 ААНБ-ын (давхардсан тоогоор) нийт 21370 удаагийн шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч баталгаажуулсан байдал, ажилгүйдлийн даатгалын сангаас 2657 даатгуулагчид олгосон тэтгэмжийн үндэслэл, тэтгэмжийн даатгалын сангаас 74051 даатгуулагчид олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг анхан шатны баримт болон мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй тус тус тулган шалгав.

Хяналт шалгалтаар тэтгэврийн даатгалын сангаас нэр бүхий 236 иргэдэд тэтгэврийг илүү тооцож олгосон нийт 339.0 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 216 иргэнд дутуу тооцож олгосон 142.2 сая төгрөгийг нөхөн олгуулахаар, хуурамч бичиг баримт бүрдүүлж, үндэслэлгүйгээр тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 123 иргэнтэй холбоотой 3.0 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, нийт төлбөрийн 71.2 хувийг барагдуулаад байна.

*Хүснэгт 28. Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчил /сая.төгрөг/*

| № | Шалгалт хийсэн аймаг, дүүрэг | Тэтгэврийн даатгалын сан | | Тэтгэмжийн даатгалын сан | | Бичиг баримтын зөрчилтэй зогсоох актын дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Сэлэнгэ | 34 | 19,9 | 5 | 6,9 | 48 | 2,141.6 |
| 2 | Завхан | 122 | 92,3 | 1 | 0,8 | 14 | 311,03 |
| 3 | Орхон | 11 | 2,6 | - | - | 10 | 220,1 |
| 4 | Дундговь | 15 | 19,6 | 14 | 7,3 | 1 | 16,4 |
| 5 | Чингэлтэй | 252 | 321,2 | 9 | 2,8 | 9 | 222,5 |
| 6 | Багахангай | 18 | 25,6 | 3 | 2,4 | 3 | 118,5 |
| | **Нийт дүн** | **452** | **481.2** | **32** | **20.2** | **123** | **3,030.1** |

Хоёр.НД-ын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулиудад хяналт шалгалт хийж, 184 ААНБ хамрагдсанаас зөрчилгүй 92 АО-д зөвлөмж өгч, 92 ААНБ-д 4.1 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос 889.0 сая төгрөгийн шимтгэл, 436.5 сая төгрөгийн алданги, нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, 81.0 хувийг барагдуулав.

Гурав.Аймаг, дүүргийн НДГ-тай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн 719 ААНБ-ыг шалгаж, үүнээс 463 АО-д зөвлөмж өгч, 256 ААНБ-д 1.1 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос 208.1 сая төгрөгийн НДШ, 90.4 сая төгрөгийн алданги, 15.3 сая төгрөгийн торгууль, нийт 313.7 сая төгрөгийн акт, алданги тогтоож, 51.2 хувийг барагдуулсан байна.

Дөрөв.Хөндлөнгийн хяналт, шалгалтаар аймаг, дүүргийн НДГ-ууд 2024 оны жилийн эцсийн байдлаар 993.4 сая төгрөгийн төлбөр, зөрчлийн авлагатай байсан бол 1.1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 800.3 сая төгрөгийг барагдуулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тав.Дотоодын хяналт шалгалтаар 21 аймаг, 9 дүүргийн НДГ нь 2025 оны эхэнд 5.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 15.6 тэрбум төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, нийтдээ 21.4 тэрбум төгрөгийн төлбөр зөрчлөөс 11.9 тэрбум төгрөгийн авлага барагдуулж, НДС-д төвлөрүүлэн 2025 оны жилийн эцсийн байдлаар 9.5 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 29. Дотоодын хяналт, шалгалтын тайлангийн нэгтгэл*

| № | Аймаг, дүүргийн нэр | Оны эхний үлдэгдэл | Тайлангийн хугацаанд | | Жилийн эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| | | | Шалгаж илрүүлсэн төлбөрийн дүн | Барагдуулсан төлбөрийн дүн | |
| 1 | Архангай | 545,505.3 | 176,748.3 | 373,562.3 | 348,691.3 |
| 2 | Баян-өлгий | 1,967.7 | 660,596.4 | 517,393.4 | 145,170.7 |
| 3 | Баянхонгор | 87,877.0 | 189,108.1 | 194,201.1 | 82,784.0 |
| 4 | Булган | 90,347.3 | 213,768.3 | 233,202.1 | 70,913.5 |
| 5 | Говь-Алтай | 14,600.0 | 131,617.0 | 141,318.6 | 4,898.4 |
| 6 | Говьсүмбэр | 10,907.9 | 181,478.7 | 76,170.8 | 116,215.8 |
| 7 | Дархан-Уул | 292,459.31 | 293,206.4 | 237,266.8 | 3,483,98.91 |
| 8 | Дорноговь | 98,944.5 | 947,476.2 | 239,415.5 | 807,005.2 |
| 9 | Дорнод | 30,433.1 | 171,608.1 | 137,167.3 | 64,873.9 |
| 10 | Дундговь | 2,814.2 | 197,679.5 | 99,445.2 | 101,048.5 |
| 11 | Завхан | 336,607.5 | 446,329.4 | 419,705.6 | 363,231.3 |
| 12 | Орхон | 25,308.5 | 564,529.6 | 411,588.8 | 178,249.3 |
| 13 | Өвөрхангай | 84,056.5 | 185,145.3 | 187,951.7 | 81,250.1 |
| 14 | Өмнөговь | 29,941.2 | 257,262.9 | 255,826.3 | 31,377.8 |
| 15 | Сүхбаатар | 24,538.0 | 687,624.2 | 275,281.7 | 436,880.5 |
| 16 | Сэлэнгэ | 218,596.0 | 1,185,482.3 | 809,068.5 | 595,009.8 |
| 17 | Төв | 62,682.7 | 179,326.8 | 156,681.2 | 85,328.3 |
| 18 | Увс | 47,999.0 | 266,335.2 | 245,302.0 | 69,032.2 |
| 19 | Ховд | 228,786.7 | 188,191.2 | 206,270.8 | 210,707.1 |
| 20 | Хэнтий | 41,471.3 | 324,284.0 | 290,872.4 | 74,882.9 |
| 21 | Хөвсгөл | 225,126.1 | 102,587.7 | 131,000.8 | 19,6713 |
| 22 | Багануур | 518,791.7 | 145,650.6 | 118,785.8 | 545,656.5 |
| 23 | Багахангай | 28,760.0 | 164,194.8 | 38,611.0 | 154,343.8 |
| 24 | Баянгол | 453,603.6 | 1,148,884.8 | 947,467.7 | 655,020.7 |
| 25 | Баянзүрх | 1,188,574.7 | 1,016,066.4 | 1,192,523.5 | 1,012,117.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 26 | Налайх | 12,360.6 | 186,448.2 | 126,566.6 | 72,242.2 |
| 27 | Сонгинохайрхан | 238,293.9 | 1,328,603.9 | 868,549.1 | 698,348.7 |
| 28 | Сүхбаатар | 356,955.4 | 1,504,681.2 | 1,285,518.1 | 576,118.5 |
| 29 | Хан-Уул | 194,456.0 | 1,020,198.6 | 675,309.8 | 539,344.8 |
| 30 | Чингэлтэй | 300,875.2 | 1,528,858.4 | 1,043,266.6 | 7,864,67.05 |
| | **Дүн** | **5,793,640.9** | **15,593,972.5** | **11,935,291.1** | **9,452,322.4** |

Зургаа.ТДС-ийн эрсдэлээс хамгаалах, цахим хяналт, шалгалтаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, төлбөрийг сүүлийн 3 жилийн хугацаанд гаргуулаагүй нийт 31647 (давхардсан тоогоор) тэтгэвэр авагчийн судалгааг гаргуулан аймаг, дүүргээр ангилан, нийт 24372 тэтгэвэр авагч нарын мэдээллийг хүргүүлж, 25 тэтгэвэр авагчтай холбоотой 195.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, илүү авсан 140.8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг 72.2 хувиар барагдуулсан байна. Мөн МУ-ын харьяатаас гарсан 25 иргэдийн нийт 379.8 сая төгрөгийн тэтгэвэр олголтын үндэслэлийг шалгаж, 5 тэтгэвэр авагчид илүү олгогдсон нийт 29.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт тогтоож, зөрчлийг бүрэн барагдуулсан.

### 13.3 Төлөвлөгөөт бус хяналт, шалгалт

Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн НДГ-т шалгалт хийж, НДШ төлөлтийн тайланг үндэслэлгүйгээр хуурамчаар тайлагнасан нийт 58 АО-той холбоотой 487 хүний 34.3 тэрбум төгрөгийн цалин хөлсийг мэдээллийн санд илүү бүртгэсэн зөрчлийг илрүүлсэн бөгөөд зөрчил илэрсэн АО-ийн жагсаалтыг гарган Тагнуулын ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт тус тус хүргүүлэн шалгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, СЗХ, Татварын ерөнхий газартай хамтарсан “Финанс мониторинг” нэгдсэн арга хэмжээний хүрээнд ББСБ-дын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 60 ББСБ-дыг хамруулж, нийт 35 ББСБ-ын НДШ-ийг дутуу тооцсон 719.6 сая төгрөгийн ЦХТАО-д ногдох 171.0 сая төгрөгийн шимтгэл, 77.6 сая төгрөгийн алданги, нийт 248.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, төлбөр зөрчлийг 100.0 хувь барагдуулан ажиллалаа. Мөн НДШ ногдох их хэмжээний орлогыг нуусан байж болзошгүй үндэслэлээр 5 ББСБ-ын 302 даатгуулагчид олгосон 1.2 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос НДШ дутуу тооцсон зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шалгуулж байна.

### 13.4 Нийгмийн хамгааллын хяналт, шалгалт

Нийгмийн хамгааллын чиглэлээр хийгдсэн төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад зөрчлийн 3 хэрэг нээж шалган шийдвэрлэсэн бол хялбаршуулсан журмаар 75 зөрчил шалган шийдвэрлэж, 52.4 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулав. Тайлангийн хугацаанд нийт 3228 зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 925.9 сая төгрөгийн нөхөн төлбөрийн акт тогтоож, 1193 заалттай 243 хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Мөн 132

ААНБ-ын НДШ-ийн 6.5 тэрбум төгрөгийн өр төлбөрөөс 65 ААНБ-ын 1.5 тэрбум төгрөгийн НДШ-ийн өр төлбөрийг бүрэн болон хэсэгчлэн барагдууллаа. Үүнд:

Нэг.Их, дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн цахилгаан, эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх, дамжуулах болон боловсруулах үйлдвэрлэлийн 273 ААНБ-ыг хамруулан хяналт шалгалт хийж, нийт 1456 зөрчил илрүүлж, 636 заалт бүхий улсын байцаагчийн 146 хугацаатай албан шаардлагыг хүргүүлснээс 544 заалт буюу 85.5 хувь нь биелэгдсэн байна. Мөн 114 даатгуулагчтай холбоотой 63.6 сая төгрөгийн НДШ, алданги нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн 91 акт тогтоож, нийт төлбөр зөрчлийн 67.5 хувь буюу 42.9 сая төгрөгийг НДС-д нөхөн төлүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 21 ААНБ-д 23.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, 100 хувь барагдуулсан.

Хоёр.Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын бүрдүүлэлт, зарцуулалтад 21 аймаг, 9 дүүргийн НДГ-ыг хамруулж, ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон 591 даатгуулагчийн 550.6 сая төгрөгийн тэтгэмжийг НДС-д буцаан төвлөрүүлэх тухай улсын байцаагчийн 27 акт тогтоож, дутуу олгосон 262 даатгуулагчийн 141.9 сая төгрөгийг даатгуулагчдад нөхөн олгох тухай улсын байцаагчийн 18 акт тогтоож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай давхардсан тоогоор 55 заалттай улсын байцаагчийн 18 албан шаардлагыг 13 аймаг, 5 дүүргийн НДГ-т хүргүүлэв. Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн нийт 692.5 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс барагдуулалт 301.1 сая төгрөг буюу 43.5 хувийн гүйцэтгэлтэй байна.

*Хүснэгт 30. Ажилгүйдлийн даатгалын сангийн илэрсэн зөрчил*

| № | Аймаг, дүүргийн НДГ | Илүү олгосон | | Дутуу олгосон | | Нийт зөрчил | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчил | Мөнгөн дүн | Зөрчил | Мөнгөн дүн | Зөрчил | Мөнгөн дүн |
| 1 | Баян-Өлгий | 7 | 9,232,429.0 | 1 | 1,762,327.0 | 8 | 10,994,756.0 |
| 2 | Баянхонгор | 9 | 9,764,077.0 | 5 | 2,392,801.0 | 14 | 12,156,878.0 |
| 3 | Говь-Алтай | 17 | 4,810,628.0 | 10 | 3,811,969.0 | 27 | 8,622,597.0 |
| 4 | Говьсүмбэр | 22 | 27,566,071.0 | - | - | 22 | 27,566,071.0 |
| 5 | Дархан-Уул | 11 | 6,839,607.0 | - | - | 11 | 6,839,607.0 |
| 6 | Дорноговь | 16 | 12,094,084.1 | - | - | 16 | 12,094,084.1 |
| 7 | Дорнод | 21 | 25,389,691.0 | 3 | 3,103,080.0 | 24 | 28,492,771.0 |
| 8 | Дундговь | 5 | 4,621,371.0 | - | -- | 5 | 4,621,371.0 |
| 9 | Завхан | 26 | 16,525,260.9 | 8 | 7,157,469.3 | 34 | 23,682,730.2 |
| 10 | Орхон | 28 | 30,387,320.0 | 18 | 21,641,229.0 | 46 | 52,028,549.0 |
| 11 | Өмнөговь | 14 | 15,397,740.0 | 12 | 10,784,992.0 | 26 | 26,182,732.0 |
| 12 | Сүхбаатар | 12 | 11,073,151.0 | 38 | 9,773,118.0 | 50 | 20,846,269.0 |
| 13 | Сэлэнгэ | 30 | 33,192,370.5 | 12 | 8,770,501.2 | 42 | 41,962,871.6 |
| 14 | Төв | 64 | 37,746,819.9 | 39 | 23,962,631.4 | 104 | 62,474,265.4 |
| 15 | Увс | 13 | 10,239,740.3 | 5 | 3,150,558.4 | 18 | 13,390,298.7 |
| 16 | Ховд | 7 | 4,297,790.0 | 2 | 730,576.0 | 9 | 5,028,366.0 |
| 17 | Хөвсгөл | 10 | 13,068,110.7 | 18 | 9,033,655.0 | 28 | 22,101,765.7 |
| 18 | Хэнтий | 128 | 70,423,559.2 | 24 | 9,621,331.0 | 152 | 81,809,552.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | Багануур | 20 | 19,805,471.0 | 9 | 1,904,229.2 | 29 | 21,709,700.3 |
| 20 | Баянгол | 7 | 40,369,691.0 | 1 | 844,875.0 | 8 | 41,214,566.0 |
| 21 | Баянзүрх | 13 | 13,672,087.0 | - | - | 13 | 13,672,087.0 |
| 22 | Налайх | 15 | 9,614,203.9 | 46 | 17,391,881.2 | 61 | 27,006,085.1 |
| 23 | Сонгинохайрхан | 17 | 23,077,140.3 | 1 | 473,346.0 | 18 | 23,550,486.3 |
| 24 | Сүхбаатар | 2 | 2,036,962.0 | - | - | 2 | 2,036,962.0 |
| 25 | Хан-Уул | 17 | 28,495,944.0 | - | - | 17 | 28,495,944.0 |
| 26 | Чингэлтэй | 63 | 71,100,003.0 | 10 | 5,679,384.6 | 89 | 76,779,418.6 |
| | **Нийт** | **594** | **550,841,352.3** | **262** | **141,989,953.9** | **853** | **695,360,783.7** |

Гурав.Барилга угсралт, барилгын материал, үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 38 ААНБ-дад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчилд улсын байцаагчийн нийт 34.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийн 23 даатгуулагчтай холбоотой 3 акт, 200 заалт бүхий 32 хугацаатай албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 4.7 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 20 ААНБ-ын 211.8 сая төгрөгийн НДШ-ийн хуримтлагдсан өрнөөс 10 ААНБ-ын 102.4 сая төгрөгийг барагдуулсан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны бүтээгдэхүүн худалдаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй ААНБ-дад хийсэн хяналт шалгалтаар илэрсэн 345 зөрчил дутагдалд давхардсан тоогоор нийт 200 заалт бүхий улсын байцаагчийн 33 хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, 111 заалт буюу 32.1 хувь нь биелсэн бол 370 ажилтантай холбоотой 222.4 сая төгрөгийн ЦХТАО-оос тооцсон 57.3 сая төгрөгийн шимтгэл, алдангийн хамт акт тогтоож, уг төлбөрийг НДС-д бүрэн төлүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 7 байгууллагад 8.5 сая төгрөгийн торгох шийтгэл ногдуулж, бүрэн барагдуулсан. Мөн 9 ААНБ-ын нийт 189.7 сая төгрөгийн НДШ-ийн хуримтлагдсан өрийг хянан шалгаж, 185.5 сая төгрөгийг НДС-д төлүүлж, өр авлагыг бүрэн барагдуулав.

## 14. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ

### 14.1 Мэдээллийн ил тод байдал

НДБ-ууд цахим хуудсандаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 27 төрлийн 54 мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах үүрэгтэй. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт;
- Хүний нөөц;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа;
- Ажил, үйлчилгээ;
- Бусад.

*Хүснэгт 31. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хувиар/*

| Мэдээлэл байршуулалт | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|
| Салбарын хэмжээнд | 69.8 | 81.4 | 90.2 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 90.7 | 92.8 | 90.4 |

НДБ-дын мэдээллийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 90.2 хувьтай байна. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал - 90.4;
- Хугацаандаа нийтлэгдсэн байдал - 97.1;
- Мэдээллийн бүрэн бүтэн байдал - 93.2;
- Эх сурвалжийн тодорхой байдал – 83.0 хувиар тус тус үнэлэгдсэн.

### 14.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу НДБ-ууд нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 11340 мэдээллийг байршуулахаас 11250 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 90 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба мэдээлэл байршуулалт 100.0 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.2 хувьтай байна.

*Хүснэгт 32. Мэдээлэл байршуулалт /тоо, хувиар/*

| Үзүүлэлт | Нийт мэдээлэл | Хугацаанд нь мэдээлсэн | Хугацаа хоцорсон | Нийт мэдээлэл байршуулалт | Хугацаандаа байршуулсан |
|---|---|---|---|---|---|
| НДС | 5484 | 5456 | 28 | 100.0 | 99.5 |
| НДБ-ын үйл ажиллагаа | 5856 | 5794 | 62 | 100.0 | 98.9 |
| **Дүн** | **11340** | **11250** | **90** | **100.0** | **99.2** |

НДС-ийн мэдээлэл байршуулалт 100.0, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.5 хувьтай байгаа бол байгууллагын санхүү, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт 100.0 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 98.9 хувьтай байна.

### 14.3 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах

2025 онд салбарын хэмжээнд албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 3153 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46908 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулав.

Иргэд, даатгуулагч, АО-д НД-ын багц хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг сурталчлан таниулах, тэдний ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 3775 удаагийн танхимын болон цахим сургалтыг давхардсан тоогоор 18473 ААНБ-ын 208458 иргэд, даатгуулагчийг хамруулан зохион байгуулан ажилласан.

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран Унгар, Бельги, Чех, Австри улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдэд НД-ын ач холбогдол, сайн дураар даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөөг хүргэв.

НДЕГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу МХ, ОНХЗ-ны гишүүд хамтран "Нийгмийн даатгалын авлагын менежмент" сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулан явууллаа. Сургалтад аймаг, дүүргийн НДГ-ын дарга, шимтгэл хураалт, өр авлага хариуцсан байцаагч зэрэг нийтдээ 423 албан хаагчдыг оролцуулж, НДШ-ийн авлагыг барагдуулах арга зүй, олон улсын туршлага

сургамж, авлагад нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны үр дүнгийн чиглэлээр хичээл бэлтгэж заасан бөгөөд цаашид авлагыг барагдуулах талаар төв, орон нутгийн НДБ-ын анхаарах асуудлын талаар зөвлөмж гаргав.

НД-ын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор НДЕГ-ын цахим хуудас болон @sigomongolia сошиал хуудсаар дамжуулан рийл 42, стори рийл 8, постер мэдээлэл 370, контент 16, 2D видео контент 2, 3D видео контет 2, цаг үеийн мэдээ, мэдээлэл 237, шууд дамжуулалт 4, нийт 681 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн бөгөөд давхардсан тоогоор хандалт 25.2 сая хүнд хүрч 97115 удаа түгээсэн байна.

Хэвлэл мэдээллийн 45 байгууллагаар 470 /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар НД-ын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан.

**14.4 Лавлах үйлчилгээ**

НД-ын үйлчилгээний лавлах утсанд нийт 703.2 мянган дуудлага ирснээс 537.6 мянган иргэд, даатгуулагч мэдээллийн ажилтантай холбогдон мэдээлэл авсан бол автомат хариулагчаас 26.6 мянган иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон байна.

Тайлант хугацаанд иргэд, даатгуулагчдаас цахимаар нийтдээ 6510 санал хүсэлт, асуулт, үүнээс www.ndaatgal.mn аппликейшний "Санал хүсэлт" булангаар дамжуулан 1096 санал хүсэлт, sanal@ndaatgal.mn вэб хуудсаар 438, 3Г-ын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 4976 асуулт ирснийг ажлын 5 хоногт багтаан хариуг тэдний утсаар болон цахим хаягаар нь хүргүүлсэн.

## 15.ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛ

Тайлангийн хугацаанд гадаад харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлээ улам өргөжүүлж, иргэд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, харилцан НДШ төлсөн жилийг тооцож, тэтгэвэр, тэтгэмж авах, давхардлыг арилгахад чиглэгдсэн гэрээ хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, шинээр байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажилллалаа.

Холбогдох гэрээ хэлэлцээрүүдийн дагуу:

- Бүгд Найрамдах Солонгос улсад НДШ төлсөн 53 иргэний 254.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичиг;
- Бүгд Найрамдах Чех улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 95 иргэний МУ-д НД-ын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 41 иргэний даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлт;
- Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 8 иргэний мэдээлэл;
- Оросын Холбооны Улсад ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 73, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 48 иргэний ажилласан жилийн тодорхойлолт;
- Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 32, тус улсаас өндөр насны тэтгэвэр авагч 25 иргэний оршин суугаа газрын

хаягийн баталгаажуулалт, МУ-д шимтгэл төлж, ажилласан жилийг баталгаажуулах хүсэлт гаргасан 30 иргэний хүсэлт;
- Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох 1 хүний мэдээллийг тус тус холбогдох улсын хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудад хүргүүллээ.

Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсуудтай НД-ын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

## 16.ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

### 16.1 Хүний нөөц

ЗГ-ын 2025 оны 52, НДҮЗ-ийн 14 дүгээр тогтоол болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/163 дугаар тушаалаар АА 9 орон тоотой, НДЕГ 6 газар, 5 хэлтэстэй, НДБ-ууд 1341 орон тоотой ажиллахаар батлагдсан бөгөөд үүнээс төрийн захиргааны албан хаагч 1111, төрийн үйлчилгээний албан хаагч 230 байна.

*Хүснэгт 33. НД-ын салбарын албан хаагчдын бүтэц, албан тушаалын ангилал /тоо, хувиар/*

| № | Албан тушаалын ангилал | Тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Удирдах албан тушаалтан | 155 | 11.56 |
| 2 | Гүйцэтгэх албан тушаалтан | 1186 | 77.44 |
| | Нийт | 1341 | 100.0 |

| № | Төрийн албан тушаалын ангилал | Тоо |
|---|---|---|
| 1 | Төрийн захиргааны албан хаагч | 1113 |
| 2 | Төрийн үйлчилгээний албан хаагч | 228 |
| 4 | Үүнээс: Улсын байцаагч | 627 |

2025 оны жилийн эцсийн байдлаар НД-ын салбарын хэмжээнд 1285 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас 71.7 хувь буюу санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 921, 9.6 хувь буюу эрх зүйч 124, 18.7 хувь буюу бусад мэргэжлийн 240 албан хаагч байна. Боловсролын хувьд доктор 3, магистр 112, бакалавр 1097 албан хаагч ажиллаж байна.

*Хүснэгт 34. НД-ын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил, нас хүйсийн мэдээлэл*

| № | Боловсрол | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Доктор | 3 | Эдийн засагч | 349 |
| 2 | Магистр | 112 | Нягтлан бодох бүртгэл, татвар | 355 |
| 3 | Бакалавр | 1097 | Санхүү, банк, даатгал | 217 |
| 4 | Бусад | 73 | Эрх зүйч | 124 |
| | | | Бусад | 240 |

| № | Нас | Тоо | Хүйс | Тоо |
|---|---|---|---|---|
| 1 | 30 хүртэлх | 150 | Эрэгтэй | 232 |
| 2 | 31-40 | 528 | Эмэгтэй | 1053 |
| 3 | 41-50 | 439 | - | - |
| 4 | 51-60 | 168 | - | - |

### 16.2 Үйл ажиллагааны зардал

НДБ-ын урсгал үйл ажиллагааны зардалд 2025 онд 67.4 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 62.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

График 19. НДБ-ын үйл ажиллагааны зардал /тэрбум.төг/




Тайлант хугацаанд дараах зардлуудыг олгосон. Үүнд:

- Бусад урсгал шилжүүлэг – 2,081.4 сая төгрөг
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ – 137.8 сая төгрөг
- Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс – 148.3 сая төгрөг
- Харуул, хамгаалалт – 102.2 сая төгрөг
- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардал – 1,705.9 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.

## 17. ДҮГНЭЛТ

НДҮЗ нь тайлант хугацаанд НД-ын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого", ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, "Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил"-ийн зорилтуудыг хэрэгжүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

НДБ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 9 зорилт, 69 арга хэмжээний биелэлт 94.8 хувь буюу "Бүрэн хангалттай" хэрэгжсэн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар НДС-ийн орлого 5,455.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,231.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлж, 723.5 мянган хүнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 5,848.5 тэрбум төгрөг зарцуулж, гүйцэтгэл 99.6 хувьтай байна.

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон НД-ын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, АО, харилцагч байгууллагуудад НД-ын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Мэдээллийн нэгдсэн системээр 259.2, Portal.ndaatgal.mn системээр 216.2, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган АО-ийн НДШ-ийн тайланг цахимаар хүлээн авч 98.0 хувийг шийдвэрлэлээ. НД-ын 81 үйлчилгээнээс 46 үйлчилгээ бүрэн цахимжуулсан байна.

Тайлангийн хугацаанд ЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэл, НДҮЗ-ийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилт 94.2 хувьтай байна.

Эндээс үзэхэд тайлангийн хугацаанд НДБ-уудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, ажил үүргийг зохих түвшинд биелэгдсэн байна.

Цаашид НД-ын багц хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулан НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг сайжруулах, тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх санхүүжилтийн хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, даатгуулагч бодит хуримтлалтай болох, хуримтлалаа эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд зарцуулах, тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу нэмэлт тэтгэвэр авах, тэтгэврийг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалин хөлсөнд итгэлцүүрийг хэрэглэх, тэтгэмж авах нөхцөлийг сайжруулах, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

НДБ 2026 оныг "Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх жил" болгон НД-ын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн төрлийг нарийвчлан тогтоох, АО-д шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, шимтгэлийн нөхөн төлөх НДС-ийн менежментийг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэд, даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчинг бүрдүүлэх, МХ, ОНХЗ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, НДС-ийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллах зорилт тавьж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ

# СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ᠨᠡᠶᠢᠭᠡᠮ ᠦᠨ ᠳᠠᠭᠠᠲᠭᠠᠯ ᠤᠨ ᠦᠨᠳᠦᠰᠦᠨ ᠦ ᠵᠥᠪᠯᠡᠯ ᠰᠢᠰᠲ᠋ᠧᠮᠴᠢᠯᠡᠭᠰᠡᠨ ᠦᠨᠡᠯᠡᠭᠡᠨ ᠦ ᠲᠠᠢᠯᠤᠨ

Улаанбаатар хот

2026 он

# АГУУЛГА


ӨМНӨХ ҮГ

1. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ
2. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ
3. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
   - 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт
   - 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа
     - 3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт
     - 3.2.2 Мэргэжлийн хорооны үйл ажиллагаа
   - 3.3 Эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, хяналт
   - 3.4 Үндсэн үйл ажиллагаа
     - 3.4.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл
     - 3.4.2 Нийгмийн даатгалын сангийн орлого
     - 3.4.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт
     - 3.4.4 Нийгмийн даатгалын хамралт
     - 3.4.5 Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал
     - 3.4.6 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага
     - 3.4.7 Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэлт
     - 3.4.8 Нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл, шимтгэлийн өр, авлага
     - 3.4.9 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа
     - 3.4.10 Эрүүл мэндийн магадлал
     - 3.4.11 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах
     - 3.4.12 Хяналт шалгалт
     - 3.4.13 Мэдээллийн ил тод байдал
     - 3.4.14 Лавлах үйлчилгээ
     - 3.4.15 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа
     - 3.4.16 Хүний нөөц
     - 3.4.17 Үйл ажиллагааны зардал
     - 3.4.18 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
4. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ
5. ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ
6. УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| Товчлол | Тайлал |
|---|---|
| АА | Ажлын алба |
| ААНБ | Аж ахуйн нэгж, байгууллага |
| АО | Ажил олгогч |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ГБХНХЯ | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| ЗГ | Засгийн газар |
| КБЭХА | Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагч |
| МБ | Монголбанк |
| МУ | Монгол улс |
| МУИС | Монгол улсын их сургууль |
| МХ | Мэргэжлийн хороо |
| МҮЭХ | Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо |
| МҮОНРТ | Монголын үндэсний олон нийтийн радио телевиз |
| НД | Нийгмийн даатгал |
| НДБ | Нийгмийн даатгалын байгууллага |
| НДГ | Нийгмийн даатгалын газар |
| НДЕГ | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| НДС | Нийгмийн даатгалын сан |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НДҮЗ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл |
| НДСЧҮ | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл |
| ОНХЗ | Олон нийтийн хяналтын зөвлөл |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СЭЗИС | Санхүү, эдийн засгийн их сургууль |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ТДНД | Тэтгэврийн даатгалын нэрийн данс |
| ТДС | Тэтгэврийн даатгалын сан |
| ТНС | Тэтгэврийн нөөц сан |
| ХААИС | Хөдөө аж ахуйн их сургууль |
| ХЧТА | Хөдөлмөрийн чадвар түр алдалт |
| ЦХТАО | Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ


| Хүснэгтийн дугаар | Хүснэгтийн нэр |
|---|---|
| Хүснэгт 1. | Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө |
| Хүснэгт 2. | НДҮЗ-ийн баталсан тогтоол |
| Хүснэгт 3. | МХ-ны хуралдааны мэдээлэл |
| Хүснэгт 4. | Бодлогын баримт бичгийн хэрэгжилт |
| Хүснэгт 5. | Хууль, тогтоол, шийдвэрийн биелэлт |
| Хүснэгт 6. | НДС-ийн орлогын биелэлт, төрлөөр |
| Хүснэгт 7. | НДС-ийн орлогын гүйцэтгэл, сангаар |
| Хүснэгт 8. | НДС-ийн зарлагын гүйцэтгэл, сангаар |
| Хүснэгт 9. | НДС-аар үйлчлүүлсэн хүний тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 10. | Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 11. | Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 12. | ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| Хүснэгт 13. | Үнэт цаасны хүүгийн тооцоолол |
| Хүснэгт 14. | Хуралдаан, уулзалтын мэдээлэл |
| Хүснэгт 15. | ТНС-ийн харилцах дансны үлдэгдэл |
| Хүснэгт 16. | 2025 оны жилийн эцсийн авлага барагдуулалтын мэдээ |
| Хүснэгт 17. | НД-ын санхүүжилт 2020-2025 он |
| Хүснэгт 18. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон хүний тоо |
| Хүснэгт 19. | Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байдал |
| Хүснэгт 20. | Хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан |
| Хүснэгт 21. | Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн тоон үзүүлэлт |
| Хүснэгт 22. | Шалгалтаар илэрсэн төлбөр зөрчил |
| Хүснэгт 23. | Дотоодын хяналт шалгалтын тайлангийн нэгтгэл |
| Хүснэгт 24. | Мэдээллийн ил тод, нээлттэй байдал |
| Хүснэгт 25. | НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо |
| Хүснэгт 26. | НД-ын салбарын албан хаагчдын боловсрол, мэргэжил, нас, хүйсийн мэдээлэл |
| Хүснэгт 27. | Мэдээлэл байршуулалт |

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ



| Графикийн дугаар | Графикийн нэр |
|---|---|
| График 1. | Системчилсэн үнэлгээний үе шат |
| График 2. | НДБ-ын тогтолцоо |
| График 3. | МХ-ны бүтэц, бүрэлдэхүүн |
| График 4. | НДС-ийн төсөв |
| График 5. | НДС-ийн орлогын бүтэц, эзлэх хувь |
| График 6. | НД-ын хамралт |
| График 7. | Тэтгэврийн зарлага |
| График 8. | Тэтгэвэр авагчдын бүтэц |
| График 9. | Тэтгэврийн хэмжээ |
| График 10. | Тэтгэмжийн зарлага |
| График 11. | ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага |
| График 12. | Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн |
| График 13. | НДС-ийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого |
| График 14. | Хуримтлалын сангийн бүтэц |
| График 15. | НДС-ийн харилцах дансны үлдэгдэл |
| График 16. | НДШ-ийн өр, авлага |
| График 17. | НДБ-ын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл |

# ӨМНӨХ ҮГ



НДҮЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайланг танилцуулж байна.

НДҮЗ нь УИХ-аас томилогддог, НД-ын тогтолцооны удирдах дээд байгууллага бөгөөд 2025 онд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, НД-ын хууль тогтоомжуудад заасан бүрэн эрх, чиг үүргийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн НД-ын салбарыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд НДҮЗ нь НД-ын талаар төрөөс баримтлах бодлого, НД-ын багц хууль, холбогдох бусад хууль тогтоомж, УИХ, ЗГ-аас баталсан дунд болон урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд НД-ын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангахтай холбоотой дүрэм, журам, зөвлөмж, аргачлал, батлах, хяналт тавих, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт НД-ын чиглэлээр тусгагдсан зорилтын хэрэгжилтийг зохион байгуулах, НДС-ийн орлого, зарлага, НДС-ийн болон салбарын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг хэлэлцэх, дүгнэлт гаргах, НД-ын хамралтыг нэмэгдүүлэх, сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн зохицуулалтыг хийж, иргэн, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн НД-ын талаархи хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэгдсэн олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ.

НД-ын хууль эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулаад байгаа бөгөөд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг УИХ-д өргөн бариад байна. Энэхүү хуулийн төсөл нь МУ-д тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын, хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах юм.

НДС-д 2025 онд 5.2 их наяд төгрөгийн орлого хуримтлуулж, 723.5 мянган хүнд 5.8 их наяд төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олголоо. Жилийн эцсийн байдлаар НД-ын мэдээллийн санд 63.8 мянган АО, 1.2 сая албан журмаар, 170.0 мянган сайн дураар даатгуулагч бүртгэгдсэн нь НД-ын хамралт өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 6.0 хувиар нэмэгдүүлснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянган төгрөг, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээ 572.0 мянган төгрөг болж, дундаж тэтгэвэр 870.9 мянган төгрөгт хүрч, тэтгэврийн нэмэгдэлд 300.1 тэрбум төгрөг зарцуулсан. Мөн 0-3 насны хүүхдээ асарч байгаа 16.9 мянган эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 3.9 мянган эх /эцэг болон 55.2 мянган малчны тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс болон тэтгэмжийн даатгалын сангаас хариуцан төлж, нийгмийн даатгалд хамруулав. Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа 3.6 мянган хүний тэтгэврийн хэмжээг нас барсан нөхөр /эхнэр/-ийн авч байсан тэтгэврийн 20.0 хувиар нэмэгдүүлэв.

Тайлангийн хугацаанд НДСЧҮ-ээс 700.0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 15.0 хувийн хүүтэй байршуулснаар 70.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгийг арвижуулсан байна. ЗГ-ын үнэт цаасны хүүгийн орлого 27.0 тэрбум төгрөг орж, НДС-г нэмэгдүүллээ.

Нас барсан даатгуулагчийн болон амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг буяны зан үйлийн зардлын өсөлттэй уялдуулж 3.0-4.5 сая төгрөг болгон тус тус 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь тэдний гэр бүлд нь тохиолдсон санхүүгийн эрсдэлийг хуваалцах чухал шийдвэр болов.

НДҮЗ нь тайлангийн хугацаанд нийт 6 удаа хуралдаж, 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 25 тогтоол батлан гаргасан бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэх 4 тогтоолыг ЗХХАУНС-д бүртгүүлэв. МХ нийтдээ 7 удаа хуралдаж 13 асуудлыг хэлэлцэж, дүгнэлт зөвлөмж, санал гаргаж, холбогдох газруудад хүргүүлсэн байна. ОНХЗ 5 удаа хуралдаж, 16 дүгнэлт, 22 зөвлөмжийг гаргаж, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаа, НДС-ийн болон НДБ-ын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллалаа.

НД-ын харилцаанд оролцогч, хамтран ажилласан ЗГ, АО, даатгуулагч талуудад талархал дэвшүүлье.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Т.АУБАКИР

## 1. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХЭЛБЭР, ТӨРӨЛ

УИХ-ын Төрийн байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу НДҮЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хууль зүйн яам /хуучин нэрээр/-наас боловсруулсан "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу гаргаж, үнэлгээ хийсэн болно.

*График 1. Системчилсэн үнэлгээний үе шат*

БЭЛТГЭЛ ТӨЛӨВЛӨЛТ

↓

ҮНЭЛЭХ АЖИЛЛАГАА

↓

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ТОГТООХ ҮНЭЛГЭЭ

↓

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХАРЬЦУУЛАЛТ

↓

ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ, ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

*Системчилсэн үнэлгээний зорилго:*

Үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

*Системчилсэн үнэлгээний зорилт:*

Үнэлгээний зорилт нь байгууллагын дэвшүүлсэн зорилго, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, үр нөлөө болон тогтвортой байдлын уялдаа холбоо, хэрэгжилтийг тодорхойлж, бодит байдалд нийцсэн байдлаар төлөвлөсөн, хэрэгжиж буй болон хэрэгжсэн үйл ажиллагааг үнэлсэн болно.

*Системчилсэн үнэлгээний хэлбэр:*

Үнэлгээний хэлбэр нь хэрэгжсэн хөтөлбөр болон арга хэмжээнд өгөх хэрэгжилтийн үнэлгээ /ретроспектив/ болно.

*Системчилсэн үнэлгээний төрөл:*

Үнэлгээ нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгод ямар хэмжээнд хүрснийг тодорхойлоход чиглэх бөгөөд системчилсэн үнэлгээ хийхдээ "Дотоодын буюу өөрийн байгууллагын үнэлгээ"-ний хэлбэрийг сонгож, дараах чиглэлээр үнэлгээ хийлээ. Үүнд:

- Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт.
- НДҮЗ-ийн үйл ажиллагаа.
- Үндсэн үйл ажиллагаа.

## 2. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙХ БЭЛТГЭЛ АЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТ

*Үнэлгээнд оролцогч байгууллагуудын цар хүрээ:*

- НДҮЗ-ийн АА;
- НДЕГ;
- Эрүүл мэндийн магадлалын төв, салбар зөвлөлүүд;
- Мэдээлэл технологийн төв;
- Аймгийн НДГ;
- Дүүргийн НДГ;
- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн НД-ын алба;
- Маргаан хянан шийдвэрлэх төв, салбар зөвлөлүүд;
- Мэргэжлээс шалтгаалсан өвчин судлалын төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг.

*Үнэлгээний зорилго, хамрах хүрээг тодорхойлох:*

- Үнэлгээний зорилго, хамрах хүрээ нь байгууллагын бүх салбар, нэгжийн хүрээнд үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг бүх талаар тодорхойлоход чиглэсэн болно.

*Хүснэгт 1. Системчилсэн үнэлгээ хийх төлөвлөгөө*

| | Хугацаа | 2-р сар | 3-р сар | 4-р сар |
|---|---|---|---|---|
| | Хэрэгжүүлбэл зохих ажлууд | | | |
| Төлөвлөлтийн шат | Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлсон уулзалт хийх | | | |
| | Үнэлгээний баг бүрдүүлэх | | | |
| | Үнэлгээний төлөвлөгөө боловсруулах | | | |
| | Үнэлгээ хийх талаар НДЕГ-т албан бичиг хүргүүлэх | | | |
| | Тайлан гаргаж өгөх, НДЕГ-ын холбогдох албан тушаалтантай уулзах | | | |
| Үнэлгээний шат | Баримт бичигтэй танилцах | | | |
| | Тайлангийн талаар тодруулга, асуулга авах | | | |
| | Ярилцлага хийх | | | |
| | Дүн шинжилгээ хийх | | | |
| | Дүгнэлт гаргах | | | |
| | Тайлан гаргах | | | |
| | Зөвлөмж бичих | | | |
| | ГБХНХЯ-нд танилцуулж, санал авах | | | |
| | НДҮЗ-ийн гишүүдэд танилцуулж, санал авах | | | |
| | Гишүүд болон яамнаас ирсэн саналуудыг тусгаж, тайланг эцэслэн боловсруулж, гаргах | | | |
| | УИХ-ын Тамгын газар, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороонд хүргүүлэх | | | |

## 3. СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

### 3.1 Байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт "Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн даатгалын газар, сум, дүүргийн тасаг, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэнэ" гэж заасан.

НДҮЗ нь ЗГ, даатгуулагч, ажил олгогчийг төлөөлсөн нийт 9 гишүүнтэй бөгөөд ажлын алба нь 9 орон тоотойгоор НДҮЗ-ийн бүрэн эрх, үйл ажиллагаа хэвийн явуулах, НД-ын асуудлаар шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, судалгаа, дүгнэлт гаргуулах, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, туслах чиг үүрэгтэй ажиллаж байна. Мөн НДҮЗ-ийн дэргэд орон тооны бус 9 гишүүнтэй МХ, 7 гишүүнтэй ОНХЗ тус тус ажиллаж байна.

*График 2. НДБ-ын тогтолцоо*




Салбарын хэмжээнд НД-ын бодлогын хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий нийт 1285 алба хаагч, улсын байцаагчид ажиллаж байна.

### 3.2 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа

НДҮЗ нь тайлант хугацаанд төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг удирдлага болгож, НД-ын хууль тогтоомжид заасан бүрэн эрхийнхээ хүрээнд НД-ын талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллалаа.

#### 3.2.1 Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын хэрэгжилт

НДҮЗ нь 2025 онд нийт 6 удаа хуралдан 29 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, 25 тогтоол батлан гаргасан. Эдгээр тогтоолуудаас нийтээр заавал дагаж мөрдүүлэх 4 тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгүүлэв.

*Хүснэгт 2. НДҮЗ-ийн баталсан тогтоол**

| Тогтоолын дугаар | Тогтоолын нэр |
|---|---|
| 01 | Журам батлах тухай. (Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гараани үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулсан журам) |
| 02 | Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг тогтоох тухай. |
| 03 | Төлөвлөгөө батлах тухай. (Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус мэргэжлийн хорооны 2025 оны ажлын төлөвлөгөө) |
| 04 | Төлөвлөгөө батлах тухай. (Орон тооны бус олон нийтийн хяналтын зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөө) |
| 05 | Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай. |
| 06 | Төлөвлөгөө батлах тухай. (Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө) |
| 07 | Хөрөнгийн хэмжээг тогтоох тухай. (НДСЧҮ-ээс арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгө) |
| 08 | Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг шинэчлэн батлах тухай. |
| 10 | Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай. |
| 11 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай. |
| 12 | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай. |
| 13 | Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай. |
| 15 | Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай. (Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө) |
| 19 | Журам шинэчлэн батлах тухай. (Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам) |
| 20 | Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай. |
| 21 | Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар шинэчлэн батлах тухай. (Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загвар) |
| 22 | Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар батлах тухай. (Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загвар) |
| 24 | Үндэсний зөвлөлийн дэд даргыг томилох тухай. |

*Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэгт заасан НДҮЗ-ийн дотоод зохион байгуулалт, зохицуулалтын шинжийг агуулсан тогтоолыг оруулаагүй болно.

*НДС-ийн хөрөнгийг өсгөн арвижуулав*

НДҮЗ-ийн 05, 07, 08 дугаар тогтоолуудаар МХ-ны эрсдэлийг тооцсон мэргэжлийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн 2025 онд НДСЧҮ-ээс мөнгөн хадгаламж хэлбэрээр арилжааны банканд байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар тус тус баталж өгсөн. Ингэснээр НДС-ийн хөрөнгийг 105.0 тэрбум төгрөгөөр арвижуулах боломж бүрдсэн бөгөөд тайлант оны 5-12 дугаар сарын хүү болох 70.2 тэрбум төгрөгөөр сангийн хөрөнгө нэмэгдлээ. ЗГ-ын үнэт цаасны хүү болох 27.0 тэрбум төгрөгийн өгөөжийг НДС-д оруулаад байна. Мөн НДҮЗ-ийн 22 дугаар тогтоолоор ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн гэрээний загварыг баталснаар ТНС-ийн хөрөнгийг арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж, тус хөрөнгийг арвижуулан өсгөх боломжийг хангаж өглөө.

НДҮЗ-ийн 2025 оны 13, 20 дугаар тогтоолуудаар НДҮЗ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу КБЭХА-аас 6.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 11, Чингис хаан банкнаас 2.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 8 ширхэг үл хөдлөх хөрөнгийг тус тус НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авснаар Капитал, Чингис хаан банкнаас авах НДС-ийн авлага багасаж, орлого нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

*НД-ын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалсан чухал шийдвэрүүдийг гаргав.*

Монголын “Буяны зан үйлийн холбоо” ТББ-ын гаргасан буяны үйл ажиллагаа эрхэлдэг 14 ААНБ-ын үнэ тарифын судалгаанаас үзэхэд үйлчилгээний дундаж үнэ 2.9-10.9 сая төгрөг байгаа нь нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгодог тэтгэмжээс 0.9-8.9 сая төгрөгөөр их байгаа юм. Иймд НДҮЗ-ийн 11 дүгээр тогтоолоор тэтгэмжийн хэмжээг буяны зан үйлийн зардлын өсөлттэй уялдуулж, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 3.0, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг 4.5 сая төгрөг болгон тус тус 1.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, шинэчлэн тогтоов. Ингэснээр нас барсан даатгуулагчийг оршоох, чандарлах дундаж зардлыг бүрэн, харьцангуй өндөр зардлын 30 орчим хувийг НДС-аас бүрдүүлж, гэр бүлд нь тохиолдсон санхүүгийн эрсдэлийг багасгах ач холбогдолтой шийдвэр болов.

НДС-аас даатгуулагчдад олгодог төлбөр, зардлын нэг нь ҮОМШӨ-ний даатгалын сангаас сэргээн засах сувиллын тусламж, үйлчилгээний ор хоногийн төлбөрийг олгодог явдал юм. Бараа бүтээгдэхүүний үнэ, ашиглалтын болон хэрэглээний зардлууд тогтмол өсч байгаатай холбоотойгоор одоо мөрдөгдөж байгаа ор хоногийн төлбөр нь нэг даатгуулагчийн сувилалд хэвтэн эмчлүүлэхэд гардаг бодит зардалд хүрэхгүй байна. Мөн ердийн рашаан, сувиллын үнэд судалгаа хийхэд нэг ор хоногийн дундаж үнэ нь 107.1-128.6 мянган төгрөг байна. Иймд ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжих сувилалд олгох нэг ор хоногийн зардлын

хэмжээг 110.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлж, даатгуулагчдад үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг авлаа.

ГБХНХЯ, ҮСХ-ны санал болон МХ-ны дүгнэлт, зөвлөмжид үндэслэн ТДНД-ны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.34 хувь, тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл "К" коэффициентийг 2025 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жил байхаар тогтоов. Өндөр насны тэтгэврийг ТДНД-ны аргаар бодох 2 гол үзүүлэлтийг ийнхүү шинэчлэн тогтоосноор тухайн жилд өндөр насны тэтгэврээ энэ аргаар тогтоолгох иргэний тэтгэврийн хэмжээг бодитой тогтоох шийдвэр болж байна.

НДҮЗ-ийн 2025 оны 06 дугаар тогтоолоор ҮОМШӨ-ний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг баталж, 1.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.

### 3.2.2 Мэргэжлийн хорооны үйл ажиллагаа

НДҮЗ-ийн дэргэдэх орон тооны бус МХ нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЗГ-ын 2024 оны 254, 256 дугаар тогтоол, "Мэргэжлийн хорооны ажиллах журам"-ын хүрээнд НД-ын тогтолцоо, хууль тогтоомж, НДБ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох, сангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад НДҮЗ-д мэргэжлийн зөвлөгөө, дүгнэлт гаргах чиг үүрэгтэй бөгөөд судалгаа, эрсдэлийг үнэлж, дүгнэлт, зөвлөмж, санал гаргадаг.

*График 3. МХ-ны бүтэц, бүрэлдэхүүн*




Тайлангийн жилд МХ нийтдээ 7 удаа хуралдаж 13 асуудлыг хэлэлцэж, дүгнэлт, зөвлөмж, санал гарган ГБХНХЯ, НДҮЗ, НДЕГ-т тус тус хүргүүлсэн байна.

*Хүснэгт 3. МХ-ны хуралдааны мэдээлэл*

| № | Хуралдсан огноо | Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд | Ирц |
|---|---|---|---|
| 1. | 2025.01.06 | 1.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, НДҮЗ-ийн АА, МХ, ОНХЗ-тэй хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслүүдийг тус тус хэлэлцэж, гишүүдээс гаргасан саналуудыг тусгаж, батлуулахаар НДҮЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв. | 100% |
| 2. | 2025.01.27 | 1.ТДНД-ны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг жилийн 12.2 хувиар тогтоох дүгнэлт гаргав. | 100% |
| | | 2.НДСЧҮ-ийг арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг 11.4 хувиар тогтоохыг дэмжиж, дүгнэлт зөвлөмж гаргав. | |
| 3. | 2025.02.19 | 1.“ЗГ-ын үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээ батлах тухай” ЗГ-ын тогтоолын төслийг хэлэлцэж, НДСЧҮ-ээс 300.0 тэрбум төгрөгөөр ЗГ-ын үнэт цаас авахыг дэмжиж, дүгнэлт гаргав. | 100% |
| | | 2.НДСЧҮ-ээс Төрийн сангийн нэгдсэн данс болон системийн нөлөө бүхий арилжааны банкнуудад мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр тогтоох саналыг дэмжиж, дүгнэлт, зөвлөмж гаргав. | |
| | | 3.ГБХНХЯ-наас ирүүлсэн “Оюутан, залуучууд, ахмад насны нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх бодлогын зураглал”-д дүгнэлт гаргуулах тухай албан бичигтэй танилцаж, 5 чиглэлээр дүгнэлт гаргаж, хүргүүлэв. | |
| | | 4.МБ, СЗХ-нд хийсэн уулзалтын тайланг сонсоод НДҮЗ-ийн хуралдаанд танилцуулахаар болов. | |
| 4. | 2025.04.04 | 1.2025 онд НДСЧҮ-ээс банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн хэмжээг НДЕГ-аас ирүүлсэн 2 дахь хувилбар буюу 4 банканд ижил хувиар байршуулахыг дэмжсэн дүгнэлт, зөвлөмж гаргав. | 100% |
| 5. | 2025.06.18 | 1.ГБХНХЯ-аас боловсруулсан НД-ын багц хуулиуд, холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцээд 12 санал гаргаж, тайлбар, үндэслэлийн хамт хүргүүлэв. | 88.9% |
| 6. | 2025.10.15 | 1.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд, цаашид улам эрчимжүүлж ажиллахыг гишүүдэд үүрэг болгов. | 88.9% |
| 7. | 2025.12.04 | 1.“Банкнуудын үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал”-ын төслийг хэлэлцээд “Арилжааны банканд мөнгөн хадгаламж байршуулахад баримтлах журам” гэж өөрчлөх зөвлөмж өгөв. | 77.8% |
| | | 2.МХ-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцээд, цаашид улам эрчимжүүлж ажиллахыг гишүүдэд үүрэг болгов. | |
| | | 3.Хорооны 2025 оны жилийн эцсийн ажлын тайланг сонсож, НДҮЗ-д танилцуулахыг МХ-ны даргад даалгалаа. | |

### 3.3 Эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, хяналт

НД-ын чиглэлээр МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” баримт бичигт тусгагдсан 2 зорилт, 9 арга хэмжээний хэрэгжилт 92.0, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт, 1 арга хэмжээний хэрэгжилт 100.0, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2 зорилт, 11 арга хэмжээний хэрэгжилт 95.8, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 2 зорилт, 4 арга хэмжээний хэрэгжилт 100.0, нийт дүнгээр 96.95 хувийн биелэлттэй буюу “Үр дүнтэй” гэж дүгнэлээ.

*Хүснэгт 4. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт /тоо, хувиар/*

| № | Хөгжлийн бодлого, чиглэлийн нэр | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| 1 | “Алсын хараа-2050” | 2 | 9 | 92.0 |
| 2 | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл | 2 | 4 | 100.0 |
| 3 | МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө | 1 | 1 | 100.0 |
| 4 | ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 2 | 11 | 95.8 |
| 5 | Нийт дүн | 7 | 25 | 96.95 |

МУ-ын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, ЗГ-ын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, НДҮЗ-ийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалтыг тус тус салбарын хэмжээнд хяналтад авсан.

*Хүснэгт 5. Хууль, тогтоол шийдвэрийн биелэлт /хувиар/*

| Хууль, тогтоол шийдвэр | | | Бүгд | Үүнээс: УИХ-ын байнгын Хорооны тогтоол | ЗГ-ын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | Ерөнхий сайдын албан | МУ-ын хууль | НДҮЗ-ийн тогтоол |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | | 37 | 1 | 5 | 1 | 14 | 2 | 2 | 12 |
| Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо | | | 68 | 1 | 5 | 2 | 23 | 22 | 2 | 13 |
| Үнэлгээ | Хэрэгжсэн | | 53 | - | 2 | 2 | 17 | 20 | 2 | 10 |
| Үнэлгээ | Хэрэгжих шатанд | Тодорхой үр дүнд хүрсэн | 7 | 1 | 1 | | 2 | 2 | | 1 |
| Үнэлгээ | Хэрэгжих шатанд | Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай/ | - | - | - | - | - | - | - | - |
| Үнэлгээ | Хэрэгжээгүй | Зохион байгуулалтаас | - | - | - | - | - | - | - | - |
| Үнэлгээ | Хэрэгжээгүй | Хөрөнгө дутагдсанаас | - | - | - | - | - | - | - | - |
| Үнэлгээ | Хугацаа болоогүй | | 8 | - | 2 | | 4 | - | - | 2 |
| Үнэлгээ | Хэрэгжих боломжгүй | | - | - | - | - | - | - | - | - |
| Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/ | | | 25 | - | 2 | - | 5 | 6 | 2 | 10 |
| **Дүн** | | | **94.2** | **50.0** | **83.3** | **100.0** | **94.7** | **95.5** | **100.0** | **95.5** |

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээгээр:

- "Хэрэгжсэн" буюу биелэлт бүрэн хангагдсан 53;
- "Хэрэгжих шатанд" буюу зохион байгуулалтын арга хэмжээ авсан, холбогдох шийдвэр гарсан, дээд шатны байгууллагад хүргүүлсэн "тодорхой үр дүнд хүрсэн" 7;
- "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" 8;
- "Тухайн шийдвэрт заасан хугацаа дууссан", "бүрэн хэрэгжсэн" хяналтаас хасуулах 5 шийдвэрийн 25 заалт байна.

НД-ын салбарын хэмжээнд хэрэгжиж буй шийдвэрийн хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 37 хууль, тогтоол, шийдвэрийн 68 заалтын 88.3 хувь "Хэрэгжсэн", 5.83 хувь "Хэрэгжих шатанд", 11.8 хувь "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" биелэлтийн дундаж 94.2 хувиар дүгнэгдлээ.

### 3.4 Үндсэн үйл ажиллагаа

- НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, НД-ын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, НДС-ийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах;
- НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, НДС-ийн хуримтлал бий болгох;
- НД-ын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;
- НД-ын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг АО, даатгуулагч, иргэн болон НД-ын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж, шийдвэр гаргах, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах;
- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, НД-ын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;
- НД-ын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил, арга зүйн үйлчилгээ үзүүлэх;
- НД-ын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх болно.

### 3.4.1 Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл

Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар НДС-ийн орлогыг 5,455.6 тэрбум төгрөг, зарлагыг 5,869.5 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 5,231.9 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, орлогын гүйцэтгэл 95.9 хувь, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 5,848.5 тэрбум төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 99.6 хувьтай байна.

*График 4 . НДС-ийн төсөв /тэрбум.төг/*




2024 оноос хэрэгжиж эхэлсэн НД-ын багц хуульд заасны дагуу даатгуулагчийн төлөх зарим шимтгэлийг улсын төсвөөс хариуцах болсонтой холбогдуулан улсын төсвөөс олгох дэмжлэг өнгөрсөн оноос 23.6 хувиар нэмэгдэж, 1,452.5 тэрбум төгрөг болсон.

### 3.4.2 Нийгмийн даатгалын сангийн орлого

Тайлангийн хугацаанд НДС-д 5,455.6 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 5,231.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлсэн. /Энэ дүнд улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 1,452.5 тэрбум төгрөг ороогүй./

*График 5. НДС-ийн орлогын бүтэц, эзлэх хувь*



Нийт шимтгэлийн орлогын 52.9 хувь буюу 2,765.9 тэрбум төгрөгийг АО-ийн төлсөн шимтгэл, 40.9 хувь буюу 2,138.1 тэрбум төгрөгийг албан журмаар даатгуулагчийн төлсөн шимтгэл, 3.8 хувь буюу 201.4 тэрбум төгрөгийг сайн дураар даатгуулагч /гадаадад ажиллаж буй иргэд, ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн шимтгэлийн орлого/, 2.4 хувь буюу 126.5 тэрбум төгрөгийг бусад орлого эзэлж байна.

*Хүснэгт 6. НДС-ийн орлогын биелэлт, төрлөөр /тэрбум.төг, хувиар/*

| № | Орлогын төрөл | 2024 | 2025 | Өмнөх онтой харьцуулсан /хувь/ |
|---|---|---|---|---|
| 1 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 1,175.0 | 1,452.5 | 23.6 |
| 2 | АО-ийн төлсөн шимтгэлийн орлого | 2,457.5 | 2,765.9 | 12.5 |
| 3 | Албан журмаар даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 1,758.0 | 2,138.1 | 21.6 |
| 4 | Сайн дураар даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 184.5 | 198.7 | 7.6 |
| 5 | Гадаадад ажиллаж буй иргэдийн төлсөн шимтгэлийн орлого | 1.5 | 1.1 | -26.6 |
| 6 | ҮОМШӨ-ний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн төлсөн шимтгэлийн орлого | 1.8 | 1.6 | -11.1 |
| 7 | Бусад орлого | 31.4 | 126.5 | 302.8 |
| | **Нийт** | **5,609.7** | **6,684.4** | **19.2** |

*Хүснэгт 7. НДС-ийн орлогын гүйцэтгэл, сангаар /тэрбум.төг, хувиар/*

| № | Орлого | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт орлогод эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 4,239.8 | 81.0 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 479.5 | 9.2 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 353.3 | 6.8 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 159.3 | 3.0 |
| | **Нийт** | **5,231.9** | **100.0** |

### 3.4.3 Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт

НДС-ийн зардлын төсөв 5,869.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бол 5,848.5 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт зарцуулсан.

*Хүснэгт 8. НДС-ийн зарлагын гүйцэтгэл, сангаар /тэрбум.төг, хувиар/*

| № | Зардал | Мөнгөн дүн /тэрбум.төг/ | Нийт зардалд эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Тэтгэврийн даатгалын сан | 5,341.2 | 91.3 |
| 2 | Тэтгэмжийн даатгалын сан | 291.5 | 5.0 |
| 3 | ҮОМШӨ-ний даатгалын сан | 52.1 | 0.9 |
| 4 | Ажилгүйдлийн даатгалын сан | 163.7 | 2.8 |
| | **Нийт** | **5,848.5** | **100.0** |

НДС-ийн зарлага өмнөх оны мөн үеэс 741.3 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өссөн.

*Хүснэгт 9. НДС-аар үйлчлүүлсэн хүний тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Нийгмийн даатгалын сан | 2023 | | 2024 | | 2025 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Тэтгэвэр | 486.4 | 3,617.0 | 505.6 | 4,666.5 | 521.5 | 5,341.2 |
| 2 | Тэтгэмж | 248.7 | 212.5 | 176.8 | 256.3 | 161.3 | 291.5 |
| 3 | ҮОМШӨ | 7.4 | 41.5 | 6.7 | 48.1 | 6.6 | 52.1 |
| 4 | Ажилгүйдэл | 30.1 | 110.2 | 30.8 | 136.3 | 34.1 | 163.7 |
| 5 | Даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 50 хувийн буцаалт | 310.9 | 11.8 | - | - | - | - |
| 6 | Үйл ажиллагааны зардал | - | 43.2 | - | - | - | - |
| | **Нийт** | **1,083.5** | **4,036.2** | **699.0** | **5,107.2** | **723.5** | **5,848.5** |

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.5 мянган хүн /0.5 хувь/, зарцуулалт 741.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

### 3.4.4 Нийгмийн даатгалын хамралт

2025 онд НД-д 63.8 мянган ААНБ, албан журмаар 1190.7, сайн дураар 169.8, малчин 56.5 мянган даатгуулагч мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байна.

*График 6. НД-ын хамралт /мян.хүн, ажил олгогч/*




НД-ын мэдээллийн санд 63.8 мянган ААНБ бүртгэгдсэн нь 2024 онтой харьцуулахад 7.1 мянган АО буюу өмнөх оны суурь түвшингээс 93.4 хувиар нэмэгдэж, 112.2 мянган хүнийг албан журмаар даатгалд шинээр хамруулан ажилласан. 2025 онд хүрэх түвшингээс 85.7 хувь буюу 23.1 мянган хүнийг сайн дураар даатгалд шинээр, нийт хамрагдвал зохих малчдын тоог 125.6 хувь буюу 10.7 мянгаар нэмэгдүүлж ажилласан байна. Мөн 505.0 мянган хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эх/эцэг, 0-3 насны хүүхдээ асарч байгаа 1.3 мянган эхийг сайн дураар даатгалд нэмж хамруулав.

### 3.4.5 Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардал

*Тэтгэврийн даатгалын сан*

ТДС-аас 2025 онд нийт 521.5 мянган тэтгэвэр авагчдад 5,341.2 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон.

*Хүснэгт 10. Тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Өндөр насны тэтгэвэр | 382.8 | 2,887.2 | 402.3 | 3,760.4 | 418.8 | 4,315.8 |
| 2 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 62.5 | 341.8 | 61.6 | 410.7 | 59.4 | 455.5 |
| 3 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 19.8 | 113.4 | 20.0 | 137.1 | 20.3 | 157.7 |
| 4 | Цэргийн тэтгэвэр | 21.3 | 273.1 | 21.7 | 358.0 | 23.0 | 411.4 |
| 5 | Олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.3 | - | 0.8 |
| | **Нийт** | **486.4** | **3,615.5** | **505.6** | **4,666.5** | **521.5** | **5,341.2** |

*График 7. Тэтгэврийн зарлага /тэрбум.төг/*




Тэтгэврийн даатгалын зардал өмнөх оноос 674.7 тэрбум төгрөг буюу 14.5 хувиар өссөн.

*График 8. Тэтгэвэр авагчдын бүтэц /хувиар/*




Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 91.3 хувь нь бүрэн тэтгэвэр, 8.7 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байна.

*График 9. Тэтгэврийн хэмжээ /мян.төг/*




Улсын хэмжээгээр дундаж тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.

## *Тэтгэмжийн даатгалын сан*

Тэтгэмжийн даатгалын сангаас 161.3 мянган даатгуулагчдад 291.5 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгожээ.

*Хүснэгт 11. Тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж | 145.6 | 32.6 | 90.3 | 38.1 | 94.2 | 44.6 |
| 2 | Жирэмсний болон амаржсаны тэтгэмж | 61.6 | 147.7 | 51.3 | 187.8 | 53.1 | 215.9 |
| 3 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж | 14.2 | 28.3 | 14.3 | 29.0 | 14.0 | 28.1 |
| 4 | Эхийн хүүхдээ асрах чөлөөтэй байсан хугацааны шимтгэл, тэтгэмж | 27.3 | 3.8 | 20.9 | 1.35 | 8.9 | 2.9 |
| 5 | Олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.05 | - | 0.06 |
| | **Нийт** | **248.7** | **212.4** | **176.8** | **256.3** | **161.3** | **291.5** |

*График 10. Тэтгэмжийн зарлага /тэрбум.төг/*



Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.2 тэрбум төгрөг буюу 13.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*ҮОМШӨ-ний даатгалын сан*

2025 оны жилийн эцсийн байдлаар 6.6 мянган даатгуулагчдад хөдөлмөрийн чадвар алдсан, тэжээгчээ алдсан, ХЧТА, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувиллын зардалд ҮОМШӨ-ний даатгалын сангаас 52.1 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан.

*Хүснэгт 12. ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*

| № | Тэтгэвэр тэтгэмжийн төрөл | 2023 он | | 2024 он | | 2025 он | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 3.5 | 31.8 | 3.4 | 37.5 | 2.9 | 38.2 |
| 2 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 0.5 | 4.0 | 0.4 | 4.8 | 0.4 | 5.8 |
| 3 | ХЧТА-ны тэтгэмж | 1.5 | 1.8 | 1.2 | 2.6 | 1.8 | 3.8 |
| 4 | Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж | - | - | - | 0.09 | 0.03 | 0.08 |
| 4 | Хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр | 0.01 | 0.01 | 0.01 | 0.02 | 1.3 | 0.01 |
| 5 | Рашаан сувиллын зардал | 1.9 | - | 1.7 | 1.3 | 0.2 | 1.0 |
| 6 | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | - | 1.1 | - | 0.04 | - | 1.5 |
| 7 | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэврийн даатгалын шимтгэл | - | 1.8 | - | 1.7 | - | 1.6 |
| 8 | Олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээ | - | - | - | 0.08 | - | 0.07 |
| | **Нийт** | **7.4** | **41.5** | **6.7** | **48.1** | **6.6** | **52.1** |

*График 11. ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /тэрбум.төг/*




ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага өмнөх оноос 4.0 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*Ажилгүйдлийн даатгалын сан*

2025 онд ажилгүйдлийн даатгалын сангаас 34.1 мянган даатгуулагч 163.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авч өмнөх оноос 27.4 тэрбум төгрөг буюу 20.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*График 12. Ажилгүйдлийн тэтгэмж авагчдын тоо, зарцуулсан мөнгөн дүн /мян.хүн, тэрбум.төг/*




### 3.4.6 Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага

*Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалт*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг, ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт мөнгөн үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах харилцааг зохицуулсан журам"-д НДСЧҮ-ийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулахаар заасан.

*Хүснэгт 13. Үнэт цаасны хүүгийн тооцоолол /төгрөгөөр/*

| № | Хугацаа | 1 жил | 2 жил | 3 жил | Дүн |
|---|---|---|---|---|---|
| | | 8.50-9.50% | 9.0% | 9.5% | |
| | ЗГ-ын ҮЦ | 179/НД-106/25 гэрээтэй 100,000,000,000 | 100,000,000,000.00 | 100,000,000,000.00 | 300,000,000,000.00 |
| 1 | 2025.05.15 | 4,215,068,493.15 | 4,463,013,698.63 | 4,710,958,904.11 | 13,389,041,095.89 |
| 2 | 2025.11.15 | 4,284,931,506.85 | 4,536,986,301.37 | 4,789,041,095.89 | 13,610,958,904.11 |
| **2025 онд НДС-нд төвлөрсөн үнэт цаасны хүү** | | | | | **27,000,000,000.00** |
| 3 | 2026.05.15 | | 4,463,013,698.63 | 4,710,958,904.11 | 9,173,972,602.74 |
| 4 | 2026.11.15 | | 4,536,986,301.37 | 4,789,041,095.89 | 9,326,027,397.26 |
| 5 | 2027.05.15 | | | 4,710,958,904.11 | 4,710,958,904.11 |
| 6 | 2027.11.15 | | | 4,789,041,095.89 | 4,789,041,095.89 |
| **Нийт хүү дүн** | | 8,500,000,000.00 | 18,000,000,000.00 | 28,500,000,000.00 | **55,000,000,000.00** |
| 1 | 2026.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 2 | 2026.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| 3 | 2027.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 4 | 2027.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| 5 | 2028.05.15 | 4,710,958,904.11 | | | |
| 6 | 2028.11.15 | 4,789,041,095.89 | | | |
| **179/НД-106/25 гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 15-нд сунгасан бондын хүү** | | **28,500,000,000.00** | | | |
| **Нийт** | | 37,000,000,000.00 | 18,000,000,000.00 | 28,500,000,000.00 | **83,500,000,000.00** |

2024 онд худалдан авсан ЗГ-ын 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хүүгийн орлого нийт 83.5 тэрбум төгрөгийн орлого орно. Үүнээс 2025 онд хүүгийн орлого 27.0 тэрбум төгрөг орсон.

ЗГ-ын 2025 оны 192 дугаар тогтоолоор НДСЧҮ-ээс 300.0 тэрбум төгрөгөөр үнэт цаас худалдан авах хөрөнгө батлагдсан боловч Сангийн яамнаас үнэт цаасыг нээлттэйгээр арилжсан ба нээлттэй арилжаанд оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулан ГБХНХЯ-нд холбогдох саналыг хүргүүлээд байна.

МХ-ны дүгнэлт зөвлөмжийг үндэслэн НДҮЗ-ийн 07, 08 дугаар тогтоолуудаар 2025 онд НДСЧҮ-ээс Банкны тухай хуулийн 13.1.20-д заасан системийн нөлөө бүхий арилжааны банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөг, хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар тус тус оны эхэнд шинэчлэн баталсан. Эдгээр шийдвэрийг үндэслэн НДЕГ-аас Хаан, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкнуудтай хэлцэл хийж, энэхүү 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэйгээр мөнгөн хадгаламж хэлбэрээр дээрх 4 банканд хуваан байршуулсан. Энэхүү хөрөнгө оруулалтын дүнд нийт 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор НДС-ийн орлого арвижих боломж бүрдсэн. Банкуудтай байгуулсан гэрээний дагуу 05-12 дугаар сарын хүү болох 70.2 тэрбум төгрөгийг НДС-д төвлөрүүлж, https://shilendans.gov.mn/ сайт, https://www.ndaatgal.mn/ цахим хуудсаар даатгуулагч, иргэдэд тогтмол, ил тод мэдээлж байна.

*График 13. НДС-ийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого*




*Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаанд хяналт тавих олон нийтийн хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа.*

ОНХЗ нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолын дагуу НДСЧН-ийг санхүүгийн хэрэгсэлд оруулах үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг.

ОНХЗ тайлант онд танхимаар 3 удаа, цахимаар 2 удаа, нийтдээ 5 удаа хуралдаж, 5 удаа ажлын уулзалт зохион байгуулсан байна. ОНХЗ-өөс эрхлэх асуудлын хүрээнд НДЕГ-т нийт 16 дүгнэлт, 22 зөвлөмжийг хүргүүлэв.

Үүнд:

- НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааны тайлан, мэдээлэлд хяналт, шалгалт хийж, цаашид анхаарах асуудлаар 9 дүгнэлт, 10 зөвлөмж;
- Сангийн чөлөөт үлдэгдлийг арилжааны банканд байршуулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй мэдээлсэн байдалд шалгалт хийж, холбогдох арга хэмжээг авах талаар 1 дүгнэлт, 4 зөвлөмж;
- НДС-ийн санхүүгийн болон нэгдсэн төсвийн 2025 оны 2 дугаар улирлын мониторинг хийсэн тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авах арга хэмжээний талаар 1 дүгнэлт, 8 зөвлөмж;
- НДБ-ын үйл ажиллагааны төсвийн 2025 оны 2 дугаар улирлын мониторинг хийсэн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг үндэслэн цаашид анхаарах асуудлаар 5 дүгнэлт.

*Хүснэгт 14. Хуралдаан, уулзалтын мэдээлэл*

| № | Хугацаа | Хэлэлцэж, шийдвэрлэсэн асуудлууд |
|---|---|---|
| **1.** | 2025.01.06 | 1.ОНХЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, НДҮЗ-ийн АА, МХ-той хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төслүүдийг хэлэлцэж, гишүүдийн саналыг тусган батлуулахаар НДҮЗ-д хүргүүлэв. |
| **2.** | 2025.02.07 | 1.Мөнгөний бодлого, арилжааны банкны дундаж хүү, 2025 онд төрөөс баримтлах мөнгөний бодлогын хүрээнд гадаад худалдааны тэнцэл, валютын нөөц, инфляц, тэтгэврийн зээлийн өсөлт, бууралтын талаарх мэдээлэл болон тэтгэврийн зээлийн хүүг бууруулах боломж, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, ЗГ-аас гаргасан бондыг үнэт цаасны зах зээлд арилжаалах бэлтгэл хангах, үнэт цаасны зах зээлийн өгөөжийг хадгаламжийн хүүтэй харьцуулан статистик мэдээлэл авах зэрэг асуудлаар МБ, СЗХ, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны төлөөлөлтэй хийсэн уулзалтын тухай зөвлөлийн даргын танилцуулгыг сонсов. |
| **3.** | 2025.03.17 | НДЕГ-ын удирдлагуудтай уулзаж, зөвлөлийн үйл ажиллагаа явуулах нөхцөлийг хангах, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болон хяналтын чиг үүргийн талаарсанал солилцож, хамтран ажиллахаар тогтов. |
| **4.** | 2025.03.24 | ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор батлагдсан НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журмын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах зорилгоор зөвлөмж боловсруулж, НДЕГ-т хүргүүлэв. |
| **5.** | 2025.04.05 | 1.ЗГ-ын үнэт цаас худалдах, худалдан авах 2024 оны 199/НД73/24 дугаар гэрээний хэрэгжилттэй танилцаж, хүүгийн орлогыг тогтоосон |

| | | |
|---|---|---|
| | | хугацаанд НДС-д төвлөрүүлж, гэрээ хэвийн хэрэгжиж байна гэж дүгнэлээ. |
| | | 2. МБ-ны үнэт цаасыг арилжааны банкнаас бусад байгууллага, сангаас худалдан авах боломжгүй тул НДСЧҮ-ээс худалдан авах үйл ажиллагаа хийгдээгүй талаар хэлэлцэж, холбогдох тайлан, зөвлөмжид тусгахаар шийдвэрлэв. |
| | | 3.ЗГ-ын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байгаа нийгмийн даатгалын сангийн харилцах дансны үлдэгдэлд сар бүр хүү тооцох зохицуулалт хэрэгжихгүй байгаа тул, холбогдох журмын хэрэгжилтийг хангуулах талаар дүгнэлт гаргав. |
| 6. | 2025.04.21 | 1.НДСЧҮ-ийг системийн нөлөө бүхий банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах үйл ажиллагааны талаар НДЕГ-аас ирүүлсэн мэдээллийг хэлэлцэж, цаашид анхаарах асуудлаар дүгнэлт, зөвлөмж гаргалаа. |
| | | 2.2025 онд НДСЧҮ-ээс банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудад байршуулах мөнгөн хадгаламжийн хэмжээг банк бүрээр тогтоохдоо аль нэг банканд давуу байдал олгохгүй байх, өөрийн хөрөнгөөс хувь тэнцүүлэн тогтоох чиглэл баримтлах тухай дүгнэлт, зөвлөмж гаргав. |
| 7. | 2025.05.16 | Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн талаар НДЕГ-ын албан хаагчдад мэдээлэл хийж, цаашид анхаарах асуудлаар чиглэл өгөв. |
| 8. | 2025.07.04 | 1.НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаа болон ил тод, нээлттэй шилэн байдлыг хэрхэн хэрэгжүүлснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд удирдамж батлан, 2 баг томилон хяналт тавьж, цаашид анхаарах асуудлаар НДЕГ-т зөвлөмж, дүгнэлт хүргүүлэв. Хяналт шалгалтаар үр дүн хангалтгүй, хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал тогтоогдоогүй. |
| | | 2.НДЕГ-т 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр өгсөн 6 зөвлөмжийн биелэлтэд үнэлгээ хийж, 1 зөвлөмж хэрэгжээгүй, 1 зөвлөмж хэрэгжих шатандаа явж байгааг тогтоож, цаашид биелэлтийг сайжруулах чиглэлээр холбогдох тайлбар, арга хэмжээ авахыг үүрэг болгов. |
| 9. | 2025.09.18 | 2025 оны эхний 3 сарын НДС-ийн орлого бүрдүүлэлт зарцуулалт, зарлагын гүйцэтгэл болон бусад холбогдох нээлттэй мэдээлэлд мониторинг, дүн шинжилгээ хийх ажлын удирдамж батлан, 2 багийг томилж, тайлан танилцуулга зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв. |
| 10. | 2025.10.22 | 1.НДС-ийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн 2025 оны 2 дугаар улирлын тайланд дүн шинжилгээ, мониторинг хийх удирдамжийн дагуу зөвлөлийн гишүүд тайланд дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, холбогдох тайлан, мэдээллийг хүргүүлэхээр болов. |
| | | 2.НДБ-ын төсвийн гүйцэтгэлийн 2 дугаар улирлын тайлангийн тоо, мэдээлэлд дүн шинжилгээг хийж ажлын тайлан мэдээллийг НДҮЗ-ийн АА-нд хүргүүлэв. |

| | | |
|---|---|---|
| **11.** | 2025.11.15 | Макро эдийн засгийн мэдээлэл, үнэт цаасны зах зээлийн индекс мэдээнд дүн шинжилгээ хийсэн танилцуулга боловсруулан АА-нд хүргүүлэв. |
| **12.** | 2025.12.04 | 1.НДЕГ-аас ирүүлсэн тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг арилжааны банканд байршуулах "Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар", "Банкнуудын үйл ажиллагаанд шалгуур үзүүлэлт тогтоох аргачлал"-ын төсөлтэй танилцаж дүгнэлт зөвлөмж өгөв. |
| | | 2.НДЕГ-т, орон нутгийн НДБ болон холбогдох газруудаас ирүүлсэн АО, даатгуулагчийн нийтлэг эрх ашигт хамаарах өргөдөл гомдол, саналын шийдвэрлэлттэй танилцав. НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагаатай холбоотой асуудлаар өргөдөл, гомдол санал, хүсэлт ирээгүй байна. |
| | | 3.Жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэж, эрчимжүүлэх арга хэмжээ авахыг үүрэг болгов. |
| **13.** | 2025.12.10 | 1.2025 оны жилийн эцсийн ажлын тайланг хэлэлцэн, НДҮЗ-ийн хурлаар танилцуулахаар шийдвэрлэв. |

### 3.4.7 Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэлт

ЗГ-ын 2024 оны 256 дугаар тогтоолоор "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам"-ыг баталж, НДШ төлж буй 1.2 сая даатгуулагч бүр "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болж, нийт 295.3 тэрбум төгрөгийн бодит мөнгөн хуримтлал үүсгэв.

Тайлангийн хугацаанд ТДС-аас 80.0 тэрбум төгрөгийг ТНС-нд нэмж байршуулж, 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2025 оны харилцах дансны хүүгийн орлого 7.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 302.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Харин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцах дансанд байсан 215.3 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, 15.11 хувийн хүүтэй Төр, Хаан, Голомт, Худалдаа хөгжлийн банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж эхэлсэн бөгөөд оны сүүлчийн нэг өдрийн хүү болох 89.1 сая төгрөгийг ТНС-д төвлөрүүлсэн.

*График 14. Хуримтлалын сангийн бүтэц*



*Хүснэгт 15. ТНС-ийн харилцах дансны үлдэгдэл /сая.төг/*

| Үзүүлэлт | Худалдаа хөгжлийн банк | Хаан банк | Голомт банк | Төрийн банк | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| Харилцах дансны 2024 оны үлдэгдэл | 61,859.1 | 81,370.0 | 41,582.9 | 30,494.9 | 215,306.9 |
| 2025 онд нэмж байршуулсан | - | 35,000.0 | 20,000.0 | 25,000.0 | 80,000.0 |
| 2025 оны харилцахын хүүгийн орлого | 1,877.2 | 2,625.4 | 1,397.8 | 1,391.9 | 7,292.3 |
| 2025.12.30-ний үлдэгдэл | 63,736.3 | 118,995.4 | 62,980.7 | 56,886.8 | 302,599.3 |
| Хадгаламжид байршуулсан дүн 2025.12.31 | 51,541.0 | 92,635.2 | 49,164.4 | 21,966.5 | 215,307.1 |
| Хадгаламжийн хүү 1 хоног | 21.3 | 38.4 | 20.3 | 9.1 | 89.1 |
| Харилцах дансны 2025 оны үлдэгдэл | 12,217.0 | 26,398.6 | 13,836.6 | 34,929.4 | 87,381.3 |

Даатгуулагч нь өөрийн тэтгэврийн мөнгөн хуримтлалын мэдээллээ төрийн үйлчилгээний "E-Mongolia" системийн "Профайл" цэс, НДБ-ын portal.ndaatgal.mn цахим систем болон гар утасны "nDaatgal" аппликейшны "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал" хэсгээс харах боломжтой.

Даатгуулагч ТНС-д байршуулсан мөнгөн хөрөнгөө ямар санхүүгийн хэрэгсэлд оруулахаа сонгох боломжийг нь бүрдүүлж, гар утасны Ndaatgal аппликэйшн болон даатгуулагчдад зориулсан www.portal.ndaatgal.mn цахим хуудсаар санал авах ажлыг 7 дугаар сараас эхлүүллээ.

### 3.4.8 Нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл, шимтгэлийн өр, авлага

2025 оны жилийн эцсийн байдлаар НДС дотоод, гадаадын 9 арилжааны банкны харилцах дансанд 1,998.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*График 15. НДС-ийн харилцах дансны үлдэгдэл /тэрбум.төг/*



*Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага*

НДБ-д 2025 онд 638.0 мянган АО, 1,350.0 мянган даатгуулагч, 5.2 тэрбум төгрөгийн НДШ-ийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлсэн.

*График 15. НДШ-ийн өр, авлага тэрбум.төг/*




НДС-ийн 36.3 мянган ААНБ-аас авах шимтгэлийн авлага 2025 оны эхэнд 520.5 тэрбум төгрөг байсан бөгөөд тайлангийн хугацаанд 24.2 мянган ААНБ-ын 266.7 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, оны эхний авлагыг 51.3 хувиар бууруулсан болови оны эцэст 40.7 мянган АО-ын 697.6 тэрбум төгрөгт хүрч энэ онд 430.9 тэрбум төгрөгийн өр шинээр үүссэн.

Энэ нь нийт АО-ын 64.1 хувьд нь 370.3 мянган даатгуулагч ажиллаж байгаа нь нийт даатгуулагчдын 30.8 хувийг эзэлж байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар нийт авлагын 15.6 хувь буюу 109.0 тэрбум төгрөг нь эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлэн бүртгэгдсэн бөгөөд, 84.4 хувь буюу 588.6 тэрбум төгрөг нь НДШ-ийн авлага байна.

Хүснэгт 16. 2025 оны жилийн эцсийн авлага барагдуулалтын мэдээ /тэрбум.төг/

| 2025 оны НДШ-ийн авлага | | 2025 онд барагдуулсан дүнгээр | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт барагдуулсан | | | Хэсэгчилж барагдуулсан | | Бүрэн барагдуулсан | | Барагдуулаагүй АО тоо | Барагдуулаагүй авлагын дүн |
| АО тоо | Авлагын дүн | АО тоо | Авлагын дүн | Хувь | АО тоо | Авлагын дүн | АО тоо | Авлагын дүн | | |
| 36.3 | 520.5 | 24.2 | 266.7 | 51.3 | 2.7 | 42.7 | 21.5 | 224.0 | 12.1 | 253.8 |

Нийт 697.6 тэрбум төгрөгийн НДШ-ийн өрийн 5.9 хувь буюу 40.7 тэрбум төгрөг нь урсгал өр (0-30 хоногийн насжилттай), 94.1 хувь буюу 656.8 тэрбум төгрөгийн өр нь хуримтлагдсан өр байна.

*Улсын төсвөөс авах авлага*

УИХ-аас 2020 онд баталсан Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн дагуу үзүүлсэн

хөнгөлөлт, чөлөөлөлтөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 197.2 тэрбум төгрөгийн улсын төсвийн санхүүжилтийн авлагатай байна.

*Хүснэгт 17. НД-ын санхүүжилт 2020-2025 он /тэрбум.төг/*

| Д/д | Үзүүлэлт | Дүн | Дүнд эзлэх хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Шимтгэлээс чөлөөлөлт – ААНБ | 793.6 | 86.36% | 38.8 мянган ААНБ, 411.7 мянган даатгуулагч |
| 2 | Шимтгэлээс чөлөөлөлт – Сайн дураар даатгуулагч | 81.4 | 8.85% | 169.2 мянган даатгуулагч |
| 3 | Ажилгүйдлийн даатгалын дэмжлэг | 44.1 | 4.80% | 80.9 мянган даатгуулагч |
| 4 | Нийт санхүүжилтийн авлага | 919.2 | 100% | НДШ-ээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн улсын төсвийн санхүүжилтийн авлага |
| 5 | Олгосон санхүүжилт 2020–2025 | 722.0 | 78.55% | Улсын төсөв + олон улсын төсөл |
| 7 | 2025 оны үлдэгдэл авлага | 197.2 | 21.45% | Төсөвт шилжээгүй үлдэгдэл |

*<u>Олон жилийн насжилттай, өндөр дүнтэй бусад авлага</u>*

2003 оноос өмнөх хугацаанд НДС-д үүсч хуримтлагдсан 6.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч, 271.8 сая төгрөг, 2025 онд ХОТШ банкны өрнөөс 9.8 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд нийт 6.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 3.4.9 Мэдээлэл технологийн үйл ажиллагаа

НДБ төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх, ашиг сонирхлоос ангид байх зорилтын хүрээнд салбарын хэмжээнд ашиглагддаг мэдээллийн нэгдсэн SICOS системийг 320 суманд нэвтрүүлж дуусгалаа. Ингэснээр:

- АО-ийн НДШ-ийн тайлан хүлээн авах;
- Шинэ АО бүртгэх;
- АО-ийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх;
- Сайн дураар даатгалын гэрээ байгуулах;
- Сайн дураар даатгуулагчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх;
- Тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлт үүсгэх;
- Даатгуулагчийн хүсэлтээр НДШ төлөлтийн лавлагаа гаргах зэрэг дээрх бүх үйлчилгээг иргэд сумандаа нэг дороос авах боломжтой болж, үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал сайжирлаа.

Тайлант хугацаанд шинээр 3 бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлэв:

1. Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг хэлэлцэн шийдвэрлэсэн

мэдээллийг бүртгэх, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг програмчлан шинээр дэд систем хөгжүүлэн нэвтрүүлснээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох.

2. "Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам"-д заасан аргачлалын дагуу даатгуулагчийн 2024 он ба түүнээс өмнөх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийг автоматаар тооцоолон буцаан олгох.

3. НД-ын нийт бүтээгдэхүүн үйлчилгээний тоон мэдээллийг дэлгэрэнгүй харах боломж бүхий "Dashboard"-ыг шинэчлэн боловсруулж нэвтрүүлсэн. Уг "Dashboard"-оос НД-ын бүтээгдэхүүн үйлчилгээний нийт 25 төрлийн багц мэдээллийг харьяалагдах аймаг, дүүргээр задлан дэлгэрэнгүй харах боломжийг бүрдүүллээ.

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон НД-ын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, АО, харилцагч байгууллагуудад НД-ын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Үүний дунд мэдээллийн нэгдсэн систем (Sicos)-ээр 259.3, Portal.ndaatgal.mn системээр 216.2, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган АО-ийн НДШ-ийн тайланг цахимаар хүлээн авч 98.0 хувийг шийдвэрлэлээ. НД-ын 81 үйлчилгээнээс 46 үйлчилгээ бүрэн цахимжсан байна.

### 3.4.10 Эрүүл мэндийн магадлал

Тайлангийн хугацаанд төв болон аймаг, дүүргийн 31 зөвлөл нь ЗГ-ын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-ийн дагуу 300 гаруй гишүүдтэйгээр эрүүл мэндийн магадлах үйл ажиллагааг улсын хэмжээнд эрхлэн явууллаа. 2025 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 99639 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 2.0 хувиар буурсан байна. Нийслэлд 37089, орон нутагт 58832 иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгожээ.

*Хүснэгт 18. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, тогтоолгосон хүний тоо /сүүлийн 10 жилээр/*

| № | Он | Хүний тоо | | Бүгд | Өмнөх онтой харьцуулсан хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Нийгмийн даатгалын сан | Нийгмийн халамжийн сан | | |
| 1 | 2016 | 63237 | 48786 | 112023 | -2.1 |
| 2 | 2017 | 72311 | 42059 | 114370 | 2.1 |
| 3 | 2018 | 69827 | 41637 | 111464 | -2.5 |
| 4 | 2019 | 71722 | 39664 | 111386 | -0.1 |
| 5 | 2020 | 72151 | 38242 | 110393 | -0.9 |
| 6 | 2021 | 67132 | 38475 | 105607 | -4.3 |
| 7 | 2022 | 64717 | 38518 | 103235 | -2.2 |
| 8 | 2023 | 63441 | 39234 | 102675 | -0.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | 2024 | 62447 | 39165 | 101612 | -1.0 |
| 10 | 2025 | 61352 | 38287 | 99639 | -2.0 |

2016-2025 оныг хүртэл хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт хүний тоо 11.1 хувиар, үүнээс: НДС-аас хөдөлмөрийн чадвар алдсан тэтгэвэр авагчдын тоо 3.0 хувь, нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагчдын тоо 21.5 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд эрүүл мэндийн магадлалын цахим мэдээллийн санд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн 108296 иргэн бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 10054 иргэн шинээр тогтоолгож, 41680 иргэн хугацаагаа сунгуулж, 8647 иргэний шийдвэр цуцлагдсан байна.

*Хүснэгт 19. Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэсэн байдал**

| № | Шалтгаан | Шийдвэрийн төрөл | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сунгасан | Шинээр тогтоосон | Шилжин ирсэн | Хурлаар ороогүй | Тогтоосон шийдвэр идэвхтэй | Цуцалсан | Нийт |
| 1 | Ахуйн осол | 527 | 236 | 0 | 0 | 763 | 312 | 1075 |
| 2 | Ердийн өвчин | 39184 | 9631 | 498 | 46214 | 95527 | 8011 | 103538 |
| 3 | Мэргэжлээс шалтгаалсан өвчин | 1334 | 54 | 0 | 624 | 2012 | 214 | 2226 |
| 4 | Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй | 366 | 38 | 1 | 0 | 405 | 34 | 439 |
| 5 | Үйлдвэрлэлийн осол | 219 | 85 | 5 | 562 | 871 | 81 | 952 |
| 6 | Хүүхэд насандаа | 51 | 10 | 0 | 0 | 61 | 5 | 66 |
| | **Нийт** | 41681 | 10054 | 504 | 47400 | 99639 | 8657 | 108296 |

*Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан хүний тоо орсон.

Хүснэгт 20. Хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан /сүүлийн 3 жилээр/

| № | Шалтгаан | 2023 | | 2024 | | 2025 | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Хувь | Тоо | Хувь | Тоо | Хувь |
| 1 | Ердийн өвчин, ахуйн осол | 99172 | 96.6 | 98408 | 96.8 | 96756 | 97.1 |
| 2 | Мэргэжлээс шалтгаалсан | 2600 | 2.5 | 2282 | 2.2 | 2012 | 2.0 |
| 3 | Үйлдвэрлэлийн осол | 903 | 0.9 | 922 | 0.9 | 871 | 0.9 |
| | **Нийт** | 102675 | 100.0 | 101612 | 100.0 | 99639 | 100.0 |

Мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлүүлсэн иргэдийн тоо жил дараалан буурч байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоо мөн буурч, өмнөх оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад 5.5 хувиар буурсан байна.

### 3.4.11 Сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах

2025 онд салбарын хэмжээнд албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 3153 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46908 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулав.

Иргэд, даатгуулагч, АО-д НД-ын багц хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг сурталчлан таниулах, тэдний ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 3775 удаагийн танхимын болон цахим сургалтыг давхардсан тоогоор 18473 ААНБ-ын 208458 иргэд, даатгуулагчийг хамруулан зохион байгуулан ажиллалаа.

Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөлтэй хамтран Унгар, Бельги, Чех, Австри улсад ажиллаж амьдарч байгаа Монгол иргэдэд НД-ын ач холбогдол, сайн дураар даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөөг хүргэв.

НДЕГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу МХ, ОНХЗ-ны гишүүд хамтран "Нийгмийн даатгалын авлагын менежмент" сэдэвт сургалтыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулан явууллаа. Сургалтад аймаг, дүүргийн НДГ-ын дарга, шимтгэл хураалт, өр авлага хариуцсан байцаагч зэрэг нийтдээ 423 албан хаагчдыг оролцуулж, НДШ-ийн авлагыг барагдуулах арга зүй, олон улсын туршлага сургамж, авлагад нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааны үр дүнгийн чиглэлээр хичээл бэлтгэж заасан бөгөөд цаашид авлагыг барагдуулах талаар төв, орон нутгийн НДБ-ын анхаарах асуудлын талаар зөвлөмж гаргав.

НД-ын хууль тогтоомж, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор НДЕГ-ын цахим хуудас болон @sigomongolia сошиал хуудсаар дамжуулан рийл 42, стори рийл 8, постер мэдээлэл 370, контент 16, 2D видео контент 2, 3D видео контет 2, цаг үеийн мэдээ, мэдээлэл 237, шууд дамжуулалт 4, нийт 681 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн бөгөөд давхардсан тоогоор хандалт 25.2 сая хүнд хүрч 97115 удаа түгээсэн байна.

Хэвлэл мэдээллийн 45 байгууллагаар 470 /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар НД-ын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж ажилласан.

### 3.4.12 Хяналт шалгалт

НД-ын салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, өмнөх онд хийгдсэн хяналт шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийлээ.

*<u>Дээд газрын хяналт, шалгалт</u>*

НДҮЗ-өөс МХ, ОНХЗ-тэй хамтран Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 35 дугаар зүйлийн 35.9, НДҮЗ-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн НДГ-дад НД-ын хууль тогтоомжоор хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, НД-ын асуудлаар шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн туслалцаа

үзүүлэх, шаардлагатай мэдээлэлд тулгуурлан дүгнэлт, зөвлөмж гаргах, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар ЗГ, НДҮЗ-ийн тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, Эрүүл мэндийн магадлалын зөвлөл, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн үйл ажиллагаа, АО, даатгуулагч, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр зөвлөмж, дүгнэлт өглөө.

*Төлөвлөгөөт хяналт, шалгалт*

Нэг.НД-ын багц хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Дундговь, Сэлэнгэ, Завхан, Орхон аймаг, Багахангай, Чингэлтэй дүүргийн НДГ-т төлөвлөгөөт хяналт, шалгалтыг 2018-2024 оны үйл ажиллагааг хамруулан НДС-ийн хөрөнгийн зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгаж, ердийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр шинээр тогтоолгосон нийт 17015 иргэний тэтгэврийн тогтоолт, олголтын үндэслэл, мөн давхардсан тоогоор нийт 234791 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд тулгуурлан шалгалаа.

*Хүснэгт 21. Шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн тоон үзүүлэлт*

| № | Шалгалт хийсэн аймаг, дүүрэг | Шалгалтад хамрагдсан огноо | Санхүүгийн жил | Хувийн хэргийн тооллого | Тэтгэвэр-ийн олголт /цахим/ | Шинэ болон нөхцөлийн тэтгэврийн тогтоолт | Тэтгэмж | | Шимтгэлийн тайлан авалт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Цахим | Цаас | Цахим | Цаас |
| 1 | Багахангай | 2022-2024 | 3 | 830 | 2319 | 256 | 61 | 605 | 13 | 183 |
| 2 | Дундговь | 2018-2023 | 6 | 349 | 50577 | 2705 | 897 | 15946 | 16 | 532 |
| 3 | Чингэлтэй | 2022-2024 | 3 | 1165 | 77210 | 6831 | 1031 | 41046 | 10337 | 6700 |
| 4 | Сэлэнгэ | 2023-2024 | 2 | 1140 | 42637 | 4084 | 381 | 12933 | 98 | 490 |
| 5 | Завхан | 2023-2024 | 2 | 639 | 27088 | 2199 | 287 | 3521 | 177 | 712 |
| 6 | Орхон | 2019-2023 | 5 | - | 34960 | 940 | - | - | 2112 | - |
| | **Дүн** | **2018-2024** | **21** | **4123** | **234791** | **17015** | **2657** | **74051** | **12753** | **8617** |

Дээрх аймаг, дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн 947 ААНБ-ын (давхардсан тоогоор) нийт 21370 удаагийн шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч баталгаажуулсан байдал, ажилгүйдлийн даатгалын сангаас 2657 даатгуулагчид олгосон тэтгэмжийн үндэслэл, тэтгэмжийн даатгалын сангаас 74051 даатгуулагчид олгосон жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн үндэслэлийг анхан шатны баримт болон мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлтэй тус тус тулган шалгав.

Хяналт шалгалтаар тэтгэврийн даатгалын сангаас нэр бүхий 236 иргэдэд тэтгэврийг илүү тооцож олгосон нийт 339.0 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр, 216 иргэнд дутуу тооцож олгосон 142.2 сая төгрөгийг нөхөн олгуулахаар, хуурамч бичиг баримт бүрдүүлж, үндэслэлгүйгээр тэтгэвэр тогтоолгосон нэр бүхий 123 иргэнтэй холбоотой 3.0 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, нийт төлбөрийн 71.2 хувийг барагдуулаад байна.

*Хүснэгт 22. Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчил /сая.төг/*

| № | Шалгалт хийсэн аймаг, дүүрэг | Тэтгэврийн даатгалын сан | | Тэтгэмжийн даатгалын сан | | Бичиг баримтын зөрчилтэй зогсоох актын дүн | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн | Хүний тоо | Мөнгөн дүн |
| 1 | Сэлэнгэ | 34 | 19,9 | 5 | 6,9 | 48 | 2,141.6 |
| 2 | Завхан | 122 | 92,3 | 1 | 0,8 | 14 | 311,03 |
| 3 | Орхон | 11 | 2,6 | - | - | 10 | 220,1 |
| 4 | Дундговь | 15 | 19,6 | 14 | 7,3 | 1 | 16,4 |
| 5 | Чингэлтэй | 252 | 321,2 | 9 | 2,8 | 9 | 222,5 |
| 6 | Багахангай | 18 | 25,6 | 3 | 2,4 | 3 | 118,5 |
| | **Нийт дүн** | **452** | **481.2** | **32** | **20.2** | **123** | **3,030.1** |

Хоёр.НД-ын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд хувийн хэвшлийн их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулиудад хяналт шалгалт хийж, 184 ААНБ хамрагдсанаас зөрчилгүй 92 АО-д зөвлөмж өгч, 92 ААНБ-д 4.1 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос 889.0 сая төгрөгийн шимтгэл, 436.5 сая төгрөгийн алданги, нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчлийг илрүүлж, 81.0 хувийг барагдуулав.

Гурав.Аймаг, дүүргийн НДГ-тай хамтран эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн 719 ААНБ-ыг шалгаж, үүнээс 463 АО-д зөвлөмж өгч, 256 ААНБ-д 1.1 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос 208.1 сая төгрөгийн НДШ, 90.4 сая төгрөгийн алданги, 15.3 сая төгрөгийн торгууль, нийт 313.7 сая төгрөгийн акт, алданги тогтоож, 51.2 хувийг барагдуулсан байна.

Дөрөв.Хөндлөнгийн хяналт, шалгалтаар аймаг, дүүргийн НДГ-ууд 2024 оны жилийн эцсийн байдлаар 993.4 сая төгрөгийн төлбөр, зөрчлийн авлагатай байсан бол 1.1 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж, 800.3 сая төгрөгийг барагдуулж, 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 1.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тав.Дотоодын хяналт шалгалтаар 21 аймаг, 9 дүүргийн НДГ нь 2025 оны эхэнд 5.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас 15.6 тэрбум төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, нийт 21.4 тэрбум төгрөгийн төлбөр зөрчлөөс 11.9 тэрбум төгрөгийн авлага барагдуулж, НДС-д төвлөрүүлэн 2025 оны жилийн эцсийн байдлаар 9.5 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 23. Дотоодын хяналт, шалгалтын тайлангийн нэгтгэл*

| № | Аймаг, дүүргийн нэр | Оны эхний үлдэгдэл | Тайлангийн хугацаанд | | Жилийн эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| | | | Шалгаж илрүүлсэн төлбөрийн дүн | Барагдуулсан төлбөрийн дүн | |
| 1 | Архангай | 545,505.3 | 176,748.3 | 373,562.3 | 348,691.3 |
| 2 | Баян-өлгий | 1,967.7 | 660,596.4 | 517,393.4 | 145,170.7 |
| 3 | Баянхонгор | 87,877.0 | 189,108.1 | 194,201.1 | 82,784.0 |
| 4 | Булган | 90,347.3 | 213,768.3 | 233,202.1 | 70,913.5 |
| 5 | Говь-Алтай | 14,600.0 | 131,617.0 | 141,318.6 | 4,898.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 6 | Говьсүмбэр | 10,907.9 | 181,478.7 | 76,170.8 | 116,215.8 |
| 7 | Дархан-Уул | 292,459.31 | 293,206.4 | 237,266.8 | 3,483,98.91 |
| 8 | Дорноговь | 98,944.5 | 947,476.2 | 239,415.5 | 807,005.2 |
| 9 | Дорнод | 30,433.1 | 171,608.1 | 137,167.3 | 64,873.9 |
| 10 | Дундговь | 2,814.2 | 197,679.5 | 99,445.2 | 101,048.5 |
| 11 | Завхан | 336,607.5 | 446,329.4 | 419,705.6 | 363,231.3 |
| 12 | Орхон | 25,308.5 | 564,529.6 | 411,588.8 | 178,249.3 |
| 13 | Өвөрхангай | 84,056.5 | 185,145.3 | 187,951.7 | 81,250.1 |
| 14 | Өмнөговь | 29,941.2 | 257,262.9 | 255,826.3 | 31,377.8 |
| 15 | Сүхбаатар | 24,538.0 | 687,624.2 | 275,281.7 | 436,880.5 |
| 16 | Сэлэнгэ | 218,596.0 | 1,185,482.3 | 809,068.5 | 595,009.8 |
| 17 | Төв | 62,682.7 | 179,326.8 | 156,681.2 | 85,328.3 |
| 18 | Увс | 47,999.0 | 266,335.2 | 245,302.0 | 69,032.2 |
| 19 | Ховд | 228,786.7 | 188,191.2 | 206,270.8 | 210,707.1 |
| 20 | Хэнтий | 41,471.3 | 324,284.0 | 290,872.4 | 74,882.9 |
| 21 | Хөвсгөл | 225,126.1 | 102,587.7 | 131,000.8 | 19,6713 |
| 22 | Багануур | 518,791.7 | 145,650.6 | 118,785.8 | 545,656.5 |
| 23 | Багахангай | 28,760.0 | 164,194.8 | 38,611.0 | 154,343.8 |
| 24 | Баянгол | 453,603.6 | 1,148,884.8 | 947,467.7 | 655,020.7 |
| 25 | Баянзүрх | 1,188,574.7 | 1,016,066.4 | 1,192,523.5 | 1,012,117.6 |
| 26 | Налайх | 12,360.6 | 186,448.2 | 126,566.6 | 72,242.2 |
| 27 | Сонгинохайрхан | 238,293.9 | 1,328,603.9 | 868,549.1 | 698,348.7 |
| 28 | Сүхбаатар | 356,955.4 | 1,504,681.2 | 1,285,518.1 | 576,118.5 |
| 29 | Хан-Уул | 194,456.0 | 1,020,198.6 | 675,309.8 | 539,344.8 |
| 30 | Чингэлтэй | 300,875.2 | 1,528,858.4 | 1,043,266.6 | 7,864,67.05 |
| | **Дүн** | **5,793,640.9** | **15,593,972.5** | **11,935,291.1** | **9,452,322.4** |

Зургаа.ТДС-ийн эрсдэлээс хамгаалах, цахим хяналт, шалгалтаар эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, төлбөрийг сүүлийн 3 жилийн хугацаанд гаргуулаагүй нийт 31647 (давхардсан тоогоор) тэтгэвэр авагчийн судалгаа гаргуулан аймаг, дүүргээр ангилан, нийт 24372 тэтгэвэр авагч нарын мэдээллийг хүргүүлж, 25 тэтгэвэр авагчтай холбоотой 195.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, илүү авсан 140.8 сая төгрөгийн төлбөр зөрчлийг 72.2 хувиар барагдуулсан байна. Мөн МУ-ын харьяатаас гарсан 25 иргэдийн нийт 379.8 сая төгрөгийн тэтгэвэр олголтын үндэслэлийг шалгаж, 5 тэтгэвэр авагчид илүү олгогдсон нийт 29.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, улсын байцаагчийн акт тогтоож, зөрчлийг бүрэн барагдуулсан.

*<u>Төлөвлөгөөт бус хяналт, шалгалт</u>*

Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн НДГ-т шалгалт хийж, НДШ төлөлтийн тайланг үндэслэлгүйгээр хуурамчаар тайлагнасан нийт 58 АО-той холбоотой 487 хүний 34.3 тэрбум төгрөгийн цалин хөлсийг мэдээллийн санд илүү бүртгэсэн зөрчлийг илрүүлсэн бөгөөд зөрчил илэрсэн АО-ийн жагсаалтыг гарган Тагнуулын ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт тус тус хүргүүлэн шалгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, СЗХ, Татварын ерөнхий газартай хамтарсан "Финанс мониторинг" нэгдсэн арга хэмжээний хүрээнд ББСБ-дын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 60 ББСБ-дыг хамруулж, нийт 35 ББСБ-ын НДШ-ийг дутуу тооцсон 719.6 сая төгрөгийн ЦХТАО-д ногдох 171.0 сая төгрөгийн шимтгэл, 77.6 сая төгрөгийн алданги, нийт 248.6 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн акт тогтоож, төлбөр зөрчлийг 100.0 хувь барагдуулан ажиллалаа. Мөн НДШ ногдох их хэмжээний орлогыг нуусан байж болзошгүй үндэслэлээр 5 ББСБ-ын 302 даатгуулагчид олгосон 1.2 тэрбум төгрөгийн ЦХТАО-оос НДШ дутуу тооцсон зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн, шалгуулж байна.

### 3.4.13 Мэдээллийн ил тод байдал

НДБ-ууд цахим хуудсандаа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дахь хэсэгт заасан 27 төрлийн 54 мэдээллийг ил тод, нээлттэй байршуулах үүрэгтэй. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт;
- Хүний нөөц;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа;
- Ажил, үйлчилгээ;
- Бусад.

Хүснэгт 24. Мэдээллийн ил тод, нээлттэй байдал /хувиар/

| Мэдээлэл байршуулалт | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|
| Салбарын хэмжээнд | 69.8 | 81.4 | 90.2 |
| Нийгмийн даатгалын ерөнхий газар | 90.7 | 92.8 | 90.4 |

НДБ-дын мэдээллийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 90.2 хувьтай байна. Үүнд:

- Мэдээллийн хүртээмжтэй байдал - 90.4;
- Хугацаандаа нийтлэгдсэн байдал - 97.1;
- Мэдээллийн бүрэн бүтэн байдал - 93.2;
- Эх сурвалжийн тодорхой байдал – 83.0 хувиар тус тус үнэлэгдсэн.

### 3.4.14 Лавлах үйлчилгээ

НД-ын үйлчилгээний лавлах утсанд нийт 703.2 мянган дуудлага ирснээс 537.6 мянган иргэд, даатгуулагч мэдээллийн ажилтантай холбогдон мэдээлэл авсан бол автомат хариулагчаас 26.6 мянган иргэн мэдээлэл, зөвлөгөө сонссон байна.

Тайлант хугацаанд иргэд, даатгуулагчдаас цахимаар нийтдээ 6510 санал хүсэлт, асуулт, үүнээс www.ndaatgal.mn аппликейшний "Санал хүсэлт" булангаар дамжуулан 1096 санал хүсэлт, sanal@ndaatgal.mn вэб хуудсаар 438, ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 4976 асуулт ирснийг ажлын 5 хоногт багтаан хариуг тэдний утсаар болон цахим хаягаар нь хүргүүлсэн.

### 3.4.15 Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

Тайлангийн хугацаанд гадаад харилцаа, хамтын ажиллагаа, түншлэлээ улам өргөжүүлж, иргэд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, харилцан НДШ төлсөн жилийг тооцож, тэтгэвэр, тэтгэмж авах, давхардлыг арилгахад чиглэгдсэн гэрээ хэлэлцээрүүдийг хэрэгжүүлэх, шинээр байгуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллалаа.

Холбогдох гэрээ хэлэлцээрүүдийн дагуу:

- Бүгд Найрамдах Солонгос улсад НДШ төлсөн 53 иргэний 254.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичиг;
- Бүгд Найрамдах Чех улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 95 иргэний МУ-д НД-ын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 41 иргэний даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлт;
- Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 8 иргэний мэдээлэл;
- Оросын Холбооны Улсад ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 73, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 48 иргэний ажилласан жилийн тодорхойлолт;
- Бүгд Найрамдах Унгар Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 32, тус улсаас өндөр насны тэтгэвэр авагч 25 иргэний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалт, МУ-д шимтгэл төлж, ажилласан жилийг баталгаажуулах хүсэлт гаргасан 30 иргэний хүсэлт;
- Бүгд Найрамдах Турк Улсад тэтгэвэр тогтоолгох 1 хүний мэдээллийг тус тус холбогдох улсын хамтран ажиллах эрх бүхий байгууллагуудад хүргүүллээ.

Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Ард Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсуудтай НД-ын хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр байгуулахаар ажиллаж байна.

### 3.3.16 Хүний нөөц

ЗГ-ын 2025 оны 52, НДҮЗ-ийн 14 дүгээр тогтоол болон Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/163 дугаар тушаалаар АА 9 орон тоотой, НДЕГ 6 газар, 5 хэлтэстэй, НДБ-ууд 1341 орон тоотой ажиллахаар батлагдсан бөгөөд үүнээс төрийн захиргааны албан хаагч 1111, төрийн үйлчилгээний албан хаагч 230 байна.

*Хүснэгт 25. НДБ-ын албан хаагчдын албан тушаалын ангилал, тоо*

| № | Албан тушаалын ангилал | Тоо | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Удирдах албан тушаалтан | 155 | 11.56 |
| 2 | Гүйцэтгэх албан тушаалтан | 1186 | 77.44 |
| | Нийт | 1341 | 100.0 |

| № | Төрийн албан тушаалын ангилал | Тоо |
|---|---|---|
| 1 | Төрийн захиргааны албан хаагч | 1113 |
| 2 | Төрийн үйлчилгээний албан хаагч | 228 |
| 4 | Үүнээс: Улсын байцаагч | 627 |

2025 оны жилийн эцсийн байдлаар НД-ын салбарын хэмжээнд 1285 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас 71.7 хувь буюу санхүү, эдийн засгийн мэргэжилтэй 921, 9.6 хувь буюу эрх зүйч 124, 18.7 хувь буюу бусад мэргэжлийн 240 албан хаагч

байна. Боловсролын хувьд доктор 3, магистр 112, бакалавр 1097 албан хаагч ажиллаж байна.

*Хүснэгт 26. НДБ-ын албан хаагчдын боловсрол, мэргэжил, нас хүйс*

| № | Боловсрол | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Доктор | 3 | Эдийн засагч | 349 |
| 2 | Магистр | 112 | Нягтлан бодох бүртгэл, татвар | 355 |
| 3 | Бакалавр | 1097 | Санхүү, банк, даатгал | 217 |
| 4 | Бусад | 73 | Эрх зүйч | 124 |
| | | | Бусад | 240 |

| № | Нас | Тоо | Хүйс | Тоо |
|---|---|---|---|---|
| 1 | 30 хүртэлх | 150 | Эрэгтэй | 232 |
| 2 | 31-40 | 528 | Эмэгтэй | 1053 |
| 3 | 41-50 | 439 | - | - |

### 3.4.17 Үйл ажиллагааны зардал

НДБ-ын урсгал үйл ажиллагааны зардалд 2025 онд 67.4 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс хүлээгдэж буй гүйцэтгэлээр 62.8 тэрбум төгрөгийг зарцуулж, 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант хугацаанд дараах зардлуудыг олгосон. Үүнд:

- Бусад урсгал шилжүүлэг – 2,081.4 сая төгрөг
- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ – 137.8 сая төгрөг
- Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн хөлс – 148.3 сая төгрөг
- Харуул, хамгаалалт – 102.2 сая төгрөг
- Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн зардал – 1,705.9 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

*График 17. НДБ-ын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл*




### 3.3.18 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу НДБ-ууд нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 11340 мэдээллийг байршуулахаас 11250 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 90 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба мэдээлэл байршуулалт 100.0 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.2 хувьтай байна.

*Хүснэгт 27. Мэдээлэл байршуулалт /тоо, хувиар/*

| Үзүүлэлт | Нийт мэдээлэл | Хугацаанд нь мэдээлсэн | Хугацаа хоцорсон | Нийт мэдээлэл байршуулалт | Хугацаандаа байршуулсан |
|---|---|---|---|---|---|
| НДС | 5484 | 5456 | 28 | 100.0 | 99.5 |
| НДБ-ын үйл ажиллагаа | 5856 | 5794 | 62 | 100.0 | 98.9 |
| Дүн | 11340 | 11250 | 90 | 100.0 | 99.2 |

НДС-ийн мэдээлэл байршуулалт 100.0, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.5 хувьтай байгаа бол байгууллагын санхүү, үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт 100.0 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 98.9 хувьтай байна

## 4. ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

НДҮЗ нь системчилсэн үнэлгээнд хамрагдах хугацаанд НД-ын багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, УИХ-ын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", 2015 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого", ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, "Нийгмийн даатгалын шинэчлэлийн жил"-ийн зорилтуудыг хэрэгжүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

НДБ-ын 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 9 зорилт, 69 арга хэмжээний биелэлт 94.8 хувь буюу "Бүрэн хангалттай" хэрэгжсэн байна.

2025 оны жилийн эцсийн байдлаар НДС-ийн орлого 5,455.6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 5,231.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 95.9 хувиар биелүүлж, 723.5 мянган хүнд тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 5,848.5 тэрбум төгрөг зарцуулж, гүйцэтгэл 99.6 хувьтай байна.

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны "ХУР" систем болон НД-ын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, АО, харилцагч байгууллагуудад НД-ын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Мэдээллийн нэгдсэн системээр 259.3, Portal.ndaatgal.mn системээр 216.2, нийт 475.5 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 61.9 мянган АО-ийн НДШ-ийн тайланг цахимаар хүлээн авч 98.0 хувийг шийдвэрлэлээ. НД-ын 81 үйлчилгээнээс 46 үйлчилгээ бүрэн цахимжсан байна.

Тайлангийн хугацаанд ЗГ-ын тогтоол, хуралдааны тэмдэглэл, НДҮЗ-ийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт 94.2 хувьтай байна.

Системчилсэн үнэлгээ хийгдсэн хугацаанд НДБ-уудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон,

шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, ажил үүргийг зохих түвшинд биелэгдсэн байна.

Цаашид НД-ын багц хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулан НД-ын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг сайжруулах, тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, санхүүжилтийн хуваарилалтын зарчмаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, даатгуулагч бодит хуримтлалтай болох, хуримтлалаа эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтэд зарцуулах, тэтгэврийн тусгай зохицуулалтын дагуу нэмэлт тэтгэвэр авах, тэтгэврийг жил бүр инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох цалин хөлсөнд итгэлцүүрийг хэрэглэх, тэтгэмж авах нөхцөлийг сайжруулах, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, НДС-ийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн удирдлага, зохицуулалтыг хийж, холбогдох хууль тогтоомжийн дагуу даатгуулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

## 5.ЦААШДЫН БОДЛОГО, ЧИГЛЭЛ

НДБ 2026 оныг "Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх жил" болгон НД-ын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, даатгуулагчийн төрлийг нарийвчлан тогтоох, АО-д шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, шимтгэлийн нөхөн төлөх НДС-ийн менежментийг сайжруулах, мэдээллийн ил тод байдлыг хангах, иргэд, даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчинг бүрдүүлэх, МХ, ОНХЗ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллах зорилт тавьж байна.

НД-ын багц хуулийг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй, ил тод байдлыг хангах замаар байгууллагын хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах, НД-ын үйлчилгээг иргэд даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагчдад чирэгдэлгүй шуурхай хүргэх боломжийг судлах, орчин үеийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх, НД-ын талаар төрөөс хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтийг хангуулах, МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2026 онд НД-ын салбарын хэмжээнд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- НД-ын багц хууль, холбогдох бусад дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах, НД-ын салбарын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, авлигаас ангид байлгахад чиглүүлэх;
- "Шинэ сэргэлтийн бодлого", "Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, МУ-ыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, МУ-ын хөгжлийн

2026 оны төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Тэтгэврийн даатгалын тогтолцоо нь хуваарилалтаас хуримтлалын тогтолцоонд шилжиж байгаатай холбогдуулан ТНС-г бүрдүүлэх, хөрөнгө оруулах, даатгуулагч тус бүрээр хуваарилах ажлыг зохион байгуулах, шаардлагатай хүний нөөцөөр хангах, чадавхжуулах;
- НДС-ийн хөрөнгийг найдвартай оновчтой удирдах, мөнгөн хөрөнгийн хөрвөх чадвар, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж, эрсдэлийг бууруулах зорилгоор сангийн хөрөнгийг арвижуулахад удирдлагаар хангаж, үр ашгийг өсгөн нэмэгдүүлэх, хууль эрх зүйн боломжийг бүрдүүлэх, НДС-ийн хөрөнгийг өгөөжтэй болгох, эрсдэлийн удирдлагын чадавх, бүтцийг хөгжүүлэх;
- Иргэд, даатгуулагч хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж, нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- МХ, ОНХЗ-ийн үйл ажиллагаа эрчимжүүлэн, НДСЧҮ-ийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах шийдвэр гаргахад шаардлагатай судалгаа, эрсдэлийг үнэлэх, санал дүгнэлт гаргах, хяналт тавьж ажиллах;
- НД-ын мэдээллийн цахим системийг сайжруулан хөгжүүлж, НДБ-ын болон НДС-ийн санхүүгийн системийг бүрэн цахимжуулах, мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх;
- НД-ын үйлчилгээг даатгуулагч, АО-д хүртээмжтэй, ээлтэй болгох, даатгуулагчдын санхүүгийн хуримтлалыг дэмжсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулан бүрэн цахимжуулах;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн сахилгыг мөрдөж ажиллах;
- НДБ-ын системийн шинэчлэл, НД-ын үйл ажиллагааг өргөжүүлэх, малчдын НД-ын хамралтыг нэмэгдүүлэх, алслагдсан баг, хороонд амьдарч буй даатгуулагчид НД-ын үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд анхаарах зэрэг болно.

Эдгээр зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлснээр НД-ын хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаж, иргэд, даатгуулагчид, АО-д үзүүлэх НД-ын үйлчилгээ улам сайжирна.

## 6.УИХ-ЫН БАЙНГЫН ХОРООНООС ӨГСӨН ҮҮРЭГ, ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

*1.Жил бүрийн эхэнд Үндэсний зөвлөлүүдийн хуралдаанаар банканд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшинг банк тус бүрээр батлах, тухайн банканд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг нь тооцдог байх;*

НДСЧҮ-ээс 2024 онд худалдан авсан ЗГ-ын 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хүүгийн орлого нийт 83.5 тэрбум төгрөгийн орлого орохоос 2025 онд хүүгийн орлого 27.0 тэрбум төгрөгийг НДС-д төвлөрүүллээ. Мөн ЗГ-аас 2025 онд 300.0 тэрбум төгрөгөөр үнэт цаас худалдан авах хөрөнгө батлагдсан боловч Сангийн

яамнаас үнэт цаасыг нээлттэйгээр арилжиж, худалдан авч чадаагүй тул нээлттэй арилжаанд оролцох эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар журмын төслийг боловсруулж байна.

ТДС-аас 80.0 тэрбум төгрөгийг ТНС-нд нэмж байршуулж, 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2025 оны харилцах дансны хүүгийн орлого 7.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, мөнгөн хөрөнгийн нийт үлдэгдэл 302.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцах дансанд байсан 215.3 тэрбум төгрөгийг 1 жилийн хугацаатай, 15.11 хувийн хүүтэй Төр, Хаан, Голомт, Худалдаа хөгжлийн банканд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж эхэлсэн бөгөөд оны сүүлчийн нэг өдрийн хүү болох 89.1 сая төгрөгийг ТНС-д төвлөрүүлсэн.

*<u>2.Хадгаламжийн хүүг тогтоохдоо үзүүлэлт болон авсан хүүгийн дунджаас гадна банкнуудын санал болгосон өндөр хүүг харгалзан тогтоох;</u>*

НДҮЗ-ийн тогтоолоор 2025 онд НДСЧҮ-ээс мөнгөн хадгаламж хэлбэрээр арилжааны банканд байршуулах хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, хүүгийн доод хэмжээг жилийн 14.2 хувиар тус тус баталж өгсөн. Ингэснээр НДС-ийн хөрөнгийг 105.0 тэрбум төгрөгөөр арвижуулах боломж бүрдсэн бөгөөд тайлант оны 5-12 дугаар сарын хүү болох 70.2 тэрбум төгрөгөөр сангийн хөрөнгө нэмэгдлээ.

*<u>3.НДС-аас Капитал банканд байршуулсан хадгаламжийн хөрөнгийг холбогдох яам, агентлагийн төсвийн эрх захирагч нарт арга хэмжээ авч ажиллахыг чиглэл болгох.</u>*

**Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэхээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

КБЭХА-аас НДС-ийн өр төлбөрт 104.2 тэрбум төгрөг барагдуулахаас 46.6 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, 57.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2025 онд 8.1 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж, өр төлбөрт хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөөс 72.37 м.кв талбайтай 189.8 сая төгрөгийн өртөгтэй 1 ширхэг үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулж, 22 иргэн, ААНБ-д түрээслүүлж, 335.6 сая төгрөгийн түрээсийн орлогыг НДС-д төвлөрүүлэв.

**Чингис хаан банканд байршиж байгаа сангийн мөнгөн хөрөнгийг барагдуулахаар хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Чингис хаан банк ХХК-иас НДС-ийн өр төлбөрт 103.6 тэрбум төгрөг барагдуулахаас 19.9 тэрбум төгрөгийн өрийг барагдуулж, 83.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 12.4 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 7.4 тэрбум төгрөгийн 11 ширхэг үл хөдлөх хөрөнгийг хүлээн авлаа.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА

АЛСЫН ХАРАА 2050" МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Зорилт арга хэмжээний дугаар | Арга хэмжээ | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|
| **Хоёр.ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | |
| **2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.** | | | | |
| 1 | 2.6.15. | Ажилгүйдлийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно. | Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр нэмэгдүүлэх тооцоо, судалгааг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулав. | 90 |
| **Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | |
| **3.1. Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ** | | | | |
| 2 | 3.1.1. | Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчдыг нийгмийн даатгалд даатгуулах тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг нийгмийн даатгалын байгууллага 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.<br><br>Албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах талаар:<br><br>- Хуулийн 21 дүгээр зүйлийн 21.21 дэх хэсэгт гурав хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сайн дурын даатгалд даатгуулбал түүний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас болон улсын төсвөөс хариуцахаар;<br>- Хуулийн 21.22 дахь хэсэгт эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг сайн дурын даатгалд даатгуулбал түүний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцахаар;<br>- Хуулийн 21.23 дахь хэсэгт малчин, туслах малчин сайн дурын даатгалд даатгуулбал түүний тодорхойлсон орлогын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох орлогоос тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс хариуцах зохицуулалтыг тус тус тусгасан.<br><br>2025 оны 12 дугаар сарын байдлаар:<br><br>Сайн дурын даатгалд даатгуулагч /0-3 насны хүүхдээ асарч байгаа/ 16.9 мянган эхийн төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын шимтгэлийн 50 хувь буюу 2.9 тэрбум төгрөгийг тэтгэмжийн даатгалын сангаас, 7.3 тэрбум төгрөгийг улсын төсвөөс, нийт 10.2 тэрбум төгрөгийг; | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа 3.9 мянган эх /эцэг/-ийн төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэл буюу 10.2 тэрбум төгрөгийг улсын төсвөөс;<br>- Малчин, туслах малчин 55.2 мянган даатгуулагчийн төлөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувь буюу 26.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс тус тус хариуцан төлж, эдгээр иргэдийг сайн дурын даатгалд хамруулав. | |
| 3 | 3.1.2. | Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно. | Нийгмийн даатгалын хууль, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг тус тус баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.<br>Эдгээр хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газрын тогтоол, Сайдын тушаал, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 68 дүрэм, журам, зааврыг батлуулан хэрэгжилтийг хангаж, хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас боловсруулсан Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгах санал, холбогдох тооцоолол, тайлбар болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд албан бичгээр хүргүүлэв. | 100 |
| 4 | 3.1.3. | Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно. | Тэтгэврийн олон давхаргат тогтолцоо буюу суурь тэтгэвэр, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт тус газрын албан хаагчид томилогдон ажиллаж, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох судалгаа тооцоолол хийх зэрэг ажлуудад Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллав. | 90 |
| 5 | 3.1.4. | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлж, төрийн болон хувийн тэтгэврийн сангаас тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг дэмжинэ. | Тэтгэврийн олон давхаргат тогтолцоо буюу суурь тэтгэвэр, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/48 дугаар тушаалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус газрын албан хаагч томилогдон ажиллав.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. | 90 |
| | | Нийгмийн даатгалын | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | 3.1.5 | мэдээллийн системийг боловсронгуй болгож, хяналтыг сайжруулна. | ***Мэдээллийн нэгдсэн системийн нэвтрүүлэлт:*** Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд сүүлийн үеийн дэвшилтэт технологид суурилсан, уян хатан, динамик суурьтай, бодит цагийн горимд ажиллах мэдээллийн нэгдсэн систем "SICOS", мөн иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан "Иргэний болон ажил олгогчийн портал систем /Portal.ndaatgal.mn/"-ийг 2024 оноос эхлэн үе шаттайгаар нэвтрүүлсэн.<br>Энэ ажлын хүрээнд "SICOS" системд тэтгэврийн 38, тэтгэмжийн 10, орлого шимтгэлийн 7 буюу сайн дураар даатгуулагчийн 5, акт, алдангийн орлогын 1 төрлийн, байгууллагын албан журмын даатгалын 1 багц бүтээгдэхүүн, зөрчил бүртгэх 3, бусад бүтээгдэхүүн буюу илүү төлсөн шимтгэлийн буцаан олголтын, мөнгөжүүлсэн орлогын тооцооллын, лавлагаа тодорхойлолтын зэрэг нийт 66 төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлсэн.<br>Үүний дунд иргэд даатгуулагч, тэтгэвэр, тэтгэмж авагч, ажил олгогчдод үзүүлэх нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, хэрэглэгч бодит цагийн горимоор үйлчилгээг тухай бүр хэвийн авч байна.<br>Иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан "Иргэний болон ажил олгогчийн портал систем" /Portal.ndaatgal.mn/"-ээр сайн дураар даатгуулагч нь сайн дурын гэрээ байгуулах /5 төрөл/, шимтгэл төлөх, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж болон ҮОМШӨ хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлтийг илгээх, лавлагаа тодорхойлолт авах, мөнгөжүүлсэн орлогын дүнгээ харах зэрэг үйлчилгээнүүдийг цахимаар авч байна.<br>Мөн Portal.ndaatgal.mn системээр ажил олгогч нь ажилтны тушаалын мэдээллийг бүртгэх, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаа илгээх, шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтоо авах, албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт илгээх зэрэг үйлчилгээг цахимаар авч байна. *Тухайлбал:*<br>✓2025 оны эхний хагас жилийн байдлаар "SICOS" системээр 172.0 мянга, Portal.ndaatgal.mn системээр 123.0 мянга, нийт 295.0 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр 55.5 мянган ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч 97.0 хувийг шийдвэрлэсэн байна. Үүнд:<br>- Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт 111.9 мянган хүсэлтийг хүлээн авч 98.2 хувийг шийдвэрлэсэн байна;<br>- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох нийт 134.0 мянган хүсэлтийг хүлээн авч 95.2 хувийг шийдвэрлэсэн байна.<br>- Өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 49.0 мянган иргэний хүсэлтийг хүлээн авч 96.0 хувийг шийдвэрлэсэн байна.<br>***Тэтгэвэр олголт:*** 550.0 мянга орчим тэтгэвэр авагч /давхардсан тоогоор нийтдээ 3.3 сая/-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг сар бүр тооцоолж системээр тооцоолон цаг хугацаанд нь олгох боломжийг бүрдүүлсэн.<br>910 эрүүл мэндийн байгууллагаас 78.8 мянган албан журмаар даатгуулагчийн, 6.9 мянган сайн дураар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 26.6 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 112.3 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>***Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан:*** Нийт 55.5 мянган ажил олгогчийн сар бүр илгээсэн 333.0 мянган удаагийн тайлан, давхардсан тоогоор 5.0 сая албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 100 хувь цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна. | 90 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Ажил олгогчоос цахимаар илгээсэн 79.0 мянган албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>***Санхүүгийн жилийн эцсийн тайлан гаргах:*** Мэдээллийн нэгдсэн системээр төв орон нутгийн нийгмийн даатгалын 30 нэгжийн 2024 оны жилийн эцсийн сангийн санхүүгийн тайланг гаргахтай уялдуулан системд шаардлагатай өөрчлөлт хөгжүүлэлт хийх, нэгжүүдэд аргачлал, заавар, чиглэл, зөвлөгөө өгөх, сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Тухайлбал:<br>***Системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт:*** Дараах тайлангуудыг гаргах хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлсэн. Үүнд:<br>- Ажил олгогч, сайн дураар даатгуулагчийн тайлангийн шалгах баланс болон бусад хавсралт тайлангууд;<br>- Санхүүгийн нэгтгэл тайлан болон хавсралт тайлангууд;<br>- Хүний тооноос хамаарсан тайлангууд . . . . гэх мэт.<br><br>***Заавар, аргачлал, зөвлөгөө өгөх чиглэлээр:*** Санхүүгийн чиглэлээр бүх нэгжийн ахлах нягтлан бодогч, сангийн нягтлан бодогч, тэтгэвэр тэтгэмж, ажил олгогч хариуцсан болон хяналтын байцаагч нарт тэтгэврийн тайланг шалгах балaнстай тааруулах, сайн дурын даатгалын тайлан, акт, алдангийн тайлан, харилцахын гүйлгээнүүдийг шалгаж үлдэгдлийг тааруулах талаар аргачлал заавар өгсөн.<br>Бүтээгдэхүүний чиглэлээр бүх нэгжийн тэтгэвэр, тэтгэмжийн болон үйлчилгээний хэлтсийн дарга, байцаагч, сангийн болон ахлах нягтлан бодогч нартай нэг бүрчлэн тулж ажиллан тулгамдсан асуудлуудыг цаг тухайд нь судлан аргачлал заавар зөвлөгөө өгсөн.<br><br>***Сургалтын чиглэлээр:*** Санхүүгийн жилийн эцсийн тайлан гаргахтай холбогдуулан байцаагч ажилтнуудад дараах сэдвүүдээр онлайн болон танхимын сургалт хийсэн. Үүнд:<br>- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын санхүү бүртгэл, тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн нийт 125 байцаагчид "Тэтгэврийн зөрүү хуваарь үүсгэх", "Тэтгэврийн олголт хаах", "Үйлдвэрлэлийн ослын сангаас хариуцах ногдуулалт үүсгэх" сэдвээр онлайн сургалт;<br>- Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын тэтгэвэр тэтгэмжийн хэлтсийн дарга, тэтгэмжийн байцаагч, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, сангийн нягтлан бодогч зэрэг нийт 112 байцаагчид "Тэтгэмжийн тайлан" гаргах сэдвээр онлайн сургалт;<br>- Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын ажилтнуудтай хамтран аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын тэтгэврийн хэлтсийн дарга, тэтгэврийн байцаагч, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга, сангийн нягтлан зэрэг нийт 133 байцаагчид "Тэтгэврийн тайлан" гаргах сэдвээр онлайн сургалт;<br>- Байцаагч ажилтнуудын мэдээллийн нэгдсэн систем ашиглалтын ур чадварыг сайжруулах зорилгоор тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, СДД болон албан журмын даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний чиглэлээр болон Зөрчил дэд системээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байцаагчдад ажлын нэг өдрийн танхимын болон онлайн сургалт явуулсан.<br>Уг сургалтад танхимаар 76, онлайнаар 100 гаруй байцаагч ажилтнууд хамрагдсан.<br>Мөн ажил олгогч, даатгуулагчийн портал системийн ашиглалтаар хичээл заасан. | |
| | | Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа | 2025 оны 12 дугаар сарын байдлаар 63.7 мянган ажил олгогч, 1180.5 мянган хүнийг албан журмын даатгалд, сайн дурын даатгалд 169.8 мянган хүн хамрагдсан.<br>Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын байгууллагууд малчдын нийгмийн баталгааг хангах, хамралтыг нэмэгдүүлэх талаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний дарга, нягтлан бодогчдыг албан журмын даатгалд хамруулах талаар Үндэсний хорооны ажлын албатай хамтран ажиллаж байна. | 70 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийнэ. | Сайн дурын даатгалын ач холбогдол, хамралтыг нэмэгдүүлэх талаар С1 телевиз, Монголын үндэсний Олон нийтийн радио, "Хилийн чанад дахь Монголчуудын зөвлөл"-д ярилцлага, мэдээлэл өгч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудсаар дамжуулан  ээлжит "Лайв"-т холбогдох мэргэжилтэнүүд оролцсон. Уг лайв мэдээлэл 1.4 мянган иргэнд хүрч 559 иргэдийн комментэд хариулт өгөв.<br>Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан "Ажилтай өрх-Аз жаргалтай гэр бүл" нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон иргэдэд нийгмийн даатгалын тухай зөвлөгөө, мэдээллийг өгч ажиллав.<br>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран 2025 оны 04 дүгээр сарын 28, 29-ний өдөр зохион байгуулсан сургалтад "Нийгмийн даатгалын хамралтын өнөөгийн байдал, анхаарах асуудал" сэдвээр илтгэл танилцуулга хийв.<br>Мөн 45 /давхардсан тоогоор/ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 230 /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд ярилцлага, танилцуулга, мэдээ, нэвтрүүлэг, хэлэлцүүлэг зэрэг сэтгүүлзүйн төрлөөр олон нийтэд хүргэж ажиллав. | |
| 7 | 3.1.6. | Нийгмийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлно | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай, ил тод, хараат бус байх зарчмыг баримтлан дараах санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж болно гэж заасан. Үүнд:<br>- Засгийн газрын үнэт цаас;<br>- Монгол банкны үнэт цаас;<br>- Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж;<br>- Монголбанкнаас тогтоосон системийн ач холбогдол бүхий арилжааны банк (цаашид "арилжааны банк" гэх)-нд байршуулах мөнгөн хадгаламж.<br><br>Мөн Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-ыг баталсан.<br>Хууль журмын дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br><br>*Засгийн газрын үнэт цаас худалдан авах чиглэлээр:*<br><br>Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2024 оны 14 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад 2024 онд зарцуулах хөрөнгийн хэмжээг 300,000.0 сая төгрөгөөр баталсны дагуу Засгийн газрын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 199/НД73/24 дугаартай гэрээг Сангийн яамтай байгуулж, эхний 100,000.0 сая төгрөгийг 8.5 хувийн хүүтэйгээр 1 жил, хоёр дахь 100,000.0 сая төгрөгийг 9.0 хувийн хүүтэйгээр 2 жил, гурав дахь 100,000.0 сая төгрөгийг 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатайгаар тус тус худалдан авч, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлсэн. Гэрээнд үнэт цаасны хүүг хагас жилд нэг удаа төлөхөөр заасны дагуу эхний хүү болох 13.4 тэрбум төгрөгийг хүлээн аваад байгаа ба нийт 55.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох юм.<br><br>*Монголбанкны үнэт цаасны арилжаанд оролцох чиглэлээр:*<br><br>Тус газар Монголбанкны үнэт цаас худалдан авах талаар хүсэлт хүргүүлсэн боловч Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 15 дугаар зүйлд Монголбанк нь хуулийн хүрээнд мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээс бусад | 100 |

зорилгоор үнэт цаас арилжаалахыг хязгаарладаг. Өөрөөр хэлбэл Төв банкны үнэт цаас нь банк хоорондын захын эх үүсвэрт нөлөөлөх мөнгөний бодлогын хэрэгсэл бөгөөд хөрөнгө оруулалтын хэрэгсэл биш юм.

Түүнчлэн Монголбанкны ерөнхийлөгчийн 2020 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А-205 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Төв банкны үнэт цаасны арилжааны журам"-д үнэт цаасны арилжаанд зөвхөн арилжааны банкуудыг оролцуулахаар зохицуулсан тул боломжгүй гэсэн хариуг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр А-5/03 дугаартай албан бичгээр ирүүлсэн.

*Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах чиглэлээр:*

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т сангийн чөлөөт үлдэгдлийг Төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахаар, мөн зүйлийн 13.5-д хүүгийн хэмжээ нь Засгийн газрын үнэт цаасны хүүгийн хэмжээтэй тэнцүү байхаар тогтоосон боловч өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл Төрийн санд хүүгүй байршиж байна.

Харин арилжааны банкууд 2024 оноос нийгмийн даатгалын сангийн харилцах дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд жилийн гурван хувийн хүү олгож байна.

Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг найдвартай, үр өгөөжтэй, хариуцлагатай удирдах зорилгоор тус газар 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/847 дугаартай албан бичгээр Монголбанканд харилцах данс нээлгэх, харилцах дансны үлдэгдэлд арилжааны банкуудын олгодог хүүгийн хэмжээтэй ижил хүү олгох талаар хүсэлт хүргүүлсэн.

Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга болон Сангийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн "Харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай" А-7/08/4 дугаартай хамтарсан тушаалын дагуу Төрийн сангийн нэгдсэн дансны үлдэгдэлд жилийн тогтмол гурван хувийн хүүг олгож байгаа ба нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгө нь Төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байгаа тул сангийн эх үүсвэрийг тусад нь удирдах тохиолдолд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авч дахин хандах талаар Монголбанкнаас хариу ирүүлсэн.

Үүний дагуу 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн "Хүсэлт хүргүүлэх тухай" 01/1415 дугаартай албан бичгээр Монголбанканд нийгмийн даатгалын сангийн харилцах данс нээх тухай зөвшөөрлийг Сангийн яамнаас хүссэн боловч өнөөдрийг хүртэл хариу ирүүлээгүй байна.

*Банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах чиглэлээр:*

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн "Хөрөнгийн хэмжээг тогтоох тухай" 07 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 (долоон зуун) тэрбум төгрөгөөр тогтоосон. Мөн 03 дугаар сарын 24-ний өдрийн "Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээ шинэчлэн батлах тухай" 08 дугаар тогтоолоор банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталсан.

Тус газар дээрх шийдвэрүүдийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд хугацаатай мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулахаар арилжааны банкуудаас санал авч, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хороо, Олон нийтийн зөвлөлөөр хэлэлцүүлэн санал, дүгнэлт, зөвлөмжийн дагуу 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэйгээр сар бүр хүү олгох нөхцөлтэйгээр хадгаламж хэлбэрээр байршуулсан.

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг найдвартай үр өгөөжтэй хөрөнгө оруулалтад байршуулснаар 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 34.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олоод байна. | |
| 8 | 3.1.8. | Тэтгэврийн даатгалын хагас хуримтлалын тогтолцоонд хэсэгчлэн шилжүүлж, 1979 оноос хойш төрсөн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг бодит хуримтлал болгоно. | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна" гэж заасан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэтгэврийн нөөц санд 2024 онд 212.2 тэрбум төгрөг, 2025 онд 25.0 тэрбум төгрөг, нийт 237.2 тэрбум төгрөгийг банкны системд нөлөө бүхий ХААН, Худалдаа хөгжил, Голомт, Төрийн банканд төвлөрүүлээд байна.<br>Мөн хуулийн 29.5-д тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогыг түүний саналд үндэслэн Засгийн газрын үнэт цаас, Монголбанкны үнэт цаас, Төрийн сангийн нэгдсэн дансанд байршуулах мөнгөн хадгаламж, Банкны тухай хуулийн 3.1.20-д заасан арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулахаар тус тус заасан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т "Энэ хуулийн 13.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлж, даатгуулагчаас санал авах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>*Тухайлбал* Монголбанканд 2025 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр "Мэдээлэл хүсэх тухай" 01/2030 дугаар албан бичгээр банкны системд нөлөө бүхий арилжааны банкны мэдээлэл, 01/2049 албан бичгээр Монголбанкны үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар, Сангийн яаманд 09 дүгээр сарын 03-ны өдөр "Мэдээлэл хүсэх тухай" 01/2048 дугаартай албан бичгээр Засгийн газрын үнэт цаас худалдан авах боломжтой эсэх талаар, 01/2053 дугаартай албан бичгээр төрийн сангийн нэгдсэн дансанд мөнгөн хадгаламж байршуулах боломжтой эсэх талаар мэдээлэл авахаар тус тус хүсэлт гаргаад байна. | 90 |
| 9 | 3.1.9. | Тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрэн хуримтлалын тогтолцоонд шилжүүлэх үе шатыг эхлүүлнэ. | Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг шинэчлэн боловсруулж 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д "Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна" гэж заасан.<br>Тухайлбал: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29.3.1-д "энэ хуулийн 18.1-д заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлого" гэж заасны дагуу 2024 оноос эхлэн шимтгэлийн орлогыг хуримтлал болгох арга хэмжээ үе шаттай хэрэгжүүлж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш тэтгэврийн нөөц санд 2024 онд 212.2 тэрбум төгрөг, 2025 онд 25.0 тэрбум төгрөг, нийт 237.2 тэрбум төгрөгийг банкны системд нөлөө бүхий ХААН, Худалдаа хөгжил, Голомт, Төрийн банканд төвлөрүүлээд байна. | 100 |
| | | | **ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | **92.0** |

--oOo--

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛД
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Зорилт, үйл ажиллагаа | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин | | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ** | | | | | | | |
| ***2.6.Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ:*** | | | | | | | |
| 2.6.2. | Ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаар үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | | Хуулийн шинэчлэлтэй уялдуулан бусад хууль, тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна. | 2021 | Ажилгүйдлийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн уялдаа холбоо хангалттай биш. | Даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор, суурьшилтай, урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогч ажилгүйдлийн даатгалын санд төлөх шимтгэлээс 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж буй Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-иар 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр өөрчлөн баталсан.<br><br>Хуульд өөрчлөлт орсноор:<br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй;<br>- Ажлын байраа хадгалсан, нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хувь хэмжээ нэмэгдсэн.<br><br>Мөн хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Журам батлах тухай" 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар "Ажил олгогчид ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ыг баталсан бөгөөд шимтгэлийн хөнгөлөлтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн ажил олгогчдод үзүүлнэ. | 100 |
| **ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА** | | | | | | | |
| 3.1 | ***Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл*** | | | | | | |
| 3.1.1 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг | - | Нийгмийн даатгалын багц хууль | 2021 | Нийгмийн даатгалын эрх зүйн | 1.Нийгмийн даатгалын тогтолцоо, хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодитой хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ. | | батлагдсан байна. | | шинэчлэл хийгдээгүй, олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй байна. | өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталж, Нийгмийн даатгалын байгууллага 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдөөс уг хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 4 дүгээр зүйл "Хувийн нэмэлт тэтгэвэр"-ээр даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг бүрдүүлэх, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл "Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх"-ээр иргэд даатгуулагчдыг бодитой хуримтлалтай болгох эрх зүйн орчныг тус тус бүрдүүлэв.<br>3.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаас гадна, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/48 дугаар тушаалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус газрын нэг албан хаагч томилогдон ажиллав.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2026 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн болно.<br>4. Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар ажил олгогч, албан журмын даатгуулагчийн хувьд ажил олгогч болон даатгуулагчийн тус тус төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувь, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувиар тус тус мөнгөжүүлж тэтгэврийн нөөц санд байршуулав. | |
| 3.1.2. | Иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны | - | Нэрийн дансны үлдэгдлийн тодорхой | 2021 | Хууль эрх зүйн орчин бүрдсэн байна. | 1.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд "Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх"-ээр заасан бөгөөд 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 1,129.7 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ. | | хувийг гэр бүлд нь өвлүүлэх талаарх хуулийн заалт батлагдсан байна. | | | мянган даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого 292.2 тэрбум төгрөг, хүүгийн орлого 9.5 тэрбум төгрөг, нийт 301.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулаад байна.<br>2.Тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтын хүрээнд нэрийн дансны орлогыг үе шаттайгаар мөнгөжүүлж уг орлогын тодорхой хэсгийг даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид нь 2030 оноос эхлэн өвлүүлэхээр хуульчилсан. | |
| 3.1.5. | Нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцийн түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ. | 310.1 тэрбум,төг/ Улсын төсөв/<br><br>327.2 тэрбум.төг /Тэтгэврийн даатгалын сан/ 2022 оны зарлагын төсвөөс | Инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлсэн байна. | 2023 | Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 550.0 мян төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 440.0 мян төгрөг | **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцийн жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов.<br>Уг тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 300.1 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар баталж 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсны дүнд дундаж тэтгэвэр 876.9 мянган төгрөгт хүрсэн болно. | 100 |
| | **НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | | | | | | **100** |

---oOo---

ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв (сая төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорил тот түвшин | Хүрсэн түвшин (хүрээгүй бол шалтгаан, нөхцлийг тайлбарлах) | Гүйцэт гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **2.1. ЧИНЭЭЛЭГ МОНГОЛ ХҮН** | | | | | | | | |
| **2.1.1** | ***Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого*** | | | | | | | |
| | **2.1.1.1. Нийгмийн даатгалын тогтолцоог сайжруулж, иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлнэ..** | | | | | | | |
| 2.1.1.1 | 1 | Хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шинэчлэлийг үргэлжлүүлж тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг хуримтлуулах; | Улсын төсөв Бусад эх үүсвэр (1917,465.3) | Тухайн жилийн хуримтлуулсан шимтгэл, хувь | - | 2 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар даатгуулагчийг бодитой хуримтлалтай болгох эрх зүйн шинэчлэл хийж, тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжихээр зохицуулсан.<br>Энэ зорилтын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1,129.7 мянган даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого 292.2 тэрбум төгрөг, хүүгийн орлого 9.5 тэрбум төгрөг, нийт 301.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн нөөц санд байршуулав.. | 90 |
| | 2 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | Улсын төсөв (1,515,232.2) | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | **Нэг.**Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Санал хүргүүлэх тухай" 01/763 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>**Хоёр.**Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах: Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1 хувиар бууруулахад 261.0 тэрбум төгрөгөөр, 2 хувиар бууруулахад 523.0 тэрбум төгрөгөөр тус тус тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого буурах тооцооллыг гаргав.<br>- Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлсөнд дээд хэмжээг баримтлах: Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлснөөс тооцох шимтгэлийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоовол нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 174.9 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>- Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс тооцох шимтгэлийг уян хатан тогтоох: Ажил гүйцэтгэх гэрээ, Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагчийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар тогтоовол уг хуулийн өөрчлөлтөд 28.9 мянган даатгуулагч хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 25.3 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>- ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2-1.0 хувиар бууруулах: Уг арга хэмжээний хүрээнд ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувийг 0.1-0.9 хувиар бууруулахад шимтгэлийн орлого 89.3 тэрбум төгрөгөөр буурах, 0.1 хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэхээр тооцоход ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 25.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого нийт 115.1 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>- Ажилгүйдлийн даатгалын санд ачааллыг бууруулах зорилгоор ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр бууруулахад шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр буурах, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр нэмэгдүүлэхэд шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэх тооцооллыг гаргав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Гурав** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд:<br>- Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлэх: Эмэгтэй даатгуулагч (55-60), 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эх (50-55), газрын доор, хортой, халуун (эрэгтэй 50-55, эмэгтэй 45-50), хүнд (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) нөхцөлд ажиллагч, малчны (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) тэтгэвэр тогтоолгох насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 28.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>- Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох жилийг нэмэгдүүлэх: Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийг 10 жил болгон нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 32.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>- Хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн эрх үүсэх хугацааг нэмэгдүүлэх. Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар" гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "нийтдээ 60 сар ба түүнээс дээш сар" гэж, Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар" гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс тасралтгүй 36 сар" гэж тус тус нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 18.8 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>- Өндөр насны тэтгэврийг 2018 оноос өмнө тогтоолгосон 206.6 мянган эмэгтэй тэтгэвэр авагчийн ажилласан жилийг хүүхдийн тоогоор нэмэгдүүлэхэд тэтгэврийн зардалд 111.0 тэрбум төгрөг нэмж шаардагдах тооцооллыг гаргав. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Дөрөв.**Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллыг хийв. Үүнд:<br>- Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг 55 хоногоор тооцож олгоход сангийн зардал 20.6 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>**Тав.**Тэтгэвэр, тэтгэмж, ҮОМШӨ, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцооллыг хийв.<br>- **Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тус тус хуулийн төслийг 2026 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.** | |
| 2.1.1.22. | 3 | **Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.** | Улсын төсөв | Нийгмийн даатгалын тэтгэврийн нэмэгдэл, хувь | 14.6 | 6 | **Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцийн жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов.**<br>Уг тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 300.1 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар баталж 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсны дүнд дундаж тэтгэвэр 876.9 мянган төгрөгт хүрсэн болно. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.1.3.Нийгмийн баталгаа** | | | | | | | | |
| 2.1.3.1 | **Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, "E-Mongolia" платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.** | | | | | | | |
| 2.1.3.2 | **Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| | 4 | Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх; | Бусад эх үүсвэр 2,634.10 | Үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгж, байгууллагын тоонд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь | 58.6 | 61.8 | Үндэсний статистикийн хорооны мэдээллээр 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тоо 116.8 мянга, ажиллах хүч 1,466.3 мянган хүн, 2024 оны жилийн эцсийн байдлаар малчдын тоо 313.2 мянга байна.<br>Нийгмийн даатгалын байгууллага 2025 онд 7.6 мянган ажил олгогч, 122.1 мянган албан журмаар даатгуулагч, 23.1 мянган сайн дураар даатгуулагч, үүнээс 10.7 мянган малчныг нийгмийн даатгалд шинээр хамруулсан.<br>Нийгмийн даатгалын сангийн 12 сарын мэдээгээр нийт 63.7 мянган ажил олгогч, 1,350.3 мянган даатгуулагч, 56.5 мянган малчныг нийгмийн даатгалд хамруулсан байна.<br>Аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь 54.5;<br>Даатгуулагчийн эзлэх хувь-80,0;<br>- Малчнаар даатгуулагчдын эзлэх хувь-18.0 | 87.8 |
| | | | | Нийт ажиллах хүчинд даатгуулагчийн эзлэх хувь | 81 | 81.1 | | |
| | | | | Нийт малчны тоонд нийгмийн даатгалд хамрагдсан малчны эзлэх хувь | 21 | 23 | | |
| | 5 | Нийгмийн даатгалын үйлчилгээг их өгөгдөлд суурилан бүрэн цахимжуулж, тоног төхөөрөмжийг шинэчлэх; | Улсын болон орон нутгийн төсөв<br>7,500.0 | Цахимжуулах үйлчилгээ, өссөн дүнгээр | 24 | **26** | Нийгмийн даатгалын 75 үйлчилгээнээс 47 үйлчилгээг бүрэн цахимжуулаад байна.<br>**Нэг. Нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөлд нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг тогтмол нийлүүлэн ажиллав.**<br>Нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд үүсгэх их өгөгдлийн (Big Data) системд шаардлагатай мэдээллийг хэрхэн нууцлан хамгаалах, мөн бусад байгууллагын өгөгдөлтэй хэрхэн уялдуулах талаарх аргачлалыг | 90 |

боловсруулах, батлах ажилд оролцов. Энэхүү аргачлалд суурилан мэдээлэл нийлүүлэхэд шаардлагатай өгөгдлийн сангийн бүтэц, өгөгдлийн талбарууд, формат, нууцлалын зэрэглэл зэргийг тодорхойлж нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг /data/-ийг нийлүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.

Мөн улсын хэмжээнд үүсгэж буй их өгөгдлийн экосистемд өгөгдөл нийлүүлэх боломж, техникийн хэрэгжилтийг турших зорилгоор "И-Монгол" УТҮГ-тай хамтран туршилтын өгөгдөл дамжуулах, API холболт, өгөгдлийн формат, найдвартай байдал, хамгаалалтын түвшнийг шалгах тестүүдийг хийсэн.

Энэ хүрээнд харилцан тохирсон өгөгдлийн бүтэц, урсгалыг туршиж, шаардлагатай сайжруулалтыг хийж нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг /data/-ийг нийлүүлсэн.

Түүнчлэн **Засгийн газрын төвлөрсөн "Дашбоард систем"**-д зориулсан салбарын холбогдох мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж, тогтмол хүргүүлэн ажиллав.

**Хоёр. Иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор хүргэв.**

Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР систем болон нийгмийн даатгалын Portal.ndaatgal.mn веб системээр дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогч, харилцагч байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар тогтмол хүргэн ажиллав. Үүний дүнд:

2025 оны эхний 11 сарын байдлаар мэдээллийн нэгдсэн систем (Sicos)-ээр **259.2 мянган**, Portal.ndaatgal.mn системээр **216.2 мянган**, нийт **475.5 мянган** тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлт, мөн сар бүр **61.9 мянган** ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахимаар хүлээн авч **98.0%**-ийг шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | o Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт **153.4 мянган** хүсэлтийг хүлээн авч **98.9%-**ийг шийдвэрлэсэн байна;<br>o Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох нийт **230.9 мянган** хүсэлтийг хүлээн авч **97.5%-**ийг шийдвэрлэсэн байна.<br>o Өндөр нас, ХЧА-ны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох **80.8 мянган** иргэний хүсэлтийг хүлээн авч **96.9%-**ийг шийдвэрлэсэн байна.<br>o *Тэтгэвэр олголт:*<br>*сар бүр дунджаар **530.1 мянган** тэтгэвэр авагч (давхардсан тоогоор нийтдээ 6.1 сая)-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг системээр тооцоолон цаг хугацаанд нь холбогдох банк руу илгээсэн байна.<br>o *Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан:*<br>*нийт **61.9 мянган** ажил олгогчийн сар бүр илгээсэн **681.1 мянган** удаагийн, давхардсан тоогоор **8.8 сая** албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг **100%** цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.<br>*ажил олгогчоос цахимаар илгээсэн **81.1 мянган** албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>o *Эмнэлгийн хуудас:*<br>***992** эрүүл мэндийн байгууллагаас **176.7 мянган** албан журмын болон сайн дурын даатгуулагчийн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, **58.5 мянган** даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт **235.2 мянган** эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>o *Лавлагаа тодорхойлолт:*<br>E-Mongolia нэгдсэн портал болон Portal.ndaatgal.mn системээр иргэд даатгуулагч, | |

ажил олгогч нийт **6156.6 мянган** лавлагаа тодорхойлолтыг цахимаар авсан байна. Үүнд:

* Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи, монгол хэл/: **5536.3 мянга**
* Ажил олгогч шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт **92.6 мянга**.
*Нийгмийн даатгал төлж байсан эсэх тодорхойлолт: **273.5 мянга**
* Өндөр нас, ХЧА, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас /англи, монгол хэл/: **86.2 мянга**
* Иргэн /даатгуулагч/-д НДС-гаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт: **61.2 мянга**
* ХЧА-ын хувь, хугацаа тогтоосон акт: **51.2 мянга**
* Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа: **55.6 мянга.**

***www.opendata.gov.mn:***

* Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн Газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаарх нийгмийн даатгалын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган www.opendata.gov.mn болон www.ndaatgal.mn вэб сайтуудад цаг хугацаанд нь байршуулсан.

**Дөрөв. Иргэд, даатгуулагчид руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэв.**

Иргэд, даатгуулагч, ажил олгогч руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах боломжуудыг бүрдүүлэв. Тухайлбал:

**Тав. Portal.ndaatgal.mn системд өөрчлөлт, хөгжүүлэлт хийж нэвтрүүлэв.**

- Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр, ҮОМШӨ-ний

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүлж даатгуулагчаас цаасан баримт шаардахгүйгээр нийгмийн даатгалын мэдээллийн санд тулгуурлан даатгуулагчийн мэдээллийг цахимаар шалган тэтгэврийг цахимаар тогтоох боломж бүрдсэн. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээр нийт 210 даатгуулагч цахимаар тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасны 72.5 %-ийг шийдвэрлэсэн байна<br>- Ажил олгогчийн портал системийн хэрэглэгчийн эрхийн удирдлагыг сайжруулж айгууллагын дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан өөрийн ажлын чиг үүрэгт тохирсон эрхээр нэвтрэх боломжтой болж, эрхийн хуваарилалт, хязгаарлалтыг илүү тодорхой болгов.<br>- Нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх боломжийг бүрдүүлснээр ажил олгогчид илүү найдвартай, баталгаатай байдлаар тайлангаа илгээх нөхцөл бүрдсэн. 2025 оны эхний 11 сарын байдлаар 1.0 мянга гаруй ажил олгогч сар бүр тайлангаа тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна.<br>- Ажил олгогчдод системийн шинэчлэлт, өөрчлөлт болон бусад шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх зориулалтаар "Зар мэдээний булан" шинээр нэмэв.<br>- ҮОМШӨ-ий даатгуулагчийн сэргээн засах төв болон сувилалд ирэх буцах унааны зардлын хүсэлтийг **Portal.ndaatgal.mn вэб** системээр цахимаар авах хөгжүүлэлтийг хийж туршин нэвтрүүлэхэд бэлэн болгов.<br>- Цахим архивын программ хангамжид бүртгэсэн мэдээллийг салбарын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн нэгдсэн систем /SICOS/-д ашиглах боломжийг бүрдүүлж иргэд, даатгуулагчдад үзүүлэх үйлчилгээний хурд, чанар сайжирч, бичиг баримт шалгах, мэдээлэл баталгаажуулах үйл ажиллагаа богиносож, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрэн хангагдах болно. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Зургаа. "Тэтгэврийн нөөц сан"-гийн мөнгөжүүлсэн орлогыг тооцон олон сувгаар цахимаар хүргэх ажлыг зохион байгуулав.**<br><br>2025 оны 05 дугаар сард "Тэтгэврийн нөөц сан"-д байршуулсан 25.0 тэрбум төгрөг, 10 дугаар сард байршуулсан 40.0 тэрбум төгрөгийг даатгуулагчдад хуваарилан мөнгөжүүлсэн орлогоор бүртгэсэн.<br>Энэхүү мэдээллийг даатгуулагч "Нийгмийн даатгал" аппликейшн, "E-Mongolia" портал, Portal.ndaatgal.mn системээр дамжуулан "Мөнгөжүүлсэн хуримтлал"-ын мэдээллээ он, оноор сонгож харах боломжийг бүрдүүлэв.<br><br>**Долоо. Мэдээлэл солилцох сервис шинээр боловсруулан нэвтрүүлэв.**<br><br>**E-Mongolia** порталаар дамжуулан даатгуулагч **жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны** болон **ажилгүйдлийн тэтгэмж,** мөн **хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр** тогтоолгох хүсэлтийг **цахимаар** гаргах боломжийг бүрдүүлэх зориулалтаар холбогдох **4 төрлийн сервисийг** шинээр боловсруулан **И-Монгол УТҮГ**-т **хүргүүлэв.** | |
| 2.1.3.3 | ***Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.*** | | | | | | | |
| | 6 | Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч бүрийг "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал"-тай болгож, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх; | "Улсын төсөв, Бусад эх үүсвэр" 1,917,465.30 | Хуримтлалтай болсон даатгуулагч, мянган хүн | - | 1,400 | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар зохицуулсан.<br>Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө, төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, хяналт тавих журам"-ыг баталсан.<br>Тэтгэврийн нөөц санд 2024, 2025 онуудад улсын төсвөөс хөрөнгө хуваарилаагүй ба тэтгэврийн даатгалын санд төлөгдсөн шимтгэлийн | **90** |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | орлогоос арилжааны 4 банкан дахь (ХААН, Голомт, ХХБ, Төрийн банк) тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд 2024 онд 212.3 тэрбум төгрөг, 2025 онд нэмж 80.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлснээр нийтдээ 292.3 тэрбум төгрөгийг байршуулсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1,129.7 мянган хуримтлалтай болсон.<br>Тэтгэврийн нөөц сангийн үлдэгдэл 2025 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар /харилцахын дансны үлдэгдэлд тооцсон хүүг нэмж тооцсон/ 301.8 тэрбум төгрөг байна.<br>Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг даатгуулагч бүрээр бүртгэн мэдээллийг даатгуулагчдад "Нийгмийн даатгал" аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ системээр мөн E-Mongolia апплекейшний "Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал" цэсээр олон нийтэд ил тод мэдээлэн ажиллав. | |
| | ***Хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах хууль, эрх зүйн зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.*** | | | | | | | |
| 2.1.3.4 | 7 | Тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах зохицуулалтыг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нарийвчлан тусгах хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; | | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | 1.Тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хагас хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтын хүрээнд 2025 оны оны эхний 11 сарын байдлаар ажил олгогч, албан журмын даатгуулагчийн хувьд ажил олгогч болон даатгуулагчийн тус тус төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг тус тус 1 хувь, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувиар тооцон мөнгөжүүлж тэтгэврийн нөөц санд байршуулав.<br>2.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт "даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлнэ" гэж заасны дагуу даатгуулагч нас барвал түүний мөнгөжүүлсэн орлогыг хууль ёсны өв залгамжлагчид нь өвлүүлэх бөгөөд мөн хуулийн 29.7 дахь хэсэгт "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг энэ хуулийн 29.8-д заасан журмын дагуу өвлүүлнэ." гэж заасны дагуу нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр бол нэрийн дансны мөнгөжүүлсэн орлого, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт зарцуулах нийт хөрөнгийн хэмжээг тооцож, үлдэгдлийг мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 29.6 дахь хэсгийг 2030 оноос эхлэн хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 2030 оноос эхлэн нас барсан даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид Иргэний хууль болон Нотариатын тухай хуульд заасны дагуу өвлүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| | ***Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ.*** | | | | | | | |
| 2.1.3.5 | 8 | Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их хуралд өргөн мэдүүлэх; | | Арга хэмжээний хэрэгжилт, хувь | - | 100 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд зааснаар тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаас гадна, хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөрт сайн дурын үндсэн дээр хамрагдаж нэмэлт тэтгэвэр авах эрх зүйн орчинг бүрдүүлсэн.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоог бий болгох ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/48 дугаар тушаалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус газрын мэргэжилтэн томилогдон ажиллаж байна.<br>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн | 100 |
| | ***Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.*** | | | | | | | |
| 2.1.3.6. | 9 | Засгийн газар хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрийг | | Байгуулсан хэлэлцээр, өссөн дүнгээр | 6 | 7 | 1.Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 03 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулсан шинжээчдийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шинээр байгуулах; | | | | түвшний 3 дахь шатны уулзалтад оролцов. Уулзалтаар Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, харилцагч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох маягтыг хэлэлцэх уулзалтыг 2025 оны 9 дүгээр сард Австри Улсын Вена хотод хийхээр харилцан тохиролцов.<br>2."Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах талаар 2025 оны 09 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд БНАУ-ын нийгмийн даатгалын холбоонд зохион байгуулагдсан уулзалтад тус газрын удирдах, гүйцэтгэх 4 албан хаагч оролцов. Хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд солилцох холбогдох хууль тогтоомжийн гэрчилгээ, Мэдэгдэл, Тэтгэвэр тогтоолгох өргөдөл, Монгол Улсад/ Австри Улсад даатгуулсан бүртгэлийн гэрчилгээ, Эмнэлгийн дэлгэрэнгүй дүгнэлт, Бодит зардлын мэдэгдэл, Статистик мэдээлэл, Холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн статистик мэдээлэл зэрэг талууд хооронд мэдээлэл солилцож нийт 16 маягтыг хэлэлцэж нэгдмэл санал хүрсэн болно.<br>3.Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх 2 дахь удаагийн уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Уулзалтад Австралийн Нийгмийн үйлчилгээний яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь Австралийн Элчин сайдын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөл оролцож, дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулах, хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар санал солилцов.<br>Мөн Австралийн Холбооны Улстай “Нийгмийн хамгааллын хэлэлцээр” байгуулах хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан уулзалтаар хэлэлцээрийн төслийг боловсруулж, протокол үйлдэв.<br>4.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцээр"-ийн хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг соёрхон батлуулах явцын талаар харилцан мэдээлэл солилцов<br>Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг батлуулах хоёр улсын шинжээчдийн хамтарсан ажлын хэсэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 албан хаагч томилогдон ажиллав. Уг ажлын хэсэг 2017 онд байгуулагдсанаас хойш 18 удаагийн хэлэлцээ хийж, хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулсан. Хэлэлцээрийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн соёрхон батлав.<br>5. Бүгд Найрамдах Киргиз Улсын Нийгмийн сангийн газрын төлөөлөлтэй 2025 оны 04 дүгээр 30-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулан хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, тэтгэврийн бодлогын талаар харилцан туршлага солилцов.<br>6. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 5 дах удаагийн уулзалтад 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр оролцов. Уулзалтаар 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан 4 дэх шатны хэлэлцээрийн мөрөөр авсан арга хэмжээг хэлэлцэн цаашдын хэлэлцээний талаар санал солилцов | |
| 2.1.3.7 | ***Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгоно.*** | | | | | | | |
| | 10 | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг | | Нээлттэй байршуулсан мэдээлэл, хувь | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг | 100 | 1. **www.shilen.gov.mn** | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нээлттэй байршуулах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах; | | | www.shilen.gov.mn вебсайтад нийтэлж байна. | | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, мөнгөн хөрөнгийн 2024 оны мэдээллийг www.shilen.gov.mn цахим хуудаст байршуулав.<br>2025 онд Нийгмийн даатгалын сангийн орлогын 676, нийгмийн даатгалын сангийн зарлагын 2,246, мөнгөн хөрөнгийн 2,972, нийт 5,894 мэдээллийг байршуулан ажиллав.<br><br>2. ***www.opendata.gov.mn:***<br><br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн Газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2025 оны эхний хагас жилийн байдлаарх нийгмийн даатгалын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган www.opendata.gov.mn болон www.ndaatgal.mn вэб сайтуудад цаг хугацаанд нь байршуулсан.<br>3.Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2024 оны жилийн эцсийн, 2025 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, биелэлт, сар бүрийн сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулав<br>4.Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2024 оны "Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай" 14 дүгээр тогтоолын дагуу 2024 онд нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 300.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын дотоод үнэт цаас худалдан авсан ба гэрээний дагуу 2025 онд үнэт цаасны хүүгийн орлогоор 27.0 тэрбум төгрөгийг хүлээн авч сангийн хөрөнгийг өсгөн арвижуулав.<br>Мөн Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай" 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан.<br>Сангийн яамтай 2024 онд байгуулсан Засгийн газрын үнэт цаас худалдан авах гэрээний эхний 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хугацаа дууссан тул гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 179/НД-106/25 дугаар гэрээг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байгуулан 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатайгаар сунгаж өгөөжийг нэмэгдүүлэв.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15 хувийн хүүтэй, сар бүр хүү олгох нөхцөлтэйгөөр мөнгөн хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай байршуулж мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн.<br>Мөнгөн хадгаламжийн 2025 оны 05-11 дүгээр сарын хүү болох 61.2 тэрбум төгрөгийг холбогдох дансанд бүрэн хүлээн авч, банкуудтай тооцоо нийлэн баталгаажуулан ажиллав.<br>Дээрх мэдээллийг www.ndaatgal.mn вэб, shilen.dans.gov.mn цахим хуудас, байгууллагын цахим хуудас, фэйсбүүк, пэйж хаягаар мэдээлж ажиллав. | |
| **НИЙТ ДУНДАЖ** | | | | | | | | **95.8** |

--oOo—

"МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ"-Д НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилтот түвшин (Хувь) | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар) | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Он | Түвшин (Хувь) | | | |
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| ***Зорилго 3.4.1.*** Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ. | | | | | | | | |
| 3.4.1.1 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх | *Улсын төсөв* (304,726.7) | Тэтгэврийн нэмэгдлийн хувь | 2024 | 22.7 | 6 | Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов.<br>Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 300.1 тэрбум төгрөгийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуулиар батлуулж 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсны дүнд дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрч 6 хувиар өссөн болно. | 100 |
| **ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ** | | | | | | | | **100** |

--oOo--

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар агуулга | Шийдвэрийн дэс дугаар | Зүйл заалтын дэс дугаар | Биелэлт | Үнэлгээ /Шалтгаан/ | | | | | | Хэрэгжих боломжгүй | Хяналтаас хасуулах тухай санал /Хүчингүй болсон эсэх/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хэрэгжсэн | Хэрэгжих шатанд | | Хэрэгжээгүй | | Хугацаа болоогүй | | |
| | | | | | | Тодорхой үр дүнд хүрсэн | Удаашралтай /Эрчимжүүлэх | Зохион байгуулалтаас | Хөрөнгө дутагдснаас | | | |
| **1.в.Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол** | | | | | | | | | | | | |
| 1 | 2025.05.24<br><br>Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай<br><br>1.6.Нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой үүсэн маргааныг хууль тогтоомжийн дагуу эцэслэн шийдвэрлэх, шаардлагатай бол холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах; | №03 | 1.6 | Тус компани нь Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөөс эхлэн "Петрочайна дачин тамсаг" ХХК нэрээр нийгмийн даатгалын шимтгэл төлөгч байгууллагаар бүртгүүлэн өнөөдрийг хүртэл нийгмийн даатгалын шимтгэл төлж байна.<br>"Петрочайна дачин тамсаг" ХХК нь 2016-2024 онд 5,338 монгол ажилтан, 2,542 гадаад ажилтан, нийт 7,880 ажилтныг албан журмын нийгмийн даатгалд хамруулан 164.5 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг тооцож, нийт 36.3 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн.<br>Түүнчлэн Улсын Их Хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай" хуулийн дагуу тус компани нь 2020-2021 онд 2.6 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдсөн.<br>Тус компанид 2015-2022 оны хооронд Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, | | 50 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаас хийсэн хяналт шалгалтаар дараах зөрчлүүд илэрсэн байна.<br>- 2015 онд Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын даргын баталсан "Хяналт шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2013-2014 оны санхүүгийн баримтад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж улсын байцаагчийн актаар нэр бүхий ажилтнуудад олгосон 4.2 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дутуу тооцсон 979.1 сая төгрөгийн шимтгэл, 489.5 сая төгрөгийн алдангийг нөхөн төлүүлж илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан.<br>- 2016 онд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын баталсан "Хяналт шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2005-2012 оны санхүүгийн баримтад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж улсын байцаагчийн актаар нэр бүхий 125 ажилтанд олгосон 3.3 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дутуу тооцсон 793.7 сая төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлж илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан.<br>- 2019 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан "Хяналт шалгалтын ажлын удирдамж"-ийн дагуу хийсэн хяналт шалгалтаар "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2016-2018 оны санхүүгийн баримтад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж улсын байцаагчийн актаар нэр бүхий 4,404 ажилтанд олгосон 13.3 тэрбум төгрөгийн | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дутуу тооцсон 3.1 тэрбум төгрөгийн шимтгэл, 1.5 тэрбум төгрөгийн алдангийг нөхөн төлүүлж илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан.<br>- 2020 онд Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны шалгалтаар эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж "Петрочайна дачин тамсаг" ХХК-ийн 2019-2020 оны санхүүгийн баримтад Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж нэр бүхий 1,701 ажилтанд олгосон 6.3 тэрбум төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос дутуу тооцсон 1.6 тэрбум төгрөгийн шимтгэл нөхөн төлүүлэх шийдвэр гарч Зөрчлийн хэрэг нээн харьяаллын дагуу Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газарт шилжүүлсэн ба өнөөдрийн байдлаар шүүхийн шатанд хянагдаж байна. | | | | | | | | |
| **1.е.Засгийн газрын тогтоол** | | | | | | | | | | | | |
| 2 | 2025.02.26<br><br>Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай<br><br>1.Монгол үндэстний уламжлалт баяр цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 тасарч, шинийн 2, 3-ны өдөр бямба, ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 03, 04, 05-ны өдрийн даваа, мягмар, лхагва гарагт ажилтан, албан хаагчдыг амраах, 2025 оны ажлын жилд багтаан нөхөж ажиллуулах зохицуулалт хийх; | №109 | Бүх заалт | Монголын үндэсний уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдээр амарсан 2025 оны 03 дугаар сарын 03-ны Даваа гарагийн ажлын өдрийг, 03 дугаар сарын 04-ний Мягмар гарагийн ажлын өдрийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/57 дугаар тушаалаар 03 дугаар сарын 16-ны өдрийн Ням гараг, 03 дугаар сарын 25-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар 03 дугаар сарын 29-ний өдрийн Бямба гараг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/371 дүгээр тушаалаар 2025 оны 03 дугаар сарын 05-ны Лхагва гарагийн ажлын өдрийг 12 дугаар сарын 27-ны өдрийн Бямба гараг тус тус аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд шилжүүлэн ажиллуулав. | 100 | | | | | | | 6.4.1. |
| 3 | 2025.04.16 | №192 | | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг | | 50 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай<br><br>1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат /нэг жил болон түүнээс дээш/ бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 /гурван зуун/ тэрбум хүртэлх төгрөгөөр батлалсугай.<br>2. Хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | | | батлах тухай" 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан.<br>2025 онд хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хөрөнгийн биржээр нээлттэй худалдаж байгаа тул Нийгмийн даатгалын ерөнхий газар уг арилжаанд үнэт цаасны компаниар зуучлуулан оролцох шаардлагатай болсон тул Засгийн газрын 2024 оны "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1228 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | | | | | | | |
| 4 | 2025.06.04<br><br>Ажил, амралтын цагийн зохицуулалтын тухай<br><br>1.Үндэстний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь бямба, ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн лхагва, пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраах, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийх; | №279 | | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16.17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраах, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийх тухай Засгийн газрын 279 дүгээр тогтоолын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн "Ажил, амралтын өдөрт зохицуулалт хийх тухай" А/188 дугаар тушаалаар 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд нөхөн ажиллав. | 100 | | | | | | | 6.4.1 |
| 5 | 2025.12.03<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам батлах тухай | №183 | Бүх заалт | Тус журмаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | | | | ХБ | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 2025.12.03<br><br>Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө батлах тухай<br><br>2. **Төлөвлөгөөнд** нийцүүлэн салбарын хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг баталж, холбогдох хууль **тогтоомжийн** дагуу хяналт шалгалт хийж ажиллах; | | №184 | | Уул уурхай, барилга, замын бүтээн байгуулалтын ажилд туслан гүйцэтгэх ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагуудад нийгмийн хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт **шалгалт** хийх объектын жагсаалт батлагдаж ирээгүй бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр тогтоолт, олголт, Асаргааны тэтгэмж, амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмжийн тогтоолт, олголт, Протез, ортопед, тусгай хэрэгслийн нийлүүлэлт, олголт, Ахмадын амралт, сувилал, магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувиллын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг II,IV улиралд хийж гүйцэтгэнэ. | | | | | | ХБ | | |
| **1.ё.Ерөнхий сайдын захирамж** | | | | | | | | | | | | | |
| 7 | 2025.08.13<br><br>**Нийгэмд шударга ёсыг бэхжүүлэх, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай** | 3.9.Олон нийтэд ил тод болгохоор хуульд заасан мэдээллийг тухай бүр байгууллагын цахим хуудсанд нэлттэй байршуулж, тогтмол шинэчилж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулах; | №64 | 3.9 | Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай" А/20 дугаар тушаалыг баталсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж, шинэчилж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д Дотоод аудит, мониторингийн газар тогтмол хяналт тавьж ажилладаг бөгөөд мэдээллийн ил тод, нээлттэй байдалд улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийдэг.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсан байршуулж илгээдэг бөгөөд салбарын хэмжээнд Нийгмийн | 100 | | | | | | | |

даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д тогтмол хяналт тавьж, улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр салбарын хэмжээнд байгууллагын цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал Нийгмийн даатгалын ерөнхий газар 94.3 хувь, салбарын хэмжээнд 81.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.4 хувь;
- Хүний нөөц талаар мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.2 хувь;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.6 хувь;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.8 хувь;
- Бусад мэдээллийн ил, тод нээлттэй байдал 83.1 хувьтай байна.

Мөн мэдээлэл байршуулалтыг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг үнэлэх 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр үнэлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газар

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 92.3 хувь, салбарын хэмжээнд 81.0 хувьтай байна<br>Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (Shilen.gov.mn)-д байршуулах нээлттэй мэдээллийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах талаарх албан бичгийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Ажил зохион байгуулж, тайлан мэдээ ирүүлэх тухай" 02/2092 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлж ажиллав. | | | | | | | | |
| | | 5. Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлж, ил тод байдлыг бэхжүүлэн, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах; | | 5 | Нийгмийн даатгалын байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/109 дүгээр тушаалаар 3 зорилт, 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Төлөвлөгөөнд Авлигатай тэмцэх хүсэл зориг, хүчин чармайлтыг манлайлах, бүх түвшинд шударга ёсыг эрхэмлэж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах талаар дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд:<br>- Авлигатай тэмцэх газраас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар бэлтгэн гаргасан видео контент, нийтлэл, зурагт хуудас, нэвтрүүлэг, мэдээ бүхий 42 (давхардсан тоогоор) мэдээллийг тухай бүр нь Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээллийн самбар, албан ёсны цахим хуудсаар дамжуулан нийгмийн даатгалын салбарын албан хаагчид болон иргэд, даатгуулагчдад сурталчлан ажиллав.<br>- Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбарын тухай бүр шинэчилж, тогтмол ажиллуулах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын салбарын хэмжээд 31 самбарыг ажиллуулан | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | самбарын мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллав.<br>- *Шүгэл үлээхийг дэмжих зорилгоор мэдээлэл өгөх, хамгаалалтын арга хэлбэр, ач холбогдлын талаар албан хаагч, олон нийтэд сурталчлах арга хэмжээний хүрээнд*<br>✓ “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар Авлигын талаарх мэдээлэл өгөх сувгууд буюу Нийгмийн даатгалын байгууллагын дугаар, Авлигатай тэмцэх газрын 110 дугаар, Нийгмийн даатгалын байгууллагын Эрх бүхий албан тушаалтны мэдээллийг тус бүр байршуулав;<br>✓ Газрын албан хаагч нарт зориулсан санал хүлээн авах хайрцаг, албан хаагчдад зориулсан дотоод сургалтаар шүгэл үлээхийг дэмжих, аливаа хэлбэрээр хавчин гадуурхахгүй байх талаар томилох эрхий бүхий албан тушаалтан нар уриалан шүгэл үлээхийг дэмжихээ илэрхийлэв;<br>✓ Иргэд, даатгуулагчдад зориулсан Нийгмийн даатгалын байгууллагын цахим хуудас, цахим сүлжээгээр дамжуулан шүгэл үлээх боломжтой талаар богино хэмжээний видео бичлэг, постерыг бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулан ажиллав.<br><br>- *Нийгмийн даатгалын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллага хооронд байгуулж буй аливаа гэрээ, хэлэлцээрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар зохицуулалт тусгах арга хэмжээний хүрээнд:*Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын ерөнхий газрын арилжааны банкуудтай 2025 онд байгуулсан “Хамтран ажиллах гэрээ, бусад байгууллагатай хийсэн Хамтран ажиллах гэрээ, Санамж бичиг, Хөдөлмөрийн гэрээ, Ажил гүйцэтгэх гэрээ, Хөлсөөр ажиллах, | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс 2025 онд банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 700.0 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламж байршуулах гэрээ зэрэг бусад байгууллага, албан тушаалтантай байгуулсан 83 гэрээ, хэлцэл, санамж бичигт "Талууд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна" гэх заалтыг тусган Нийгмийн даатгалын ерөнхий газар авлигаас ангид байхаа илэрхийлэн ажиллав.<br>- Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг өргөжүүлэх замаар албан тушаалтнаас хамаарах нөлөөллийг багасгах, эрсдэлд өртөх магадлал, боломжийг бууруулах арга хэмжээний хүрээн дараах ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>- *Нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд* "Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын дунд хугацааны хөтөлбөр"-ийг боловсруулан Газрын даргын зөвлөлийн хурлаар 2 удаа хэлэлцүүлэн, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/138 дугаар тушаалаар батлав.<br>- Тухайн жилд Нийгмийн даатгалын байгууллагаас авлига ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай эрх бүхий байгууллагаас шаардлага хүргүүлсэн, ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн, үүссэн байж болзошгүй тохиолдолд зөрчлийг таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/1081 дугаар албан бичгээр "Улсын байцаагч нарын хувийн ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байж болзошгүй үйлдлийг шалгуулах тухай" албан бичиг, | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/1201 дугаар албан бичгээр “Баримт шалгуулах, хууль зөрчсөн байж болзошгүй тухай” албан бичгийг тус тус Авлигатай тэмцэх газарт, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Хуурамч бичиг баримт үйлдсэн эсэхийг тогтоолгох тухай” 01/1237 дугаар албан бичгийг Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газарт шалгуулахаар хүргүүлэн ажиллав.<br>- “Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 01/743 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажиллав.<br>- Нийгмийн даатгалын байгууллага, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нарт зориулан “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, түүний ойлголт”, “Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл” сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 12, 28-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад нийт 285, танхимаар 35, цахимаар 250 албан хаагч хамрагдав.<br>- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь” сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан бөгөөд сургалтад Нийгмийн даатгалын | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | еренхий газрын удирдлага болон нягтлан бодогч нийт 18 албан хаагч хамрагдав. | | | | | | | |
| **1.ж.Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | | | | | |
| 8 | 2025.01.14<br><br>"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III" –ын хэрэгжилтийн талаар<br><br>12.5. Монгол хэлний тухай хуулийн 7.2-т заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах болсон тул үг асуудлаар холбогдох байгууллагуудад "Зөвлөмж" хүргүүлж, хэрэгжилтийг нэгтгэн удирдлага, зохицуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах; | №03 | 12.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Сургалт зохион байгуулах тухай" 2025 оны А/07 дугаар тушаал. НД-10/25 дугаартай "Сургалтын гэрээ"-нд үндэслэн үндэсний Монгол бичгийн сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 93 албан хаагчийг хамруулан, 2025 оны 01 дүгээр сарын 13-наас 02 дугаар сарын 26-ны өдрийн хооронд танхимаар зохион байгуулав.<br>Сургалтыг "Тарвалин хийд"-ийн дэргэдэх шашины сургуулийн үндэсний монгол бичгийн багш Б.Базаррагчаа заан, нийт 20 удаагийн хичээл буюу 40 академик цагийн сургалтаар Монгол бичгийн үүсэл, үндсэн болон нэмэлт зурлага, тоо бичих, эгшиг үсэг, эгшиг зохицох ёсон, зөөлөн, хатуу дэвсгэр үсгийн дүрэм, үсэг холбох, төсгөх дүрэм, гадаад үг тэмдэглэх, дагавар, тийн ялгалын нөхцөл, монгол бичгийн фонт суулгах, ашиглах, дадлага ажлуудыг гараар бичих, компьютерээр бичих, гэрийн даалгавар, багаар ажиллуулан, тухай бүр шалган үнэлгээ өгч ажиллав. Нийт албан хаагчид дундаас дээш түвшинд Монгол бичигтэй болсон. НДЕГ-аас албан бичиг, тушаалыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Монгол бичгээр давхар хөтлөн явуулж байна. | 100 | | | | | | | 6.4.1 |
| 9 | 2025.07.23<br><br>Улсын хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн салбар дундын уялдааг хангах талаар 2026 оны төсвийн төсөлд тусгах саналын тухай<br><br>5.Төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй, шуурхай үзүүлэх, цахимжуулж ажиллах; | №09 | 5 | 1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/138 дугаар тушаалаар "Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын дунд хугацааны хөтөлбөр", 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан.<br>Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд 2025 онд хийгдэх хөгжүүлэлтийн ажлын төлөвлөгөө"-г баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, ажил олгогч, даатгуулагчдад нийт 75 төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагаас 47 төрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулаад байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай" А/253 дугаар тушаалаар хөдөлмөрийн чадвар алдсаны /мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний/ тэтгэвэр тогтоолгох цахим хүсэлт авах боломжийг даатгуулагчийн программ /https://portal.ndaatgal.mn/#/landing/-д бүрдүүлэн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж хүсэлтийг хүлээн авч тэтгэвэр тогтоох үйл явцыг хэрэгжүүлж байна.<br>Мөн байцаагч ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор 330 сумын нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын үйл ажиллагаанд SICOS системийг нэвтрүүлж, мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогчдод үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.<br>Цаашид нийгмийн даатгалын үйлчилгээг даатгуулагчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн, их өгөгдөлд тулгуурлан, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар авах боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | | | | | | | | |
| 10 | 2025.08.06<br>Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг олон нийтэд ил тод, нээлттэй болгох талаар | №11 | 9.1 | Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 оны хагас, бүтэн жил, 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудас (ndaatgal.mn)-т 2025 оны 08 | 100 | | | | | | | 6.4.5 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэлийн 2024 он болон 2025 оны эхний хагас жилийн тайлан, үнэлгээг байгууллагын цахим хуудсанд 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор байршуулан олон нийтэд ил тод, нээлттэй болгох; | | | | дугаар сарын 20-ны дотор бүрэн байршуулсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын хэмжээнд 2024 оны эхний хагас жилээр 57 албан хаагч, 2024 оны жилийн эцсийн байдлаар 78 албан хаагч, 2025 оны хагас жилийн байдлаар 85 төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон үнэлгээг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулж ажиллав. | | | | | | | | |
| 11 | 2025.08.06<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилтийн талаар<br>9.7 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1 дэх хэсгийн хэрэгжилттэй холбоотой нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахад цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар зөвлөмж, дүгнэлт гаргуулж байх; | | №11 | 9.7 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахтай холбоотой ажил үйлчилгээ 2025 онд гараагүй бөгөөд гарсан тохиолдолд Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны яамны холбогдох газраас зөвлөмж, дүгнэлт гаргуулж ажиллана. | 50 | | | | | | | |
| 12 | 2025.09.02<br>Ерөнхий сайдын 2025 оны 1, 2, 3, 4 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар | 1.2.Удаашралтай, гүйцэтгэл нь хангалтгүй байгаа үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, шуурхай зохион байгуулах; | №15 | 1.2 | Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/221 дүгээр тушаалаар "Ерөнхий сайдын албан даалгаврыг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжилтийг сар бүрийн 25-ны өдрийн дотор ирүүлж байхаар Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 08/1981 дүгээр албан бичгийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн.<br>Тус төлөвлөгөөнд 2 чиглэлээр 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Дээрх албан даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн өгөгдсөн үүрэг | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даалгаварт чиглэсэн ажлыг зохион байгуулж байгаа боловч зарим нэгжүүдэд хэрэгжилт хангалтгүй байгаа үүрэг даалгаврууд байна.<br>Иймд өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт үүрэг даалгавар өгч ажиллаж байна. | | | | | | | | |
| | | 1.2.Хамтран хэрэгжүүлэхээр даалгасан үүрэг, даалгаврыг биелүүлэхдээ ажлын уялдаа, холбоог сайжруулж, харилцан мэдээлэл солилцон, нягт хамтран ажиллах; | | 1.3 | Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар нь 2 хэсэг, 13 заалт, Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгавар нь "Иргэн, тээтэй, чадварлаг, мэргэшсэн, бүтээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх, төрийн албаны шинэтгэлийг эрчимжүүлэх чиглэл"-ийн хүрээнд 5 заалт, мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд өгөгдсөн даалгавар нийгмийн даатгалын салбарт хамаарах асуудлаар тусгагдсан 3 заалт байна.<br>Дээрх албан даалгаврын хэрэгжилтийн хувьд нэгжүүд хамтран хийх, мэдээлэл солилцох чиглэлээр ажиллаж, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 | | | | | | | |
| 13 | **2025.09.02**<br>**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд Заасан нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хийсэн 2024 оны үнэлгээний нэгдсэн тайлан**<br>1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд 2025 оны 10 дугаар сарын 01-ний дотор бүрэн байршуулах; | | №15 | 1 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан нээлттэй мэдээллийг үнэн зөв, иргэдэд ойлгомжтой байдлаар цахим хуудсандаа 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор бүрэн байршуулж илгээсэн бөгөөд салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д тогтмол хяналт тавьж, улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийдэг. | 100 | | | | | | | 6.4.5. |

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр салбарын хэмжээнд байгууллагын цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал Нийгмийн даатгалын ерөнхий газар 94.3 хувь, салбарын хэмжээнд 81.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:

- Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.4 хувь;
- Хүний нөөц талаар мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.2 хувь;
- Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил, тод нээлттэй байдал 82.6 хувь;
- Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал 79.8 хувь;
- Бусад мэдээллийн ил, тод нээлттэй байдал 83.1 хувьтай байна.

Мөн мэдээлэл байршуулалтыг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг үнэлэх 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр үнэлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газар 92.3 хувь, салбарын хэмжээнд 81.0 хувьтай байна

Мөн Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (Shilen.gov.mn)-д байршуулах нээлттэй мэдээллийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах талаарх албан бичгийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Ажил зохион байгуулж,

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тайлан мэдээ ирүүлэх тухай" 02/2092 дугаар албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. | | | | | | | |
| 14 | 2025.09.10<br>Иргэдээс төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2025 оны эхний хагас жилийн тайлангийн талаар<br><br>3.Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын бүртгэл, ангилал, шийдвэрлэлтийг нэгдсэн мэдээллийн санд тухай бүр бүртгүүлж байх; | №16 | 3 | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газарт 1,3 дугаар улирал, дүүргийн Нийгмийн даатгалын газар, албан тушаалтанд 2025 оны 1 дүгээр улиралд, аймгийн Нийгмийн даатгалын газар, албан тушаалтанд 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 3 дугаар улиралд иргэдээс ирүүлсэн, мөн Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төв 11-11 утсанд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэлх хугацаанд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын бүртгэл, түүнд ашиглаж байгаа программ, өргөдөл, гомдлын агуулга, шийдвэрлэлтийн байдал, өргөдөл гомдолд тусгагдсан асуудлуудад судалгаа хийх, үр дүнг тооцох, шийдвэрлэлтийн үйл ажиллагаа, дээд газарт хүргүүлж байгаа өргөдөл гомдлын мэдээ зэрэгт 3 удаа хяналт-шинжилгээ хийв.<br>Хяналт-шинжилгээ хийх явцад аймаг, дүүргийн Нийгмийн Нийгмийн даатгалын газруудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн систем, программын талаарх судалгааг гаргасан бөгөөд газрууд албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Able, ERP, E-Doc, E-office зэрэг 1-3 программ хангамжийг ашиглаж байгаа хэдий ч Булган, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын газрууд өргөдөл гомдлын бүртгэлд программ ашигладаггүй, өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэрт бүртгэж хяналтын карт хөтөлсөн байна.<br>Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдал, зөрчил, дүгнэлтийг гаргаж, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулж хяналт-шинжилгээний дүн мэдээ, | 100 | | | | | | |

тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1216, 02/1680 дугаар албан бичгээр болон цахимаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж байгууллагын цахим хуудаст мэдээлсэн.

Мөн Хяналт-шинжилгээний тайлан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1681 дүгээр албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. Тус зөвлөмжийн 2.2-т өргөдөл, гомдлыг Able программаар бүртгэлжүүлж, ашиглалтыг сайжруулахыг үүрэг болгосон.

2.Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар иргэд, даатгуулагчдаас нийтдээ 6,510 санал хүсэлт, асуулт, үүнээс www.ndaatgal.mn аппликейшний “Санал хүсэлт” булангаар дамжуулан 1,096 санал хүсэлт, sanal@ndaatgal.mn вэб хуудсаар 438, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 4,976 асуулт ирснийг ажлын 5 хоногт багтаан хариуг иргэд, даатгуулагчид утсаар болон цахим хаягаар нь хүргүүлэн ажиллалаа.

2025 оны жилийн эцсийн байдлаар аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудын “Callpro” утсанд нийтдээ 703,243 дуудлага ирснээс 537,618 дуудлагад хариулж, алдсан дуудлага 165,624 байна. Аймгийн Нийгмийн даатгалын газруудын хувьд дуудлага алдалт 12.4 хувьтай, нийслэлийн дүүргүүдийн хувьд 26.9 хувьтай, нийт дүнгээрээ 24 хувийн дуудлага алдалттай байна.

Нийгмийн даатгалын Дуудлагын төвийн 7777-1289 утсаар нийт 79 477 дуудлага хүлээн авснаас 52 914 нь мэдээллийн

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилтантай холбогдсон, 26563 нь автомат хариулагчаас мэдээлэл авсан байна.<br>Мөн иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор ажиллуулж буй @sigomongolia хуудасны чатбот мессенжерт нийт 81 020 иргэн хандсанаас, автомат хариулагчаас 49 942, зөвлөгөө мэдээлэл авсан 27 163, холбоос руу нэвтэрсэн 3 540, санал, хүсэлт 375 ирсэн байна.<br>Түүнчлэн "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай" хуулийн дагуу нийгмийн даатгалын байгууллагад 2025 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | | | | | | | |
| 15 | 2025.09.10<br>Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний тайлангийн дүнгийн талаар | 1.1.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн төслийг боловсруулахдаа тухайн асуудлаар өмнө нь гарсан шийдвэртэй утга агуулгын хувьд давхардуулан гаргахгүй байх, санхүү, төсвийн асуудлыг тусгасан, шалгуур үзүүлэлттэй, хэрэгжихүйц байхад анхаарах; | №16 | 1.1 | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн ХЭГ/2738 дугаар албан бичгийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/277 дугаар тушаалаар салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтэд судалгаа хийж давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулан ажиллаж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, биелэлтэд судалгаа хийж давхардал, хийдлийг илрүүлж, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж тайланг тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/2959 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.<br>Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдалд үндэслэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Үүрэг даалгавар хэрэгжүүлж ажиллах | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тухай"01/3075 дугаар албан бичгээр Зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮТ-ийн нийгмийн даатгалын тасгийн дарга нарт хүргүүлэв. | | | | | | | | |
| | | 1.2.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг өмнөх тайлант хугацааны биелэлттэй харьцуулж, салбарын хэмжээнд нэгтгэн, хүрсэн үр дүнг товч тодорхой, үнэн, зөв тайлагнах; | | 1.2 | Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр заасан хяналтад авсан зүйл, заалтуудын хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол нийт 18 шийдвэрийн 18 заалт байна.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 96.5 хувиар үнэлж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 01/1732 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухай бүр хяналтад авч бүртгэх, мөн зохион байгуулалтын нэгжийн дарга, албан хаагчдад танилцуулж биелэлтийг журамд заасан хугацаанд ирүүлж байхыг тус зөвлөмж болгов. | 100 | | | | | | | |
| | | 1.3.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зохицуулалтад шаардагдах төсөв хөрөнгийг шийдвэрлэх; | | 1.3 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаанд шаардагдах төсөв хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд тухай бүр шийдвэрлэж байна. | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1.4.Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллах; | | 1.4 | Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тайлагнахдаа салбар хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг тогтмол хянаж, үр дүнг нэмэгдүүлж ажиллахыг нэгжийн бүх удирдлагуудад үүрэг болгон ажиллаж байна.<br>Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдалд үндэслэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Үүрэг даалгавар хэрэгжүүлж ажиллах тухай"01/3075 дугаар албан бичгээр Зохион байгуулалтын нэгжийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮТ-ийн нийгмийн даатгалын тасгийн дарга нарт хүргүүлэв. | 100 | | | | | | | |
| 16 | 2025.09.24<br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар<br><br>1 "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүргэх, эрчимжүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; | №18 | 1 | Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөн"-д нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр "Хүний хөгжлийн бодлого" бүлгийн Зорилго 3.4.1-д "Тэтгэврийн насны хүн амын нийгмийн баталгааг дээшлүүлнэ" зорилтын хүрээнд 3.4.1.1-д "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх" гэсэн 1 арга хэмжээ тусгагдсан.<br>Энэхүү арга хэмжээний хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт "Тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ" гэж заасны дагуу Засгийн газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 221 дүгээр | 100 | | | | | | | 6.4.1 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоолоор нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувиар нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 689.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэврийн доод хэмжээг 572.4 мянган төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоов.<br>Уг тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд шаардагдах 300.1 тэрбум төгрөгийн төсвийг Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуулиар батлуулж 505.6 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулсны дүнд дундаж тэтгэвэр 832.7 мянган төгрөгт хүрч 6 хувиар өссөн бөгөөд хэрэгжилт 2025 оны төлөвлөсөн зорилтот түвшинд 100 хувь хүрсэн. | | | | | | | |
| 17 | 2025.09.24<br><br>Монгол Улсын Засгийн газрын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний дүнгийн талаар<br><br>1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх; | №18 | 1 | Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-д нийгмийн даатгалын чиглэлээр хэрэгжүүлэхээр: 2 бүлэг, 3 зорилго, 10 зорилт, 16 арга хэмжээ тусгагдсанаас Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй буюу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэх 5 арга хэмжээ, Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах 2 зорилт бүхий 11 арга хэмжээ байна.<br><br>Хяналт шинжилгээгээр:<br><br>- Хэрэгжиж дууссан 100 хувийн хэрэгжилттэй "***Үр дүн гарсан***" 1 арга хэмжээ;<br>- Хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа 10 арга хэмжээ; | 100 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа цаашид үргэлжлүүлэн хэрэгжих 10 арга хэмжээний хэрэгжилтийг авч үзвэл:<br><br>**“Үр дүнтэй”** буюу 87.8-100 хувийн хэрэгжилттэй 10 арга хэмжээ байна. Үүнд:<br><br>- 100 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ;<br>- 90 хувийн хэрэгжилттэй 3 арга хэмжээ;<br>- 87.8 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ;<br><br>Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн дунджийг жилийн эцсийн байдлаар 95.78 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэгдсэн. | | | | | | | | |
| 18 | 2025.09.24<br><br>Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах, төсвийн зарцуулалтын хяналтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийн мөрөөр<br><br>3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд ил тод, нээлттэй байхаар заасныг болон Төрийн болон албаны нууцын тухай хууль, журмыг зөрчин үндэслэлгүйгээр нууцалсан мэдээллийг ил болгох ажлыг шуурхай зохион байгуулах | №18 | 3 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/48 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Нийгмийн даатгалын байгууллагын албаны нууцад хамаарах 12 төрлийн мэдээллийг албаны нууцад хамааруулсан үндэслэл, мэдээллийн хүрээнд үүсч хөтлөгдөж буй баримт бичгийн тоо, задруулах үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллагын ашиг сонирхол, үйл ажиллагаанд хэрхэн хохирол учруулах, төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл хэрхэн бий болох талаарх тайлбар бүхий дэлгэрэнгүй судалгааг гаргаж Тагнуулын ерөнхий газарт Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/1962 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Мөн уг жагсаалтад шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах, бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан мэдээ, мэдээллийг ил болгох талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг Нийгмийн | | 50 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, танилцуулгыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 01/2667 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | | | | | | | |
| 19 | 2025.10.08<br><br>Төрийн байгууллагуудад ашиглагдаж байгаа цахим систем, мэдээллийн санд дүн шинжилгээ хийсэн ажлын хэрэгжилт | 1.Эрхлэх асуудлын хүрээнд бүрдүүлсэн төрөлжсөн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг "Төрийн мета-өгөгдлийн нэгдсэн сан"-д бүртгүүлэх; | №20 | 1 | Нийгмийн даатгалын мэдээллийн сангийн мета өгөгдлийг Үндэсний статистикийн хороонд холбогдох журмын дагуу хүргүүлэн metadata.nso.mn хуудсанд байршуулсан. Үүнд "Нийгмийн даатгалын орлогын бүтээгдэхүүн" 32 үзүүлэлт, "Нийгмийн даатгалын зардлын бүтээгдэхүүн" 14 үзүүлэлт бүхий мэдээллийг статистикийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. | 100 | | | | | | | |
| | | 2.Төрийн байгууллагуудын ашиглаж байгаа цахим систем болон мэдээллийн санг цахим систем (System.gov.mn)-д бүртгүүлэх; | | 2 | Мэдээллийн системийн бүртгэл, дүгнэлт, зөвлөмжийн систем (system.gov.mn) -д нийгмийн даатгалын салбарт ашиглагдаж буй "Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем", "Able" - Албан бичиг" системүүдийг бүртгүүлж, холбогдох мэдээллийг байршуулсан. | 100 | | | | | | | |
| | | 3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр үзүүлэх; | | 3 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт заасны дагуу төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ээр дамжуулан иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилтын хүрээнд нийгмийн даатгалын байгууллага нь иргэд, даатгуулагч, ажил олгогч болон харилцагч байгууллагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг өргөжүүлэх, бодит цагийн горимоор цахимаар хүргэх ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.<br>Энэхүү ажлын хүрээнд төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системээр дамжуулан нийгмийн даатгалтай холбоотой нэг шатлалт 12 төрлийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Үүний үр дүнд 2025 онд: | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Иргэд, даатгуулагч болон ажил олгогчид нийт 5.9 сая удаагийн лавлагаа, тодорхойлолтыг E-Mongolia системээр дамжуулан цахимаар авсан;<br>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи, монгол хэл/-ыг 5.5 сая удаа;<br>- Нийгмийн даатгал төлж байсан эсэх тодорхойлолтыг 273.5 мянган удаа;<br>- Өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас /англи, монгол хэл/-ыг 86.2 мянган удаа;<br>- Иргэн /даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолтыг 61.2 мянган удаа;<br>- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актыг 51.2 мянган удаа;<br>- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагааг 55.6 мянган удаа;<br>- Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтыг 204 удаа тус тус авсан байна.<br><br>Түүнчлэн нийгмийн даатгалын хоёр шатлалт үйлчилгээнүүд болох ажилгүйдлийн тэтгэмж, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах хүсэлтийг E-Mongolia системээр дамжуулан хүлээн авахтай холбоотой мэдээллийг И-Монгол УТҮГ-т хүргүүлээд байна. | | | | | | | | |
| 20 | 2025.11.05<br><br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01, 02, 03, 04 Албан даалгавраар өгсөн хугацаатай үүрэг даалгаврын талаар | №26 | | Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны "Хугацаатай үүрэг, даалгавар өгөх тухай" ХЭГ/3155 дугаар албан бичиг, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Хугацаатай үүрэг, даалгавар хүргүүлэх тухай" 02/3631 албан бичгийн дагуу Ерөнхий сайдын Албан даалгавар, Засгийн | 100 | | | | | | | 6.4.1 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын 26 дугаар хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн тайлан, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3137 дугаар албан бичгээр 15 хуудас бүхий хавсралтаар Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн | | | | | | | | |
| 21 | 2025.12.17 Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар | 1.1.захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайланг үндэслэн ач холбогдлоо алдаж, дагаж мөрдөхгүй болсон шийдвэрүүдийг хүчингүй болгох, хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөн хийх; | №33 | 1.1 | Хугацаа болоогүй | | | | | | ХБ | | |
| | | 1.2.хуулиар тусгайлан эрх олгосон захиргааны байгууллага өөрчлөгдсөнтэй холбогдуулан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрүүдийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх; | | 1.2 | Хугацаа болоогүй | | | | | | ХБ | | |
| | | 1.3.хуулиар тусгайлан захиргааны хэм хэмжээний акт батлах, эрх олгосны дагуу баталсан боловч захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд | | 1.3 | Хугацаа болоогүй | | | | | | ХБ | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүртгүүлээгүй шийдвэрийг 2026 оны 1 дүгээр улиралд багтаан бүртгүүлэх; | | | | | | | | | | | |
| | | 1.4.захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой зохицуулалт агуулсан захиргааны хэм хэмжээний актыг хуульд нийцүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах; | | 1.4 | Хугацаа болоогүй | | | | | | ХБ | | |
| **1.з.Ерөнхий сайдын албан даалгавар** | | | | | | | | | | | | | |
| 22 | 2025.06.18 №01<br><br>Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг сайжруулах тухай | 1.1.Шинжлэх ухааны судалгаа, нотолгоонд суурилсан шийдвэр гаргаж, ард иргэдээ сонсон, итгэл, хүлээлт, шаардлагад нь нийцэж ажиллах | №01 | 1.1 | Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн саналыг холбогдох хууль, тогтоомж, судалгаа, тооцоолold үндэслэн /тэтгэврийн хэмжээг 2026 онд 10.3 хувиар нэмэгдүүлэхээр тусгасан/ боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны "Төсвийн төсөл, төсөөллийн санал хүргүүлэх тухай" 01/1740 тоот албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Монгол Улсын Засгийн газраас 2026 оны төсвийн төсөлд тэтгэврийн хэмжээг 6.0 хувиар нэмэгдүүлэх, тэтгэврийн нэмэгдэлд 333.5 тэрбум төгрөг зарцуулах тооцооллын хамт Улсын Их Хуралд өргөн барьсан.<br>Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2026 оны төсвийн төслийг хэлэлцэх үеэр ард иргэдээс тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж 1,500.0 мянган төгрөг болгох шаардлага тавьсны дагуу тэтгэврийн доод хэмжээг 1,000.0 болон 1,500.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэх, тэтгэврийг тогтмол дүнгээр буюу 73.0 мянган төгрөг, 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, тэтгэврийг 8.0, 8.6, 10.3 хувиар нэмэгдүүлэх зэрэг | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хувилбаруудаар тооцооллуудыг тус тус хийж, тухай бүр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлж ажиллав.<br>Дээрх тооцооллуудад үндэслэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсөвт тэтгэврийг 8.6 хувиар нэмэгдүүлэх, тэтгэврийн нэмэгдэлд 478.0 тэрбум төгрөгийг зарцуулахаар эцэслэн батлав.<br>Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэхээр шийдвэрлэсний дагуу тэтгэврийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 524.7 мянган тэтгэвэр авагчид 496.1 тэрбум төгрөгийн тэтгэврийг хугацаанд нь олгов. | | | | | | | | |
| | | 1.2.Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах | | 1.2 | Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангах бодлогын хүрээнд нийгмийн даатгалын байгууллага байцаагч, ажилтнуудыг мэргэшүүлэх, иргэд, даатгуулагчдад чирэгдэлгүй, түргэн шуурхай, мэргэжлийн түвшинд үйлчилгээ үзүүлэх, мэргэшсэн төрийн албан хаагчдыг бэлтгэх, нийгмийн баталгааг нь хангах зорилгоор нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах шалгалтыг жил бүр зохион байгуулан ажиллаж байна.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/208 дугаар тушаал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн "Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын хуудасны загвар батлах тухай" А/303 дугаар тушаалын дагуу улсын байцаагчийн | 100 | | | | | | | |

шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр багтаан зохион байгуулав.

Салбарын удирдлагын манлайллыг мэргэжлийн түвшинд хариуцлагатай хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж ажиллах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:

- Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө"-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын салбарын "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, Төрийн албаны зөвлөлийн "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" дэд системд байршуулав.
- Төлөвлөгөөнд тусгасны дагуу Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав.
- Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороонд 2025 онд ирүүлсэн 6 гомдол мэдээллийг шалгаж, 2 албан хаагч зөрчил гаргасан талаарх дүгнэлтийг Ёс зүйн дэд хорооны 2025 оны 04, 06 дугаар дүгнэлтээр томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэн ажиллав.
- Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | “Төрийн албаны шинэчлэл” хэлэлцүүлэгт оролцов.<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар “Төрийн албан хаагч бид” гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим хуудаст байршуулан түгээн ажиллав. | | | | | | | | |
| | | 1.3.Сахилга, хариуцлагыг өндөржүүлж, бүх шатанд төсвийн хэмнэлтийн горимыг сахин, үр ашиггүй зардлыг танах, төрийн байгууллагын бүтэц, чиг үүргийн давхардлыг арилгаж, орон тоог үе шаттай цөөлөх | | 1.3 | 1.Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд нэмэлт оруулсантай холбогдуулан төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагч нарыг батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаарт багтаан зарлагыг санхүүжүүлэн өр, авлага үүсгэхгүй ажиллахыг үүрэг болгосон.<br>Уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан төсөвтөө багтаан тухайн сардаа зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй, төсвийн сахилга бат, санхүүгийн хариуцлагыг хангаж ажиллах чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны “Чиглэл хүргүүлэх тухай” 01/2381 дугээр албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>2.Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлогын хүрээнд Гэр бүл, | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" А/163 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын 1477 орон тоог 136-аар бууруулан 1341 тоотой байхаар шинэчлэн баталсны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/237, "Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/238, "Аймгийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/239 дүгээр тушаалуудаар нийгмийн даатгалын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | | | | | | | | |
| | | 1.4.Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инноваци, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах | | 1.4 | Ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө гарган, цахим шилжилтийг эрчимжүүлэх, салбарын онцлогт нийцсэн инноваци, шинэ технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, шийдвэр гаргалтад хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах чиглэлээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд:<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/138 дугаар тушаалаар "Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжуулалтын дунд хугацааны хөтөлбөр"," 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г баталсан. Дээрх хөтөлбөрийг | 100 | | | | | | | |

хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд 2025 онд хийгдэх хөгжүүлэлтийн ажлын төлөвлөгөө"-г баталж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

2. Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн цогц системийг 2024 оны 1 дүгээр сараас эхлэн үе шаттайгаар шинэчлэн нэвтрүүлж байна. Энэхүү систем нь уян хатан, динамик технологид суурилсан бүтээмж өндөртэй систем бөгөөд бодит цагийн (real-time online) өгөгдлийн санг бүрдүүлж, иргэд, даатгуулагчид, ажил олгогч болон харилцагч байгууллагуудад шуурхай, найдвартай үйлчилгээг бодит цагийн горимоор үзүүлэх боломжийг бүрдүүлсэн Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж буй томоохон мэдээллийн систем юм.

3. Нийгмийн даатгалын байгууллагаас иргэд, ажил олгогч, даатгуулагчдад нийтдээ 75 төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагаас 46 төрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулаад байна.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай" А/253 дугаар тушаалаар хөдөлмөрийн чадвар алдсаны /мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний/ тэтгэвэр тогтоолгох цахим хүсэлт авах боломжийг даатгуулагчийн программ /https://portal.ndaatgal.mn/#/landing/-д бүрдүүлэн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж хүсэлтийг хүлээн авч тэтгэвэр тогтоох үйл явцыг хялбарчилав.

5. Байцаагч ажилтнуудын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор 330 сумын нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын үйл ажиллагаанд SICOS системийг нэвтрүүлж, мэдээллийн нэгдсэн системээр дамжуулан иргэд, даатгуулагч,

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажил олгогчдод үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэв.<br>6. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Төсөв, гүйцэтгэл" төрлийн "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ" цэс дэх мэдээллийг мэдээлэхэд цаг хугацаа их шаардагддаг тул албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, ажил олгогч, даатгуулагч, иргэдийг үнэн зөв бодит мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд түргэн шуурхай хүргэх зорилгоор дээрх мэдээллийг Шилэн дансны цахим хуудаст автоматаар оруулах (роботжуулах) үйл ажиллагааг нэвтрүүлсэн. | | | | | | | | |
| | | 1.5.Улс төрөөс ангид чадахуйн зарчимд суурилсан хүртээмжтэй, шуурхай, хариуцлагатай төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг эрс бууруулах бодитой ажлыг зохион байгуулан, тодорхой ахиц гаргаж, үр дүнг тайлагнах | | 1.5 | Төрийн албыг бэхжүүлж, хүнд суртал, шат дамжлагыг бууруулах ажлын хүрээнд иргэд даатгуулагч, ажил олгогчдод цахимаар мэдээллээ хурдан шуурхай авах, үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэн цахим үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн ажиллав. Үүнд:<br>- Иргэд, ажил олгогч, даатгуулагчдад нийт 75 төрлийн үйлчилгээ үзүүлж байгаагаас 46 төрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулав. Тухайлбал:<br>✓Иргэд даатгуулагч, ажил олгогчид зориулсан "Иргэний болон ажил олгогчийн портал систем" /Portal.ndaatgal.mn/"-ээр сайн дураар даатгуулагч нь сайн дурын гэрээ байгуулах /5 төрөл/;<br>✓Шимтгэл төлөх, жирэмсний болон амаржсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж болон тэтгэвэр, ҮОМШӨ хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлтийг илгээх;<br>✓Лавлагаа тодорхойлолт авах, мөнгөжүүлсэн орлогын дүнгээ харах зэрэг үйлчилгээнүүдийг цахимаар авч байна.<br>✓Мөн Portal.ndaatgal.mn системээр ажил олгогч нь ажилтны тушаалын мэдээллийг бүртгэх, нийгмийн даатгалын шимтгэлийн | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайлангаа илгээх, шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолтоо авах, албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлт илгээх зэрэг үйлчилгээг цахимаар авч байна.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай" A/253 дугаар тушаалаар хөдөлмөрийн чадвар алдсаны /мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний/ тэтгэвэр тогтоолгох цахим хүсэлт авах боломжийг даатгуулагчийн программ /https://portal.ndaatgal.mn/#/landing/-д бүрдүүлэн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч тэтгэвэр тогтоож байна.<br><br>Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн порталаар иргэд даатгуулагч, ажил олгогч нийгмийн даатгалын 12 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авч байна. | | | | | | | | |
| | | 1.6.Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх бодитой арга хэмжээг авч, хэрэгжүүлэх | | 1.6 | 1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх зорилгоор холбогдох журамд заасны дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгааны 8 арга хэмжээг хувийн хэвшлээр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын 6 арга хэмжээг хувийн хэвшлээр, 3 | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | арга хэмжээг төрийн бус байгууллагаар, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах 1 арга хэмжээг хувийн хэвшлээр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний чиглэлээр хийх тандан судалгаа, эрсдэлийн болон хяналт шинжилгээ, үнэлгээний 4 арга хэмжээг хувийн хэвшлээр, 4 арга хэмжээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэж ажиллав.<br>2. Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банкнаас авах нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө тооцон хүлээн авч борлуулан авлага барагдуулах ажлыг зохион байгуулсан.<br>Энэхүү ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Капитал банк болон Чингис хаан банкны нийгмийн даатгалын санд төлөх өр төлбөрийг барагдуулах чиглэлээр мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх "Дэлгэрэнгүй хууль" НҮТББ-тай НДЕГ/20250103001 дугаартай гэрээг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулан, ажлын төлөвлөгөө гарган ажилласан ба тайлант онд 16 ажил гүйцэтгэж, гэрээг дүгнэсэн. | | | | | | | | |
| | | 1.7.Салбарын хэмжээнд нэн тулгамдсан шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай асуудлыг Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд тусгуулан шуурхай шийдвэрлэх | | 1.7 | Засгийн газрын 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх ажлыг тусгуулав. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 11 дүгээр тогтоолоор нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3,000,000 /гурван сая/ | 100 | | | | | | | 6.4.5 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төгрөг, амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоож, 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж ажиллахаар шийдвэрлэв.<br>Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 2026 онд зарцуулах зардлын төсвийн дээрх батлагдсан дүнгээр тооцож, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан бөгөөд 14.8 тэрбум төгрөгөөр батлагдсан болно. | | | | | | | | |
| | | 1.8.Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаанд оролцох журмыг чанд мөрдөж, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгүүдтэй нягт уялдаатай ажиллах, хүндэтгэлтэй хандах | | 1.8 | 1.Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, Х.Баасанжаргал, Б.Түвшин, Ө.Шижир, Д.Энхтүвшин нараас тус тус ирүүлсэн албан бичгийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, даатгуулагчид, тэтгэвэр, тэтгэмж авагчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатараас ирүүлсэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төсөлд өгөх саналаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1111, 04/1373, 01/1526, 01/1782, 01/2597, 01/2864 дүгээр албан бичгүүдээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамаар уламжлан хүргүүлэв.<br>2.Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс ирүүлсэн албан бичгийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажил олгогч, даатгуулагчид, тэтгэмж авагчдын судалгааг Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 01/1656 дугаар албан бичгээр хүргүүлэв. | | | | | | | | |
| | | 2.1.Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, гадаад бодлогын үзэл баримтлал болон бусад хууль тогтоомжийг чанд мөрдөж, зөрчсөн үйлдэл гаргахгүй байх | | 2.1 | 1."Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн хэрэгжилтийг хангах, ослын даатгалын тогтолцоог судлах ажлын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотод байрлах тус улсын нийгмийн даатгалын холбоонд Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдах, гүйцэтгэх 4 албан хаагч ажиллав. Албан томилолтын хүрээнд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд солилцох Холбогдох хууль тогтоомжийн гэрчилгээ, Мэдэгдэл, Тэтгэвэр тогтоолгох өргөдөл, Монгол Улсад/ Австри Улсад даатгуулсан бүртгэлийн гэрчилгээ, Эмнэлгийн дэлгэрэнгүй дүгнэлт, Бодит зардлын мэдэгдэл, Статистик мэдээлэл, Холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн статистик мэдээлэл зэрэг талууд хооронд мэдээлэл солилцох 16 маягтыг хэлэлцэж нэгдмэл саналд хүрлээ.<br>2.Засгийн газар Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг батлуулах хоёр улсын шинжээчдийн хамтарсан ажлын хэсэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 албан хаагч томилогдон ажиллав. Уг ажлын хэсэг 2017 онд байгуулагдсанаас хойш 18 удаагийн хэлэлцээ хийж, хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулсан. Уг хэлэлцээрийг Улсын Их хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж соёрхон баталлаа. | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 3.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 5 дах удаагийн уулзалтад 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр оролцов. Уулзалтаар 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан 4 дэх шатны уулзалтын мөрөөр авсан арга хэмжээг хэлэлцэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцов.<br>4.Австралийн Холбооны Улстай "Нийгмийн хамгааллын хэлэлцээр" байгуулахаар 2024 оноос ажиллаж байгаа бөгөөд талууд 2025. Оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо биечилсэн уулзаж хэлэлцээг зохион байгуулав.<br>5.Гадаад улсад ажиллаж амьдарч буй Монгол Иргэдэд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг танилцуулах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Унгар Улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн талаар 2025 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Бүгд Найрамдах Австри Улсад оршин суугаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн талаар 2025 оны 10 дугаар сарын 12-ны өдөр, Бүгд Найрамдах Чех Улсад оршин суугаа Монгол Улсын иргэдэд Нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээрийн талаар 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдөр тус тус биечлэн болон цахимаар мэдээлэл өгч, иргэдийн асуултад хариулж, санал хүсэлтийг хүлээн авч ажиллав. | | | | | | | | |
| | | 2.2.Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг зохих журмын дагуу ил | | 2.2 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны А/48 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан Нийгмийн даатгалын байгууллагын албаны нууцад хамаарах 12 төрлийн мэдээллийг албаны нууцад хамааруулсан үндэслэл, мэдээллийн | | 50 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | болгох арга хэмжээг арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | | хүрээнд үүсч хөтлөгдөж буй баримт бичгийн тоо, задруулах үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллагын ашиг сонирхол, үйл ажиллагаанд хэрхэн хохирол учруулах, төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл хэрхэн бий болох талаарх тайлбар бүхий дэлгэрэнгүй судалгааг гаргаж Тагнуулын ерөнхий газарт Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 01/1962 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Мөн уг жагсаалтад шинжилгээ хийж, шинэчлэн боловсруулах, бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан мэдээ, мэдээллийг ил болгох талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/266 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Ажлын хэсгээс гаргасан дүгнэлт, танилцуулгыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын17-ны өдрийн 01/2667 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | | | | | | | |
| | | 2.3.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгах үүргийн биелэлтэд харьяа байгууллага, хуулийн этгээдийн хэмжээнд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох | | 2.3 | Нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэгт хамаарах нээлттэй мэдээллийг олон нийтэд хүргэх, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай" А/20 дугаар тушаалыг баталсан.<br>Нийгмийн даатгалын байгууллагын ил тод байдлыг хангах зорилгоор нээлттэй мэдээллийг тогтмол шинэчилж, shilen.gov.mn системд байршуулж байгаа бөгөөд мэдээллийн үнэн зөв, заасан хугацаанд мэдээлж байгаа эсэхэд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн | | 50 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар тогтмол хяналт тавьж мэдээлэл, зөвлөмжөөр хангаж ажиллаж байна.<br>Байгууллагын цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлээгүй, хугацаа хоцроож мэдээлсэн, дутуу мэдээлсэн, мэдээллийг шинэчлээгүй, мэдээлэл хариуцагчаас тавьсан мэдээллийн эх сурвалж тодорхойгүй, мэдээллийн бүрэн бүтэн байдал хангалтгүй, хамааралгүй мэдээлэл байршуулсан зэрэг нийтлэг алдаа дутагдал давтагдсаар байна.<br>Иймд илэрсэн алдаа дутагдалд дүгнэлт хийж, мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай" 02/259 дугаар Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.<br>Мөн Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (Shilen.gov.mn)-д байршуулах нээлттэй мэдээллийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах талаарх албан бичгийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Ажил зохион байгуулж, тайлан мэдээ ирүүлэх тухай" 02/2092 дугаар албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. | | | | | | | | |
| | | 2.4.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Нийгмийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмж хэрэг, хүнд | | 2.4 | *Ашиг сонирхолын зөрчлөөс ангид ажиллаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг, хүнд суртал, шударга бус байдалтай туушгай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх арга хэмжээний хүрээнд:*<br><br>- Нийгмийн даатгалын байгууллага, Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүд, Эрүүл | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | суртал, шударга бус байдалтай тууштай тэмцэх, таслан зогсоох, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглахгүй байх, төрийн байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх | | | мэндийн магадлалын төв зөвлөлийн болон аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч нарт зориулан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, түүний ойлголт", "Авлигын гэмт хэрэг ба авлигын хор хөнөөл" сэдэвт сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 12, 28-ны өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад нийт 285, танхимаар 35, цахимаар 250 албан хаагч хамрагдав.<br>- Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх нь" сэдэвт сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын удирдлага, нягтлан бодогч нийт 18 албан хаагч хамрагдав.<br>- Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн төлөвлөгөөт шалгалтаар эрх бүхий нийтийн албан тушаалтан өөрийн эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж бусдад давуу байдал би болгосон байх магадлалтай, гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар Авилгатай тэмцэх газар, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар, Нийслэлийн прокурорын газарт 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 01/1237, 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/1540 дугээр албан бичгүүдээр хандаж, нотлох баримтыг хүргүүлэн ажиллав. Уг ажлын хүрээд Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газарт хуурамч баримт бичиг үйлдсэн үйлдэлд Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт ажиллаж байсан Д.Бат-Эрдэнийг яллагдагчаар татаж, Авлигатай тэмцэх газарт бусдад давуу байдал олгосон Н.Ариунаад холбогдуулан хэрэг үүсгэж мөрдөн шалгах ажиллагаа үргэлжиж байна. | | | | | | | | |

- Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын дарга С.Нямжав өөрийн удирдлага доор ажиллаж байгаа албан хаагчид хөндлөнгөөс нөлөөлж өөрийн хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгосон үйлдлийн талаах Авлигатай тэмцэх газарт 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 01/1545 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Эрх бүхий байгууллагаас хэрэг үүсгэн шалгаж, С.Нямжавыг яллагдагчаар татаж, 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 болон 8.5 дугаар зүйлд заасны дагуу хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тогтоосон тул 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Завхан аймгийн прокурорын газарт хохирогч, иргэний нэхэмжлэгчээр мэдүүлэг өгч ажиллав.
- 2025 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж"-ийн дагуу "Томъёо сургууль цэцэрлэгийн цогцолбор" аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийх явцад Нийгмийн даатгалын ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтнууд хахууль нэхсэн талаар мэдээллийг Томъёо сургуулийн нягтлангаас ирүүлсэнийг Авлигатай тэмцэх газарт шалгуулах хүсэлт хүргүүлж хэрэг бүртгэлийн хэрэг нээж шалгалт явагдаж байна.

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар "Төрийн албан хаагч бид" гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, аймаг, дүүргийн Нийгмийн

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгалын 30 газрын цахим хуудаст байршуулан түгээв.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран жил бүр зохион байгуулдаг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтыг цахим хэлбэрээр 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж сургалтад салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн 250 гаруй дарга, гишүүд хамрагдав.<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ЭММЗ-д 6 жилээс дээш ажиллаж байгаа төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг өөрчлөх тухай чиглэлийг Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр 09/2110 дугаар албан бичгийг салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дарга нарт хүргүүлэв. | | | | | | | | |
| | | 2.5.Төрийн албан хаагчийн хууль бусаар томилж, чөлөөлөх, аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэхгүй байх | | 2.5 | 1.Нийгмийн даатгалын байгууллага нь мерит зарчмыг эрхэмлэн ажилладаг бөгөөд анхан шатны байгууллагад идэвх санаачлагатай ажилласан албан хаагчдыг шилжүүлэн дээд шатны байгууллагад томилон ажиллуулж байна.<br>Нийгмийн даатгалын байгууллага нь мерит зарчмыг эрхэмлэн ажилладаг бөгөөд анхан шатны байгууллагад идэвх санаачлагатай ажилласан албан хаагчдыг шилжүүлэн дээд шатны байгууллагад томилон ажиллуулж байна. 2025 онд 8 төрийн жинхэнэ албан хаагчид тус газраас дэвшин дээд шатны байгууллагад ажилласан бөгөөд 11 төрийн албан хаагчид албан тушаалын адил ангилал, зэрэглэлд хууль, журамд нийцүүлэн шилжин ажилласан байна. | 100 | | | | | | | |

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг Төрийн албаны хууль болон бусад хууль, журмын дагуу шилжүүлэн томилж, чөлөөлж байна.

2.Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссоос ирүүлсэн 2025 оны 06/08 дугаар "Зөвлөмж"-ийн дагуу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах талаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/473 дугаар албан бичиг, "Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хуулиар тогтоосон хүний ажил хөдөлмөр эрхлэх эрхийг хязгаарлахгүй байх, ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх зөвлөгөөг өгч, сургалтыг үе шаттай зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах, удирдлагын манлайлал үзүүлэн ажиллах, дурдсан асуудлаар арга хэмжээ зохион байгуулах талаар зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны Тус газрын 2025 оны 01/399 дүгээр албан бичгийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн.

3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлийн газрын даргын баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө"-ний 3.1-д "Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох хуулиудыг хүний эрхийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх сургалт"-ыг танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулахаар тусгасны дагуу сургалтыг 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулав.

Монгол Улсын Хүний Эрхийн үндэсний Комиссоос ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 06/08 дугаар "Зөвлөмж"-

ийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав.

-Тус газрын 2025 оны 01/399 дүгээр албан бичгээр "Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон бусад хуулиар тогтоосон хүний ажил хөдөлмөр эрхлэх эрхийг хязгаарлахгүй байх, ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх зөвлөгөөг өгч, сургалтыг үе шаттай зохион байгуулж нийт ажилтнуудыг хамруулах, удирдлагын манлайлал үзүүлэн ажиллах, зөвлөмжид дурдсан асуудлаар арга хэмжээ зохион байгуулах талаар Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тухай Зөвлөмж хүргүүлсэн.

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт, төлөвлөлийн газрын даргын баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө"-ний 3.1-д "Хөдөлмөрийн тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох хуулиудыг хүний эрхийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх сургалт"-ыг танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулахаар тусгасан. Энэхүү сургалтыг 2025 оны 3 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулав.

-Нийгмийн даатгалын байгууллага нь мерит зарчмыг эрхэмлэн ажилладаг бөгөөд анхан шатны байгууллагад идэвх санаачлагатай ажилласан албан хаагчдыг шилжүүлэн дээд шатны байгууллагад томилон ажиллуулж байна. 2025 оны байдлаар 8 төрийн жинхэнэ албан хаагч тус газраас дэвшин дээд шатны байгууллагад ажиллаж, 11 төрийн албан хаагч албан тушаалын адил ангилал, зэрэглэлд хууль, журамд нийцүүлэн шилжин ажилласан.

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2.6.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах | | 2.6 | 1. Улсын Их Хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаар Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлд нэмэлт оруулсантай холбогдуулан төсвийн төвлөрүүлэн болон төсвийн шууд захирагч нарыг батлагдсан төсөв, орон тооны дээд хязгаарт багтаан зарлагыг санхүүжүүлэн өр, авлага үүсгэхгүй ажиллахыг үүрэг болгосон.<br>Уг хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 01/2381 дүгээр албан бичгийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлж, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн сар, улирлын хуваарийг баримтлан төсөвтөө багтаан тухайн сардаа зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулж ажиллах чиглэл хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.<br>Мөн Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу "Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлан ажиллах" гэсэн заалтыг тусгасан бөгөөд хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 онд хэрэгцээгүй худалдан авалт болон гадаад томилолтын зардал гараагүй болно. | 100 | | | | | | | |
| 23 | 2025.07.25<br><br>Засгийн газраас шуурхай авч хэрэгжүүлэх зарим арга | 1.2.Төрийн албан тушаалын чиг үүргийн давхардлыг арилгах, удирдах албан тушаалтны тоог бууруулах арга хэмжээ авч, байгууллагын орон тоог нэмэгдүүлэхтэй холбоотой | №04 | 1.2 | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, улсын хэмжээнд нийт төрийн байгууллагуудын тоог орон тоог 9 хувиар хасаж, нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд 136 орон тоогоор бууруулсантай холбогдуулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээний тухай | аливаа шийдвэр гаргахгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоо болон сул орон тоог царцааж, **нөхөн томилгоо** хийхгүй байх | | | 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар. Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" А/163 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын 1477 орон тоог 136-аар бууруулан 1341 тоотой байхаар шинэчлэн баталсны дагуу 33 албан тушаалын тодорхойлолтыг 2025 оны Төрийн албаны зөвлөлийн ээлжит 33 дугаар хуралдаанаар удирдах болон гүйцэтгэх 33 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах зөвшөөрөл олгосон. | | | | | | | | |
| | | 1.3.Иргэддээ чин **шударгаар** үйлчилдэг, ёс зүйтэй **төрийн** албыг бэхжүүлэх зорилгоор нийцүүлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг төрийн бүх шатны удирдлагад; | | 1.3 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдүүлэх, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах арга хэмжээний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө"-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд **Нийгмийн** даатгалын салбарын "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж, Төрийн албаны зөвлөлийн "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" дэд системд байршуулав.<br>- Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад танхимаар 380, цахимаар 950 | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гаруй албан хаагч хамрагдаж, сургалтаар дараах чиглэлээр мэдлэг, мэдээлэл өгч, дадлагаар бататгасан үр дүнтэй 7 удаагийн сургалтыг зохион байгуулав. Үүнд:<br>✓ Дэд хорооны гишүүдэд ёс зүйн зөрчлийг бусад зөрчлөөс ялгах, хурал зохион байгуулах, гомдол мэдээлэл шийдвэрлэх хугацаа, албан хаагч нарт сургалт, нөлөөллийн арга хэмжээг байнга зохион байгуулж байх талаар;<br>✓ Дарга нарын зөвлөлийн гишүүдэд Ёс зүйн тухай хууль тогтоомж, томилох эрх бүхий албан тушаалтны эрх, үүргийн талаар;<br>✓ Албан хаагч нарт Ёс зүйн тухай хууль, хэм хэмжээний талаар, албан хаагчийн ёс зүй, эдлэх эрх, хүлээх үүргийн талаар;<br>- Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны шинэчлэл" хэлэлцүүлэгт оролцов.<br>- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар "Төрийн албан хаагч бид" гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим хуудаст байршуулан түгээн ажиллав.<br>Нийгмийн даатгалын албан хаагчдын чадавхжуулах сургалтыг албан хаагчдын дунд зохион байгуулах, хууль сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллаж байна. | | | | | | | | |
| | | 1.4 **Төрийн** байгууллагын ёс зүйн дэд хороог 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор гүйцэзн байгуулж ажиллуулах; | | 1.4 | Төрийн албан хаагчийн ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх зорилгод нийцүүлэн Нийгмийн даатгалын ерөнхий газар, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын газарт ёс зүйн дэд хороог бүрэн байгуулав. | 100 | | | | | | | 6.4.5. |
| | | 1.7.Төрийн албаны тухай хуульд заасанаас бусад | | 1.7 | Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны | 100 | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үндэслэлээр төрийн албан хаагчдыг төрийн албанаас чөлөөлөхгүй, халахгүй, хуулиар чиг үүрэгт нь өөрчлөлт ороогүй тохиолдолд төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахгүй байх, төрийн байгууллагын зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг нь хэвээр хадгалагдан үлдсэн төрийн жинхэнэ албан хаагчдыг чөлөөлөх, халах, албан тушаал бууруулах, шилжүүлэх шийдвэр гаргахгүй байх | | төлөвлөгөөнд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9.0 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэх бодлогын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн "Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын орон тооны дээд хязгаар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай" А/163 дугаар тушаалаар нийгмийн даатгалын байгууллагын 1477 орон тоог 136-аар бууруулан 1341 тоотой байхаар шинэчлэн батлсны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Нийгмийн даатгалын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/237, "Дүүргийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/238, "Аймгийн нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/239 дүгээр тушаалуудаар нийгмийн даатгалын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийг батлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. | | | | | | | | |
| | | 1.8.Ажлын байрны нээлттэй мэдээлэлд үндэслэн төрийн албан хаагчдыг хувийн хэвшилд шилжүүлэн ажиллуулах санал боловсруулж, цалин хөлс, нийгмийн баталгааны | 1.8 | Нийгмийн даатгалын байгууллага нь төрийн албаны мерит зарчмаар анхан шатны байгууллагад идэвх санаачлагатай ажилласан 2025 оны байдлаар 8 төрийн жинхэнэ албан хаагч тус газраас дэвшин дээд шатны байгууллагад ажиллаж, 11 төрийн албан хаагч албан тушаалын адил ангилал, | 100 | | | | | | | 6.4.1 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | талаарх мэдээллийг төрийн албан хаагчдад хүргэх уулзалт, арга хэмжээг Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах; | | | зэрэглэлд хууль, журамд нийцүүлэн шилжин ажилласан.<br>Төрийн албаны зөвлөлөөс "Төрийн байгууллагаас хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих өдөрлөг"-ийг 2025 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр МҮХАҮТ-ын их танхимд зохион байгуулсан сургалтад төвийн 6 дүүргээс нийт 15 албан хаагч оролцсон. | | | | | | | | |
| | | 13.1. Капитал, Чингис хаан банкуудад байршуулаад авч чадаагүй нийгмийн даатгалын сангийн чөлөөт хөрөнгийг эргүүлж авах талаар хуулийн байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжилтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулах; | | 13.1 | Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банкнаас авах нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө тооцон хүлээн авч борлуулан авлага барагдуулах ажлыг зохион байгуулж байна. Энэхүү ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Капитал банк болон Чингис хаан банкны нийгмийн даатгалын санд төлөх өр төлбөрийг барагдуулах чиглэлээр мэргэжлийн хууль зүйн туслалцаа үзүүлэх "Дэлгэрэнгүй хууль" НҮТББ-тай НДЕГ/20250103001 дугаартай гэрээг 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулан, ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.<br>1.Чингис хаан банкнаас нэхэмжилсэн 103.5 тэрбум төгрөгнөөс 19.9 тэрбум (мөнгөөр 12.4 тэрбум төгрөг, хөрөнгөөр 7.5 тэрбум төгрөг) тэрбум төгрөгийн төлбөр барагдаж 83.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br>2.Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн 104.2 тэрбум төгрөгнөөс 46.6 тэрбум (мөнгөөр 15.0 тэрбум төгрөг, хөрөнгөөр 31.6 тэрбум төгрөг) төгрөгийн төлбөр барагдаж 57.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. | 100 | | | | | | | 6.4.5. |
| | | 13.2.Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд ил тод, шилэн болгох арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор авах; | | 13.2 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn<http://www.shilendans.gov.mn> сайтад 12 удаа хуулийн хугацаанд байршуулан ажилласан. Үүнд: | 100 | | | | | | | 6.4.5. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - Тэтгэврийн даатгалын сангаас нийт 521,511 даатгуулагчид 5,340,612,635.560 төгрөгийн тэтгэвэр;<br>- Тэтгэмжийн даатгалын сангаас нийт 161,305 даатгуулагчид 291,458,989.330 төгрөгийн тэтгэмж;<br>- ҮОМШӨ-ний даатгалын сангаас нийт 8,121 даатгуулагчид 51,982,366.700 төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр;<br>- .Ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 34,053 даатгуулагчид 163,720,933.580 төгрөгийн тэтгэмж тус тус зарцуулав.<br><br>Мөн төсвийн хуваарийн дагуу:<br>- Олон нийтийн хяналтын зардалд 78,110,940 төгрөг;<br>- Ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн, сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардалд 539,059,870 төгрөгийг тус тус зарцуулж зардлыг http://www.shilendans.gov.mn> цахим хуудаст мэдээлсэн. | | | | | | | | |
| | | 13.6.Нас барсан даатгуулагчийн ар гэрт нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулж, шийдвэрлүүлэх; | | 13.6 | 1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан нөхцөлийг хангасан нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг холбогдох тооцооллын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 01/1545 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.<br>Уг асуудлыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 11 дүгээр тогтоолоор нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3,000,000 /гурван сая/ | 100 | | | | | | | 6.4.5. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төгрөг, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоож, 2026 оны 01 дүгээр сарын 0¹-ний өдрөөс хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.<br>2.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 2026 онд зарцуулах зардлын төсвийн дээрх батлагдсан дүнгээр тооцож, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан бегеед 14.8 тэрбум төгрөгөөр батлагдсан болно. | | | | | | | | |
| | | | | **2.а.Монгол Улсын хууль** | | | | | | | | |
| 24 | 2023.07.07<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий хууль<br><br>38.9.Энэ хуулийн 38.2-т заасан хяналт шалгалт хийх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална. | 38.9 | | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.9-д "Энэ хуулийн 38.2-т заасан хяналт шалгалт хийх журмыг нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална" гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/298 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын хяналт шалгалтын нэгдсэн журам"-ыг баталсан.<br>Мөн газрын даргын 2025 оны А/299 дүгээр тушаалаар 2024 оны "Маягтуудын загварыг шинэчлэн батлах тухай" А/199 дүгээр тушаалын хавсралтад "Нийгмийн даатгалын хяналт шалгалт хийх томилолт", "Хяналт шалгалтын баримт бичгийг танилцуулж гардуулан өгсөн тухай тэмдэглэл", "Хяналт шалгалтын баримт бичгийг иргүүлэх хүсэлт", "Хяналт шалгалтын баримт бичгийг хүлээлгэн өгсөн бүртгэл"-ийн загваруудыг нэмж шинэчлэн баталсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/298 дугаар тушаалыг Захиргааны хэм хэмжээний актын улсан нэгдсэн сангийн 7433 дугаарт бүртгэсэн. | 100 | | | | | | | 6.4.1 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25 | 2023.07.07<br><br>Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай<br><br>15.4.Энэ хуулийн 15.1.2-т заасан сул зогсолтын хугацаат ажил олгогчийн санал, холбогдох мэдээлэл, хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн нийгмийн даатгалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно. | | 15.4 | Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Журам батлах тухай" А/336 дугаар тушаалаар "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацаат тогтоох журам"-ыг баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны "Захиргааны хэм хэмжээний акт бүртгүүлэх тухай" 01/3221 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.<br>Энэхүү журам батлагдсанаар ажил олгогчийн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас сул зогссон хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажил олгогчдод санхүүгийн дэмжлэг үзүүлэх боломж бүрдэх юм. | 100 | | | | | | 6.4.1 |
| Хэсгийн дундаж 100 хувь | | | | | | | | | | | |
| НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ | | | | | | | | | | | |
| 26 | 2025.01.27<br>Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцох журам" батлах тухай<br><br>1. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллах; | №01 | 1 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан "Нэрийн данс нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдэл тооцох журам"-ын дагуу даатгуулагчид нэрийн данс нээх, бүртгэх, гарааны үлдэгдэл, нэрийн дансы эцсийн үлдэгдэл тооцох бодлогын даалгаврыг байгуулах чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны 04/3431 дүгээр албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлснээр нийт 1.7 сая гаруй даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны жилийн эцсийн байдлаарх үлдэгдлийг | 100 | | | | | | 6.4.1 |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооцоолж, тооцооллыг шалгах ажлыг гүйцэтгэж байна. | | | | | | | | |
| 27 | 2025.02.27 "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө" батлах тухай | 2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулахыг хариуцан хэрэгжүүлэх байгууллагуудад үүрэг болгосугай. | №06 | 2 | Нийгмийн даатгалын үндсэний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-нд нийт 62 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсан бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу 43 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Төлөвлөгөөнд тусгагдсан бусад 19 арга хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 2.1-д "... төлөвлөгөөнд тусcан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна." гэж заасны дагуу тендер шалгаруулалтыг зарласан боловч хамтран зохион байгуулах мэргэжлийн байгууллагууд уг шалгаруулалтад оролцоогүй болно. | 100 | | | | | | | 6.4.5. |
| | | 3. ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг | | 3 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан 43 арга хэмжээг хэрэгжүүлэх | 100 | | | | | | | 6.4.5. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | санхүүжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах; | | | ажлыг зохион байгуулж, 1,625.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгов | | | | | | | | |
| 28 | 2025.02.24<br><br>Харангийн хэмжээг тогтоох тухай | 1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталсугай.<br>2.Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээний өөрчлөлттэй уялдуулан энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хувийг өөрчлөх тухай саналыг тухай бүр танилцуулан энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллах; | №07 | 1 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 2025 оны 05 дугаар сард 700.0 тэрбум төгрөгийг мөнгөн хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай байршуулан, хүүг сар бүр тогтмол нийгмийн даатгалын сангийн холбогдох дансанд төвлөрүүлж, тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангасан.<br>Энэ талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн.<br>Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу тайлант оны 05-12 дугаар сарын хүү болох 70.1 тэрбум төгрөгийг хүлээн авч нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг өсгөв. Энэхүү хадгаламжийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгө өсөж арвижих боломжийг бүрдүүлсэн. | 100 | | | | | | | 6.4.5. |
| 29 | 2025.03.24<br><br>Мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээ шинэчлэн батлах тухай | 1.Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн 14.20 хувиар шинэчлэн баталсугай.<br>2.Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, | №08 | 2 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн системийн нөлөө бүхий арилжааны 4 банканд 2025 оны 05 дугаар сард 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатай мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулсан. Энэ талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон пэйж хуудсаар мөн https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлэн ажилласан.<br>Мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу тайлант оны 05-12 дугаар сарын хүү болох 70.1 тэрбум төгрөгийг хүлээн авч нийгмийн | 100 | | | | | | | 6.4.5. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээний өөрчлөлттэй уялдуулан энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хувийг өөрчлөх тухай саналыг тухай бүр танилцуулан энэ тогтоолыг хэрэгжүүлж ажиллах; | | | даатгалын сангийн хөрөнгийг өсгөв. Энэхүү хадгаламжийн хугацаанд нийтдээ 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор сангийн хөрөнгө өсөж арвижих боломжийг бүрдүүлсэн.<br>Монголбанкны тухайн үеийн бодлогын хүү, арилжааны банкуудын байгууллагын хугацаатай хадгаламжийн хүүгийн дундаж хэмжээ, арилжааны банк хоорондын захын хүүгийн дундаж хэмжээ өөрчлөгдөөгүй тул Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл баталсан хадгаламжийн хүүгийн дээд хэмжээг өөрчлөх хэрэгцээ шаардлага үүсээгүй. | | | | | | | | |
| 30 | 2025.07.23<br>Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай<br><br>1.Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 11.34 хувиар тогтоосугай.<br>2.Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2023 оны үлдэгдэл, 2024 оны орлогд тус тус хүү тооцох ажлыг 2025 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулж, даатгуулагчдыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах; | №10 | 2 | Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эхний үлдэгдэл болон 2024 онд бүртгэсэн шимтгэлийн орлогод 11.34 хувиар хүү тооцож, нэрийн дансны 2024 оны орлогын эцсийн үлдэгдлийг тодорхойлж, цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, "Нийгмийн даатгал" аппликэйшн болон portal.ndaatgal.mn цахим хуудсаар дамжуулан даатгуулагчдад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны 04/3431 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн | | 50 | | | | | | |
| 31 | 2025.07.23<br>Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br><br>1.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3,000,000 /гурван сая/, амьгүй донор болж эс, эд эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай. | №11 | 1 | 1. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, "Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 11 дүгээр тогтоолоор нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 3,000,000 /гурван сая/ төгрөг, амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг 4,500,000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоож, 2026 оны 01 дүгээр | 100 | | | | | | | 6.4.1. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.<br>2.Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж, амьгүй донор болж эс, эд, эрхтэнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжид 2026 онд зарцуулах зардлын төсвийн дээрх батлагдсан дүнгээр тооцож, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан бөгөөд 14.8 тэрбум төгрөгөөр батлагдсан болно. | | | | | | | | |
| 32 | 2025.07.23<br><br>Сэргээн засах болон сувиллын тусламж,үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай | 1.Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн ҮОМШӨДС-аас олгох хэмжээг нэг ор хоногт 110,000 /нэг зуун арван мянга/ төгрөгөөр тогтоосугай.<br>2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, ҮОМШӨДС-аас сэргээн засах болон сувиллын байгууллагуудад олгож буй санхүүжилт, үйлчилгээний чанарт тогтмол хяналт тавьж ажиллах: | №12 | 2 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Журам батлах тухай" 02 дугаар тогтоолоор баталсан "Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам"-ын дагуу Сонгон шалгаруулалтаар Орхон аймгийн "Эрдэнэт сувиллын цогцолбор", Улаанбаатар хотын "Оргил рашаан сувилал" ХХК, Багануур дүүргийн "Багануур сувилал" ХХК, Дархан-Уул аймгийн "Тулга сувилал" ОНӨААТҮГ, Улаанбаатар хотын "Сэргээн засах клиник эмнэлэг" ХХК, Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэнгийн "Ургамал сувилал", "Альфамедикал центр" ХХК, "Хос шинэс" ХХК, Төв аймгийн "Си Си хатан" ХХК, Хөвсгөл аймгийн "Галт халуун рашаан" ХХК, Өвөрхангай аймгийн "Ананд хужирт" ХХК тус тус шалгарч Нийгмийн даатгалын ерөнхий газар нь эдгээр сувиллуудтай "Даатгуулагчид сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г нэг жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна.<br>Эдгээр сэргээн засах төв болон сувиллуудын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор НДЕГ-ын даргын 2025 оны А/283, А/287 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан Өвөрхангай аймгийн Хужирт суман дахь "Ананд хужирт", Орхон аймаг дахь | 100 | | | | | | | 6.4.1. |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Эрдэнэт", Дархан-Уул аймаг дахь "Тулга" сувиллуудын үйл ажиллагаатай танилцах, зөвлөмж, чиглэл өгөх ажлыг зохион байгуулан ажиллав. | | | | | | | | |
| 33 | 2025.07.23<br><br>Өр төлбөрт хөрөнгө хүлээн авах тухай | 1.Чингис хаан банк ХХК-ийн 2,422,081,050 /хоёр тэрбум дөрвөн зуун хорин сая наян нэгэн мянга тавин/ төгрөгийн үнэлгээтэй 8 /найм/ ширхэг үл хөдлөх хөрөнгийг, Капитал банк ХХК-ийн 1,213,363,600 /нэг тэрбум хоёр зуун арван гурван сая гурван зуун жаран гурван мянга зургаан зуун/ төгрөгийн үнэлгээтэй 9 /ес/ ширхэг үл хөдлөх хөрөнгийг тус тус НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авахыг зөвшөөрсүгэй.<br>2.Чингис хаан банк ХХК-аас өр төлбөрт тооцон авах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Капитал банк ХХК-аас өр төлбөрт тооцон авах үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.<br>3.НДҮЗ-ийн 2021 оны 18 дугаар тогтоолоор баталсан "НДС-ийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын хэрэгжитийг хангаж, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө хүлээн авахтай холбоотой | №13 | 2.3 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 13 дугаар тогтоолын дагуу Капитал банкнаас орон сууц, авто зогсоолын зориулалттай 9 нэр төрлийн 1.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй, Чингис хаан банкнаас 8 нэр төрлийн орон сууц, үйлчилгээ, оффисын зориулалттай 2.4 тэрбум төгрөгийн үнэлгээтэй үл хөдлөх хөрөнгө хүлээн авсан. Эдгээр хөрөнгийн улсын бүртгэлийн нэр шилжүүлэх ажлыг бүртгэлийн байгууллагад хүсэлт тавин шийдвэрлүүлж, тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангасан.<br>Журмын хүрээнд өр төлбөр барагдуулах хөрөнгийн саналыг Газрын зөвлөл болон НДҮЗ-д танилцуулснаар дээрх хөрөнгүүдийг хүлээн авч өр төлбөрийг барагдуулсан | 100 | | | | | | | 6.4.1. |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам НДҮЗ-д тайлагнах; | | | | | | | | | | | |
| 34 | 2025.12.22<br>"Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам" батлах тухай<br><br>2.Батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг улирал бүр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд тайлагнаж байх; | №19 | | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хүрээнд "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.<br>Журмыг шинэчлэн батлуулснаар нийгмийн даатгалын сангийн авлага, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулахад баримтлах зарчим тодорхой болж, нийгмийн даатгалын сангийн авлагыг бууруулах, мөнгөн хөрөнгийг санд төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. | | | | | | ХБ | | |
| 35 | 2025.12.22<br>Өр төлбөрт хөрнгө хүлээн авах тухай<br><br>1.Капитал банк ХХК-ийн 5,317,310,695.0 (таван тэрбум гурван зуун арван долоон сая гурван зуун арван мянга зургаан зуун ерэн тав) төгрөгийн үнэлгээтэй хавсралтад дурдсан 2 (хоёр) ширхэг үл хөдлөх хөрөнгийг нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт тооцон авахыг зөвшөөрсүгэй.<br>2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 19 дүгээр тогтоолоор батлсан "Нийгмийн даатгалын сангийн авлагад үл хөдлөх хөрөнгийг хүлээн авах, хадгалах, хамгаалах, ашиглах, түрээслүүлэх, худалдан борлуулах журам"-ын хэрэгжилтийг хангаж, өр төлбөрт үл хөдлөх хөрөнгө хүлээн авахтай холбоотой ажлыг шуурхай зохион байгуулж, хэрэгжилтийг улирал тутам Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд тайлагнах; | №20 | | Тогтоолын дагуу Баянгол дүүргийн 9-р хороо, 3 дугаар хороолол, Ард аюушийн өргөн чөлөө, 35-3 тоот хаягт байрлалтай 5.3 тэрбум төгрөгийн үнэлгээтэй үйлчилгээний зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэмших эрхтэй газрын хамт хүлээн авч, улсын бүртгэлийн нэр шилжүүлэхээр Баянгол дүүргийн улсын бүртгэлийн хэлтэст хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлсэн. | 100 | | | | | | | 6.4.1. |
| 36 | 2025.12.22 | №21 | | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хүрээнд нийгмийн даатгалын сангийн чөлөөт | | | | | | ХБ | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар шинэчлэн батлах тухай<br><br>2.Энэхүү тогтоолоор баталсан "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний загварыг арилжааны банктай шинээр гэрээ байгуулахад мөрдөж ажиллах; | | | үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд байршуулах "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний загварыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.<br>Энэхүү гэрээний загварыг батлуулснаар нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг банкны системд нөлөө бүхий арилжааны банканд сар бүр хүү олгох нөхцөлтэйгээр мөнгөн хадгаламж байршуулах санал хүргүүлэн НДҮЗ-ийн дэргэдэх Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн санал дүгнэлтийг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн баталсан хүүгийн хэмжээнээс доошгүй санал ирүүлсэн банктай гэрээ байгуулан мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулах боломжийг эрх зүйн хувьд бүрдүүлсэн. | | | | | | | | |
| 37 | 2025.12.22<br>Мөнгөн хадгаламжийн гэрээний загвар батлах тухай<br><br>2.Энэхүү тогтоолоор баталсан "Мөнгөн хадгаламжийн гэрээ"-ний загварыг арилжааны банктай гэрээ байгуулахад мөрдөж ажиллах; | №22 | | Тэтгэврийн нөөц сангийн 215.3 тэрбум төгрөгийг банкны системд нөлөө бүхий 4 банк (Төр, ХААН, Голомт, Худалдаа хөгжил) –нд хадгаламж хэлбэрээр нэг жилийн хугацаатай, сар бүр хүү олгох нөхцөлтэй, жилийн 15.11 хувийн хүүгийн өгөөжтэйгээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулан байршуулав.<br>Энэхүү ажлын үр дүнд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө жилдээ 32.5 тэрбум төгрөгөөр өсөх ба 2025 оны хүү болох 89.1 сая төгрөгийг хүлээн авсан.<br>Мөнгөн хадгаламж байршуулсан талаарх мэдээллийг олон нийтэд цахим хуудас болон https://shilendans.gov.mn/ хуудаст байршуулан ил тод мэдээлсэн. | 100 | | | | | | | 6.4.1 |
| **Хэсгийн дундаж 95.5 хувь** | | | | | | | | | | | | |
| **Нийт дундаж 94.2 хувь** | | | | | | | | | | | | |

–oOo–

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙГ САЛБАР, ЧИГЛЭЛЭЭР ҮНЭЛЖ, ДҮГНЭХ ХҮСНЭГТ

(2025 оны жилийн эцсийн биелэлт)

| | | | Бүгд | Үүнээс | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | УАБЗ-ийн зөвлөмж | УАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын Хуралдааны тэмдэглэл | Албан даалгавар | 2.а.Монгол Улсын хууль | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол |
| НЭГ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ | | | | | | | | | | | | | | |
| Нийгмийн даатгал | | | | | | | | | | | | | | |
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | | 37 | | 1 | | | | 5 | 1 | 14 | 2 | 2 | 12 |
| Хяналтад авсан нийт заалт, заалтын тоо | | | 68 | | 1 | | | | 5 | 2 | 23 | 22 | 2 | 13 |
| Үнэлгээ | Хэрэгжсэн | | 53 | | | | | | 2 | 2 | 17 | 20 | 2 | 10 |
| | Хэрэгжих шатанд | Тодорхой үр дүнд хүрсэн | 7 | | 1 | | | | 1 | | 2 | 2 | | 1 |
| | | Удаашралтай/ эрчимжүүлэх шаардлагатай | | | | | | | | | | | | |
| | Хэрэгжээгүй | Зохион байгуулалтаас | | | | | | | | | | | | |
| | | Хөрөнгө дутагдсанаас | | | | | | | | | | | | |
| | Хугацаа болоогүй | | 8 | | | | | | 2 | | 4 | | | 2 |
| | Хэрэгжих боломжгүй | | | | | | | | | | | | | |
| Хяналтаас хасуулах санал /хүчингүй болсон эсэх/ | | | 24 | | | | | | 2 | | 4 | 6 | 2 | 10 |
| **Дүн /хувь/** | | | **94.2** | | **50.0** | | | | **83.3** | **100** | **94.7** | **95.5** | **100** | **95.5** |

--oOo--

# ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар, заалт | Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө | Тайлбар |
|---|---|---|---|
| Салбарын хэмжээнд Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т мэдээлэл байршуулсан байдал | | Салбарын хэмжээнд 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 11,340 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 11,250 хугацаа хоцроосон мэдээлэл 90 байсан ба мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.2 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт***: Нийт 5,856 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 5,794, хугацаа хоцроосон мэдээлэл 62, мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 98.9 хувьтай байна.<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 5,484 мэдээллийг байршуулахаас хугацаандаа байршуулсан мэдээлэл 5,456, хугацаа хоцроосон мэдээлэл 28, мэдээлэл байршуулалт 100 хувь, хугацаандаа мэдээлэл байршуулалт 99.5 хувьтай байна. | - |
| *1.Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ":* | | | |
| 1 | 6.1.1.Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т "***тухайн жилийн төсөв***" төрөлд нийт 64 мэдээлэл байршуулахаас 58 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 79.7 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 20 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 62.5 хувьтай байна.<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 32 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.9 хувьтай байна. | - |
| 2 | | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т "***худалдан авах ажиллагааны төлөвлөгөө***"-төрөлд нийт 64 мэдээлэл байршуулахаас 52 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 12 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 81.3 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 32 мэдээлэл байршуулахаас 21 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 11 мэдээллийг | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 65.6 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 32 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.9 хувьтай байна. | |
| 3. | 6.1.2.Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор байршуулах; | Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т "Төсөв, гүйцэтгэл" дэд цэсээр Нийгмийн даатгалын байгууллагын санхүү, үйл ажиллагаа болон Нийгмийн даатгалын сангийн Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл-Хөтөлбөр, зориулалтаар сар бүр мэдээлсэн байна.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 755 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.<br>Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 98.3 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 384 мэдээлэл байршуулахаас 375 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 97.7 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 380 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 99.0 хувьтай байна. | - |
| 4 | 6.1.3.Дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 64 мэдээлэл байршуулахаас 63 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.<br>Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 98.4 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.9 хувьтай байна.<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 32 мэдээлэл байршуулахаас 32 мэдээллийг хугацаанд нь байршуулж, мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |

| | | | |
|---|---|---|---|
| 5. | 6.1.4.Жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийг 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 128 мэдээлэл байршуулахаас 113 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 88.3 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 30 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93.8 хувьтай байна.<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 28 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 87.5 хувьтай байна. | - |
| 6. | 6.1.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор байршуулах; | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор байршуулна.(Хугацаа болоогүй байна). | - |
| 7. | 6.1.5.Аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01–ний өдрийн дотор байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 64 мэдээлэл байршуулахаас 60 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93.8 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.9 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт:*** Нийт 32 мэдээлэл байршуулахаас 29 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 90.6 хувьтай байна. | - |
| 8. | 6.1.6.Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 731 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 98.3 хувьтай байна. Үүнд: | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | - ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** нийт 384 мэдээлэл байршуулахаас 375 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 97.7 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: нийт 384 мэдээлэл байршуулахаас 380 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 99.0 хувьтай байна. | |
| *2. Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг* **долоо хоногийн дотор мэдээлнэ":** | | | |
| 1 | 6.4.1.тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр байршуулах; | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |
| 2 | 6.4.2.тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг тухай бүр байршуулах; | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд:<br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |
| 3 | 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" мэдээллийг тухай бүр байршуулах; | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд: | - |
| 4 | 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т ."*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" төрөлд нийт 768 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд: | - |

| | | | |
|---|---|---|---|
| | хүлээн авагчийн нэр" мэдээллийг тухай бүр байршуулах; | - ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | |
| | | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т ."*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" төрөлд нийт 768 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь байршуулж мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |
| 5 | 6.4.6."худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн" мэдээллийг тухай бүр байршуулах; | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |
| 6 | 6.4.7."байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" мэдээллийг тухай бүр байршуулах; | Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 768 мэдээлэл байршуулахаас 754 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 98.2 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 371 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 96.6 хувьтай байна | - |

| | | | |
|---|---|---|---|
| | | - ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 383 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 99.7 хувьтай байна. | |
| 7 | 6.4.8."Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" мэдээллийг тухай бүр байршуулах; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шилэн дансны цахим хуудас (Shilendans.gov.mn)-т нийт 704 мэдээлэл байршуулахаас 768 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. Үүнд:<br><br>- ***Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны мэдээлэл байршуулалт:*** Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна<br>- ***Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт***: Нийт 384 мэдээлэл байршуулахаас 384 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна. Мэдээлэл байршуулалт 100 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 100 хувьтай байна. | - |

--oOo--

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| № | Хуулийн заалт | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|
| | | **Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал** | | |
| 1.1. | 8.2.1 | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн; | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/19 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын ерөнхий газрын Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр" баталсан.<br>Тус хөтөлбөрийн 2.1-т "Үйл ажиллагааны стратегийн мөн чанар", 2.2-т "Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл", 2.3-т "Эрхэм зорилго", 2.4-т "Стратегийн зорилт" болон эдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх гол зорилтуудыг тодорхойлсон.<br>Нийгмийн даатгалын байгууллагын ndaatgal.mn цахим хуудасны "Нүүр", "Танилцуулга" хэсэгт байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлж байна.<br>Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-д заасан мэдээллийн мэдээлэл байршуулалтыг мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтэлсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал зэрэг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 100 хувиар үнэлсэн. | 100 |
| 1.2. | 8.2.2 | Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг; | Нийгмийн даатгалын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаягийн талаарх мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст нээлттэй байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 100 хувиар үнэлсэн. | 100 |
| 1.3. | 8.2.3 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж; | Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үнэлгээ дотоод аудитын тайланг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст нээлттэй байршуулсан. Мөн санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хугацаа хоцроож байршуулсан байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 73 хувиар үнэлсэн. | 73 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.4. | 8.2.5 | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан Нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тайлагнасан бөгөөд Алсын хараа-2050 урт хугацааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө тайланг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 100 хувиар үнэлсэн. | 100 |
| 1.5. | 8.2.6 | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт; | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актын мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хууль, эрх зүй" хэсэгт нээлттэй байршуулсан. Мөн засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, журмыг хугацаа хоцроож байршуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 80 хувиар үнэлсэн. | 80 |
| 1.6. | 8.2.7 | Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг | Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 506 дугаар тогтоолоор баталсан албан хаагчдын Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаягийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "нээлттэй байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 98 хувиар үнэлсэн. | 98 |
| 1.7. | 8.2.8 | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ; | Нийгмийн даатгалын байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн улирал бүрийн тайланг мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст " Өргөдөл гомдол шийдвэрлэлт" хэсэгт, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт нээлттэй байршуулсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 97 хувиар үнэлсэн. | 97 |
| 1.8. | 8.2.9 | Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл; | Нийгмийн даатгалын байгууллагын статистик, мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Статистик мэдээлэл" хэсэгт сар, жилээр, статистикийн эмхэтгэлийн хамт нээлттэй байршуулсан болно. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 96 хувиар үнэлсэн. | 96 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1.9. | 8.2.10 | Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр | Нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Нүүр" болон "Мэдээ, мэдээлэл" хэсгээр мэдээлэн ажиллаж байна. Мөн цахим орчинд албан ёсны Facebook, Instagramm хуудсаараа дамжуулан иргэд даатгуулагчдад тогтмол хүргэж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 100 хувиар үнэлсэн. | 100 |
| | | **Хэсгийн дундаж хувь:** | | **93** |
| | | **Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал** | | |
| 2.1. | 8.3.1 | Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл; | Нийгмийн даатгалын байгууллагын Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хүний нөөцийн ил тод байдал" хэсэгт нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 87 хувиар үнэлсэн. | 87 |
| 2.2. | 8.3.2 | Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам; | Нийгмийн даатгалын байгууллагын Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам, мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хүний нөөцийн ил тод байдал" хэсэгт нээлттэй мэдээлэн ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 86 хувиар үнэлсэн. | 86 |
| 2.3. | 8.3.3 | Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм; | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудсанд байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 77 хувиар үнэлсэн. | 77 |
| 2.4. | 8.3.4 | Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам; | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/147 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, мэргэшүүлэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хүний нөөцийн ил тод байдал" хэсэгт нээлттэй байршуулсан. Мөн төрийн албаны тухай хууль, холбогдох дүрэм, журмыг байршуулсан болно. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 98 хувиар үнэлсэн. | 98 |
| 2.5. | 8.3.5 | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ; | Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хүний нөөцийн ил тод байдал" хэсэгт нээлттэй байршуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2.6. | 8.3.6 | Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам. | Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 218, 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаал, 2023 оны 98 дугаар тушаалын хавсралтуудыг дагаж мөрдөн ажиллаж байна. Мөн төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшин үнэлэхтэй холбоотой журам, шийдвэрүүдийг шинэчлэн байгууллагын байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст "Хүний нөөцийн ил тод байдал" хэсэгт нээлттэй байршуулсан. | 89 |
| | | **Хэсгийн дундаж хувь:** | | **89** |
| | | **Гурав. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | |
| 3.1. | 8.4.1 | Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Төсөв, гүйцэтгэл" төрөлд нээлттэй байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 93 хувиар үнэлсэн. | 93 |
| 3.2. | 8.4.2 | Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Төсөв, гүйцэтгэл" төрөлд нээлттэй байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 92 хувиар үнэлсэн. | 92 |
| 3.3. | 8.4.3 | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт; | Үндэсний аудитын газраас 2024 оны санхүүгийн тайланг бүрэн байршуулсан байна. Харин 2025 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг нэгтгэж байгаа бөгөөд хуулийн хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулна. | 98 |
| 3.4. | 8.4.4 | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ; | Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний төлбөр байхгүй. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Бусад" төрөлд нээлттэй байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 98 хувиар үнэлсэн. | 98 |
| 3.5. | 8.4.5 | Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Төсөв, гүйцэтгэл" төрөлд нээлттэй бүрэн байршуулсан. | 100 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3.6. | 8.4.7 | Цалингийн зардлаас бусад тазан сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Төсөв, гүйцэтгэл" төрөлд нээлттэй байршуулсан боловч хугацаа хоцроож байршуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 87 хувиар үнэлсэн. | 87 |
| 3.7. | 8.4.8 | Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр; | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд байгууллагын санхүү үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудасны "Төсөв, гүйцэтгэл" төрөлд нээлттэй байршуулсан боловч хугацаа хоцроож байршуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 86 хувиар үнэлсэн. | 86 |
| 3.8. | 8.4.9 | Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл; | 2025 оны шилэн дансны хөтлөлтийн тайлан, хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайланг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст тухай байршуулсан. Мөн улирал бүр нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Шилэн данс хөтлөлтөд хяналт-шинжилгээ, үнэлгээг улирал бүр хийж тайланг нээлттэй байршуулсан. | 87 |
| 3.9. | 8.4.10 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах Журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан | Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 2025 оноос худалдан авах ажиллагаа болон тендертэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр тайланг, ndaatgal.mn веб хуудсандаа байршуулж эхэлсэн бөгөөд хугацаандаа байршуулаагүй хоцроосон зөрчил илэрсэн байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 85 хувиар үнэлсэн. | 85 |
| 3.10. | 8.4.11 | Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах ажиллагаа оролцон талаарх төлөвлөгөө тайланг ndaatgal.mn веб хуудасны "Худалдан авах ажиллагаа" цэсэнд байршуулсан байна. | 75 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт; | | |
| 3.11 | 8.4.12 | Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл; | Мэдээлэл хариуцагчаас гаргасан худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон зарыг байршуулж холбогдох журам, тушаал, шийдвэрийг нээлттэй мэдээлсэн байна. | 67 |
| 3.12. | 8.4.20 | Төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан | Үндэсний аудитын газраас "Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө" сэдэв гүйцэтгэлийн аудит хийсэн тайлан дүгнэлт, албан шаардлага, зөвлөмжийг байршуулан түүнтэй холбоотой тайлан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн тайланг байршуулсан байна. | 100 |
| 3.13. | 8.4.28 | Хууль тогтоомжид заасан бусад. | Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, авлигын эсрэг үйл ажиллагааны хөтөлбөр зэргийг байршуулан ажилласан бөгөөд хуульд заасан бусад мэдээллийг хугацаандаа байршуулан ажиллаж байна. | 100 |
| | | **Хэсгийн дундаж хувь:** | | **90** |
| | | **Дөрөв. Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | |
| 4.1 | 8.5.1 | Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл; | Нийгмийн даатгалын байгууллагын Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудсанд байршуулсан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 94 хувиар үнэлсэн. | 94 |
| | | **Хэсгийн дундаж хувь:** | | **94** |
| | | **Тав. Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал** | | |
| 5.3. | 8.6.4 | Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл; | Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээллийг байгууллагын ndaatgal.mn цахим хуудаст тухай байршуулж саналыг тусган ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын мэдээлэл байршуулалтыг 4 шалгуур үзүүлэлтээр дүгнэж 92 хувиар үнэлсэн. | 92 |
| | | **Хэсгийн дундаж хувь:** | | **92** |
| | | **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ:** | | **91.6** |

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

(2025 оны жилийн эцсийн байдлаар)

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар оруулах/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1:*** *"Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1. | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, биелэлтийг хугацаанд нь гаргаж холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх; | - | -Хугацаанд нь хүргүүлсэн Бодлогын баримт бичиг болон холбогдох хууль, тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийн тоогоор; | Бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2024 онд 5 биелэлт гаргаж, Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдсан байна. | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан 2 зорилт, 9 арга хэмжээ, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан нийгмийн даатгалын холбогдолтой 5 зорилт, арга хэмжээ, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилт, арга хэмжээ, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 2 зорилт, 5 арга хэмжээний 2025 оны биелэлтийг тус тус хугацаанд нь гаргаж, Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв. | 100 |
| 1.2. | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахад холбогдох тооцоо судалгаа хийх; | - | -Боловсруулсан хуулийн төсөл;<br>-Хийгдсэн тооцоолол, судалгааны тоогоор; | Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсэгт тус газраас 1 албан хаагч ажилласан. | Хууль батлуулахад шаардлагатай тооцооллыг хугацаанд нь гаргаж ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна. | **Нэг.** Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/763 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>**Хоёр.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хүрээнд тус хуулийн төсөл болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн саналыг тус тус боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>**Гурав.** Батлан хамгаалахын сайдын 2025 оны А/36 дугаар тушаалаар баталсан Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж, хуулийн төсөлд холбогдох саналаа өгөв<br>**Дөрөв.** Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд:<br>1.*Тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулах*: Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1 хувиар бууруулахад 261.0 тэрбум төгрөгөөр, 2 хувиар бууруулахад 523.0 тэрбум төгрөгөөр тус тус тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого буурах тооцооллыг гаргав.<br>2.*Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлсөнд дээд хэмжээг баримтлах*: Ажил олгогчийн ажилтанд олгосон цалин хөлснөөс тооцох шимтгэлийн дээд хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тогтоовол нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 174.9 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав<br>3.*Ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс тооцох шимтгэлийг уян хатан тогтоох*: Ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа даатгуулагчийг тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар тогтоовол уг хуулийн өөрчлөлтөд 28.9 мянган даатгуулагч хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого 25.3 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>4.*ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.2-1.0 хувиар бууруулах*: Уг арга хэмжээний хүрээнд ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувийг 0.1-0.9 хувиар бууруулахад шимтгэлийн орлого 89.3 тэрбум төгрөгөөр буурах, 0.1 хувийг ажилгүйдлийн даатгалын санд шилжүүлэхээр тооцоход ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого 25.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэх, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого нийт 115.1 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5.*Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлагын зохистой харьцааг барих* зорилгоор ҮОМШӨ-ний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр бууруулахад шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр буурах, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.1 пунктээр нэмэгдүүлэхэд шимтгэлийн орлого 30.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэх тооцооллыг гаргав.<br>**Тав.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллуудыг хийв. Үүнд:<br>1.*Хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлэх:* Эмэгтэй даатгуулагч (55-60), 4 ба түүнээс дээш хүүхэд төрүүлж, өсгөсөн эх (50-55), газрын дор, хортой, халуун (эрэгтэй 50-55, эмэгтэй 45-50), хүнд (эрэгтэй 55-60, эмэгтэй 50 55) нөхцөлд ажиллагч, малчны (эрэгтэй 55-60, эмэгтэй 50-55) тэтгэвэр тогтоолгох насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 28.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>2.*Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох жилийг нэмэгдүүлэх:* Тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийг 10 жил болгон нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 32.7 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>3.*Хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэврийн эрх үүсэх хугацааг нэмэгдүүлэх:* Хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар" гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "нийтдээ 60 сар ба түүнээс дээш сар" гэж, Тэжээгчээ алдсаны бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "сүүлийн 10 жилд нийтдээ 60 ба түүнээс дээш сар" гэж, хувь тэнцүүлсэн тэтгэвэр тогтоолгох эрх үүсэх хугацааг "нийтдээ 60-аас доошгүй сар, үүнээс тасралтгүй 36 сар" гэж тус тус нэмэгдүүлбэл тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу тэтгэвэрт зарцуулах хөрөнгө 18.8 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх тооцооллыг гаргав.<br>4.Өндөр насны тэтгэврийг 2018 оноос өмнө тогтоолгосон 206.6 мянган эмэгтэй тэтгэвэр авагчийн ажилласан жилийг хүүхдийн тоогоор нэмэгдүүлэхэд тэтгэврийн зардалд 111.0 тэрбум төгрөг нэмж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шаардагдах тооцооллыг гаргав.<br>**Зургаа.** Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд дараах тооцооллыг хийв. Үүнд:<br>1.Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг 55 хоногоор тооцож олгоход сангийн зардал 20.6 тэрбум төгрөгөөр буурах тооцооллыг гаргав.<br>**Долоо.** Тэтгэвэр, ҮОМШӨ-ний даатгалын сангийн орлого, зарлагын хэтийн тооцооллыг хийв.<br>**Найм.** Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/48 дугаар тушаалын дагуу Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллав. | |
| 1.3. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, холбогдох заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг боловсруулах, батлуулах, нийгмийн даатгалын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр ханган ажиллах; | - | Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад өгсөн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг тухай бүр хүргүүлсэн байна. | Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2024 онд 15 чиглэл, 14 зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | Дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр ханган ажилласан байна. | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2025 онд дараах 9 зөвлөмж, зааврыг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Үүнд:<br>1.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбоотой анхаарах асуудлын талаарх зөвлөмж;<br>2.Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улстай "Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, ОХУ-ын иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй, шуурхай олгож ажиллах зөвлөмж;<br>3.Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас ирүүлсэн асуулга, тодруулгад холбогдох хууль, журам, дүрэм, зааврыг үндэслэн өгсөн зөвлөмж;<br>4.Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Заавар батлах тухай" А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалын хавсралтаар баталсан "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар"-ыг хэрэгжүүлэх зөвлөмж;<br>5.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтад "... | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | алслагдсанд тооцогдсон цэргийн анги, салбарт, алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох", Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт "Террорист үйлдлийн эсрэг тусгай ажиллагааны нэгжид ажилласан алба хаагчийн ажилласан нэг жилийг нэг жил дөрвөн сартай дүйцүүлэн тооцно" гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх зөвлөмж;<br>6.Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан төрийн албан хаагчаас бусад даатгуулагчийн давхар ажил хөдөлмөр эрхэлж, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн цалин хөлсөнд өөрчлөлт орохгүй тохиолдолд даатгуулагчийн төрлийн кодыг өөрчлөхгүй байх зөвлөмж;<br>7.Тэтгэмж бодох заавар;<br>8.Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээртэй орнуудын гадаадын иргэнд өндөр насны тэтгэвэр тогтооход баримтлах заавар;<br>9."Үйлдвэрлэлийн ослын сул зогсох хугацааг тогтоох журам"-ыг хэрэгжүүлэх зөвлөмж зэрэг болно. | |
| 1.4. | Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны орлогод хүү тооцон эцсийн үлдэгдлийн талаарх мэдээллийг даатгуулагчдад хүргэх; | - | Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны үлдэгдлийн хэмжээ | Тэтгэврийн даатгалын нэрийн дансанд 2023 оны жилийн эцсийн байдлаар 1.6 сая даатгуулагчийн 33.2 их наяд төгрөгийн шимтгэл болон шимтгэлд тооцсон хүүг бүртгэсэн. | Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдлийг тооцон даатгуулагчдад мэдээлсэн байна. | Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эхний үлдэгдэл болон бүртгэсэн шимтгэлийн орлогод 11.34 хувиар хүү тооцож, нэрийн дансны 2024 оны орлогын эцсийн үлдэгдлийг тодорхойлж, цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, "Нийгмийн даатгал" аппликэйшн болон portal.ndaatgal.mn цахим хуудсаар дамжуулан даатгуулагчдад мэдээлэл хүргэх ажлыг зохион байгуулах чиглэлийг Мэдээллийн технологийн төвд хүргүүлж, 12 сард мэдээлэхээр ажиллаж байна. | 90 |
| 1.5. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөг НДҮЗ-өөр батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | -<br>Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээний тоо,<br>-<br>Санхүүжүүлсэн хөрөнгийн хэмжээ | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 09 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2024 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна. | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-г батлуулав.<br>Төлөвлөгөөнд нийт 62 арга хэмжээ зохион байгуулахаар тусгагдсан бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу 43 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, 1,625.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгов. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | оны төлөвлөгөө"-нд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх төсвийн нарийвчилсан хуваарийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж, хэрэгжүүлэх чиглэлийн хамт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв. | | Төлөвлөгөөнд тусгагдсан бусад 19 арга хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам"-ын 2.1-д "...төлөвлөгөөнд туссан урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулна." гэж заасны дагуу тендер шалгаруулалтыг зарласан боловч хамтран зохион байгуулах мэргэжлийн байгууллагууд уг шалгаруулалтад оролцоогүй болно. | |
| 1.6. | Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах; | - | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгаа ны тоо | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр 2 арга хэмжээг зохион байгуулж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 45.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. | Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуу дтай хамтран ажилласан байна. | 1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" 06 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-ний 1.2-т тусгагдсан "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн Үндэсний III чуулган" зохион байгуулах ажлыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үндэсний тогтолцоог бэхжүүлье" уриан дор Төрийн ордны Их Монгол танхимд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулав.<br>Чуулганд яамдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо, 9 дүүрэг, 21 аймгийн ХАБЭА-н зөвлөл, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ажил олгогч, салбарын хяналтын байцаагч нар, аж ахуйн нэгж байгууллагуудын ХАБЭА-н зөвлөлийн гишүүд, ХАБЭА-н чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг их, дээд сургууль, сургалтын байгууллагууд, салбарын судлаачид, нийгмийн түншүүд зэрэг нийт 850 гаруй төлөөлөгч оролцов.<br>Уг арга хэмжээний үеэр улсын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн 9 ажил олгогчийг шалгаруулан шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчилав.<br>Зохион байгуулсан арга хэмжээ болон холбогдох | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллүүдийг хэвлэл мэдээллийн цахим сайт, олон нийтийн телевизээр орон даяар түгээж ажиллав.<br>2. Мөн мэргэжлийн байгууллагатай хамтран дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллав. Үүнд:<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, сурталчилгааны аялын хүрээнд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгааны 8 арга хэмжээ;<br>- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар даатгуулагч, ажил олгогчид зориулсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтын 6 арга арга хэмжээ;<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн, шинэ техник, технологи, инновац нэвтрүүлсэн ажил олгогчийн шилдэг туршлага, ололт, амжилтыг олон нийтэд сурталчлах 5 арга хэмжээ; | |
| 1.7. | Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах; | - | Хэрэгжилтийг хангуулсан хэлэлцээрийн тоо | Монгол Улс болон Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын хооронд байгуулсан "Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр"–ийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Нийгмийн хамгаалын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнд:<br>1. *БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд:* ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 73 хүний хүсэлтийг ОХУ-ын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлж, хоёр улсад ажилласан хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 48 хүний ажилласан жилийн тодорхойлолтыг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, 54 хүнд хэлэлцээртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөв.<br>2. *БНСУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хүрээнд:* БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд шимтгэл төлсөн 53 хүний 254.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичгийг хүлээн авч Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлэв. Мөн хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажилласан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлийг БНСУ дахь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>3. *Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд:* Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 95 хүний Монгол Улсад нийгмийн даатгалын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 41 хүний Бүгд Найрамдах Чех Улсад даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлтийг БНЧУ-ын талд хүргүүлэв.<br>*4.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Унгар Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд:* тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан болон мэдээлэл солилцох 32 хүний, Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах 30 хүний, 1 хүний сануулах маягт, 14 хүний дансны мэдээллийн маягт, Унгар улсаас өндөр насны тэтгэвэр авагч 25 хүний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалтыг Унгар Улсын талд хүргүүлэв.<br>*5.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд:* Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 8 хүний мэдээллийг Польш Улсын талд хүргүүлэв.<br>*6.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд:* 1 хүний мэдээллийг Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэв. | |
| 1.8. | Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээр шинээр байгуулах, хэлэлцээрийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах; | - | Хэлэлцээр шинээр байгуулахтай холбоотой ажилласан ажлын хэсгийн тоо | Монгол Улс Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс болон Австралийн Холбооны Улсын Засгийн газар хоорондын Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг шинэчлэхтэй холбоотой шинжээчдийн багийн уулзалтыг зохион байгуулан ажиллах ажлын хэсгийн багт орж ажилласан. | Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээр шинээр байгуулах ажлын хэсэгт ажилласан байна. | *Нэг. Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд:*<br>1.Хэлэлцээр байгуулах асуудлаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 03 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулсан шинжээчдийн түвшний уулзалтад оролцов. Уулзалтаар Хэлэлцээрийн төслийг эцэслэн тохиролцож, харилцагч байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох маягтыг хэлэлцэх уулзалтыг 2025 оны 9 дүгээр сард Австри Улсын Вена хотод хийхээр харилцан тохиролцов.<br>2.Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 16-19-ний өдрүүдэд БНАУ-ын Нийгмийн даатгалын холбоонд зохион байгуулагдсан уулзалтад тус газрын удирдах, гүйцэтгэх 4 албан хаагч оролцов.<br>Хэлэлцээрийн хэрэгжилтийн хүрээнд солилцох холбогдох хууль тогтоомжийн гэрчилгээ, Мэдэгдэл, Тэтгэвэр тогтоолгох өргөдөл, Монгол Улсад/ Австри Улсад даатгуулсан бүртгэлийн гэрчилгээ, Эмнэлгийн дэлгэрэнгүй дүгнэлт, Бодит зардлын мэдэгдэл, Статистик мэдээлэл, Холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн статистик мэдээлэл зэрэг талууд хооронд мэдээлэл солилцох 16 маягтыг хэлэлцэж нэгдмэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санал хүрсэн болно<br>***Хоёр.*** *Австралийн Холбооны Улстай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд:*<br>1.Хэлэлцээр байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэх 2 дахь удаагийн уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулав. Уулзалтад Австралийн Нийгмийн үйлчилгээний яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гадаад харилцааны яам, Монгол Улс дахь Австралийн Элчин сайдын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газрын төлөөлөл оролцож, дараагийн шатны хэлэлцээг 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулах, хэлэлцээрийн төслийг боловсруулах талаар санал солилцож, нэгдсэн санал хүрэв.<br>2.Австралийн Холбооны Улстай "Нийгмийн хамгааллын хэлэлцээр" байгуулах хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын 10-13-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо биечилсэн уулзалт хэлэлцээнд оролцож, хэлэлцээрийн төсөл дээр ажиллаж, протокол үйлдэв.<br>***Гурав.*** *Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулах ажлын хүрээнд:*<br>1.Хэлэлцээрийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Бүгд Найрамдах Казахстан Улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2025.04.10-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг соёрхон батлуулах явцын талаар харилцан мэдээлэл солилцов.<br>2.Хэлэлцээрийг батлуулах хоёр улсын шинжээчдийн хамтарсан ажлын хэсэгт Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2 албан хаагч томилогдон ажиллав. Уг ажлын хэсэг 2017 онд байгуулагдсанаас хойш 18 удаагийн хэлэлцээ хийж, хэлэлцээрийн төслийг эцэслэн боловсруулсан. Уг хэлэлцээрийг Улсын Их хурлын чуулганы 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж соёрхон баталлаа<br>**Дөрөв.** Бусад<br>1.Бүгд Найрамдах Киргиз Улсын Нийгмийн сангийн газрын төлөөлөлтэй 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцож, хоёр улсын нийгмийн хамгааллын тогтолцоо, тэтгэврийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодлогын талаар харилцан туршлага солилцов.<br>2.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан 5 дах удаагийн уулзалтад оролцов. Уулзалтаар 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдсан 4 дэх шатны хэлэлцээний мөрөөр авсан арга хэмжээг хэлэлцэн дараагийн хэлэлцээний талаар санал солилцов. | |
| 1.9. | Гадаад орны нийгмийн даатгалын байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг тодорхойлж, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх; | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2024 онд хамтран ажиллах тухай нийт 5 албан бичгийг хүргүүлж, 5 олон улсын байгууллагатай 6 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллан 20,000 ам долларын санхүүжилт бүхий сургалт, хэлэлцүүлгийг амжилттай зохион байгуулсан. | Олон улсын байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байна. | Гадаад орны нийгмийн даатгалын байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд 2025 онд хамтран ажиллах тухай найрсаг харилцааны нийт 7 албан захидлыг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ослын нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын нөхөн олговор, халамжийн үйлчилгээний газар, Унгар Улсын Будапешт хотын Тэтгэврийн даатгалын хэлтэс, Бүгд Найрамдах Чех Улсын Нийгмийн хамгааллын байгууллага, Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний тэтгэврийн алба, Бүгд Найрамдах Польш Улсын Нийгмийн даатгалын байгууллага, Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад цахимаар хүргүүлэв.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хонконгийн Албан журмын хуримтлалын сангийн газар хооронд хамтран ажиллах Санамж бичгийн төслийг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/785 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>3. Бүгд Найрамдах Хятад Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын Яам, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран ажиллах саналыг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/722, 01/740, 01/766 дугаар албан бичгүүдээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.<br>4. Бүгд Найрамдах Солонгос Улсын Ажилчдын нөхөн олговор, халамжийн үйлчилгээний газартай хамтран ажиллах санал боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/2386, 01/2764 дугаар албан бичгээр хүргүүлэв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улсын хооронд Нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах шинжээчдийн түвшний 3 дахь шатны уулзалтын хүрээнд Бүгд найрамдах Австри Улсын Европ болон олон улсын харилцааны яамны төлөөлөлтэй 2025 оны 03 дугаар 13-ны өдөр уулзалт зохион байгуулж, талууд нийгмийн даатгалын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны талаар танилцуулж, харилцан туршлага солилцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр болов.<br>6. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын санхүүжилтээр 23,400 ам долларын үнэ бүхий Нийгмийн даатгалын үйлчилгээний гарын авлага хэвлүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, видео контент хийх зэрэг чиглэлээр хамтран ажиллав. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албан бус эдийн засгийг албажуулах төсөлтэй хамтран "Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах" сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд зохион байгуулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын нийт 90 албан хаагч хамрагдав.<br>7. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-аас 2025 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх Техникийн хамтын ажиллагааны төсөд "Нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах арга хэрэгсэл, авлагын менежмент" төслийг хэрэгжүүлэх саналыг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1289 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>8. Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, системийн шинэчлэл хийх, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг ажлыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын албан бус эдийн засгийг албажуулах төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн бөгөөд энэхүү төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд үнэлгээ хийхээр ирсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөх, үнэлгээний ахлах Лосс ван дер Графтай 2025.08.22-ны өдөр уулзалт зохион байгуулав.<br>9. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Байгаль орчин ба хөдөлмөрийн зохистой нөхцөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Фредди Гуаякантай хийх уулзалтыг 2025 оны 10 дугаар .01-ний өдөр зохион байгуулж, ногоон эдийн засаг, ногоон ажлын байр, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шилжилтийн үеийн нийгмийн даатгалын асуудлаар санал солилцов.<br>10. Бүгд Найрамдах Солонгос Улсын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тогтолцоо, шилдэг туршлагыг судлах, Бүгд Найрамдах Солонгос Улс дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасгийн үйл ажиллагаатай танилцах, шалгалт хийх, холбогдох чиглэл зөвлөмж гаргах, тус ажиллаж амьдарч байгаа монголчуудтай уулзалт хийх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох ажилтнууд Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 12 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд ажиллав. | |
| 1.10. | Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулах; | - | Ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулсан мэдээлэл, сурталчилгаа, сургалтын тоо | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийн талаар ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалтыг 2024 онд нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн хэмжээнд зохион байгуулж, 14 төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын 650 гаруй иргэд, даатгуулагчдад хууль тогтоомжийг сурталчилсан. | Нийгмийн даатгалын багц хууль болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажилтан, албан хаагчид болон ажил олгогч, иргэд, даатгуулагч, олон нийтэд танилцуулах, мэдээлэх, сурталчлах, сургалт зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлах ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. МҮОНТ, SBN телевизүүдэд "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл", "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр", "Нийгмийн даатгалд даатгуулахын ач холбогдол", "Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж" зэрэг сэдвүүдээр тус тус мэдээлэл өгөв.<br>2. Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Албан журмын даатгуулагчдын холбоо зэрэг байгууллагуудын 140 гаруй ажилтнуудад "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл" сэдвээр, Тагнуулын ерөнхий газар, Нийслэлийн онцгой байдлын газрын 60 гаруй албан хаагчдад "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт" сэдвээр, нийт 200 гаруй даатгуулагчдад мэдээлэл өгөв.<br>3. Дорноговь, Дархан-Уул аймаг, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газраас зохион байгуулсан "Ажил олгогчийн зөвлөгөөн"-д оролцож, аймгийн 2,600 гаруй ажил олгогчийн дарга, захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн хэрэгжилт", "Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд ажил олгогчийн анхаарах асуудал" сэдвүүдээр мэдээлэл өгч, 130 гаруй ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой асуултад хариулж, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан "Ахмад настны эрхийн талаарх амлалтаа бэхжүүлье" хэлэлцүүлэгт оролцож буй төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллагын 30 гаруй төлөөлөгчдөд "Ахмад настны нийгмийн баталгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр" сэдвээр мэдээлэл өгөв.<br>5. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2025 оны 10 дугаар сарын 6,7-ны өдрүүдэд Баян-Өлгий аймагт зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т оролцож, Баян-Өлгий аймгийн иргэд, ажил олгогч, даатгуулагчид, Нийгмийн даатгалын газар, эрүүл мэндийн төвийн албан хаагчид болон зам дагуух Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай, Ховд аймгуудын Нийгмийн даатгалын газрын албан хаагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллав.<br>6. Унгар улс, Бүгд Найрамдах Чех улсад ажиллаж амьдарч байгаа 90 гаруй иргэд, даатгуулагчдад тэтгэвэр тогтоолтын талаар цахим сургалт зохион байгуулж, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.<br>7. Монгол HD телевиз, ORI студитэй хамтран зохион байгуулсан "Бизнесээ томруулъя" арга хэмжээнд оролцож, 500 гаруй гарааны болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд "Нийгмийн даатгалын үйлчилгээ, боломж" сэдвээр мэдээлэл өгөв. | |
| 1.11. | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулах, гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, гэрээг шинэчлэх санал боловсруулах; | - | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Нийгмийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 34, НД04/24 дугаартай "Хамтран ажиллах гэрээ"-г шинэчлэн байгуулав. | Гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, шинэчлэн байгуулах санал боловсруулж, батлуулсан байна. | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2024 онд байгуулсан НД04/24 дугаартай "Хамтран ажиллах гэрээ"-г дүгнэж, 2025 оны НД09/25, ЭМДЕГ-25/27 дугаартай "Хамтран ажиллах гэрээ"-г шинэчлэн байгуулав.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн хооронд 2025 оны НДСБ-02 дугаартай "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг байгуулав.<br>Санамж бичгийн хүрээнд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, ач холбогдлын талаар ажил олгогч, иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд, олон улсын туршлага сэдэвт сургалт зохион байгуулахаар 2025 оны НД-49/25 дугаар бүхий "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулав.<br>3. Нийгмийн даатгалын багц хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, даатгуулагчдын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрх ашийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг 5 жилийн хугацаатай байгуулав.<br>4. Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох, дүрэм, журмын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, ажил олгогч эздийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг 4 жилийн хугацаатай байгуулав.<br>5. Нийгмийн даатгалын багц хууль, Худалдаа аж үйлдвэрийн танхимын тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хүрээнд түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, бизнес эрхлэгч ажил олгогч, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимын "Хамтын ажиллагааны санамж бичиг"-ийг 3 жилийн хугацаатай байгуулав.<br>6. Монголын ахмадын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу "Хамтран ажиллах санамж бичиг"-ийн төслийг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1744 дүгээр албан бичгээр Монголын ахмадын холбоонд хүргүүлэв. | |
| 1.12. | Цэргийн алба хаагчид тэтгэвэр тогтоох, олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр цэргийн байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, шинэчлэн байгуулах; | - | Шинэчлэн байгуулсан гэрээний тоо | Тагнуулын ерөнхий газартай НД-03/24, 08/24 дугаартай "Нийгмийн даатгалын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар хоорондын цэргийн тэтгэврийн чиглэлээр хамтран ажиллах гэрээ", Зэвсэгт хүчний Жанжин штабын Тагнуулын газартай нууцын зэрэглэлтэй хамтран ажиллах гэрээг тус тус шинэчлэн байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллав. | Гэрээ, санамж бичгийн хэрэгжилтэд хяналт тавьж, шинэчлэх санал боловсруулж, батлуулсан байна. | 1. Цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг хангах, тэтгэврийн үйлчилгээг чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор цэргийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/735 дугаар албан бичгээр цэргийн 10 байгууллагатай байгуулсан гэрээнд өөрчлөлт оруулах саналаа ирүүлэх албан бичгийг хүргүүлэв.<br>2. Батлан хамгаалахын сайд, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах заавар"-ыг хэрэгжүүлэх зөвлөмжийн хамт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.<br>3. Цэргийн алба хаасны, цэргийн хөдөлмөрийн чадвар алдсаны, цэргийн тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг цахимд шилжүүлэх ажлын хүрээнд цэргийн алба хаагчийн тушаал, шийдвэрийн лавлагаа, цэргийн алба хаасан тооцоолол болон холбогдох бусад | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийг цахимаар солилцох зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаалаар байгуулсан Ажлын хэсэгт ажиллав.<br>4. Нийгмийн даатгалын ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2025 оны А/193, А/390 дугаар хамтарсан тушаалын дагуу Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тэтгэвэр тогтоон олгох ажлын хүрээнд алба хаагчдын тушаал шийдвэрийн лавлагаа, тооцоолол мэдээллийг цахимаар солилцох ажлын хэсэгт ажиллав. | |
| 1.13. | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025 оны төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | НДС-ийн орлого 5,893.3 тэрбум төгрөг /Улсын төсвийн татаас орсон дүн/, Зарлага 5,188.4 тэрбум төгрөг | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг олгосон байна. | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | Аймаг, дүүргийн төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлэн, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын төсвийг олгосон байна. | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар сангийн орлого (улсын төсвийн санхүүжилт орсон дүнгээр)-ыг 6,908.1 тэрбум төгрөгөөр, зарлагыг 5,869.5 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарь батлах тухай" А/01, "Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/15, А/50, А/143, А/161, А/201, А227, А/282, А/320 дугаар тушаалуудаар нийгмийн даатгалын сангийн төсвийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарийг батлуулан, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | 100 |
| 1.14. | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн аймаг, нийслэл, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг | Үйл ажиллагааны урсгал зардал 75.1 тэрбум төгрөг | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг олгосон байна. | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн | Аймаг, дүүргийн төсвийн нарийвчил-сан хуваарь, сар, улирлын хуваарийг нийгмийн даатгалын байгууллагууд дад үйл | Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 67.4 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарь батлах тухай" А/02, "Үйл ажиллагааны урсгал зардлын 2025 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/16, А/49, А/129, А/154, А/200, А/243, А/276, А302 дугаар тушаалуудаар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарийг батлуулан, аймаг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах: | | | даатгалын байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. | ажиллагааны урсгал зардлын төсвийг олгосон байна. | дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | |
| 1.15. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх; | - | Хуулийн хугацаанд боловсруулж хүргүүлсэн төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн хязгаарын санал | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2025-2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангийн 2026-2028 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Санал хүргүүлэх тухай" 01/636 дугаар албан бичгээр, нийгмийн даатгалын сангийн 2026 оны жилийн хязгаарын саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Санал хүргүүлэх тухай" 04/1333 дугаар албан бичгээр тус тус Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>Уг саналд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг хэвийн өсөлтөөр, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 8.0 хувиар нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох дундаж цалинг тооцох дараалсан 5 жилийн дээд хязгаарыг 2,400,000 төгрөг болгох зэрэг өөрчлөлтүүдийг тусган нийгмийн даатгалын сангийн орлогыг 8,794.4 тэрбум төгрөгөөр, үүнээс төр хариуцах иргэдийн тэтгэвэр болон шимтгэлийн хөнгөлөлтийг 2,774.8 тэрбум төгрөгөөр, сангийн нийт зарлагыг 6,963.5 тэрбум төгрөг байхаар тус тус тооцов. | 100 |
| 1.16. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг жендерийн мэдрэмжтэй төлөвлөлт ба төсөвлөлтийн аргаар боловсруулж, Нийгмийн даатгалын | - | -2025 оны 07 сарын 20-ны өдрийн дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн төсөл, төсөөлөл | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай" 1/1112 дугаар албан бичгээр нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026-2028 оны төсвийн төсөл, төсөөллийг боловсруулж, ирүүлэх чиглэлийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагуудад хүргүүлж, ирүүлсэн саналыг хянан нэгтгэж, нэгтгэсэн төсвийн саналыг боловсруулж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2-т заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Төсвийн төсөл, төсөөллийн санал хүргүүлэх тухай" 01/1740 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв.<br>Уг төсвийн төслийн саналд тэтгэвэр, тэтгэмж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ерөнхий газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндсэний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх; | | | төсөөллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын зөвлөл, Нийгмийн даатгалын үндсэний зөвлөлөөр тус тус хэлэлцүүлэн, Гэр бүл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг 2025 оны 07 дугаар сарын 20-ний дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | авагчдын тоо, сангийн зарлагыг нас, хүйсээр ангилан тооцож, тэтгэвэр бодох цалингийн дээд хязгаарыг 2,400.0 болгон нэмэгдүүлэхэд 333.8 тэрбум төгрөг, тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан 10.3 хувиар нэмэгдүүлэхэд 572.5 тэрбум төгрөг шаардагдах тооцооллыг тусгав. | |
| 1.17. | Монгол Улсын төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх; | - | -Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн Аймаг, дүүргийн, сар, улирлын хуваарийн саналын тоо | 2025 оны төсвийн аймаг, дүүргийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | 2026 оны төсвийн аймаг, нийслэлийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийн саналыг боловсруулан 2025 оны 12 дугаар сарын 15-ны дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийг 60.2 тэрбум төгрөгөөр, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн орлогыг 7,824.7 тэрбум, үүнээс улсын төсвийн татаасыг 1,624.6 тэрбум төгрөг, сангийн зарлагыг 6,584.8 тэрбум төгрөгөөр тус тус баталсан.<br>Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон сар, улирлын хуваарь, Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон сар, улирлын хуваарийг боловсруулан, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1-д заасан хугацаанд буюу 12 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ. | 100 |
| 1.18. | Нийгмийн даатгалын байгууллагуудыг нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны урсгал зардлын төсөв, төлөвлөгөө | - | Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуу | Холбогдох асуудлаар 27 удаагийн зөвлөмж, чиглэлийг аймаг, дүүргийн Нийгмийн | Нийгмийн даатгалын байгууллагуудын төсөв, төлөвлөгөө | 1. Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны дунд хугацааны төсөөллийг батлсан аргачлал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулах нэгдсэн удирдлага, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах; | | дад хүргүүлсэн зөвлөмж, чиглэлийн тоо, Зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, үр дүн | даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллав. | хуулийн хугацаанд боловсруулаг дсан байна. | зөвлөмжийн дагуу сум, дүүрэг, тасгийн холбогдох байцаагч, ажилтнуудыг ажлын хэсэгт ажиллуулан боловсруулж, цахим системээр 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэх зөвлөмж, чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны "Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай" 04/1364 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.<br>2. Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 07 сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 01/3031 дүгээр албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/2381 дүгээр албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад чиглэл хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. | |
| 1.19. | Нийгмийн даатгалын салбарын статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэх, жендерийн нарийвчилсан үзүүлэлтээр баяжуулах, мэдээллийн сан бүрдүүлэх; | - | Статистик үзүүлэлтийн нэгтгэлийг шинэчлэн, нарийвчилсан баяжуулсан мэдээллийн сангийн тоо | 2023 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтийг шинэчилсэн. | 2024 оны жилийн эцсийн статистик үзүүлэлтээр шинэчилсэн байна. | 1. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тоо, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээ зэрэг статистик мэдээллийг аймаг, дүүргээр 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн гаргав.<br>2. Нийгмийн даатгалын салбарын 2024 оны статистик мэдээллийг Үндэсний статистикийн хорооны даргын 2024 оны "Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай" A/175 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Үндэсний статистикийн хороонд тус тус хугацаанд нь хүргүүлэв. | 100 |
| **Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | |
| ***Зорилт 2:*** *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, эмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох; | - | Төсвийн зардлыг 5,882,758.8 сая төгрөгөөс хэтрүүлэхгүй байна. | Нийгмийн даатгалын сангаас 5,087,002.64 сая төгрөгийн зардал олгосон. | Нийгмийн даатгалын сангаас 5,882,758.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар нийгмийн даатгалын сангийн зарлагыг нийт 5,869.4 тэрбум төгрөгөөр тодотгон батлсан.<br>Тодотгосон төсвийн хүрээнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд нийт 5,832.1 тэрбум төгрөг олгож, 99.4 хувийн биелэлттэй, зарлагын гүйцэтгэлийг хангуулав. Үүнд: | 85.0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгоно. | - Тэтгэврийн даатгалын сангаас 5,360.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 5,334.7 тэрбум төгрөг;<br>- Тэтгэмжийн даатгалын сангаас 280.5 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 281.9 тэрбум сая төгрөг;<br>- ҮОМШӨ-ний даатгалын сангаас 66.6 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 52.0 тэрбум төгрөг;<br>- Ажилгүйдлийн даатгалын сангаас 161.8 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс 163,.5 тэрбум төгрөг тус тус зарцуулав.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны "Журам батлах тухай" А/183 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын дагуу Нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн төвлөрсөн харилцах дансанд хуримтлуулсан ажил олгогч, даатгуулагчийн төлсөн шимтгэл, алданги, торгуулийн нийт 5.159.9 тэрбум төгрөгийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлэх арга хэмжээ авсны үр дүнд батлагдсан төсөвт багтаан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг олгож, шалгуур үзүүлэлтийг хангаж зорилтот түвшинд хүрсэн. | |
| 2.2. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах; | - | Тайлагнасан тоо | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг 2 удаа зохион байгуулсан. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг 2 удаа нэгтгэн хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлнэ. | 1. Нийгмийн даатгалын байгууллагуудад 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах хуваарийг хүргүүлэн мэргэжил арга зүйн заавар чиглэл өгч, нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн тайлангуудыг хуульд заасан хугацаанд хянан нэгтгэж, Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэв.<br>2. Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу Үндэсний аудитын газраар нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангуудад аудит хийлгэж, мөн аймаг, дүүргийн аудиторуудтай хамтран ажиллав.<br>Засгийн газрын нэгтгэсэн тайлангийн аудитын хугацаанд Үндэсний аудитын газрын аудитын баг нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл, судалгаа, тайлбар, тодруулгуудыг тухай бүр хугацаанд нь гарган өгөв. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хамтран ажилласны ажлын үр дүнд Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна" гэж дүгнэсэн.<br>Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангуудын дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Даргын зөвлөлд танилцуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хуулийн хугацаанд хүргүүлэв.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, 2024 он, 2025 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн нэгтгэсэн тайлан, аудитын дүгнэлт, биелэлт, сар бүрийн сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулав.<br>Төсвийн тухай хуульд заасан цагалбарт багтаан нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн 2 удаагийн 4 төрлийн нэгтгэсэн тайланг дээд шатны 4 байгууллагад хүргүүлснээр шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж, зорилтот түвшинд хүрсэн. | |
| 2.3. | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулах, гэрээний биелэлтийг хангах; | - | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хууль, дүрэм, журмын дагуу удирдсан байна. | Засгийн газрын дотоод үнэт цаас 300,000.0 сая төгрөгөөр худалдан авсан. | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулж, гэрээний биелэлтийг хангана. | Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-д заасны дагуу нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн тооцооллыг тэтгэмжийн даатгалын сан болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан тус бүрээр, мөн мөнгөн хадгаламжийн хүүгийн хэмжээний тооцооллыг тус тус хийж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлсэн.<br>Үүний дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс банкны системд нөлөө бүхий арилжааны банканд 2025 онд хадгаламж хэлбэрээр байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хэмжээг 700.0 тэрбум төгрөгөөр, 08 дугаар тогтоолоор мөнгөн хадгаламжийн 2025 оны хүүгийн доод хэмжээг жилийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 14.2 хувиар тус тус баталсан.<br>Банкны системд нөлөө бүхий арилжааны банкнуудаас 2-3 удаа санал авч Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 08 дугаар тогтоолоор баталсан хүүгийн хэмжээнээс доошгүй санал ирүүлсэн Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банканд сар бүр хүү олгох нөхцөлтэй, 1 жилийн хугацаатай мөнгөн хадгаламж байршуулах санал, гэрээний төслийн хамт Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо болон Олон нийтийн хяналтын зөвлөлд хүргүүлэн санал, дүгнэлт авч ажилласан.<br>Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл 700.0 тэрбум төгрөгийг жилийн 15.0 хувийн хүүтэй, сар бүрийн эцэст хүү тооцох нөхцөлтэй, нэг жилийн хугацаатай хадгалуулахаар мөнгөн хадгаламжийн гэрээг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Хаан банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банктай тус тус байгуулан мөнгөн хөрөнгийг байршуулж мэдээллийг байгууллагын https://www.ndaatgal.mn/ цахим хуудасны шилэн данс хэсэг, https://shilendans.gov.mn/ цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулан даатгуулагч, иргэдэд мэдээлсэн.<br>Банкуудтай байгуулсан гэрээний дагуу 05-11 дүгээр сарын хүү болох 61.2 тэрбум төгрөгийг холбогдох дансанд бүрэн хүлээн авч, сар бүр тооцоо нийлэн баталгаажуулав.<br>Хадгаламжийн хүү хүлээн авсан тухай мэдээг сар бүр байгууллагын цахим хуудасны шилэн данс хэсэгт болон Facebook page хуудсаар олон нийтэд ил тод мэдээлэн ажиллав.<br>Энэхүү хадгаламжийн хугацаанд нийт 105.0 тэрбум төгрөгийн хүүгийн орлогоор нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг өсгөх боломжтой болсон.<br>Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль болон Засгийн газрын 2025 оны "Засгийн газрын болон Монголбанкны үнэт цаас худалдан авах хөрөнгийн хэмжээг батлах тухай" 192 дугаар тогтоолоор нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлээс Засгийн газрын урт хугацаат (нэг жил болон түүнээс дээш) бонд, Монголбанкны үнэт цаас худалдан авахад зарцуулах хөрөнгийн хэмжээг 2025 онд 300.0 (гурван зуун) тэрбум хүртэлх төгрөгөөр тус тус баталсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Засгийн газрын бонд худалдан авсан 2024 оны гэрээний эхний 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны хугацаа дууссан тул худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах 179/НД-106/25 дугаар гэрээг Сангийн яамтай 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр байгуулан 9.5 хувийн хүүтэйгээр 3 жилийн хугацаатайгаар сунгаж өгөөжийг нэмэгдүүлэв.<br>Сангийн чөлөөт үлдэгдлээс 2024 онд 300.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын бонд худалдан авах гэрээг Сангийн яамтай байгуулснаар санхүүгийн сахилга баттай, үр ашигтай, эрсдэлгүй, найдвартай зөв хөрөнгө оруулалтыг хийснээр үнэт цаасны хүүгийн орлогоор 27 тэрбум төгрөгийг хүлээн авч нийгмийн даатгалын санг арвижууллаа.<br>Сангийн яам хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор 2025 оноос Засгийн газрын дотоод үнэт цаасыг хөрөнгийн биржээр нээлттэй худалдаж байгаа тул уг арилжаанд үнэт цаасны компаниар зуучлуулан оролцох шаардлагын үүднээс Засгийн газрын 2024 оны "Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулахаар төслийг бэлтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1228 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлснээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон. | |
| 2.4. | Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, даатгуулагч тус бүрээр хуваарилах ажлыг зохион байгуулах, судалгаа, тооцоог хийж, холбогдох газарт хүргүүлэн, хэрэгжилтийг хангах; | - | Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг хууль, дүрэм, журмын дагуу удирдсан байна. | Тэтгэврийн нөөц санд 212.2 тэрбум төгрөгийг байршуулсан. | Мөнгөжүүлэхэд бэлэн орлогын мэдээллийг сар бүр Мэдээллийн технологийн төвөөс авч тэтгэврийн нөөц санд байршуулж, мэдээлнэ. | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байхаар заасны дагуу 80.0 тэрбум төгрөгийг нэмж, байршуулснаар 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нөөц сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нийт 301.8 тэрбум төгрөг болсон.<br>Тэтгэврийн мөнгөн хуримтлалын мэдээллийг даатгуулагчдад гар утасны нийгмийн даатгал аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ систем, И-Монголиа системээр тогтмол мэдээлэв.<br>Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-д заасны дагуу тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг даатгуулагчийн санал үндэслэн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөрөнгө оруулж болох зохицуулалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж бэлтгэл ажлыг хангаад байна. Үүнд:<br>Тэтгэврийн нөөц санд байршсан мөнгөн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах даатгуулагчийн саналыг И-Монгол цахим платформ болон гар утасны Ndaatgal аппликэйшн, www.portal.ndaatgal.mn цахим хуудсаар дамжуулан авах ажлыг 2025 оны 07 дугаар сараас эхлүүлсэн.<br>Зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулах боломжтой эсэх талаар холбогдох байгууллагуудаас саналыг авч ажилласан ба сар бүр хүү олгох нөхцөлтэй, нэг жилийн хугацаатай хадгаламж байршуулах тохиолдолд Төрийн банк, ХААН банк, Голомт банк, Худалдаа хөгжлийн банкнаас 15.11 хувь, Хас банкнаас **12.5** хувийн хүүг олгох саналыг тус тус ирүүлээд байна.<br>**Нийгмийн даатгалын үндсэний зөвлөлийн Ажлын албанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын** 2025 оны 01/3109 дугаар албан бичгээр мэдээллийг хүргүүлсэн. | |
| 2.5. | Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-аас нэхэмжилсэн **өр** төлбөрийг барагдуулах зорилгоор мэргэшсэн өмгөөлөгч, мэргэжлийн хуулийн байгууллагатай хамтран ажиллах; | 300.0 сая төгрөг | Өр төлбөрийн бууралт | Капитал банкны өр төлбөрийн үлдэгдэл 65.7 тэрбум төгрөг, Чингис хаан банкны өр төлбөрийн үлдэгдэл 95.2 тэрбум төгрөг байна. | Капитал банк болон **Чингис хаан** банкны өр төлбөрийн үлдэгдлийг бууруулсан байна. | Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн **104.2 тэрбум** төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 41.1 тэрбум төгрөг (мөнгөөр 14.8 тэрбум төгрөг, хөрөнгөөр 26.2 тэрбум төгрөг) 2025 онд 2.6 тэрбум төгрөгийн **төлбөр** барагдаж, **63.1 тэрбум** төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br>Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн **103.6 тэрбум** төгрөгийн авлагаас 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 18.6 тэрбум төгрөг (мөнгөөр 11.1 тэрбум төгрөг, хөрөнгөөр 7.5 тэрбум төгрөг) 2025 онд 10.2 тэрбум төгрөгийн төлбөр барагдаж, **84.9 тэрбум** төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br>Өр төлбөрийг 2025 онд нийт **12.8 тэрбум** төгрөгөөр бууруулсан үр дүнтэй ажиллав.<br>Урсгал үйл ажиллагааны 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Чингис хаан банк ХХК, Капитал банк ХХК-иас авах нийгмийн даатгалын сангийн авлагыг бүрэн барагдуулахад төлбөр авагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалан эрүү, иргэн, захиргааны анхан болон давж заалдах шатны шүүх, улсын дээд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд болон төрийн бусад байгууллагад төлөөлөх хуулийн этгээдээс хууль зүйн туслалцаа авахаар 300.0 сая төгрөгийн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөвт өртөгтэй хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах тендерийг 3 удаа зарлаж хамгийн бага үнийн саналаар шалгарсан "Дэлгэрэнгүй хууль" ТББ-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. <br> Гэрээ байгуулсан хугацаанаас хойш Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчаас 1.1 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын санд төлж барагдуулан, 30.0 орчим тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгийг олж илрүүлэн өр төлбөрт шилжүүлэн авахаар судалж байна. | |
| ***Зорилт 2.1:** "Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | - | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, <br> -Өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 28.1 мянган хүний сайн дурын даатгалд шинээр, үүнээс 9.0 мянган малчин шинээр хамруулав. | Сайн дурын даатгуулагч (малчин)-ийн тоог өмнөх оны суурь түвшин 60,6 хувиас зорилтот түвшин 61.75 хувь, үүнээс малчин даатгуулагчийг 24 хувиар нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/10 дугаар тушаалаар "2025 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн орон тооны төлөвлөгөө"-г батлан уг төлөвлөгөөнд сайн дурын даатгалд нийт 199.7 мянган даатгуулагч, үүнээс 26.9 мянган даатгуулагчийг шинээр хамруулахаар тусгаж Шимтгэл хураалт, мэргэжил, арга зүйн газрын даргын 2025 оны 01 сарын 28-ны өдрийн "Төлөвлөгөө хүргүүлэх тухай" 06/213 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <br> 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар сайн дурын даатгалд шинээр 2025 онд хүрэх түвшингээс 85.7 хувь буюу 23.1 мянган хүнийг сайн дурын даатгалд шинээр, нийт хамрагдвал зохих малчдын тоог 125.6 хувь буюу 10.7 мянгаар нэмэгдүүлж ажиллав. <br> Сайн дурын даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулах мэдээлэл хүргэх, хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнд: <br><br> -Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Албан бус эдийн засгийг албажуулах төсөл"-тэй хамтран "Нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхжуулах" сургалтыг зохион байгуулав. Мөн "Зохистой хөдөлмөрийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон холбогдох байгууллагуудтай уулзаж санал солилцон ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд бүртгэлтэй хоршооноос давхардсан тоогоор 2,379 гишүүн малчдыг сайн дурын даатгалд хамруулсан.<br>- Олон нийтэд нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулах мэдээлэл хүргэх зорилгоор C1 телевиз, Монголын үндэсний Олон нийтийн радиод ярилцлага өгч, иргэд даатгуулагчдад тус газраас зохион байгуулдаг ээлжит лайваар мэдээлэл хүргэн иргэдийн сонирхсон асуултад хариулт өгч ажиллав.<br>- Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа Монгол улсын иргэдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хилийн чанад дахь монголчуудын зөвлөлтэй хамтран АНУ, Австрали, Ази, Европ тивийн төлөөлөлтэй хамтран Блегицахим мэдээлэл, уулзалт зохион байгуулсан. Энэхүү ажлын хүрээнд Унгар, Бельги, Чех, Австри улсад ажиллаж амьдарч байгаа Монголчуудад Нийгмийн даатгалын ач холбогдол, сайн дурын даатгалын талаар мэдээлэл, зөвлөгөөг хүргэн ажиллаж байна.<br>- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн алба хаагч нарт, Сайн дурын даатгал, даатгалд хамрагдахын ач холбогдлыг иргэд даатгуулагч нарт хэрхэн хүргэх арга зүйн талаар мэдээлэл хийв.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчдыг хамруулах тоон төлөвлөгөө, мөн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ хамралтын төлөвлөгөөний биелэлтийг гол үзүүлэлт болгох талаар Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газрын даргын 2025 оны "Ажил эрчимжүүлэх тухай" 04/2383, 04/3061 дугаар албан бичгийг Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн.<br>- Төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны хүрээнд "Бизнесээ томруулъя" ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд сайн дурын даатгалын ач холбогдлыг таниулах зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан 2 удаагийн Нээлттэй хаалганы өдөрлөгт оролцон 130 иргэд даатгуулагч нарт, мөн МУИС-ийн багш оюутнууд, МОХ-оос зохион байгуулсан "Ботго эвент"-д оролцож сайн дурын даатгалын мэдээлэл зөвлөгөөг хүргэж ажилласан. | |
| 2.1.2 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | - | -Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо,<br>-Өсөлтийн хувь,<br>-Төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 4.4 мянган ажил олгогч, 134.1 мянган хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав. | 2025 оны төсвийн тухай хуулийн 31.1.1.1-т заасны дагуу өмнөх оны суурь түвшингээс 93.4 хувьд хүргэж төлөвлөгөөг биелүүлсэн байна. | Албан журмын даатгалд шинээр 2025 оны 12 дугаар сарын 08-ны байдлаар Төсвийн тухай хуулийн 31.1.1.1-т заасны дагуу өмнөх оны суурь түвшингээс 93.4 хувь буюу 7.6 мянган ажил олгогч, 122.1 мянган хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулж ажиллав.<br>Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав. Үүнд:<br><br>- Малчдын нийгмийн баталгааг хангах, хамралтыг нэмэгдүүлэх талаар "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ний дарга, нягтлан бодогчдыг албан журмын даатгалд хамруулах талаар Үндэсний хорооны ажлын албатай хамтран ажиллаж мэдээлэл солилцох ажлыг эхлүүлсэн.<br>- Шинээр бүртгүүлсэн ажил олгогчийн мэдээллийг цахимаар солилцох хамтран ажиллах хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Хүсэлт тавих тухай" 01/398 дугаар албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлэв.<br>- *Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоотой байгуулсан хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд* Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, Нийгмийн даатгалын хууль, тогтоомж, ач холбогдлыг сурталчилан таниулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Мөн салбарын хэмжээнд нийгмийн даатгалын талаар 1,778 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 104,957 ажил олгогчид мэдээлэл хүргэн ажилласан. | 100 |
| 2.1.3 | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдлээс 15-аас доошгүй хувиар бууруулах; | - | Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн оны эхний үлдэгдлээс | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага оны эхнээс 19.3 хувиар нэмэгдсэн. | Ажил олгогчоос авах нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг оны эхний | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг бууруулах талаар дараах авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнд 2025 оны эхний үлдэгдэл 520.1 тэрбум төгрөгийн шимтгэлийн өрнөөс 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 262.9 тэрбум төгрөгийн авлагыг 50.5 хувиар бууруулсан боловч шимтгэлийн өр 663.0 тэрбум төгрөгт хүрч урсгал авлага буюу энэ онд шинээр үүссэн өр 405.8 тэрбум төгрөг байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 15-аас доошгүй бууруулсан авлагын хувиар | | үлдэгдлээс 15-аас доошгүй хувиар бууруулна. | ***Нэг. Шимтгэлийн авлагыг бууруулах чиглэлээр төлөвлөгөө гарган ажилласан талаар:***<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг "Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил" болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/47 дугаар тушаалаар жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг батлан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн шимтгэлийн өрийг бууруулах талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:<br>- Шимтгэлийн авлага барагдуулах арга замыг судлах, цаашид өрийг барагдуулах, холбогдох арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах чиглэлээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/197 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын менежментийн төлөвлөгөө батлах тухай" төлөвлөгөөг баталж аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн хэрэгжилтийг хангах ажиллаж байна.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу ажил олгогчийн шимтгэлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор өндөр өртэй аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, даатгуулагчдад учирч болох санхүүгийн болон нийгмийн эрсдлийн талаар ойлгуулах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудад чиглэл өгөх, мэргэжил арга зүйгээр хангах ажиллах үүрэг бүхий ажлын хэсэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталж ажлын хэсэг Орхон, Булган аймаг, Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газруудад ажиллаж хуримтлагдсан шимтгэлийн авлага үүсгэсэн 4,760 ажил олгогчийн 32.2 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/306 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг дуусталх хугацаанд Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын | |

газруудад шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлт, шимтгэлийн авлагыг барагдуулах талаар зохион байгуулан ажлын үр дүнг тооцох, дүгнэлт өгөх, шимтгэлийн хуримтлагдсан өрийг барагдуулах талаар ажил олгогчийн удирдлагатай уулзалт зохион байгуулж тэмдэглэл хөтлөх, улсын байцаагчийн албан шаардлага, харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох мэдэгдэл хүргүүлэх, данс хаах, шимтгэлийн өр барагдуулах гэрээ байгуулсан ажил олгогчдын эргэн төлөлтийг тулган шалгах ажлыг зохион байгуулав.

- Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2023 онд баталсан А/199 дүгээр тушаалын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, хуримтлагдсан 223.8 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.

/тэрбум төгрөгөөр/

| Авсан арга хэмжээ | Авсан арга хэмжээ | | НДШЛ барагдсан | |
|---|---|---|---|---|
| | АО тоо | Мөнгөн дүн | АО тоо | Мөнгөн дүн |
| Албан шаардлага хүргүүлсэн | 2,568 | 107.8 | 1,149 | 39.5 |
| Данс хаасан | 15,525 | 230.0 | 4,570 | 56.9 |
| Уулзалт хийсэн | 2,924 | 133.3 | 1,685 | 43.3 |
| Гэрээ байгуулсан | 2,103 | 201.6 | 1,215 | 79.8 |
| Шүүхэд шилжүүлсэн | 361 | 27.8 | 235 | 4.3 |
| **Дүн** | **23,481** | **700.5** | **8,134** | **223. 8** |

*/**Тайлбар**: авлага барагдуулах арга хэмжээ нь дээрх журмын дагуу шат дараалан авч байгаа тул авлагын мөнгөн дүн, ажил олгогчийн тоо нь давхардсан дүнгээр илэрхийлэгдсэн болно/.*

-Аймаг дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас шимтгэлийн орийн хэмжээ өндөр, насжилт ихтэй, анхаарал татах хэмжээнд хүрсэн 113.4 тэрбум төгрөгийн өртэй 147 ажил олгогчийн эрх бүхий албан тушаалтнуудтай утсаар холбогдон, шимтгэлийн өрийг барагдуулах чиглэлээр уулзалт зохион байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд 1.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн өр нийгмийн даатгалын санд төвлөрсөн байна.

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ***Хоёр. Шимтгэлийн өр барагдуулах чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар:***<br><br>- Шимтгэлийн өр үүсгэсэн ажил олгогчийн мэдээллийг Сангийн яам, Боловсролын яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Гадаадын иргэн, харьяатын газар зэрэг газруудад албан бичиг хүргүүлж ажиллав.<br><br>***Гурав. Хуулийн байгууллагуудтай хамтран ажилласан талаар:***<br><br>- Удирдлагын түвшинд уулзалт зохион байгуулж санал солилцох хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1252 дугаар албан бичгээр Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлснээр 2025 оны 06 дугаар сард холбогдох удирдлагууд уулзалт хийн, санал солилцож, шимтгэлийн өртэй 287 хариуцагчаар оролцох хуулийн этгээдийг эрэн сурвалжлах, оршин суугаа газрыг тогтоох ажиллагаагаар орон нутагт зохион байгуулахад харьяа Цагдаагийн газар, хэлтсүүдийг нийгмийн даатгалын газруудтай хамтран ажиллах тухай хүсэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/2647 дугаар албан бичгээр Эрүүгийн цагдаагийн албаны эрэн сурвалжлах хэлтэст хүргүүлэв.<br>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай нийгмийн даатгалын байгууллагад холбогдох гүйцэтгэх баримт бичгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эрчимжүүлэх талаар хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийг байгуулсан.<br>Уг ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/142-А/147 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулан шимтгэлийн болон сангийн өр төлбөр, барагдуулахад хамтран ажиллах 2025 оны төлөвлөгөөг батлан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтын ажиллагааны "Санамж бичиг"-ийн хүрээнд 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 149 аж ахуйн нэгж, байгууллагын 9.3 тэрбум төгрөгийн шимтгэл, 294.7 мянган төгрөгийн алдангийг барагдуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын шимтгэлийн өрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр НД-85/25 дугаартай "Ажил гүйцэтгэх гэрээ"-г 3 сарын хугацаатай байгуулан "Өмгөөллийн цэгц хүч" ХХН-тэй хамтран ажилласны үр дүнд тус хуулийн фирм нь Банкны төлбөр барагдуулах албаны шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран ажиллаж тодорхой хаяггүй, нэр дээр нь хөрөнгөгүй нь тогтоогдсон, түдгэлзүүлсэн болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны журмаар хийгдсэн нийт 11 хуулийн этгээдийн 289.4 мянган төгрөгийн хуримтлагдсан шимтгэлийн өрийг төлүүлэв.<br><br>***Дөрөв. Итгэлцлийн аян зохион байгуулсан ажлын талаар:***<br><br>- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих, хамтран ажиллах, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг бууруулах, ажил олгогч, даатгуулагчдыг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/244 дүгээр тушаалаар "Итгэлцлийн аян"-ыг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийг дуустал 1 сарын хугацаатай зохион байгуулсан. Аяны хугацаанд 105.8 тэрбум төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулснаас 5,808 аж ахуйн нэгж байгууллагын 63.8 тэрбум төгрөгийн хуримтлагдсан шимтгэлийн өр барагдсан.<br>- МҮЭХ, МҮХАҮТ, МАОЭНХ-нд гишүүн ажил олгогч нарт "Итгэлцлийн аян"-ны холбогдох мэдээллийг хүргэн, сурталчилан таниулах, түгээх ажлыг зохион байгуулж хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж ажиллав<br><br>***Тав. Сургалт сурталчилгаа хийсэн талаар:***<br><br>- Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн ажлын албатай хамтран Нийгмийн даатгалын байгууллагын удирдлага, байцаагч, ажилтнуудад авлигын удирдлага, барагдуулах арга зам, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх орон тооны бус Мэргэжлийн хороо, Олон нийтийн хяналтын зөвлөлийн гишүүд |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам" сэдэв сургалтад танхимаар 81, цахимаар 324 нийт 405 байцаагч ажилтнууд хамрагдав.<br>- Өмгөөллийн цэгц хүч хуулийн фирмтэй хамтран 10 дугаар сарын 14-ний өдөр "Шүүхээр шийдвэрлэж буй хэрэг, маргаан, хэрэгжилтийн өнөөгийн байдал", 10 дугаар сарын 22-ны өдөр "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нийтлэг журам", 10 дугаар сарын 31-ний өдөр "Төлбөр төлөгч хуулийн этгээд болон төлбөр төлөгч иргэнээс төлбөр гаргуулах ажиллагаа" сэдэвт 3 удаагийн сургалтыг зохион байгуулж, сургалтад давхардсан танхимаар 186, цахимаар 426 тоогоор төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын холбогдох чиг үүргийн албан хаагчид хамрагдав.<br>- Хуримтлагдсан шимтгэлийн өрийг барагдуулах зорилгоор 2025 оны 9 дүгээр сард зохион байгуулсан "Итгэлцлийн аян"-ы хүрээнд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд байгууллагын албан ёсны фэйсбүүк хуудас болон цахим орчинд богино хэмжээний бичлэг буюу рийл бэлтгэн байршуулах, орон нутгийн тв радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр удирдлагын манлайлал үзүүлэн ярилцлага өгөх зэргээр ажил олгогч, даатгуулагчдад зориулсан сургалт сурталчилгааны ажлыг 1,761 удаа зохион байгуулж нийт 4.9 мянган ажил олгогч болон 33.8 мянган даатгуулагчдад мэдээлэл хүргэв. Уг аяны талаар Нийгмийн даатгалын ерөнхий газраас нийгмийн даатгалын албан хаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажил олгогч, даатгуулагчдын эрх зүйн мэдлэг, мэдээллийг сайжруулах шимтгэл төлөлтийн идэвхийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "МҮОНТ", "Тэнгэр телевиз", "Time.mn", "SBN телевиз", "Ийгл телевиз" Өдрийн сонин зэрэг олон нийтийн мэдээллийн сувгаар видео ярилцлагад 5 удаа оролцов.<br>- Ажил олгогч болон даатгуулагчид шимтгэлээ хугацаанд нь төлөөгүйгээс үүсэх эрсдэл болон ажил олгогч, даатгуулагчийн хүлээх эрх, үүрэг, нийгмийн даатгалд даатгуулсны ач холбогдлыг сурталчилсан 5 мэдээ, 36 постер, 5 рийл, 2 анимэйшн контент, 2 видео ярилцлагыг бэлтгэн түгээв. | |
| 2.1.4 | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын | - | Нийгмийн даатгалын сангийн 2025 | Нийгмийн даатгалын санд 4,369,7 тэрбум | Нийгмийн даатгалын санд | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны Төсвийн тухай хуулиар орлогын хэмжээг 6,943.7 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 21 аймаг, 9 дүүргийн | 94.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | | оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна. | төгрөгийн орлого хуримтлуулав. | 5,474,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын газрын удирдлага, шимтгэлийн орлого хариуцсан ажилтнуудтай сар бүр цахимаар богон биечлэн уулзалт зохион байгуулан тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласны үр дүнд 12 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар 4,872.7 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулахаас 4,608.7 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулж, төлөвлөгөөг 94.6 хувиар биелүүлэв. Үүнд:<br>- Тэтгэврийн даатгалын санд 4,112.8 тэрбум төгрөгийн орлого оруулахаас 3,731.9 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 90,7 хувиар;<br>- Тэтгэмжийн даатгалын санд 370.6 сая.төгрөг оруулахаас 421.7 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 113.8 хувиар;<br>- ҮОМШӨ-ний даатгалын санд 251.8 тэрбум төгрөг оруулахаас 315.2 тэрбум төгрөг буюу төлөвлөгөөг 125.2 хувиар;<br>- Ажилгүйдлийн даатгалын санд 137,4 тэрбум төгрөг оруулахаас 139,8 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж төлөвлөгөөг 101.7 хувиар тус тус биелүүлсэн байна.<br><br>2025 оны 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэл 582.6 сая.төгрөг байна. | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:** "Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1 | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичиг, холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | Хугацаанд нь Гэр бүл, хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн 7 хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан | 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаарх зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 90 хувиар, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтийг 97.5 хувь, Засгийн газрын /2020-2024/ үйл ажиллагааны хөтөлбөрт | Хяналт-шинжилгээ, үнэлгээг хугацаанд нь хийж тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн байна. | 1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний 8 сарын байдлаар **92.0** хувь буюу "**Үр дүн гарсан**" гэж дүгнэж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн 02/2433 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>2. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 90.4 хувь буюу "Үр дүнтэй" гэж дүгнэж үнэлгээний тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тусгагдсан зорилт, арга хэмжээний 91.2 хувь, Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 100 хувиар үнэлж, үнэлгээний тайланг хугацаанд нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн. | | хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1611 дүгээр албан бичгээр, Монгол Улсын Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 2025 оны эхний хагас жилийн байдлаар 100 хувь буюу "Үр дүнтэй" гэж дүгнэж үнэлгээний тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1611 дүгээр албан бичгээр тус тус хүргүүлэв<br>3. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, ҮАБЗ-ийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь буюу "Бүрэн хэрэгжсэн" гэж үнэлж, үнэлгээний тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/337 дугаар албан бичгээр, 2025 оны эхний хагас жилийн байдлаар 96.5 хувиар үнэлж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1732 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв | |
| 3.2. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлсэн 1 хяналт-шинжилгээ, үнэлгээ | 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөны биелэлтийг 94.8 хувьтай үнэлсэн. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээ бүрэн биелж, албан хаагч нар авлигаас ангид байж авлигагүй салбар | 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хяналт-шинжилгээ, үнэлгээг хийнэ | Хугацаа болоогүй |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болсон байна. | | |
| 3.3. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх; | - | Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор хийсэн 4 шилэн дансны хөтлөлтийн тайлан | Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалтыг 98 хувьтай үнэлсэн. | - Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан мэдээллийг ил тод бүрэн байршуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | 1.Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхэд 2025 оны 1 болон 3 дугаар улирлын байдлаар, мөн 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэлх хугацааг хамруулан нийт 3 удаа хяналт-шинжилгээ хийж холбогдох баримт бичигтэй тулган шалгав.<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн нийт 166,791.5 тэрбум төгрөгийн 8,745 мэдээлэл байршуулахаас 8,202 мэдээллийг хугацаанд мэдээлж мэдээлэл байршуулалт 97 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 93 хувьтай байна.<br>Хяналт шинжилгээгээр нийт 14,410.0 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс:<br><br>- 20,039 шийдвэр гүйлгээний 6,819.8 тэрбум төгрөгийн 233 мэдээллийг мэдээлээгүй;<br>- 3,233 шийдвэр гүйлгээний 3,174.6 тэрбум төгрөгийн мэдээллийг илүү мэдээлсэн;<br>- 778,530 шийдвэр гүйлгээний 4,415.5 тэрбум төгрөгийн 310 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 2,012 шийдвэр гүйлгээний 472.8 тэрбум төгрөгийн мэдээлэл байна.<br><br>Хяналт шинжилгээг хийх явцад Нийт мэдээлээгүй буюу 2,012 шийдвэр гүйлгээний 472.8 тэрбум төгрөгийн мэдээллийг нөхөн мэдээлж зөрчлийг залруулж, мэдээлэл оруулах албан тушаалтан (Сангийн болон үйл ажиллагааны нягтлан бодогч), Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга нарыг мэргэжил арга зүйгээр хангаж дахин илэрсэн алдаа, зөрчлийг гаргахгүй ажиллахыг анхааруулж зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн.<br>Хяналт-шинжилгээгээр дээрх алдаа дутагдлаас гадна дараах нийтлэг зөрчлүүд давтагдан гарсаар байна. Үүнд: | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Оруулах мэдээлэл байхгүй" төлөвөөр мэдээлсэн;<br>- Хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг бичээгүй;<br>- Мэдээллийг маягтын дагуу бүрэн гүйцэд оруулаагүй;<br>- Хавсралтад мэдээллийг pdf, excel файлаар байршуулаагүй, хөтөлбөр зориулалтыг хоосон мэдээлсэн;<br>- Хөтөлбөр зориулалтыг дансны дугаар, эдийн засгийн ангиллын кодоор (эдийн засгийн ангиллын нэршлээр мэдээлээгүй) модоолж модоллийг хэрэглэгчдэд зориулаагүй байх;<br>- Баталгаажсан тайлан, мэдээг оруулаагүй;<br>- Батлагдсан төсвийг орлого, зарлагын нийт дүнгээр мэдээлсэн буюу орлого, зарлагын ангиллаар мэдээлээгүй, батлагдсан төсвийн нийт дүнг харах боломжгүйгээр мэдээлсэн;<br>- Сан болон үйл ажиллагааны мэдээллийг зоруулж мэдээлэх;<br>- Батлагдсан төсвийн нийт дүнг харах боломжгүйгээр мэдээлсэн;<br>Тухайн төсвийг бүрэн эхээр нь мэдээлэхгүйгээр зөрүүгээр мэдээлсэн;<br>- Өөрчлөлт ороогүй сарууддад батлагдсан төсвийг дахин мэдээлсэн;<br>- Мэдээлсэн мэдээллийн мөнгөн дүн зөрүүтэй;<br>- 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт хийх байгууллагатай хийсэн гэрээний дүнг мэдээлээгүй, буруу мэдээлэх;<br>- Худалдан авалт хийсэн сар бүрийн мөнгөн дүнг өссөн дүнгээр мэдээлээгүй, буруу мэдээлэх;<br>- Худалдан авалтад газрын төлбөр, буцалтгүй тусламж зэрэг мэдээлэх ёсгүй мэдээллийг илүү мэдээлсэн;<br>- Мөнгө, хөрөнгө захиран зарцуулах шийдвэрийн огноог засаж оруулах (мэдээлэхдээ 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэр мэтээр мэдээлсэн байхад PDF файлыг нээхэд 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр гаргасан тушаал байх);<br>- Бонд цаст холбогдох газруудтай хийсэн гэрээг мэдээлээгүй;<br>- Хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоогүй буюу мэдээлэх ёсгүй тушаал шийдвэрийг мэдээлсэн (ажилд томилсон, чөлөөлсөн, цалин шинэчлэн тогтоосон, цалинтай чөлөө олгосон тухай, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох, ээлжийн амралт олгох тухай, Ёс зүйн хороо, эцэг эхийн зөвлөл, тооллогын комисс байгуулах тухай гэх мэт); | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хавсралт цэсэнд сарын мэдээг мэдээлээгүй;<br>- Бонд төрөлд мэдээлэх тушаал, шийдвэрийг "Бусад төрөл" цэсийн "Хавсралт файл" төрөлд мэдээлсэн гэх мэт<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг удирдлагад танилцуулан Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/912, 02/2768, 02/3152 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, 02/1090, 02/2819 дугаар албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тус тус хүргүүлсэн.<br>2.Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 8.1-т заасны дагуу Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2024 оны 4 дүгээр улирал, 2025 оны 1,2,3 дугаар улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлтийн тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн хяналт тавьж нэгтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/81, 02/2670 дугаар албан бичгээр дугаар албан бичгээр тус тус Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн<br>3. Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын 2025 оны 07/676 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдолмор, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай" 03 дугаар албан даалгаврыг ирүүлсэн.<br>Дээрх албан даалгаварт тусгагдсан үүрэг даалгаврыг заавал нэг бүрчлэн биелүүлж ажиллахыг Дотоод аудит, мониторингийн газрын 2025 оны "Албан даалгавар хүргүүлэх тухай" 02/529 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасгийн дарга нарт үүрэг болгосон.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай" 03 дугаар албан даалгаврын 1 дүгээр улирлын биелэлтийг цахимаар, 2, 3 дугаар улирлын биелэлтийг гаргаж, Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны 02/1719, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 02/2670 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлсэн.<br><br>Шилэн дансны тухай хууль холбогдох журмын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Шилэн дансны зөвлөмж хүргүүлэх тухай" 02/262 дугаар албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв. | |
| 3.4. | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх; | - | 2025 оны 07 дугаар сарын 10, 12 дугаар сарын 25-ний өдрийн дотор хийсэн 2 хяналт-шинжилгээ, үнэлгээ | Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны эхний 11 сарын байдлаар 79.3 хувийн гүйцэтгэлтэй байна. | - Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан, мэдээллийг бүрэн байршуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх мэдээллүүдийг Шил ажиллагаа (www.shilen.gov.mn), Нийгмийн даатгалын ерөнхий газрын (www.ndaatgal.mn) цахим хуудаст, Нийгмийн даатгалын ерөнхий газрын сошиал хаяг буюу фэйсбүүк хаягт, мэдээллийн самбарт мэдээлж олон нийтэд хүргэж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудас (ndaatgal.mn)-т нээлттэй мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, хуулийн хугацаанд бодитой байршуулж байгаа эсэх (нээлттэй мэдээллийн ил тод байдал)-д тогтмол хяналт тавьж, улирал бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж байна.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал 94.3 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Мөн мэдээлэл байршуулалтыг Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-д заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг үнэлэх 4 шалгуур үзүүлэлт (мэдээллийн хүртээмжтэй байдал, хугацаандаа нийтлэгдсэн байдал, мэдээллийн бүрэн бүтэн байдал, эх сурвалжийн тодорхой байдал)-ээр үнэлэхэд 92.3 хувьтай байна.<br>Мөн мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2025 оны "Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллах тухай" 02/259 дугаар Аймаг, | 93.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлсэн. | |
| 3.5. | "Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд аудит хийх; | - | Төлөвлөгөөт хугацаанд хийсэн 1 удаагийн аудит, хяналт тавьж, үр дүнг тооцсон ажлын тайлан /Цаашид хагас, бүтэн жилээр хяналт тавих/ | - | Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд тогтмол хяналт тавьж, үр дүнг тооцсон байна. Аудитыг хийж, аудитын тайланг бэлтгэж, санал, зөвлөмж боловсруулж удирдлагад танилцуулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтэд хийх" дотоод аудитын ажлын 02/01 дугаар удирдамжийг баталж<br>Капитал банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын санд хүлээн авсан хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, худалдан борлуулалт, түрээсийн гэрээний биелэлтийг 2021 оноос 2024 оныг дуустал хугацааг хамруулан шалгав.<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, шийдвэрийг үндэслэн Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас Нийгмийн даатгалын сангийн нэхэмжилсэн өр төлбөрт 25.0 тэрбум төгрөгийн үнэ бүхий 78 хөрөнгийг 2021, 2022 онуудад хүлээн авсан бөгөөд өр төлбөрт тооцон хүлээн авсан хөрөнгийн үлдэгдэл 13.5 тэрбум төгрөгийн 17 ширхэг хөрөнгө байна.<br>2024 оны жилийн эцсийн байдлаар тус банкнаас нэхэмжилсэн өр төлбөрт хүлээн авсан үл хөдлөх хөрөнгөнөөс 8 ширхэг үл хөдлөх хөрөнгийг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа 30 иргэн, аж ахуй нэгж байгууллагад түрээслүүлж байна.<br>Аудитыг дараах асуудлын хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын санд хөрөнгө хүлээн авсан шийдвэр, акт;<br>- Худалдан борлуулсан хөрөнгийн бүртгэл, гэрээ, гэрээний биелэлт;<br>- Түрээсийн гэрээ, гэрээний биелэлт;<br>- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдал;<br>- Өмнөх аудит болон санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчил, түүний барагдуулалт, хэрэгжилт;<br>Аудитын дүн мэдээг нэгтгэн тайланг удирдлагад танилцуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/3222 албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. | 100 |
| ***Зорилт 3.1:** "Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах" **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1 | Нийгмийн даатгалын тухай | | -Улсын | Нийгмийн | Дундговь, | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу нэр бүхий аймгуудын нийгмийн даатгалын газарт шалгаж, өмнөх шалгалтын үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх; | 56,5 сая төг | байцаагчийн акт тогтоож, төлбөрийн 70-аас дээш хувь<br>-Хийсэн хяналт шалгалтын тоо | даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг Ховд, Хэнтий, Хөвсгөл, Баян-Өлгий, Дорнод, Дундговь, Говьсүмбэр аймгуудын нийгмийн датгалын хэлтэст шалгалт хийж илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоож, 68,9 хувийг барагдуулж ажилласан. | Дархан-Уул, Орхон, Баянхонгор аймгуудын, Багануур, Налайх, Багахангай аймгуудын Нийгмийн даатгалын газарт шалгалт хийж, илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоож, төлбөрийн **70-аас** дээш хувь барагдуулж ажиллана. | баталсан удирдамжийн дагуу Багахангай, Чингэлтэй дүүрэг, Дундговь, Завхан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газар, Мэдээллийн технологийн төвд Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилт, өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллав.<br>Дээрх 2 дүүрэг, 3 аймгийн Нийгмийн даатгалын газарт хийсэн шалгалтаар нийт 676 хүнтэй холбоотой 3,088.4 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж улсын ахлах байцаагчийн 18 акт тогтоож шийдвэрлэв. Үүнд:<br>- Тэтгэврийн олголттой холбоотой 74 хүнд илүү олгосон тэтгэврийн зөрүү 203.2 сая төгрөг, дутуу олгосон 201 хүнд 61.5 сая төгрөгийн тэтгэвэр, 14 хүнд 8.3 сая төгрөгийн тэтгэмж, төлбөрийг илүү авсан иргэнээр нөхөн төлүүлэх, дутуу олгосон тэтгэврийг нөхөн олгуулахаар улсын байцаагчийн акт;<br>- Тэтгэврийн тогтоолттой холбоотой нэр бүхий 119 хүний тэтгэврийн дутуу бүрдүүлсэн баримтыг нөхөн бүрдүүлэхээр;<br>- Хуурамч баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 123 хүний тэтгэврийн олголтыг түр түдгэлзүүлэн зогсоохоор 2,775.2 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг тус тус тогтоосон.<br>- Чингэлтэй дүүргэт нэр бүхий 40 албан хаагчид 44.1 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, илүү цагийн хөлс, үр дүнгийн урамшуулал илүү тооцож олгосон зөрчилд Санхүүгийн хяналтын улсын байцаагчийн акт тогтоосон;<br>- Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2024/ШЦТ/16 дугаар шийтгэх тогтоолын дагуу Б.Эрдэнэхишиг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр анхан шатны шүүхийн шийдвэрээр 68 удаагийн үйлдлээр хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсэн болон амаржсан, ажилгүйдлийн тэтгэмж 193.5 сая төгрөг, дээрх дүнд банкны хүү 9.2 сая төгрөгийг тооцож, бүгд 202.8 сая төгрөгийг төлүүлэхээр шийдвэр гарсан байна.<br><br>Дээрх шийдвэрийг санд авлагаар бүртгэхдээ тэтгэмжийн даатгалын санд нэр бүхий 13 даатгуулагчийн 39.8 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын санд нэр бүхий 12 даатгуулагчийн 22.9 сая | |

төгрөг, бүгд нэр бүхий 25 даатгуулагчийн 62.7 төгрөгийн авлагыг санд бүртгэсэн, 2024 онд Д. Эрдэнэхишиг нэрээр 5.0 сая төгрөг бүртгэсэн боловч 125.7 төгрөгийн авлага болон 9.2 төгрөгийн сангийн хүүгийн авлагыг холбогдох санд дутуу бүртгэснийг санд бүртгүүлэн ажилласан.

2. 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Сүхбаатар дүүргийн болон бусад Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэл, Мэдээллийн технологийн төвийг шалгах", 05 дугаар удирдамж, мөн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн "Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, дүүргийн нийгмийн даатгалын газарт хийх төлөвлөгөөт бус хяналт шалгалт" 09 дүгээр удирдамжийн дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлийг шалгаж дүгнэлт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.

Төвийн 6 дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн нийт 31,194 аж ахуйн нэгж байгууллагын нөхөн тайлан өгсөн, цалин зассан, хүн нэмсэн, хүн хассан, хүн устгасан 17,219 шимтгэл төлөлтийн тайлан хүлээн авч баталгаажуулсан байдлыг шалгав.

Шалгалтаар Сүхбаатар дүүргийн болон бусад Нийгмийн даатгалын газарт нөхөн тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлийг шалгаж ажилтанд олгоогүй байх магадлалтай цалин хөлсийг нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд тусган үндэслэлгүйгээр, хуурамчаар тайлагнасан 3 аймаг, 7 дүүргийн нийгмийн даатгалын газарт 58 ажил олгогчтой холбоотой 851 хүний 34.2 тэр бум төгрөгийн цалин хөлсийг мэдээллийн сан бүртгэсэн зөрчлийг илрүүлэв.

Зөрчилтэй байх магадлалтай 32 ажил олгогчийн жагсаалтыг Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт, Тагнуулын ерөнхий газарт, мөн 26 ажил олгогчийн жагсаалтыг Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт тус тус мэдээллийг хүргүүлсэн.

Дээрх шалгалтын дүн мэдээ, тайланг Газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулсан.

***Тайлбар***: Баянхонгор, Дархан-У[illegible]л аймгийн Нийгмийн

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалын газарт хяналт шалгалт хийх албан томилолтын төсвийн зардал байхгүй тул хойшлуулсан. | |
| 3.1.2 | Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зарим аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд шалгаж, үр дүнг тооцож ажиллах; | - | -Шалгасан ажил олгогчийн тоо, -Илэрсэн зөрчил, төлбөрийн барагдуулалтын хувь, -Нэгтгэж танилцуулсан танилцуулгын тоо, үр дүн | Нэр бүхий 95 аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж 12,7 тэрбум төгрөгийн цалингийн сангаас 2985,7 сая төгрөгийн шимтгэл дутуу тооцсон зөрчил илрүүлэн, 50,0 саяас дээш төгрөгийн зөрчилтэй нэр бүхий 9 байгууллагад Эрүүгийн тухай хуулиар, бусад 10 байгууллагад Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу хариуцлага тооцсон. | Хувийн хэвшлийн Их, дээд болон дунд сургуулиуд, эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж илэрсэн зөрчлийг арилгаж, хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллана. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Бодлогын хэрэгжилт төлөвлөлтийн газрын даргын 2025 оны "Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж"-ийн дагуу Их, дээд сургууль болон коллеж, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж ажиллав.<br>Шалгалтад хувийн хэвшлийн 180 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдаж зөрчилгүй 97 ажил олгогчид зөвлөмж өгч 83 аж ахуйн нэгж, байгууллагад 2,950.1 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 750.9 сая төгрөгийн улсын байцаагчийн акт, 367.6 сая төгрөгийн алданги, бүгд 1,118.5 сая төгрөгийн акт, алданги тогтоон арга хэмжээ авч 100 хувь барагдуулж ажиллав. | 100 |
| 3.1.3 | Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад ажиллах явцад Нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, 120 буюу түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан авлагыг барагдуулах; | - | -Шинээр хамруулсан ажил олгогч, даатгуулагчийн тоо,<br>-Барагдуулсан авлагын хувь | Төлөвлөгөөт шалгалтын ажлын хүрээнд Дундговь, Дархан-Уул, Орхон, Баянхонгор, Багануур, Налайх, Багахангай аймгуудын нийгмийн даатгалын хэлтэст хийгдсэн шалгалтаар 120 буюу түүнээс дээш хоногийн насжилттай 3007,2 | Төлөвлөгөөт хяналт шалгалтйн хугацаанд нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлж, өр авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж, авлагыг бууруулсан байна | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Багахангай, Чингэлтэй дүүрэг, Дундговь, Завхан, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх явцад Нийгмийн даатгалын хуримтлагдсан өр барагдуулах ажлын хүрээнд 1 байгууллагад албан шаардлага өгч, 116 байгууллагатай өр авлага барагдуулах гэрээ байгуулсан, 172 байгууллагын дансыг хааж, 126 ажил олгогчийн өрийг бүрэн болон хэсэгчлэн барагдуулж нийт 2.8 тэрбум төгрөгийг шимтгэлийн өрийг төлүүлж ажиллав. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сая төгрөгийн хуримтлагдсан авлагыг барагдуулж ажилласан. | | | |
| 3.1.4 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчил, түүний барагдуулалтын мэдээ тайланг сан тус бүрээр, (Нийгмийн даатгалын ерөнхий газар, хөндлөнгийн хяналт шалгалт, дотоод хяналт шалгалт) нэгтгэн гаргаж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайлан, биелэлтэд хяналт тавих; | - | -Хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, -Нэгтгэсэн тайлангийн тоо, үр дүн | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажилласан. | Хяналт шалгалтаар илэрсэн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж удирдлагыг мэдээллээр хангасан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2010 оны 38 дугаар тушаалаар баталсан "Дотоодын хяналт шалгалтын тайлан мэдээ гаргах аргачлал заавар"-ын дагуу 21 аймаг, 9 дүүргийн нийгмийн даатгалын газрын 2024 онд хийсэн дотоодын хяналт, шалгалтын ажлын тайланг нэгтгэж Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэв.<br>Дотоодын хяналт шалгалтаар илсэрсэн зөрчил, төлбөрийн барагдуулалтыг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нэгтгэхэд оны эхэнд 2,788.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант хугацаанд дотоодын хяналт, шалгалтаар нийт 3,557.1 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн улсын байцаагчийн акт тогтоосон.<br>Тайлант хугацаанд актаар тогтоосон болон урьд оны барагдаагүй үлдэгдэл 6,345.5 сая төгрөгөөс 47.5 буюу 3,013.7 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж 3,331.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. | 90 |
| 3.1.5 | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | - | -Шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь,<br>-Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт<br>-Хууль сахин мөрдөлтийн түвшин,<br>-Хүргүүлсэн мэдээ тайлангийн тоо | 2024 онд 307 объектод хяналт шалгалт хийж, 969 зөрчил илрүүлж, 133 албан шаардлага хүргүүлж ажилласан. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мэдээ тайланг нэгтгэн удирдлагад танилцуулан холбогдох газарт хүргүүлсэн байна. | Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө"-ний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/78 дугаар тушаалаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр цахилгаан, эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх, дамжуулах болон боловсруулах үйлдвэрлэл зэрэг салбаруудын 351 объектод хяналт шалгалт хийхээс 273 аж ахуй нэгж байгууллага буюу 78.8 хувь хамрагдсан.<br><br>Шалгалтаар нийт 1,456 зөрчил илрүүлснээс:<br><br>- 636 заалт бүхий улсын байцаагчийн 146 хугацаатай албан шаардлагыг хүргүүлж, 544 заалт буюу 85.5 хувийн биелэлттэй<br>- 114 даатгуулагчтай холбоотой 63.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, алданги нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн 91 акт тогтоож, нийт төлбөр зөрчлийн 67.5 хувь буюу 42.9 сая төгрөгийг нийгмийн даатгалын санд нөхөн төлүүлсэн;<br>- Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 19 байгууллагад 23.0 сая төгрөгийн торгуулийн арга | 84.3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээ авч 100 хувь барагдуулж ажиллав.<br><br>Шалгалтын дүн мэдээ, танилцуулгыг Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна.<br>***Тайлбар:*** 78 аж ахуй нэгж, байгууллага нь үйл ажиллагаа зогссон, хариуцсан байцаагч байхгүй зэрэг шалтгаанаар шалгалтад хамрагдаагүй. | |
| 3.1.6 | Ажилгүйдлийн даатгалын сан 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх; | | -Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь<br>-Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь,<br>-Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт | - | Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 70 хүртэл хувийг барагдуулж ажиллана. | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны "Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 03-07/06 дугаартай удирдамжийн хүрээнд 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын гүйцэтгэлд Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль (хуучин), Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 09 дүгээр тогтоолоор баталсан "Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж олгох журам" (хуучин), Засгийн газрын 2023 оны 438 дугаар тогтоолоор батлагдсан "Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэмж олгох журам"-ын хэрэгжилтийг 20 аймаг, 8 дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 12-ны хүртэлх хугацаанд шалгалтыг хийж гүйцэтгэв.<br>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон 591 даатгуулагчийн 550.6 сая төгрөгийн тэтгэмжийг санд буцаан төвлөрүүлэх тухай улсын байцаагчийн 27 акт тогтоож, дутуу олгосон 262 даатгуулагчийн 141.9 сая төгрөгийг даатгуулагчдад сангаас нөхөн олгох тухай улсын байцаагчийн 18 акт тогтоож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай давхардсан тоогоор 55 заалттай улсын байцаагчийн 18 албан шаардлагыг 13 аймаг, 5 дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн.<br>Шалгалтаар илэрсэн нийт 692.5 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс барагдуулалт 301.1 сая төгрөг буюу 43.5 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Хяналт шалгалтыг удирдамжид заасан хугацаанд нь хийж гүйцэтгэн, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1152 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт хүргүүлсэн.<br>***Тайлбар:*** Булган аймгийн нийгмийн даатгалын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газарт нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчгүй, Багахангай дүүрэгт дотоодын төлөвлөгөөт хяналт шалгалтын хугацаа давхацсан тул хяналт шалгалт хийгдээгүй | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| *Зорилт 4: "Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон дүүргүүдийн Нийгмийн даатгалын газрын хэмжээнд гарч буй сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд захиалга хүргүүлэх, шийдвэрлүүлэх; | | Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлсэн сул орон тооны захиалгын тоо | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлд 2024 онд нийт 8 удаагийн албан бичгээр нийгмийн даатгалын ерөнхий газрын болон дүүргийн Нийгмийн даатгалын газрын удирдах болон гүйцэтгэх 88 сул орон тооны захилгыг хүргүүлээд байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын болон дүүргийн Нийгмийн даатгалын газрын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлсэн байна. | 1.Төрийн албаны салбар зөвлөлийн тусгай шалгалтыг 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан бөгөөд шалгалтад төрийн албаны удирдах 11 албан тушаалд 19 иргэн, төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх 23 албан тушаалд 36 иргэн бүртгүүлснээс 32 иргэд тэнцэж, албан тушаалд нэр дэвшүүлж, томилогдох эрх авсан.<br>2.Нийгмийн даатгалын байгууллагын сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Сонгон шалгаруулалт явуулах захиалга хүргүүлэх тухай" 01/157 дугаар албан бичгээр 35, сул орон тоо, 01/1294 дугээр албан бичгээр 3 сул орон тоог хүргүүлсэн боловч төрийн байгууллагуудын орон тоог 9 хувиар хассантай холбогдуулан тусгай шалгалт зохион байгуулагдаагүй.<br>3. Мөн Нийгмийн даатгалын байгууллагын сул орон тооны захиалгыг 2025 оны 10 сард Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/2733 дугаар албан бичгээр 36 орон тоо, 01/2966 дугаар албан бичгээр 2 сул орон тооны захилгыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлд тус тус хүргүүлж төрийн албаны тусгай шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж 36 сул орон тоонд 75 иргэн бүртгүүлсэн. | 100 |
| 4.2. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих; | | -Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор 7 ажил, үйлчилгээнд 223,3 сая төгрөгийн тусламж олгосон байна. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж, бодит тусламжийг | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/346 дугаар тушаалаар "Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг баталсан.<br>Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад 6 ажил, үйлчилгээнд 3,560.9 сая төгрөгийн дэмжлэг, тусламж олгов. Үүнд:<br>- Цалин, нэмэгдэл хөлс-3,203.1 сая төгрөг;<br>- Үр дүн урамшуулалд 144.6 сая төгрөг; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үзүүлсэн байна. | - Олон улсын эмэгтэйчүүдийн баярт зориулж 5.8 сая төгрөг;<br>- Томилолтын зардалд 152.9 сая төгрөг;<br>- Буцалтгүй тусламжид 31.6 сая төгрөг<br>- Ахмад настнуудад 22.8 сая төгрөгийг тус тус олгов. | |
| 4.3. | "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг шинэчлэн батлаж, тусламж дэмжлэг олгох; | | -Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар 1 журам | Ахмад настны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/09 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын дагуу нийт ахмад настны баталгаар хангахад 30.5 сая төгрөгийг зарцуулсан байна. | "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг шинэчлэн батлуулж, ахмад настнуудын нийгмийн баталгаар хангаж, холбогдох хууль журмын дагуу дэмжлэг тусламжийг олгосон байна. | 1 Нийгмийн даатгалын салбарын ахмадын Төрийн бус байгууллага байгуулах, нэгдсэн уулзалт зохион байгуулахтай холбоотой салбарын ахмадын нэгдсэн судалгааг авч ахмадын хороонд хүргүүлсэн.<br>2025 оны эхний 11 сарын байдлаар нийгмийн даатгалын байгууллагад 694 ахмад настан бүртгэлтэй байна.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/34 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг шинэчлэн батлав.<br>Тус журамд заасны дагуу нийт ахмад настны нийгмийн баталгаар хангахад зориулж 22.8 сая төгрөгийг олгов.Үүнд:<br>- Буцалтгүй тусламжид 4 ахмад настанд 3.0 сая төгрөг;<br>- Монгол үндэсний баяр 2025 оны цагаан сарын баярын өдрийг тохиолдуулан 81 ахмад настанд 10.9 сая төгрөг;<br>- "Олон улсын ахмадын өдөр"-ийг тохиолдуулан 82 ахмад настанд 8.9 сая төгрөгийг олгосон байна. | 100 |
| 4.4 | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах Жендэрийн дэд зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, холбогдох газарт судалгаа мэдээг гарган ажиллах; | | -Батлагдсан төлөвлөгөө 1;<br>-Судалгаа 1; | - | Төлөвлөгөө батлуулж судалгаа, мэдээг гаргаж холбогдох газруудад хүргүүлсэн байна. | 1.Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендерийн талаар баримтлах бодлогыг (2018-2024) хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн 2024 оны жилийн эцсийн биелэлтийг гаргаж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Жендерийн салбар зөвлөлд цахимаар хүргүүлэв.<br>2.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Жендерийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай" А/284 дүгээр тушаалаар "Жендерийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, Жендерийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийг, Жендерийн салбар зөвлөлийн дарга "Нийгмийн даатгалын салбарт жендерийн тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх жендэрийн салбар зөвлөлийн 2025-2026 оны төлөвлөгөө"-г тус тус батлав. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Батлагдсан төлөвлөгөөний дагуу Жендэрийн Үндэсний Хороотой хамтран сургалт зохион байгуулах талаар албан бичиг хүргүүлэв.<br>3.2025 оны 11 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд НҮБ-ын Хүүхдийн сан, Австралийн Засгийн газрын (DFAT) дэмжлэгтэйгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сан, Австралийн Засгийн газрын хамтран зохион байгуулсан "Жендэрт суурилсан нийгмийн хамгаалал" сэдэвт сургалтад жендерийн хорооны 4 гишүүн сургалтад хамрагдсан. | |
| 4.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах, ХАСУМ, мэдэгдэл тайлбарыг гаргуулах, салбарын албан хаагчдын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэх; | - | -ХАСХОМ-1, ХАСХОМ-2, ХАСХОМ-3 тайланг 2025 оны 03 дугаар сарын 15-ны дотор АТГ-т хүргүүлэх,<br>-Шинэчлэн гаргах ажлыг 2025 оны 02 сарын 15-ны дотор мэдүүлэх,<br>-Шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргуулан хүргүүлсэн байна. | -2023 оны ХАСХОМ гаргавал зохих этгээдийн Нэрсийн жагсаалтыг АТГ-т хүргүүлсэн. Салбарын хэмжээнд ХАСХОМ мэдүүлэх 100 хувь буюу 720 албан хаагчийн ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна.<br>-Тайлант хугацаад шинээр томилогдохоор нэр дэвшсэн 44 хүний ХАСУМ-ийг АТГ-т хүргүүлэн хянуулж, дүгнэлт гаргуулсан. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан тушаалтнуудын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах, ХАСУМ, мэдэгдэл тайлбарыг гаргуулах, салбарын албан хаагчдын мэдүүлэг бүрдүүлэлтийн ажлын тайлан мэдээг Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэх ажлыг шалгуур үзүүлэлтийн дагуу зохион | 1.Салбарын хэмжээнд 2024 оны хувийн ашиг сонирхол хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ) гаргах 692 албан хаагчийн нэрсийн жагсаалтыг 2025 оны 01 дүгээр сард нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/79 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, ХАСХОМ-ээ хуулиар тогтоосон хугацаанд нийт албан хаагчид 100 хувь гаргаж мэдүүлгийг хүлээн авах, хянах, хадгалах ажлыг зохион байгуулав.<br>2. 2025 оны эхний 11 сарын байдлаар 44 албан хаагч Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянуулж дүгнэлт гаргуулав.<br>3. Шинээр томилогдсон 25 албан хаагчийн Хувийн ашиг сонирхол, хөрөнгө, орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хуулийн хугацаанд гаргуулан ажиллав. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан байна. | | |
| 4.6. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд гаргасан "Нийгмийн даатгалын байгууллагад тулгамдаж буй асуудал, үүсч болох эрсдэлийн судалгаа"-нд үндэслэн эрсдэлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах; | - | -"Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад тулгамдаж буй асуудал", "Байгууллагын үйл ажиллагаар хэвийн явуулахад үүсэж болох эрсдэл"-ээр авсан судалгааны асуудал, эрсдэл бүрд хариу арга хэмжээг авах, шийдлийг газруудад хууль тогтоомжид нийцүүлэн хүргүүлсэн байна.<br>-"Шүүхийн судалгаа"-гаар авсан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх зүйн туслалцаа, зөвлөмж өгөх, шаардлагатай тохиолдолд хамран хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна. | Нийгмийн даатгалын салбарт байгаа "Нийгмийн даатгалын байгууллагад тулгамдаж буй асуудал, үүсэж болох эрсдэлийн судалгаа"-г 30 нэгжээс авч чиглэл бүрээр нэгтгэсэн. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд нэгтгэн гаргасан "Нийгмийн даатгалын байгууллагад тулгамдаж буй асуудал, үүсч болох эрсдэлийн судалгаа"-нд үндэслэн эрсдэлийг арилгах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авсан байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2024 онд нэгтгэн гаргасан Нийгмийн даатгалын салбарт байгаа "Нийгмийн даатгалын байгууллагад тулгамдаж буй асуудал, үүсэж болох эрсдэлийн судалгаа"-нд үндэслэн дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлөн оролцсон хэрэг маргааны судалгаар эрүү, иргэн, захиргааны хэрэг бүрээр ангилан шүүхээс гарсан шийдвэрийн талаар цахим архив үүсгэн бусад газар нэгжийг мэдээллээр хангаснаар Нийгмийн даатгалын байгууллагыг төлөөлөн шүүх хуралд оролцох, байгууллагын үйл ажиллагаа хэвийн явуулахад үүсэж болох эрсдэлийг бусад нэгжийн оролцсон шүүх хурал түүний шийдвэрээс харах, урьдчилан сэргийлэх боломж бүрдүүлсэн.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газраас хууль шүүхийн байгууллагад хянагдаж байгаа хэрэг, маргаан, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагыг төлөөлж, хууль ёсны эрх ашгийг хамгаалан оролцсон хэрэг маргааны шүүхийн шийдвэрийг тухай бүр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хуулийн хэлтэст, жил бүр Нийгмийн даатгалын газрын архивт хадгаламжийн нэгж үүсгэн хадгалж байх тухай албан бичгийг Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн. Үүний дагуу аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газраас тайлант хугацаанд нийт 76 шүүхийн шийдвэр ирүүлснийг цахим архив бүхий шийдвэрийн сан үүсгэж, шүүхийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж нийгмийн даатгалын газрын шинээр гаргаж буй нэхэмжлэл, хариу тайлбар, давж заалдах болон хяналтын гомдолд бусад шүүхийн шийдвэрээс эш татан тухайн газрын Хуулийн асуудал харицсан мэргэжилтэнд зөвлөгөө, эрх зүйн туслалцаа үзүүлэх замаар үүсч болох урьдчилан сэргийлэх арга хэмжээ авав.<br>- Эрсдэлийн судалгаанд үндэслэн Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд үүсч буй хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй, хүндрэлтэй эрх зүйн зохицуулалтыг нэгтгэн эрсдэлийг арилгах арга хэмжээ зохион байгуулах үүднээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод нэгжийн дарга нарт 2025 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Дотоод бичиг"-ээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэх боломжтой эсэх судлуулах санал хүргүүлсэн.<br>- Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхэд Нийгмийн даатгалын нэгжид тулгараад буй хууль хэрэглээ, хуулийн зөрчилтэй заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" албан бичгээр Нийгмийн даатгалын хууль болон бусад хуулийг зөв хэрэглэх талаар зөвлөмж хүргүүлж салбар нэгжид гаргах хууль хэрэглээний алдаа гаргах эрсдэлийг дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллав. | |
| 4.7. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан журам, дүрэм, зааврыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, хүчингүй болсон актыг хасуулах, дотоодод бүртгэл үүсгэх ажлыг зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан журам, дүрэм, зааврыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх,<br>-Захиргааны акт хүчингүй болсон тохиолдолд захиргааны актыг хасуулах,<br>-Дотоодод бүртгэл үүсгэх шинээр нэмэгдсэн, хасагдсан захиргааны актыг бүртгэх ажлыг зохион байгуулсан байна. | Хууль зүйн яамны нэгдсэн бүртгэл буюу хэм хэмжээний актын нэгдсэн бүтгэлд 2024 онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2 журмыг баталж шинээр бүртгүүлж нийт 7 хэм хэмжээний актыг бүртгүүлсэн. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан журам, дүрэм, зааврыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, хүчингүй болсон актыг хасуулах, дотоодод бүртгэл үүсгэх ажлыг зохион байгуулсан байна. | 1. Хууль зүй дотоод хэргийн яамнаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 5 хэм хэмжээний актыг "Эрх зүй мэдээллийн нэгдсэн систем"-д бүртгэсэн байгаа тухай албан бичгийг ирүүлсэн бөгөөд эдгээр актаас хүчингүй болсон шинээр гаргасан акт байгаа эсэх, хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх талаар албан бичиг ирүүлсний дагуу актын бүртгэлийн тулган шалгаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй, хүчингүй болгоогүй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан захиргааны хэм хэмжээний 2 актыг хүчингүй болгуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн "Хариу хүргүүлэх тухай" 01/161 дүгээр албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.<br>2.Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 5 шийдвэр нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа шийдвэрүүд бөгөөд биелэлтийн хувь "Бүрэн хангалттай" буюу 100 хувийн хэрэгжилттэй гэж үнэлж хяналт-шинжилгээний дүн, танилцуулга, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний саналыг Хууль зүй дотоод хэргийн яаманд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1263 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/267 дугаар тушаалаар баталсан "Тэтгэмж бодох заавар"-ыг Хууль зүйн, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн 7399 дугаарт бүртгүүлэн нийтээр дагаж мөрдөх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Ингэснээр Эрх зүйн мэдээллийн нэгдсэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санд нийт 6 хэм хэмжээний актыг бүртгүүлсэн байна. | |
| 4.8 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөг тус тус боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах; | - | -НДЕГ-ын даргын баталсан "Шударга байдлын үнэлгээг сайжруулах төлөвлөгөө" 1<br>-Тайланг хугацаанд нь хүргүүлж, үнэлгээний хувь нэмэгдсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн.<br>Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 74.5 хувиар үнэлсэн байна. | -Шударга байдлын үнэлгээг сайжруулах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.<br>-<br>Төлөвлөгөөний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байна. | 1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Шударга байдлын үнэлгээ 2023 онд 69.5 хувь, 2024 онд 74.5 хувиар үнэлэгдэж 5 хувиар дээшлүүлсэн тул 2025 онд Шударга байдлын үнэлгээг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр батлаагүй болно.<br>Харин Нийгмийн даатгалын байгууллагын Шударга байдлын үнэлгээг сайжруулах үүднээс Нийгмийн даатгалын байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөнд Шударга байдлын үнэлгээг сайжруулах **1** арга хэмжээ тусган Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар батлав.<br>2. **Нийгмийн даатгалын ерөнхий газрын** 2025 оны Шударга байдлын үнэлгээний судалгаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын 30 албан хаагчийг түүврийн аргаар сонгон хамруулав. "Шинжээч"-д Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 10 албан хаагч, хамран ажилладаг нэр бүхий 5 банкны албан хаагч, Эрүүл мэндийн магадлалын төв болон салбар зөвлөлийн шинжээч 5 эмч нийт 20 хүнийг хамруулахаар нэрсийг эрх бүхий судалгааны байгууллагад хүргүүлсэн.<br>3. "Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө"-ний биелэлтийг эхний хагас жилээр гаргаж <https://khutulbur.iaac.mn/> сайтад байршуулав.<br>Авлигатай тэмцэх газар биелэлтийн үнэлгээг гаргаагүй байгаа болно. | 90 |
| 4.9 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; | - | -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;<br>-Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, | 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороог байгуулсан 2024 оны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлсэн, салбар байгууллагын Ёс зүйн дэд хорооны судалгааг гарган нэгтгэсэн. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх үүднээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт | Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хороо нь тайлант хугацаанд дараах ажлыг хийж хэрэгжүүлээд байна. Үүнд:<br>1. **Нийгмийн даатгалын ерөнхий газрын** "Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө"-г 2025 оны 03 дугаар сард хэлэлцэн баталж уг төлөвлөгөөнд **Нийгмийн** даатгалын салбарын "Ёс зүйн дүрэм"-ийг шинэчлэн батлах, сургалт зохион байгуулах, соён гэгээрүүлэх арга хэмжээ зэрэг 10 арга хэмжээг зохион байгуулахаар тусгаж **Нийгмийн даатгалын ерөнхий газрын** "Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө"-г Төрийн албаны зөвлөлийн "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" дэд системд байршуулав.<br>Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна.<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын "Ёс зүйн дэд хороо"-нд 2025 онд нийт 9 гомдол, мэдээллийг иргэд, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх;<br>-Баталсан төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 удаа хийсэн байна. | | хангагдсан байна. | төрийн албан хаагчдаас ирүүлсэн ба үүнээс 3 гомдлыг харьяаллын дагуу Орхон, Дархан-Уул, Дундговь аймгийн Нийгмийн даатгалын газрын Ёс зүйн дэд хороодод шилжүүлэв.<br>Харин 6 гомдол, мэдээллийг Нийгмийн даатгалын Ёс зүйн дэд хороо хүлээн авч, судлан дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж Ёс зүйн дэд хорооноос ёс зүйн зөрчилгүй гаргаагүй тухай 4 дүгнэлт, Ёс зүйн зөрчилтэй тухай 2 дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн бөгөөд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасны дагуу "төрийн албанаас халах" ёс зүйн болон сахилгын шийтгэл ногдуулан шийдвэрлэснийг тус тус Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт системд бүртгэн, тайлагнав.<br>3. *Сургалт, соён гэгээрүүлэх чиглэлээр* Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны нэг гишүүн сургагч багшаар, Дэд хорооны дарга болон нэг гишүүн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны шинэчлэл" хэлэлцүүлэгт оролцов.<br>4. Төлөвлөгөөнд тусгасны дагуу Нийгмийн даатгалын салбарын Ёс зүйн дэд хорооны гишүүд, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагч нар, Нийгмийн даатгалын даргын зөвлөлийн гишүүд, Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагч нарт нийт 7 удаагийн "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж танхимаар 380, цахимаар 950 гаруй албан хаагчийг хамруулав.<br>5.Нийгмийн даатгалын салбарын нийт Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, томилох эрх бүхий албан тушаалтнуудтай 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр цахимаар уулзалт зохион байгуулж Нийгмийн даатгалын салбарт гарч байгаа ёс зүйн зөрчил, Ёс зүйн дэд хороодын нийтлэг гаргаж байгаа алдаа, түүнийг хэрхэн шийдвэрлэх, дотоод зохион байгуулалт хийж ажиллах талаар чиглэл өгөв.<br>БНСУ-дахь Нийгмийн даатгалын албан хаагч нарт Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, хуульд заасан зөрчлийг ялгаж ойлгох талаар сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулав.<br>6.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан Төрийн албан хаагчийн зарчмаар "Төрийн албан хаагч бид" гэх постер хийж Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас, 30 нэгжийн цахим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуудаст байршуулан түгээв. | |
| ***Зорилт 4.1:*** *"Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1.1 | "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ийг хэрэгжилтийг хангах үүднээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад үндэсний монгол бичгийн сургалтыг зохион байгуулах; | | -Сургалтад нийт ажилтнуудын 90-ээс дээш хувийг хамруулах, -дундаас дээш үнэлэгдсэн албан хаагчдын тоо | Монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтад 163 албан хаагчдыг цахимаар хамруулсан. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, сургалт зохион байгуулах ажлыг удирдлагаар хангах, Сургалт зохион байгуулж, албан хаагчид мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Сургалт зохион байгуулах тухай" А/07 дугаар тушаал, НД-10/25 дугаартай "Сургалтын гэрээ"-нд үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 13-наас 02 дугаар сарын 26-ны өдрүүдэд үндэсний Монгол бичгийн 20 удаагийн хичээл буюу 40 академик цагийн сургалтыг танхимаар зохион байгуулж сургалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын 93 албан хаагчийг хамруулав.<br>Сургалтыг "Тарвалин хийд"-ийн дэргэдэх шашны сургуулийн үндэсний монгол бичгийн багш Б.Базаррагчаа заан, Монгол бичгийн үүсэл, үндсэн болон нэмэлт зурлага, тоо бичих, эгшиг үсэг, эгшиг зохицох ёсон, зөөлөн, хатуу дэвсгэр үсгийн дүрэм, үсэг холбох, төсөх дүрэм, гадаад үг тэмдэглэх, дагавар, тийн ялгалын нөхцөл, монгол бичгийн фонт суулгах, ашиглах, дадлага ажлуудыг гараар бичих, компьютерээр бичих, гэрийн даалгавар, багаар ажиллуулан, тухай бүр шалган үнэлгээ өгч ажиллав. Нийт албан хаагчид дундаас дээш түвшинд Монгол бичигтэй болсон.<br>**Нийгмийн** даатгалын ерөнхий газар албан бичиг, тушаалыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн Монгол бичгээр давхар хөтлөн явуулж байна. | 100 |
| 4.1.2 | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт зохион байгуулах; | | -2-оос доошгүй удаа зохион байгуулах, -Улсын байцаагчийн эрх олгогдсон албан хаагчдын тоо | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2024 оны шалгалтад нийт 299 албан хаагч хамрагдаж, 162 албан хаагч тэнцэж, 137 албан хаагч хангалтгүй үнэлэгдсэн. | Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад улсын | 1. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын мэдээллийн нэгдсэн сантай болох ажлын хүрээнд 2014-2024 оны улсын байцаагчийн шалгалтад хамрагдсан албан хаагчдын мэдээллийг цаасан суурьтай баримтаас ексел рүү хөрвүүлж боловсруулах ажлыг эхлүүлээд байна.<br>2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/40 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн журам", 2023 оны А/170 дугаар тушаалаар батлсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, түдгэлзүүлэх, цуцлах журам"-ын төсөлд саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Санал хүргүүлэх тухай" 01/2054 дүгээр албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байцаагчийн эрх олгогдсон байна. | 2. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллав. Үүнд:<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын даргын 2025 оны "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай" 3/2749 албан бичгийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүргүүлж мөн даргын 2025 оны "Улсын байцаагчийн шалгалтын зар хүргүүлэх тухай" 03/2925 дугаар албан бичгийг "Нийгмийн даатгалын албан хаагчдын судалбал зохих хууль тогтоомжийн жагсаалт"-ын хамт аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/304 дүгээр тушаалаар Нийгмийн даатгалын улсын байцаагчийн шалгалтын сорилын сан бүрдүүлэх, хянах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, сорилын сангийн жагсаалтыг баталж 36 хууль, журмын хүрээнд нийт 2 206, үүнээс ерөнхий мэдлэгийн 1 606, онол арга зүйн 600, албан хэрэг хөтлөлтийн 50 сорилын санг нягтлан, боловсруулав.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/303 дугаар тушаалаар "Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах Дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүн, шалгалтын хуудасны загвар", Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/310 дугаар тушаалаар Улсын байцаагчийн шалгалтын бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулав,<br>- Улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх сургалтыг 11 дүгээр сарын 12-27-ны өдрүүдэд зохион байгуулж, давхардсан тоогоор 5 640 албан хаагчийг хамруулав.<br>- Шалгалт зохион байгуулахад шаардагдах зардлын төсвийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/323, А/324 дугаар тушаалаар батлан, нийслэлд улсын байцаагчийн шалгалтыг МУИС-ийн "Мэдээллийн технологи, электроник"-ийн сургуулийн 8 ангид зохион байгуулах гэрээ байгуулж шалгалтыг 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулав.<br>Салбарын хэмжээнд улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалтад нийт 436 албан хаагч улсын байцаагчийн шалгалтад хамрагдах бөгөөд шалгалтын үйл ажиллагаа орон нутагт үргэлжилж байна. |
| 4.1.3 | Нийгмийн даатгалын | | -Салбарын | Албан хаагчдыг | Сургалтын | 1. 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | хэмжээнд сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах, -Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 1,039 удаагийн сургалтад 18,261 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулсан. | хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна. | салбарын хэмжээнд нийгмийн даатгалын албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр 3,153 удаагийн сургалтад давхардсан тоогоор 46,908 албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 32 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт танхимаар 2,083, цахимаар 2,712, давхардсан тоогоор 4,795 албан хаагчийг хамруулан, доорх сургалтыг зохион байгуулав. Үүнд:<br>- БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх болон хувь хүний хөгжлийн 6 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 96 албан хаагч хамрагдав.<br>- Эблесофт ХХК-тай хамтран "Эбле программаар албан бичиг, тушаал төлөвлөх, батлуулах арга зүйн" сургалт, Сумын нийгмийн даатгалын байцаагч нарт зориулсан "SIGOS" сиситемийн сургалт, Архивчдын хөгжил сургалт, арга зүйн төвтэй хамтран "Архивын албан хэрэг хөтлөлтийн талаар" сургалт, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газартай хамтран "Хяналт шинжилгээ хийх журам, "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын талаарх сургалт, Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулсан "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэг, түүний ойлголт" сэдэвт сургалт, Багшийн сургуулийн сургалт, судалгааны төвтэй хамтран "Багшлахуй" захиалгат сургалт зэрэг болно.<br>2. Сургалтын платформд 59 видео хичээл, 76 илтгэл (ppt)-ийг байршуулж албан хаагчид хичээлүүдийг бие даан судлах боломжийг бүрдүүлэв.<br>3. Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдад цаг үеийн шинжтэй болон шинэ шинэлэг мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор 20 удаагийн мэдээллийн цагийг зохион байгуулсан бөгөөд танхимаар 954, цахимаар 2,363 нийт 3,317 албан хаагчид хамрагдав. | 100 |
| 4.1.4 | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | - Даатгуулагчид чиглэсэн сургалтыг салбарын хэмжээнд өмнөх оноос 10-аас | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 45 удаагийн сургалтад 6171 аж ахуйн нэгжийн 127544 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг | Салбарын хэмжээнд иргэд, даатгуулагч ажил олгогчдод нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг сурталчилан таниулах, тэдний ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 3,775 удаагийн танхимын болон цахим сургалтыг 18,473 аж ахуйн нэгжийн 208,458 иргэд, даатгуулагчийг хамруулан зохион байгуулснаас Нийгмийн даатгалын ерөнхий газар нь 59 удаагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | доошгүй хувиар зохион байгуулах, - 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, -Ажил иргэд, даатгуулагчдын 150-иас доошгүй хувийг хамруулсан байна. | хамруулав. | дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна. | сургалтад 5,328 иргэд, даатгуулагч, ажил олгогчийг хамруулан, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаарх зөвлөгөө, мэдээллийг түгээн ажиллав. Тухайлбал:<br>-Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Мэдээллийн лавлах -19001950, Залуусаа дэмжих үндэсний хөдөлгөөн ТББ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх алба, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх алба, Тээвэр хөгжлийн банк, Голомт банк зэрэг болно.<br>Тус газар нь хамтын ажиллагааны хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, гуравдугаар шатлалын эмнэлэг, төрийн болон хувийн их, дээд сургууль, арилжааны даатгалын компани, банкуудтай хамтран ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд нийт 24 байгууллагын 1,421 ажилтан, албан хаагчдыг хамруулан "Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл"-ийн талаар сургалт зохион байгуулав. | |
| 4.1.5 | "Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг"-ийн бэлтгэл ажлыг хангах; | - | -Салбарын хэмжээнд архив, бичиг хэргийн ажилтнуудад 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан албан хаагчдын тоо<br>-Цахим баримтыг хадгалах, хамгаалах, ашиглах талаар зохион байгуулсан ажлын тоо | -Нийгмийн даатгалын ерөнхий газрын 1998-2009 оны түр хадгалах архивын баримтаас хугацаа дууссан баримтыг устгалд оруулсан<br>-Баримтын бүрэн бүтэн аюулгүй байдлыг хангах, галын аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс галын хор шинэчлэн стандартын дагуу галын хорийг шинээр байрлуулсан. Хортон шавьж, мэрэгч амьтнаас урьдчилан сэргийлж архивын өрөөнд хулганы хор тавьсан. | -Нийгмийн даатгалын ерөнхий газрын архивын өрөөнд засвар хийнэ.<br>-Хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай саналын Архивын ерөнхий газарт хүргүүлнэ.<br>-Салбарын хэмжээнд архив, бичиг хэргийн ажилтнуудад сургалт зохион | 1. Архивын ерөнхий газраас "Архивын баримтын хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт"-ыг шинэчлэхтэй холбогдуулан Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хөтлөгдөж байгаа 17 төрлийн баримт бичгийн хадгалах хугацааг өөрчлөх, нэмэх саналыг Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудаас авч нэгтгэн БНШК-оор хэлэлцүүлэн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий Захиргаа удирдлагын газрын даргын 2025 оны 03/548 дугаар албан бичгээр Архивын ерөнхий газарт хүргүүлэв<br>2.Нийгмийн даатгалын ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр "Архив, албан хэрэг хөтлөлтийн стандарт", 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр "Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилт" сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулав.<br>3. Цахим баримтыг хадгалах, хамгаалах ажлын хүрээнд хадгалалтыг сайжруулан МТТ-д сервер үүсгэн нэмэлтээр хадгалж, хуулбар хувилдыг үүсгэн ажиллав.<br>4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/199 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын байгууллагын архивын дүрэм"-ийг шинэчлэн батлав.<br>5. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/246 дугаар тушаалаар Архивын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан байна.<br>-Цахим баримтыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг зохион байгуулсан байна. | байгуулав.<br>6. Мөн даргын 2025 оны "Архивын баримтын тооллого хийх тухай" А/256 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын архивт хадгалагдаж байгаа 7 791 ширхэг цаасан суурьтай хадгаламжийн нэгжид тооллого хийх ажлыг зохион байгуулав. "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 13.6 д заасны дагуу Архивын ерөнхий газарт архивт хадгалагдаж байгаа баримтын тоо хэмжээ, өөрчлөлт хөдөлгөөний мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 01/3145 дугаар албан бичгээр хүргүүлэв.<br>7.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/328 дугаар тушаалаар "Онцгой байдлын үед архивын баримтыг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө"-г батлав. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/63 дугаар тушаалаар баталсан "Архивын байгууллагын дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм"-ийн 2.3.3-т заасны дагуу ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулахаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газрын даргын 03/3211 дүгээр албан бичгийг Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэст хүргүүлсэн.<br>8. Архивын өрөөний чийг, дулаан хэмжигчийг Цаг уур орчны шинжилгээний газар байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн газраар шалгуулж баталгаажуулан гэрчилгээ авав. | |
| 4.1.6 | Албан бичгийг "Цахимаар албан бичиг солилцооны дундын систем"-тэй холбогдсон бусад байгуулагуудтай 100 хувь цахимаар солилцох; | - | Нийгмийн даатгалын байгууллага "Цахимаар албан бичиг солилцооны дундын систем"-тэй холбогдсон байгуулагуудтай цахимаар албан бичиг илгээх, хүлээн авах ажлыг зохион байгуулж, тогтмолжуулсан байна. | Нийгмийн даатгалын байгууллага нь 2024 оны жилийн эцсийн байдлаар цахимаар албан бичиг солилцох ажил 20 хувьтай байна. | Нийгмийн даатгалын байгууллага нь цахимаар албан бичиг солилцох ажлыг тогтмолжуулж , биелэлтийн хувийг өсгөсөн байна. | 1. Тус газарт 2025 оны 12 дугаар сарын 05-ны нийт 5,268 албан бичиг ирсэн байна. Үүнд:<br>- Хариутай 2,326 албан бичиг;<br>- Хариугүй 2,942;<br>- Хариутай шийдвэрлэсэн 2,256;<br>- Судалж байгаа 70;<br>- Шийдвэрлэлтийн дундаж 96.9%,<br>- Ирсэн бичиг шийдвэрлэлтийн дундаж 10.2 хоног байна.<br>2. Нийт 3 203 албан бичгийг стандартын дагуу боловсруулан хос бичгээр албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /intranet.gov.mn/-д бүртгэн холбогдох байгууллагууд руу тоон гарын үсгээр баталгаажуулан илгээв.<br>3. Албан бичиг солилцооны дундын систем Эйбл программыг ашигладаг бөгөөд бусад байгууллагуудад 100 хувь цахимаар албан бичгийг солилцож байна. | 100 |

*Зорилт 4.2: "Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.1 | Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэх, сайжруулах санал боловсруулах; | - | -Зохион байгуулсан судалгааны тоо,<br>-Оролцогчийн тоо | - | Сэтгэл ханамжийн судалгааг нийт 4 удаа авч дүгнэн, санал боловсруулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/184 дүгээр тушаалаар "Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авах журам"-ыг шинэчлэн баталж иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос авах нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгааны асуумжийг иргэний болон ажил олгогчийн портал систем (portal.ndaatgal.mn)-д байршуулан сар бүр дүнг нэгтгэн ажиллав.<br>Судалгаанд 1,874 ажил олгогч, 3,492 иргэд, даатгуулагч оролцоод байгаа ба дийлэнх нь системийн хурд, найдвартай ажиллагааг сайжруулах, техникийн алдааг багасгах, процессын шат дамжлагыг цөөлөх, программ ашиглах талаарх хэрэглэгчдэд зориулсан дэлгэрэнгүй, ойлгомжтой заавар, мэдээллийг тогтмол хүргэх зэрэг санал ирүүлсэн байна.<br>Программ хангамжид гарч байгаа алдааг засах, хөгжүүлэлт, сайжруулалт хийх, тогтворжуулах, бодлогын даалгавар боловсруулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, сургалт зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/130 дугаар тушаалаар байгуулж иргэд, байгууллагад үзүүлж байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээний алдааг засах, үйл ажиллагааг жигдрүүлэх, нэвтрээгүй буюу дутуу нэвтрүүлсэн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, судалгааны дүнд гарсан саналыг хэрэгжүүлэх чиглэлээр ажлын хэсгийн гишүүдийг баг болгон үүрэгжүүлж, системийн сайжруулалт хийн, өөрчлөлт орсон тухай бүр албан хаагч нарт мэдээлэл зөвлөгөө, сургалт хийж ажиллав. | 90 |
| 4.2.2 | Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийг судалгаа авч дүгнэх, сайжруулах санал боловсруулах; | - | -Зохион байгуулсан судалгаа,<br>-Оролцогчийн тоо | Нээлттэй өдөрлөгт 6742 иргэд, даатгуулагчдыг судалгаанд хамруулсан. | Сэтгэл ханамжийн судалгааг нийт 2 удаа авч дүгнэн, санал боловсруулсан байна. | Нийгмийн даатгалын үйлчилгээний болон ажлын байрны стандартын хэрэгжилтэд тандалт, судалгаа хийх зорилгоор нийслэлийн төвийн 6 дүүргийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлсэн 235 иргэн, нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээнд оролцсон 70 иргэнээс тус тус үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авав. Судалгаагаар оролцогчдын дийлэнх нь тэтгэвэр, сайн дурын даатгал, шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар хандсан бөгөөд хууль тогтоомжийн талаарх мэдээллийг цахим орчинд олон нийтийн сүлжээгээр илүү хүртээмжтэй түгээх талаар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санал ирүүлсэн.<br>Мөн ажилтнуудын харилцаа хандлагад сэтгэл ханамж өндөр байгаа боловч иргэдэд өгч байгаа мэдээллээ ойлгомжтой, дэлгэрэнгүй тодорхой хүргэх, мэдээлэл дутуу авснаас иргэдэд хүндрэл учирч байгаа тухай саналыг ирүүлсэн.<br>Тандалт, судалгааны дүгнэлтийг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрын нийт ажилтнуудад танхимын болон цахим хосолсон 4 удаагийн сургалтаар танилцуулж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөв. | |
| 4.2.3 | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Хариулсан дуудлагын тоо, дуудлага алдалтын хувь | Нийт 114,164 дуудлага ирж, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын байгууллага дуудлага алдалтын тоог 20 хувиас хэтрүүлэхгүй ажилласан. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, дуудлага алдалтын тоог 18 хувиас хэтрүүлэхгүй ажиллана. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээнд тогтмол хяналт тавин, дуудлагын тайланг 7 хоног бүр нэгтгэн дүнг дотоод мэдээллийн системээр мэдээлж дуудлага алдалтын тоо өндөр байгаа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад анхааруулга, зөвлөмж тухай бүр өгч ажиллав.<br>Энэ оны эхний 11 сарын байдлаар нийт 703,243 дуудлага ирснээс 537,618 дуудлагад хариулж, алдсан дуудлага 165,624 байна.<br>Аймгийн Нийгмийн даатгалын газруудад дуудлага алдалт 12.4 хувь, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад 26.9 хувь, нийт дүнгээрээ дуудлага алдалт 24 хувьтай байна.<br>Эхний хагас жилийн байдлаар дуудлага алдалтын хувь 6.6 байсан бол сүүлийн хагас жил огцом нэмэгдсэн нь ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилтээс хамааралтайгаар тэтгэмж хугацаандаа олгогдохгүй, олон хоногоор саатаж байгаатай холбоотой нийслэлийн төвийн дүүргүүдийн хувьд дуудлага ихээр нэмэгдэж, ачаалал ихэссэн байна.<br>Утасны дуудлага алдалтыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 05/2989 албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт үүрэг болгов.<br>Мөн газрын даргын зөвлөлийн хурлаар дуудлагын мэдээг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт тогтмол мэдээлж анхааруулж байна. | 70 |
| 4.2.4 | Нийгмийн даатгалын сангаас олгох зарим төрлийн тэтгэврийг цахимжуулах ажлыг зохион | - | Хэрэгжүүлсэн ажлын тоо | Нийгмийн даатгалын үйлчилгээний 85%-ийг цахимжуулсан. | Олон хүүхэдтэй эхийн нөхцлөөр | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Хөтөлбөр батлах тухай" А/138 дугаар тушаалаар "Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөр"-ийг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах; | | | | тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах, тогтоох, олгох бэлтгэл ажил хангагдсан байна | батлав.<br>Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим төрлийн тэтгэвэр түүний дотор олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулах бэлтгэл ажлыг хангаж ажиллахаар тусгасан бөгөөд **Нийгмийн даатгалын ерөнхий газрын** даргын 2025 оны "**Цахим үйлчилгээ нэвтрүүлэх тухай**" А/253 дугаар тушаалаар хөдөлмөрийн чадвар алдсаны /мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний/ **тэтгэвэр** тогтоолгох **цахим** хүсэлт авах боломжийг даатгуулагчийн программ /https://portal.ndaatgal.mn/#/landing/-д бүрдүүлэн 2025 оны 10 **дугаар** сарын 01-ний өдрөөс **нэвтрүүлж** хүсэлтийг хүлээн авч тэтгэвэр **тогтоож олгох** үйл ажиллагааг нэвтрүүлэв.<br>**Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран** ажиллаж зарим мэдээллийг **цахимаар** солилцох, мэдээллийг **нарийвчлан** шуурхай оруулдаг болсноор олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох **өндөр насны** тэтгэврийг цахимжуулах боломж бүрдэх **бөгөөд** **программын** даалгавар боловсруулах ажил хийгдэж байна.<br>**Төрийн байгууллагад** байгаа мэдээллийг **цахимаар** солилцох, цэргийн алба хаагчдын ажилласан жилийн талаарх тушаал шийдвэр, **цалингийн** тооцоо мэдээллийг цахимаар солилцох боломжийг бүрдүүлэх, улмаар Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу **тогтоох тэтгэврийг цахимжуулах** зорилгоор **Нийгмийн даатгалын** ерөнхий газрын дарга, **Шүүхийн** шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын **даргын** хамтарсан 2025 оны А/111-А/121 дүгээр, **Нийгмийн** даатгалын **ерөнхий** газар, **Цагдаагийн** ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин **штаб**, **Онцгой** байдлын ерөнхий газрын даргын хамтарсан 2025 оны А/142-А/208, А/193-А/390, А/194-А/281 дүгээр тушаалаар тус тус хамтарсан ажлын **хэсгийг** байгуулсан ба эдгээр **байгууллагуудтай** уулзалт зохион байгуулж, хууль эрх зүйн болон программ хангамжийн түвшинд хийгдэх ажлуудын талаар ярилцан бэлтгэл ажлыг хангахаар ажиллаж байна. | |
| 4.2.5 | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг | - | Шинээр бэлтгэсэн контентын | Рийл 16, постер мэдээлэл 112, контент 4, цаг үеийн | Шинэ контент бэлтгэж, олон нийтийн | Тайлант хугацаанд Рийл 42, Стори рийл 8, постер мэдээлэл 370, контент 16, 2D видео контент 2, 3D видео контет 2, мэдээ мэдээлэл 237, лайв 4 удаагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | иргэд, даатгуулагчдад ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент бэлтгэн хүргэх; | | тоо, төрлийг 1-2 хувиар нэмэгдүүлсэн байна. | мэдээ, мэдээлэл 36, нэвтрүүлэг 3, подкаст 1, видео, танилцуулга, заавар 28, шторк 1 буюу 223 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 8,945,678 хүнд хүрч 47,969 удаа түгээсэн. | мэдээллийн хэрэгсэл, сошиал сүлжээгээр дамжуулан сурталчилсан байна. | мэдээллийг бэлтгэн түгээж, давхардсан тоогоор 25,191,552 хүнд хүрч 97,115 удаа түгээв. | |
| 4.2.6 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр төрийн болон олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах; | - | -Хамтран ажилласан байгууллагын тоо;<br>-<br>Сурталчилгааны хувь, үр дүн | - | Төр болон хувийн хэвшил, олон нийтийн байгууллагатай хамтран ажиллаж үр дүнд хүрсэн байна. | Хэвлэл мэдээллийн 24 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.<br>**Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 45 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 470 (давхардсан тоогоор) удаагийн мэдээ, мэдээлэл, ярилцлага, тодруулга, хэлэлцүүлэгт оролцож нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан, түгээж ажилласан.** | 100 |
| ***Зорилт 4.3:*** *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1 | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, хүргүүлэх; | - | Саналыг боловсруулж, хүргүүлсэн байна. | 2024 онд 2 санал боловсруулж, хүргүүлсэн. | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой 2 эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс эрүүл мэндийн магадлалтай холбоотой эрхзүйн баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв. Үүнд:<br>1. Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн өөрчлөлтөд тусгуулах санал боловсруулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/763 дугаар албан бичгээр;<br>2. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл өөрчлөх, сэргээн засах, сувиллын тусламж, үйлчилгээнд хамрагдсан байдал болон эмнэлгийн хуудасны бичилт, олголтын үндэслэлд хяналт тавихад эрүүл мэндийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг солилцох зорилгоор мэдээллийн жагсаалт болон Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд цахимаар илгээх үечилсэн дүгнэлтийн загварыг тус тус | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/901 дүгээр албан бичгээр;<br>3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны "Журам, маягтын загвар батлах тухай" А/177, А/433 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам" болон "Эмнэлгийн хуудасны маягтын загвар"-т өөрчлөлт оруулах саналыг нэгтгэн 2025 оны 01/1477 дугаар албан бичгээр;<br>4. "Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгох, гэрээ байгуулах, санхүүжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих журам"-д оруулах өөрчлөлтийн саналыг 2025 оны 01/1483 дугаар албан бичгээр; | |
| 4.3.2 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинээр нэвтрүүлж буй программын хөгжүүлэлтэд дэмжлэг үзүүлэх, хэвийн үйл ажиллагааг бүрдүүлэх зорилгоор санал, программын даалгаврыг Мэдээлэл технологийн төвд тухай бүрд хүргүүлэх; | - | -Хүргүүлсэн санал,<br>-Программын даалгавар | - | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинээр нэвтрүүлэх, программын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хүргүүлсэн саналын хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны цахим шилжилт болон программтай холбоотой дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:<br>1. Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадлан шийдвэрлэх, эмнэлгийн хуудасны бичилт, олголтын болон эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн төлбөр, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн үндэслэл зэрэгт цахимаар хяналт тавих боломжийг бүрдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын магадлагч эмч *нартай "Хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах гэрээ"* байгуулж хамтран ажиллах талаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Мэдээлэл солилцох тухай" 01/557 дугаар албан бичгээр, мөн Иргэний эрүүл мэндтэй холбоотой мэдээлэл солилцох тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 01/1705, 01/2671 дүгээр албан бичгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлэв<br>2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/152 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх хөтөлбөр"-ийг баталж лан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>- Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэчилсэн программыг хөгжүүлэх, тэтгэмжийн хяналтын дэд системд өөрчлөлт оруулах талаар программын даалгаврыг ЭММТЗ-ийн даргын 2025 оны 09/17 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан бичгээр. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээхтэй холбогдсон сэргээн засах болох сувиллын тусламж үйлчилгээний зардал, унааны зардлын төлбөр олгохтой холбоотой программын даалгаврыг ЭММТЗ-ийн даргын 2025 оны 09/2129 дүгээр албан бичгээр, Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн программын хөгжүүлэлттэй холбоотой дэд системийн сайжруулалт хийх программын даалгаврыг ЭММТЗ-ийн даргын 2025 оны 09/2239 дүгээр албан бичгийг Мэдээллийн технологийн төвд тус тус хүргүүлэв.<br>- Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудасны программын хөгжүүлэлттэй холбоотой Эрүүл мэндийн яамны холбогдох газрын дарга, мэргэжилтнүүдтэй 3, Мэдээллийн технологийн төвийн холбогдох ажилтнуудтай нийт 7 удаагийн уулзалт, ярилцлага зохион байгуулав.<br>- Эрүүл мэндийн магадлалын программын ашиглалттай холбоотой сургалтыг аймаг, дүүргийн ЭММЗ-ийн магадлагч эмч нарт 2 удаа зохион байгуулав. (2025.10 сар) | |
| 4.3.3 | Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн Хамтарсан болон Дахин магадлал зохион байгуулах; | - | Хяналт шалгалтын дүн, тайлан | Дахин магадлалыг Орхон, Говьсүмбэр, Төв аймаг, хамтарсан магадлалыг Дархан-Уул, Хөвсгөл, Булган, Дундговь аймаг, Хан-Уул дүүрэгт зохион байгуулсан. | Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу 8-аас доошгүй аймаг, дүүрэгт зохион байгуулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн Дахин магадлалыг 5 удаа, Хамтарсан магадлалыг 1 удаа зохион байгуулав. Үүнд:<br>1.Дахин магадлалыг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг болон Орхон аймагт зохион байгуулж, нийт 1,420 даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг магадалснаас 1,353 /95.3%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадалж, 32 /2.3%/ даатгуулагч, хүний заалт, хувь, хугацааг өөрчилж, онош эргэлзээтэй, заалт хувь, хугацаа зөрсөн, оношийн баталгаажилт хангалтгүй 51 /3.6%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 23 /1.6%/ иргэнийг онош баталгаажуулах шинжилгээнд илгээж, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэврийг үндэслэлгүйгээр илүү олгосон 7.0 сая төгрөгийн хохирлыг Нийгмийн даатгалын санд буцаан төлүүлэхээр Улсын байцаагчийн акт тогтоож, биелэлтийг барагдуулж ажиллав.<br>Хяналт шалгалтын хугацаанд Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төв, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн 200 орчим эмч, мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн магадлалын хууль эрх зүйн шинэчлэлт, түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлын талаар сургалт зохион байгуулав. /2025.02-05 сар/<br>2.Хамтарсан магадлалыг Эрүүл мэндийн яамны дэргэдэх Сэтгэцийн болон Дотрын анагаах ухааны салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран Сэлэнгэ аймагт 2025 оны 06 дугаар сард зохион байгуулж сэтгэц, зүрх судас болон дотоод шүүрлийн өвчний улмаас хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон 1,005 иргэнийг түүврийн аргаар түүвэрлэв. Мөн удирдамжид заасны дагуу иргэд болон Нийгмийн даатгалын байцаагч нараас ирүүлсэн мэдээллийн дагуу 53, нийт 1,058 иргэнийг хамруулахаар төлөвлөснөөс 691 даатгуулагч, хүнд төрөлжсөн мэргэшлийн эмчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ хийж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон шийдвэрийн үндэслэлийг магадалснаас 489 /70.8%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр, 243 /35.2%/ давхардсан байдлаар даатгуулагч, хүний заалт, хувь, хугацааг өөрчилж магадалснаас заалт өөрчилж сунгасан 66(9.6%), хувь нэмэгдүүлсэн 32 (4.6%), хувь бууруулсан-52 (7.5%), онош эргэлзээтэй, заалт хувь, хугацаа зөрсөн, оношийн баталгаажилт хангалтгүй 69 /10%/ иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж шийдвэрлэв.<br>Хяналт шалгалтын хугацаанд Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, сумын 40 орчим эмч, мэргэжилтнүүдэд Эрүүл мэндийн магадлалын хууль эрхзүйн шинэчлэлт түүнийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, хяналт шалгалтын хугацаанд илэрсэн алдаа зөрчлийн талаар сургалт зохион байгуулав. /2025-06 сар/<br>-Сэлэнгэ аймагт зохион байгуулсан хяналт шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй нийт 323 иргэнийг 2025 оны 08-09 дүгээр сард ЭММТЗ-ийн өргөтгөсөн хурлаар 148 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэлэлцэн, 119 иргэнийг хэвээр, 21 иргэний хувь, хугацааг өөрчилж, 8 иргэнийг цуцалж шийдвэрлэв. /2025.08-09 сар/ | |
| 4.3.4 | Мэдээллийн технологийн төвтэй хамтран Эрүүл мэндийн магадлалын болон цахим эмнэлгийн | - | -Боловсруулж хүргүүлсэн 1 программын даалгавар | - | Холбогдох программд өөрчлөлт хийгдэж, | Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-д заасан чиг үүргийн хүрээнд салбар болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хуудасны программд өөрчлөлт оруулах, программын даалгавар боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах; | | | | боловсронгуй болсон байна. | даатгуулагч, хүнийг биеэр байлцуулахгүйгээр цахимаар болон баримт бичигт үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтыг магадлан шийдвэрлэх, эмнэлгийн хуудасны үндэслэлд хяналт тавих үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулахад иргэний эрүүл мэндийн мэдээллийг холбогдох байгууллагаас авах, мэдээлэл солилцох, магадлагч эмчийн зүгээс тавих хяналтыг сайжруулах нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Эмнэлгийн хуудас хянан баталгаажуулах үйл ажиллагааг сайжруулах тухай" А/241 дүгээр тушаалаар **магадлагч эмч нарын "Эмнэлгийн хуудас хянан баталгаажуулах эрх нэгтгэх хуваарь"-ийг батлуулав.**<br>**Дээрх тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд** хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсэн, амаржсаны эмнэлгийн хуудсыг хянан **баталгаажуулахтай холбоотой цахим программд** нэмэлт өөрчлөлт оруулах программын даалгаврыг ЭММТЗ-ийн даргын 2025 оны 09/2058 дугаар албан бичгээр, **цахим** эмнэлгийн хуудасны программд өөрчлөлт оруулсантай холбоотойгоор 8 зүйл бүхий зөвлөмжийг ЭММТЗ-ийн даргын 09/2236 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдэд тус тус хүргүүлэв. (2025.09 сар)<br>**Магадлагч эмч нарын эмнэлгийн хуудас хянан баталгаажуулах эрхийг нэгтгэн, ачааллыг тэнцвэржүүлснээр 1 магадлагч эмч өдөрт дунджаар 40-50 эмнэлгийн хуудас хянан баталгаажуулж, хяналтын дундаж хоног 2-3 болж багассан байна.** | |
| 4.3.5 | **Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг** тогтоох сунгах, **цуцлах** үйл ажиллагааг бусад аймаг, дүүргийн ЭММЗ-өөр шийдвэрлэх **боломжийг судлах, тогтолцооны санал боловсруулж** хүргүүлэх; | | -<br>Боловсруулсан 1 санал | - | Санал боловсруулж, ГБХНХЯ-нд хүргүүлсэн байна. | *Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа -2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгасан "Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран төрийн үйлчилгээ шат дамжлагагүй, шуурхай болно" гэсэн зорилт, "Цахим Монгол" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:*<br>-Даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар **алдалтыг** шийдвэрлэх үйл **ажиллагааны процессыг** цахимжуулах, чанарыг сайжруулах, чирэгдлийг багасгах, авлига, **ашиг** сонирхлын зөрчлөөс ангид байх арга замыг тодорхойлох, төрийн байгууллага **хоорондын** мэдээллийн солилцоог сайжруулах зорилгоор Засгийн | 90 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор баталсан "Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг боловсруулж, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд танилцуулгын хамт хүргүүлэв. /2025.12 сар/<br>-Эрүүл мэндийн магадлалын процессын цахимжуулалтад тулгуурлан даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах, шуурхай шийдвэрлэх, аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаанд цахим шинэчлэл нэвтрүүлэх хөтөлбөр" боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Хөтөлбөр батлах тухай" А/152 дугаар тушаалаар баталж, 2025 оны "Хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" 04/1337 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төв болон аймаг, дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдэд тус тус хүргүүлэв. Тус тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/164 дүгээр тушаалаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлан, хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн дэд төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллаж хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шийдвэрлэх үйл ажиллагааг SICOS системд холбосноор хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэлтийн хуудсыг цахимжуулж хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар гаргаснаар тэтгэвэр тогтоолгох процесс хялбарчилж, өөрийн хөдөлмөрийн чадвар алдалттай холбоотой мэдээлэл, лавлагааг www.portal.ndaatgal.mn болон мэдээлэл солилцооны "ХУР" системээс цаг алдалгүй, түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлж байна. /2025.05-10 сар/ | |
| ***Зорилт 4.5:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх"* **эсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | | | | | |
| 4.5.1 | Салбарын хэмжээнд хууль тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг мэдээллийн | | Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн дэвшилтэт | -Нийгмийн даатгалын багц хуулийн 100 гаруй зүйл заалтын дагуу мэдээллийн нэгдсэн | Салбарын хэмжээнд хэрэгжиж буй хууль, тогтоомж, | **Нэг.** Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хэрэгжиж буй *хууль, тогтоомжийн хэрэгжилтийг мэдээллийн технологиор дэмжих хүрээнд* мэдээллийн нэгдсэн системд холбогдох өөрчлөлт, хөгжүүлэлтийг хийж, туршин нэвтрүүлэх ажлыг гүйцэтгэн ажиллав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | технологиор дэмжин ажиллах; | | технологид суурилан үзүүлэх үйлчилгээний хэвийн ажиллагааг хангасан байх. | системд холбогдох өөрчлөлт хөгжүүлэлтийг хийж нэвтрүүлсэн.<br>-Нийгмийн даатгалын багц хуулийн дагуу 4 бүтээгдэхүүн шинээр хөгжүүлэн нэвтрүүлсэн.<br>-Засгийн Газрын 2024 оны "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 120 тоот тогтоолын дагуу нийт 520.0 мянга орчим тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийсэн.<br>-"Нийгмийн даатгал" аппликейшнийг шинэчлэн нэвтрүүлсэн.<br>-Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг өргөжүүлэн шинээр 3 сервис нэвтрүүлсэн. | шийдвэр, өөрчлөлтийн хүрээнд системд зохих хөгжүүлэлтийг хийж нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологиор дэмжсэн байна. | Тухайлбал:<br>1.Нийгмийн даатгалын шимтгэлийн НД7А тайланд ажил олгогчийн НДШ-ийн акт, алданги, торгуулийн мэдээллийг тусад нь хүснэгтэд харуулдаг болгож, эдгээр дүнг нийт шимтгэл төлөлтийн дүнд тооцон харуулах боломжийг бүрдүүлэв.<br>2.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Гадаад харилцааны болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны "Адилтгах албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай" А/48, А/130 дугаар хамтарсан тушаалын дагуу:<br>- Цэргийн атташе, атташегийн туслахаар ажиллаж байсан даатгуулагчийн төрлийн 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох;<br>- ТЕГ, АТГ зэрэг байгууллагаас даатгуулагчийн төрлийг 01001 кодоор тайлагнасан хугацааг цэргийн алба хаасны тэтгэвэр дээр хамтад нь тооцох болон бусад холбогдох өөрчлөлтүүдийг системд оруулж **цэргийн атташе гэсэн нөхцөлөөр** тэтгэвэр тогтоолгох боломжийг бүрдүүлсэн.<br>3.**Үндсэн хуулийн цэцийн гишүүн** өндөр насны тэтгэвэр тогтоолгоход, хүсэлт гаргах үед мөрдөж байсан албан тушаалын болон НДЕХ-ийн 19 дүгээр зүйлд заасан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулан тооцохтой холбогдуулан УИХ-аас 1995-2023 онуудад баталсан цалингийн мэдээллийг системд оруулсан.<br>4.Сайн дурын даатгалын алдангийн мэдээллийг Зөрчил дэд системд бүртгэж нэгдсэн хэлбэрээр хөтлөх боломжийг бүрдүүлэв. Ингэснээр даатгуулагчийн мэдээлэл, алдангийн дүн болон нийгмийн даатгалын сангуудын задаргааг системд оруулж алданги тооцох, баталгаажуулах, нэхэмжлэл үүсгэх ажиллагаа бүрэн автоматжсан.<br>5.Нийгмийн даатгалын нийт бүтээгдэхүүн үйлчилгээний тоон мэдээллийг дэлгэрэнгүй харах боломж бүхий "Dashboard"-ыг шинэчлэн боловсруулж нэвтрүүлсэн. Уг "Dashboard"-оос нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний нийт 25 төрлийн багц мэдээллийг харьяалагдах аймаг, дүүргээр задлан дэлгэрэнгүй харах боломжтой.<br><br>**Хоёр. Монгол улсын Засгийн Газрын тогтоол болон бусад шийдвэрийг хэрэгжүүлэв.** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1.Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн "Итгэлцүүр батлах тухай" 231 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэх 2025 оны итгэлцүүрийг мэдээллийн системд оруулж, 2025 онд 35.7 мянган даатгуулагчийн тэтгэврийг шинээр тогтооход ашигласан байна.<br>2.Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 03 тоот тогтоолын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинэчлэгдсэнтэй холбогдуулан дараах өөрчлөлтүүдийг хийв. Үүнд:<br>- Бүх төрлийн сайн дураар даатгуулагчийн сард төлөх шимтгэлийг тооцох хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792,000, дээд хэмжээг 5,544.000 төгрөг байхаар;<br>- Албан журмаар даатгуулагчийн шимтгэл төлөх сарын цалин хөлсний дээд хэмжээг 7920000 төгрөг байхаар;<br>- Тэтгэвэр тогтоох, тэтгэмж тооцох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 7.920.000 төгрөг байхаар тус тус өөрчлөв.<br>2.Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй Монгол Улсын иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг бүртгэх системийн хөгжүүлэлтийг хийж, туршин шалгав. Энэхүү ажлын хүрээнд 50,000 воны шимтгэлийг системд бүртгэн, гараас оруулсан ханшийн мэдээлэлд үндэслэн төгрөгт хөрвүүлэх боломжийг бүрдүүлэв. Мөн хөрвүүлсэн дүн дээр хуулийн дагуу 8.5 хувийн шимтгэлийг тооцох, шимтгэлээс үүсэх авлага болон төлөлтийн нөхөн ногдуулалтын мэдээллийг бүртгэх, тэтгэврийн шимтгэл болон цалингийн нэхэмжлэлийг автоматаар үүсгэн хаах хөгжүүлэлтийг хийлээ. | |
| 4.5.2 | Иргэд, даатгуулагчид руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх; | | Иргэд, даатгуулагчид цахимаар үзүүлж буй үйлчилгээний төрөл нэмэгдсэн цахимжуулал | Нийгмийн даатгалын үйлчилгээний 85%-ийг цахимжуулсан. | Тэтгэврийн бүтээгдэхүүний хүсэлтийг цахимаар авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлсэн | Иргэд, даатгуулагч, ажил олгогч руу чиглэсэн цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах боломжуудыг бүрдүүлэв. Тухайлбал:<br>**Нэг. Portal.ndaatgal.mn веб системд өөрчлөлт, хөгжүүлэлт хийж нэвтрүүлэв.**<br>-Даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдсаны бүрэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тын хувь | | байна. | болон хувь тэнцүүлсэн тэтгэвэр, ҮОМШӨ-ний хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ цахимаар гаргах нөхцөлийг бүрдүүлээ. Ингэснээр даатгуулагчаас цаасан баримт шаардахгүйгээр нийгмийн даатгалын мэдээллийн санд тулгуурлан даатгуулагчийн мэдээллийг цахимаар шалган тэтгэврийг цахимаар тогтоох боломж бүрдсэн. Энэхүү үйлчилгээг нэвтрүүлснээс хойш нийтдээ 210 даатгуулагч цахимаар хүсэлтээ гаргасны 72.5 хувийг шийдвэрлэсэн байна.<br>- Ажил олгогчийн портал системийн хэрэглэгчийн эрхийн удирдлагыг сайжруулав. Байгууллагын дарга, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан оорийн ажлын чиг үүрэгт тохирсон эрхээр нэвтрэх боломжтой болж, эрхийн хуваарилалт, хязгаарлалтыг илүү тодорхой болгов.<br>- Нийгмийн даатгалын тайланг тоон гарын үсгээр баталгаажуулан илгээх боломжийг бүрдүүлэв. Ингэснээр ажил олгогчид илүү найдвартай, баталгаатай байдлаар тайлангаа илгээх нөхцөл бүрдсэн.<br>- Ажил олгогчдод системийн шинэчлэлт, өөрчлөлт болон бусад шаардлагатай мэдээллийг шуурхай хүргэх зориулалтаар "Зар мэдээний булан" шинээр нэмэв.<br>- ҮОМШӨ-ий даатгуулагчийн сэргээн засах төв болон сувилалд ирэх буцах унааны зардлын хүсэлтийг **Portal.ndaatgal.mn вэб** системээр цахимаар авах хөгжүүлэлтийг хийж туршин нэвтрүүлэхэд бэлэн болгов.<br><br>**Хоёр: Сумдад мэдээллийн нэгдсэн системийг нэвтрүүлэв.**<br>Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ашиглаж буй мэдээллийн нэгдсэн системийг 320 сумын байцаагч ашиглах боломжийг бүрдүүлэв.<br>Энэ ажлын хүрээнд сумдын байцаагчийг интернэтийн төхөөрөмж, интернэтээр хангах, программ хангамжид хандах холболт /VPN/ тохиргоо хийх ажлыг гүйцэтгэв. Ингэснээр сумын байцаагч оорийн сумынхаа ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хүлээн авах, шинэ ажил олгогч бүртгэх, ажил олгогчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сайн дурын даатгуулагчийн шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, мөн тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлтийг хүсгэх, даатгуулагчийн хүсэлтээр нийгмийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа гаргаж өгөх боломжтой.<br><br>**Гурав. Шинээр бүтээгдэхүүн хөгжүүлэн нэвтрүүлэв.**<br><br>- Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн хурлаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг хэлэлцэн шийдвэрлэсэн мэдээллийг бүртгэх, хянах, баталгаажуулах үйл ажиллагааг программчлан шинээр дэд систем хөгжүүлэн нэвтрүүлэв. Ингэснээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаа орон зай хамаарахгүйгээр явагдах боломж бүрдлээ.<br>- Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/107 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Илүү төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам"-д заасан аргачлалын дагуу даатгуулагчийн 2024 он ба түүнээс өмнөх хугацаанд сард төлбөл зохих шимтгэлийн хэмжээнээс илүү төлсөн шимтгэлийг автоматаар тооцоолон буцаан олгох бүтээгдэхүүнийг хөгжүүлэн нэвтрүүлэв. Үр дүнд нь энэ оны 11 сарын байдлаар нийт 917 даатгуулагч илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлт гаргаснаас 875 даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлийн тооцооллыг системээр хийж буцаан олгосон байна.<br><br>**Дөрөв. Мэдээлэл солилцох сервис шинээр боловсруулан нэвтрүүлэв.**<br><br>Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж, мөн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ E-Mongolia порталаар дамжуулан цахимаар гаргах **сервисийг боловсруулан** И-Монгол академи УТҮГ-т хүргүүлэв.<br><br>**Тав. "Тэтгэврийн нөөц сан"-гийн мөнгөжүүлсэн орлогыг тооцон олон сувгаар цахимаар хүргэх ажлыг зохион байгуулав.**<br><br>- Даатгуулагч "Нийгмийн даатгал" аппликейшн, Portal.ndaatgal.mn веб болон E-Mongolia системүүдээр "Мөнгөжүүлсэн хуримтлал"-ын мэдээллээ он, оноор сонгож харах боломжийг бүрдүүлэв.<br>- 2025 оны 05 дугаар сард "Тэтгэврийн нөөц сан"-д | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байршуулсан 25.0 тэрбум төгрөг, 10 дугаар сард байршуулсан 40.0 тэрбум төгрөгийг даатгуулагчдад хуваарилан мөнгөжүүлсэн орлогоор бүртгэсэн бөгөөд мэдээллийг даатгуулагч "Нийгмийн даатгал" аппликейшн, "E-Mongolia" портал, Portal.ndaatgal.mn системээр дамжуулан цахимаар харах боломжийг бүрдүүлэв. | |
| 4.5.3 | Нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд их өгөгдөл/хиймэл оюун ухаан үүсгэх ажилд оролцох; | | Нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөлд нийлүүлсэн мэдээллийн тоон үзүүлэлт | - | Нийгмийн хамгааллын салбарын их өгөгдөлд нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг тогтмол нийлүүлсэн байна. | 1.Нийгмийн хамгааллын салбарын хэмжээнд үүсгэх их өгөгдлийн (Big Data) системд шаардлагатай мэдээллийг хэрхэн нууцлан хамгаалах, мөн бусад байгууллагын өгөгдөлтэй хэрхэн уялдуулах талаарх аргачлалыг боловсруулах, батлах ажилд оролцов. Энэхүү аргачлалд суурилан мэдээлэл нийлүүлэхэд шаардлагатай өгөгдлийн сангийн бүтэц, өгөгдлийн талбарууд, формат, нууцлалын зэрэглэл зэргийг тодорхойлж нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг /data/-ийг нийлүүлж, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан.<br>2.Мөн улсын хэмжээнд үүсгэж буй их өгөгдлийн экосистемд өгөгдөл нийлүүлэх боломж, техникийн хэрэгжилтийг турших зорилгоор "И-Монгол" УТҮГ-тай хамтран туршилтын өгөгдөл дамжуулах, API холболт, өгөгдлийн формат, найдвартай байдал, хамгаалалтын түвшнийг шалгах тестүүдийг хийсэн. Энэ хүрээнд харилцан тохирсон өгөгдлийн бүтэц, урсгалыг туршиж, шаардлагатай сайжруулалтыг хийж нийгмийн даатгалтай холбоотой мэдээллийг /data/-ийг нийлүүлсэн.<br>3.Түүнчлэн **Засгийн газрын төвлөрсөн "Дашбоард систем"**-д зориулсан салбарын холбогдох мэдээллийг тухай бүрд нь шинэчлэн бэлтгэж, тогтмол хүргүүлэн ажиллалаа. | 90 |
| 4.5.4 | Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төрийн нэгдсэн мэдээллийн сангаас нийгмийн даатгалын үйлчилгээг тогтвортой үзүүлэх; | - | 1.Нэгдсэн мэдээллийн санг баяжуулсан байх<br><br>2.Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийсэн байх | 1.Нэгдсэн мэдээллийн санг бодит цагийн горимоор цуглуулан ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн.<br>2.150 удаагийн мэдээллийн боловсруулалт хийсэн.<br>3.Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ: | 1.Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, нөөцлөх, төрийн нэгдсэн мэдээллийн санд байршуулах, нэгдсэн мэдээллийн | ***1. Нэгдсэн мэдээллийн санг бодит цагийн горимоор цуглуулан ашиглах боломжийг бүрдүүлэн ажиллав.***<br>Төв орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагад өдөр бүр үүсгэж буй иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг цаг тухай бүр онлайнаар цуглуулан нэгдсэн мэдээллийн санг шинэчлэн баяжуулав. Ингэснээр төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгууллагад үзүүлэх нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний цар хүрээ нэмэгдэж, хэрэглэгч **бодит цагийн горимоор** цахим үйлчилгээг тухай бүр хэвийн авах нөхцөл бүрдсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 3.Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан цахимаар мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлэн хэвийн ажиллагааг хангасан байх. | -135.2 мянган даатгуулагч, ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан.<br>-149.0 мянган даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, төлбөрөө төлөх үйлчилгээнд цахимаар хамрагдах боломжийг бүрдүүлсэн.<br>-1150 эрүүл мэндийн байгууллагаас 183.3 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 61.7 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 245 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн.<br>-Иргэд даатгуулагч, ажил олгогч E-Mongolia нэгдсэн порталаар нийт **14.8 сая** удаагийн хандалт хийж нийгмийн даатгалын 12 төрлийн лавлагаа | сангаас үйлчилгээ үзүүлэх ажил тогтвортой хийгдсэн байна.<br>2.Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа мэдээллийн боловсруулалт хийх ажлыг цаг тухай бүр гүйцэтгэсэн байна.<br>3.Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэд, даатгуулагч, төрийн болон бусад байгууллагуу дад цахимаар мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлж, тогтвортой ажиллагааг хангасан байна. | ***2. Нэгдсэн мэдээллийн сангаас 200 орчим удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа гаргав.***<br><br>УИХГ, яам, агентлаг, төрийн болон бусад байгууллагын хүсэлтээр нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн сангаас нийтдээ 200 орчим удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгааг гарган хэрэглэгчийг мэдээллээр ханган ажиллав.<br>Тухайлбал:<br><br>****** УИХ-ын нэр бүхий 5 гишүүний хүсэлтээр:***<br>- 2015-аас 2025 оны 1 улирлын байдлаарх даатгуулагчийн цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, төлсөн шимтгэлийн хэмжээ, даатгуулагчийн тоон мэдээллийг **4 удаа**;<br>- 2020-2025 оны байдлаарх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, цалин хөлс болон салбарын тоон мэдээллийг;<br>- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.7-д заасан нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгийн хэмжээг 2021-2025.08 сарын байдлаар;<br><br>****** Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүсэлтээр:***<br>- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө, дундаж тэтгэврийн хэмжээг өгөгдсөн интервалын дагуу тэтгэврийн төрөл болон хүйсээр;<br>- Цэргийн ТА, ХЧА-ын тэтгэвэр авагчдын хөдөлмөрийн чадвараа алдсан жил, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хөдөлмөрийн чадваргүй иргэний тоон мэдээллийг;<br>- Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагсдын мэдээллийг;<br>- Сүүлийн 5 жилд тэтгэвэр авсан тэтгэвэр авагчдын дэлгэрэнгүй мэдээлэл, нэрийн дансны мэдээлэл, нийт авсан тэтгэврийн дүн, тэжээгчээ алдсан үүссэн эсэх талаар мэдээллийг;<br>- 2024 онд малчин, туслах малчин төрлөөр сайн дурын даатгалд даатгуулсан нийт даатгуулагчийн нас, хүйс, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | тодорхойлолтыг цахимаар авсан. | | шимтгэл төлсөн сар, "Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай" болон "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай" хуулиар нөхөн тооцсон эсэх мэдээллийг;<br>- 10-аас дээш жил шимтгэл төлсөн, тэтгэврийн эрх үүсгээгүй, "Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай" хуулиар нөхөн даатгалд хамрагдсан нийт даатгуулагчийн нас, хүйс, нөхөн төлсөн сарын мэдээллийг;<br>- Нийслэлийн 6 том дүүрэг, нэр бүхий 4 аймгийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн мэдээллийг, 2020-2025 оны байдлаар;<br>*** *Үндэсний статистикийн хороонд:*<br>- ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны 4-р улирал, 2024 оны жилийн эцсийн байдлаарх ААНБ-ын даатгуулагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, сарын дундаж цалинг өгөгдсөн интервал, хүйс, аймаг болон бүс, эдийн засгийн ангилал, ажил мэргэжлийн код, өмчийн хэлбэр, хариуцлагын хэлбэрээр. /**Нийт 34 хүснэгтэн мэдээллийг 2 удаа**/<br>- ҮСХ-ны даргын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/175 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаарх нийгмийн даатгалын салбарын **нийт 28 хүснэгтэн** мэдээллийг;<br>*** *Татварын ерөнхий газарт:*<br>- 2024 оны байдлаарх нийт даатгуулагчдын цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилгах орлогын хэмжээ, төрлийн код, ногдуулсан шимтгэлийн хэмжээ зэрэг **дэлгэрэнгүй** мэдээллийг<br>*** *Боловсрол, шинжлэх ухааны яаманд:*<br>- Жагсаалтаар ирүүлсэн, Боловсролын зээлийн сангаас зээл авсан иргэдээс төрийн байгууллагад ажилласан даатгуулагчдын тоон мэдээллийг;<br>*** *Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт:*<br>- Халамжийн тэтгэвэр авдаг 65.0 мянган иргэнийг тэтгэвэр авдаг эсэх мэдээллийг;<br>*** *Шинэ хоршоо салбар дундын уялдааг хангах үндэсний хороонд:*<br>- УБЕГ-т хоршоогоор шинээр бүртгүүлсэн 9.3 мянган хоршооноос нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хоршооны даатгуулагчдын тоон |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийг;<br>*** *Авлигатай тэмцэх газарт:*<br>Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг **9 удаа**;<br>*** *ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн шалгах алба, Экологийн цагдаагийн албанд:*<br>- Нэр бүхий ААНБ-ын шимтгэл төлөлтийн мэдээллийг нийтдээ **60 удаа.**<br><br>Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолоор баталсан "Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу даатгуулагчийн мөнгөжүүлэхээр тооцсон болон мөнгөжүүлэхэд бэлэн орлогын хэмжээг сар бүр тооцоолж, иргэд даатгуулагчид "Нийгмийн даатгал" аппликейшн, Portal.ndaatgal.mn вэб систем, E-Mongolia порталаар авах боломжийг бүрдүүлсэн. гэх мэт.<br><br>- Өндөр нас, ХЧА-ны, тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох **80.8 мянган** иргэний хүсэлтийг хүлээн авч **96.9%**-ийг шийдвэрлэсэн байна.<br>- *Тэтгэвэр олголт:*<br>*сар бүр дунджаар **556.5 мянган** тэтгэвэр авагч (давхардсан тоогоор нийтдээ 6.1 сая)-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг системээр тооцоолон цаг хугацаанд нь холбогдох банк руу илгээсэн байна.<br>- *Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан.*<br>*нийт **61.9 мянган** ажил олгогчийн сар бүр илгээсэн **681.1 мянган** удаагийн, давхардсан тоогоор **8.8 сая** албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг **100%** цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.<br>*ажил олгогчоос цахимаар илгээсэн **81.1 мянган** албан журмаар даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>- *Эмнэлгийн хуудас:*<br>***992** эрүүл мэндийн байгууллагаас **176.7 мянган** | |

албан журмын болон сайн дурын даатгуулагчийн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, **58.5 мянган** даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт **235.2 мянган** эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч тэтгэмжийн тооцооллыг хийж үйлчилгээ үзүүлсэн байна.

- *Лавлагаа тодорхойлолт:*
  *нийгмийн даатгалын портал системээр **79.3 мянган** даатгуулагч, **92.7 мянган** ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан байна.
- *E Mongolia нэгдсэн портал:*
  *иргэд даатгуулагч, ажил олгогч **5.9 сая** удаагийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авсан байна. Үүнд:
  *Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт /англи, монгол хэл/: **5.5 сая**
  *Нийгмийн даатгал төлж байсан эсэх тодорхойлолт: **273.5 мянга**
  *Өндөр нас, ХЧА, Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас /англи, монгол хэл/: **86.2 мянга**
  *Иргэн/даатгуулагч/-д НДС-гаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт: **61.2 мянга**
  *ХЧА-ын хувь, хугацаа тогтоосон акт: **51.2 мянга**
  *Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа: **55.6 мянга**
  *Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолт: **204.**

***4. Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр хүргүүлж буй нийгмийн даатгалтай холбоотой үйл ажиллагааны хэвийн байдлыг хангаж ажиллав.***

1.Төрийн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан нийгмийн даатгалын үйлчилгээг бодит цагийн горимоор цахимаар үзүүлэх зориулалт бүхий, иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг агуулсан, **60 гаруй** төрлийн сервисийн хэвийн ажиллагааг хангаж ажиллав.

2.ХУР системээр дамжуулан үзүүлэх цахим үйлчилгээг өргөжүүлэх хүрээнд дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Даатгуулагчийн мөнгөжүүлсэн орлогын хэмжээг E-Mongolia порталаар харуулах сервисийг шинээр боловсруулан ХУР системд байршуулсан.
- Засгийн газрын 2024 оны 256 дугаар тогтоолын дагуу

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах хүсэлтийг ХУР системээр дамжуулан E-Mongolia порталаар цахимаар авах сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн.<br>3. **Үндэсний статистикийн хороотой** мэдээлэл солилцох чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:<br>- ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 дугаар тушаалаар батлагдсан **34 нэр төрлийн маягтын** дагуу даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын мэдээллийг цахим хэлбэрээр дамжуулах нөхцөлийг бүрдүүллээ. Үүний үр дүнд эдгээр мэдээллийг **дундын серверт байршуулан (баазаар өгөх хэлбэрээр)** тогтмол, түргэн шуурхай мэдээлэл солилцох боломж бүрдсэн байна.<br>- ААНБ-ын дор дурдсан томоохон мэдээллийг нийгмийн даатгалын **мэдээллийн** нэгдсэн системээс авах сервисийг боловсруулан хүргүүлсэн. Үүнд:<br>*Байгууллагын регистр, хаяг байршил, ЭЗҮАС ангилал, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр<br>*Даатгуулагчийн төрөл тус бүрээр даатгуулагчдын тоо болон төлөх шимтгэлийн мэдээлэл. Үүнээс:<br>-эмэгтэй даатгуулагчдын тоо, төлөх шимтгэлийн дүн,<br>-гадаад даатгуулагчдын тоо, төлөх шимтгэлийн мэдээлэл.<br>Энэхүү шийдэл нь мэдээллийн хүртээмж, найдвартай байдлыг сайжруулан, даатгуулагчтай холбоотой статистик болон дүн шинжилгээний мэдээллийг илүү нарийвчлалтай гаргах нөхцөлийг бүрдүүлж байна. | |
| ***БИЕЛЭЛТИЙН ХУВЬ*** | | | | | | | **94.8** |

---- oOo ----